

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
06 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 193

- Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудал*
1. /“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын
Их Хурлын тогтоолын төсөл/

7 – 193

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 02-ны өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 102 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 44 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ц.Мөнхбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Түвшин, Г.Хосбаяр;

Тасалсан: Н.Алтанхуяг, Г.Уянгахишиг;

Хоцорсон: О.Амгаланбаатар – 9 цаг 03 минут, Ц.Баатархүү – 7 цаг 18 минут, Х.Булгантуяа – 05 минут, А.Ганбаатар – 25 минут, Д.Ганбат – 01 минут, Л.Гантөмөр – 7 цаг 56 минут, Б.Жавхлан – 1 цаг 13 минут, Д.Жаргалсайхан – 11 минут, Ч.Лодойсамбуу – 28 минут, С.Лүндэг – 3 цаг 42 минут, П.Мөнхтулга – 24 минут, С.Одонтуяа – 5 цаг 06 минут, Б.Пунсалмаа – 16 минут, Ц.Туваан – 1 цаг 11 минут, Г.Тэмүүлэн – 05 минут, А.Ундраа – 2 цаг 58 минут, Р.Эрдэнэбүрэн – 02 минут.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудал
/“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Э.Лхагва, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат, Менежментийн газрын референт Д.Хосбаяр нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үг хэлэв.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын

хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 20 цаг 17 минутаас 20 цаг 35 минутад хуралдааныг даргалав.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, С.Эрдэнэболд, Т.Доржханд, О.Цогтгэрэл, Ц.Даваасүрэн, Б.Баярбаатар, А.Ариунзаяа, М.Нарантуяа-Нара, Л.Энхнасан, Ц.Идэрбат, Б.Уянга, С.Бямбацогт, Б.Найдалаа, М.Ганхүлэг, Х.Баасанжаргал, Ө.Шижир, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Мөнхбаясгалан, Ч.Анар, М.Мандхай, Б.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал, С.Эрдэнэбат, П.Наранбаяр, О.Батнайрамдал, Д.Батлут, Ч.Номин, П.Ганзориг, С.Цэнгүүн, О.Номинчимэг, Д.Ганмаа, С.Ганбаатар, Э.Болормаа, Б.Бейсен, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, Р.Батболд, Г.Дамдинням, Б.Батбаатар, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 22 цаг 47 минутаас 23 цаг 16 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Эрдэнэболд, Б.Жаргалан, А.Ариунзаяа, С.Замира, М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар, Б.Найдалаа, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, Д.Энхтүвшин нар үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх үг хэлэв. /23:44/

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун, О.Батнайрамдал, Б.Хэрлэн, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаан 00 цаг 26 минутаас 01 цаг 29 минутад завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, О.Алтангэрэл, С.Амарсайхан, Д.Ганмаа, Г.Лувсанжамц, Э.Одбаяр, Д.Бум-Очир, Х.Тэмүүжин, Ж.Баясгалан, Ж.Батсуурь, Р.Батболд, Б.Батбаатар, Д.Ганбат, Ц.Туваан, С.Одонтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлаар нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 41
Бүгд: 118
65.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу “Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.” гэсэн санал хураалт явуулах журмыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд санал хураалтад оролцохгүй гэдгийг мэдэгдэв. /02:35/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Тооллогын комисс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Тооллогын комисс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 42
Бүгд: 118
64.4 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Тооллогын комисс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /02:40/

Тооллогын комиссын даргаар Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, нарийн бичгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай, Л.Энхнасан, О.Батнайрамдал, Э.Болормаа, Д.Батлут нар ажиллахаар тогтов.

Тооллогын комисс 02 цаг 35 минутаас 02 цаг 40 минутад хуралдаж, нууц санал хураалт явуулах журам болон саналын хуудасны баталгаажуулсан

загварыг тооллогын комиссын дарга, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Тооллогын комиссын дарга М.Нарантуяа-Нара Тооллогын комиссын боловсруулсан “Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 50

Бүгд: 118

57.6 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /02:45/

Тооллогын комисс нууц санал хураалт явуулах, дүн гаргах журмын дагуу нууц санал хураалтыг 02 цаг 45 минутаас 03 цаг 47 минутад явуулж, дүнгээ гаргаж дуусав.

Тооллогын комиссын дарга, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар нууц санал хураалтад нийт 82 гишүүн оролцож, санал хураах хайрцгийг нээхэд 82 ширхэг саналын хуудас гарсан ба хүчинтэй саналын хуудас 82, хүчингүй саналын хуудас 0, зөвшөөрсөн, татгалзсан гэсэн санал тус бүрээр нэг бүрчлэн тоолж гаргахад, зөвшөөрсөн гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 44 ширхэг буюу санал хураалтад оролцсон гишүүдийн 53.7 хувь, татгалзсан гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 38 ширхэг буюу санал хураалтад оролцсон гишүүдийн 46.3 хувь гэсэн тооллогын комиссын дүнг танилцуулав.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын саналаар “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлаагүй тул Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /02:45/

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үг хэлэв.

Уг асуудлыг 03 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 9 цаг 11 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 120 гишүүн ирж, 95.2 хувийн ирцтэйгээр 03 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
17 цаг 44 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

102 гишүүн ирцэд бүртгэгдэж ирц 81 хувьтай байна.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалд оръё.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ үг хэлнэ.

Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Монгол Улсын ард иргэд ээ,

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Та бид Монгол Улсын ирээдүйг шийдвэрлэх түүхэн эгзэгтэй мөчид хамтдаа ирж байна. Учир нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 126 төлөөлөл бүхий шинэ парламентын байгуулсан анхны Засгийн газар тогтвортой ажиллаж чадах эсэх тухай шийдвэрийг Та бид өнөөдөр хамтдаа гаргах гэж байна.

Энэ асуудал хамтарсан Засгийн газар, Ерөнхий сайдын асуудал гэхээс илүү Монгол Улсын ирээдүйг цаашид ямар замаар хөтлөх вэ гэдэг салаа замын эхэнд байна.

Бид 76 гишүүнтэй парламенттай байх үед засаглалын дундаж хугацаа 1.5 орчим жил байсан. 126-тай болоод бид цаашид энэ жишгийг хэрхэн өөрчлөх вэ, яаж цаашид бид тогтвортой засаглалын асуудлыг авч үлдэх вэ гэдэг энэ асуудал өнөөдрийн чухал асуудал. Мөн 126 гишүүнтэй парламентын шинэ тогтолцооны анхны кэйс болж үлдэхээрээ түүхэн ач холбогдолтой юм.

Монгол Улс хоёр том гүрний дунд оршин тогтнодог парламентын засаглалтай ардчилсан улс. Парламент цаашдаа бүрэн эрхт байдал, ардчилсан үнэт зүйлээ хамгаалах гадна, дотнын олон сорилттой хамтдаа нүүр тулах болно.

Амьдралаа ямар байхыг сонгох, хувь тавилангаа өөрөө тодорхойлох эрх Монголын иргэдэд, тэр дундаа ард түмний төлөөлөл болсон парламентын онцгой бүрэн эрхийн асуудал.

Бид өөрсдийн үзэл бодлоо хэнээр ч заалгахгүй байх эрх чөлөөтэй бөгөөд өнөөдрийн нээлттэй хурлын үр дүнд олон нийтийн нийтлэг хүсэл эрмэлзэлд тулгуурлан төрийн эрх дээд байгууллага Улсын Их Хурал эцсийн шийдвэрээ гаргаж чадна гэдэгт миний хувьд огт эргэлзэхгүй байна.

Ардчилал бол тэнгэрээс унаж ирдэг зүйл биш бөгөөд харин хамтдаа тэмцэж босгодог үнэт зүйл билээ. Тиймээс ч миний бие өнөөдөр ард түмний төлөөлөл болсон парламентын гишүүдийн бүхий л асуултад ил тод, нээлттэй хариулах болно.

Үнэнийг бид нээлттэй ярьж чадахгүй бол, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахгүй бол энэ өөрөө парламентын ардчилал биш болж хувирна. Ил тод биш байдал, айдас хүйдэс, хөшигний цаадах тохироо улмаар ард түмний эрх чөлөөг хумьж, эрх мэдэл, эд хөрөнгийг тойрсон дарангуйллын тогтолцоо бий болж ардчиллыг устгадаг гэдгийг олон улсын түүх нотолсон гэдгийг бид бүгдээрээ мэднэ.

Дэлхий даяар ардчилал аюулд өртөж, сорилтод орж буй энэ цаг үеийг даван туулахын төлөө улс төрийн намууд нэгдэж, парламентын төлөөллийн тоог нэмж 126 гишүүнтэй цоо шинэ парламентыг сонгуулийн холимог тогтолцоогоор Та бид хамтдаа бүрдүүлсэн.

100 жилд нэг тохиох цар тахал, дайны цаг үе улс орнуудын хилийг хааж, итгэл найдвар бүдгэрч байсан цаг үед миний бие Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллах эрхэм хүндтэй үүргийг хүлээж авсан. Бид хамтдаа эдийн засгаа сэргээн тэлж, Монголын улс төрд цоо шинэ салхийг оруулж чадсан.

Сонгодог парламентын засаглалтай жинхэнэ ардчиллын бий болгохын төлөө үе үеийн Улсын Их Хурлын гишүүд бууж өгөлгүй тэмцсээр ирсэн.

Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн онцлог бол Монголын ард түмэн бидэнд ардчилалыг улам бэхжүүлэх, улсаа улам бүр хөгжүүлэх, шинэлэг дэвшилтэт бодлогыг хэрэгжүүлэх эрх, хариуцлагыг хамтад нь хүлээлгэсэн ард түмний сонголт байсан.

Монгол Улс анх удаа 126 гишүүнтэй, 5 намын төлөөлөл бүхий парламенттай болсон. Энэ нь парламентын засаглалыг бэхжүүлэх ард түмний саналыг гээхгүй байх, бодит төлөөллийг хангах түүхэн алхам болсон гэж миний хувьд үргэлж бахархдаг. Үр дүнд нь нийт гишүүдийн 64 хувь буюу 81 нь шинээр сонгогдсон гишүүд, 25 нь буюу 32 эмэгтэй гишүүн сонгогдсоноор Ази тивийн дундаж үзүүлэлтээс давсан үзүүлэлттэй байгаа.

Бид энэ амжилтыг дараа дараагийн сонгуульд цагийн зүүг ухраахгүй байх учиртай.

Улс төрийн уламжлалт сэтгэлгээнээс ангид экспертүүд, шинэ үеийнхэн парламентад жагсаалтаар сонгогдох боломж анх удаа Монгол Улсад бүрдсэн. Түүхэндээ монголчууд өөр өөр санаа, үзэл бодолтой, үзэл баримтлалтай хүмүүс зөвшилцөлд хүрэх сонгодог парламентын сонгуулийн тогтолцоог хамтдаа бид бүрдүүлсэн.

Сонгуулийн холимог тогтолцоонд шилжсэнээр хамтарсан Засгийн газар байгуулах үндэс суурь бүрдсэн гэж үзэж болно. Энэ том хариуцлагатай байсан учраас ч гурван намын хамтарсан Засгийн газрыг байгуулах нь зүйтэй гэж Ерөнхий сайдын хувьд үзсэн.

Харин өнөөдөр Та бид хамтдаа эхлүүлсэн энэ шинэчлэл зөв байсан эсэхийг Монголын ард түмэнд нотлох сонголтын өмнө хамтдаа ирээд байна. Засаглал хэрвээ тогтворгүй болж, эдийн засгийн нөхцөл байдлууд хүндэрч, намууд зөвшилцөж чадахгүй парламентын ажил гацвал парламентын засаглалын талаар олон нийтийн санаа бодлыг эргэлзээнд оруулж, улмаар ардчилсан парламентын засаглалыг мөхөлд хүргэх эрсдэлийг дагуулж болзошгүйг миний бие нэг удаа Улсын Их Хурлын чуулганд илэрхийлж байсныг Та бүхэн санаж байгаа биз.

Шинэ парламентын түүхэн дэх анхны хамтарсан Засгийн газар “Алсын хараа-2025” урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор улс орны эрх ашгийг намын болон хувийн эрх ашгаас дээгүүр тавьж “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” уриан дуурь гэрээ байгуулж хамтран ажиллаад 10 сарын хугацаа өнгөрч байна.

Энэ жил хүрэхгүй хугацаанд 60 гаруй жил яригдсан Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг, 30 гаруй жил яригдсан эрчим хүчний реформ болон

үнийн чөлөөлөлтийг, 28 жил гацсан Монгол, Францын хамтарсан ураны төслийг, 20 гаруй жил улстөржин гацсан Гашуунсухайт, Ганцмод боомтын хил холболтын төмөр замыг хамтдаа Та бид эхлүүлж чадсан.

Монголчууд бид том эрх ашгаа харж нэгдэж чадвал ямар их боломж байгаагийн бодит илэрхийлэл бол энэ юм. Энэ бол 126-тай энэ парламент, мөн хамтарсан Засгийн газрын давуу тал юм.

Мэдээж хамтарсан Засгийн газарт сул тал байна. Хамтарсан Засгийн газрын хувьд аль аль намд гомдол үүсэж, хардалт дагуулж, томилгооноос үүдсэн маргаан дэвэрч, нийгмийн хувьд ч олонх, цөөнхийн хяналт тэнцэл алдагдаж байна гэдэг бодит шүүмжлэл өрнөснийг бид хамтдаа хүлээн зөвшөөрч, мөн дүгнэх учиртай.

Гэвч эвлэлдэн нэгдэх хэцүү. Харин бусниулах бол нэг өдөр л болдог зүйл. Том төслүүдийг гацаах маш амархан. Харин гацаанаас гаргаж, учрыг нь олж, зөвшилцөлд хүрч хөдөлгөнө гэдэг маш их хугацаа шаардсан зүйл.

Засгийн газар огцрох амрах нь үнэн. Гагцхүү улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн ирээдүйд үүсэж болох алдагдсан боломжийн өртөг ямар хэмжээнд байх вэ гэдгийг бид өнөөдөр олон талаас нь шүүн хэлэлцэх учиртай.

Хамтарсан Засгийн газар Үндэсний баялгийн санг бүрдүүлэх стратегийн ордуудын 34 хувь, түүнд ногдох баялгийн хөтөлбөрийг хуримтлалын сангаар дамжуулан ард түмэнд тэгш хуваарилах хэлцэл ид дундаа үргэлжилж байх үед Ухаахудаг ордын асуудлыг Засгийн газраас өргөн барьж, Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхлээд долоо хоног болж байгаа энэ цаг хугацаанд, 9 сард болох Оюу Толгойн арбитрын маргаанд, Онтрэгийн ордын хөрөнгө оруулалтын гэрээг хийх ажил ид дундаа өрнөж байх үед, нийгмийн даатгал, татварын цогц реформыг намын бүлгүүдэд танилцуулан, дэвшилтэт буюу шаталсан татварын тогтолцоогоор орлогын тэгш бус байдлыг засах улс төрийн шийдвэр гарсан цаг хугацаанд, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн бариад хэлэлцэж эхлэх үед, хөгжлийн мега төслүүдийн 5 нь бодитоор хөдөлж, Гашуунсухайт, Ганцмод хил холболтын төмөр замыг гурав дахь талуудын ашиг сонирхолгүйгээр хөдөлгөж, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн өдөртэй давхцан улс төрд олон үйл явдал өрнөснийг Та бүхэн мэдэж байгаа.

Сүүлийн өдрүүдэд Ерөнхий сайд хамтарсан Засгийн газарт ирэх улс төрийн дайралт, энэ хүрээнд хийж буй кампанит ажил сонгуулийн өрсөлдөөний халуун өдрүүдээс илүү эрчимжиж байгаа нь ил далд ямар том хэмжээний эрх ашиг нэгдсэнийг харуулсан тод илэрхийлэл гэдгийг саруул ухаанд Монголын ард түмэн харж байгаа гэдэгт Ерөнхий сайдын хувьд бүрэн итгэлтэй байна.

Өнөөдөр судалгаагаар Монголын ард түмний 65 хувиас дээш хувь нь тогтвортой засаглалыг дэмжиж байна.

Үндэсний баялгийн сан хэрэгжиж, иргэдэд шууд өгөөжөө өгөөсэй хэмээн иргэд хүсэж байна. Ил тод байдлын төлөө үзэл бодлоо илэрхийлж буй залуучууддаа, өөр өөр өнцгөөс үзэл бодлоо илэрхийлж буй иргэддээ талархаж байна.

Харин үүнийг улс төрийн шалтаг болгож, улс төрийн тогтворгүй байдлын суурь шалтгааныг үүсгэж буйд харамсаж байна.

Миний бие төрийн өмчийн компаниудын нэг ч томилгоо, нэг ч тендер, нэг ч Засгийн газрын тусгай сангийн болон төрийн санхүүжилттэй банкны зээлд хамрагдаж, өөрийгөө өршөөх хууль санаачилж явсангүй.

Харин энэ бүхнийг илчилж, цахим засаглал, ил тод байдал, авлигын эсрэг, эрх ашгийн бүлэглэлийн эсрэг тууштай зогсож хатуу тэмцсээр ирсэн. Хэрэв би өөртөө болон өөрийнхөө хөрөнгө орлогын мэдүүлэгтээ эргэлзэж байсан бол олон галтай сэдвүүдтэй нэгэн зэрэг нүүр тулж Монгол Улсын нийтийн эрх ашгийн төлөө тэмцэхгүй тайван замаар амьдрах сонголтыг хийж болох байсан.

Хэтэрхий олон дайсантай болсноос чинь боллоо хэмээн тавлан хэлэх улс төрчид байгаа ч энэ бол хувь хүний биш Ерөнхий сайдын хувьд Монгол Улсын түүхэнд эс үйлдэл хийхийг хүсээгүй итгэл үнэмшил байсан юм.

Хэрэв миний хувьд өөртөө хөрөнгө орлогын мэдүүлэгтээ эргэлзэж байсан бол Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг төрийн мөнгөөр хувьдаа авсан хууль бус худалдан авалтын схемийг ажлын хэсгийн ахлагчийн хувьд илчилж, Хөтөлийн цемент, Дарханы төмөрлөг, Бор-Өндөрийн хувьчлалыг буцаахгүй байж болох байсан.

Эрдэнэс Тавантолгойн нүүрсний худалдан авалт оффтейк гэрээг илчилж, биржийн худалдааг зохион байгуулж, гаднын менежментийг зарлахгүй байж бас болох байсан. Чингис, Самуурай бондуудын өрийг төлөхийн төлөө Хөгжлийн банкны 1.8 их наяд төгрөгийн зээлийг олон нийтэд ил тод болгохгүй дарж бас болох байсан.

E-Mongolia болон нээлттэй мэдээллийн цахим хуудас нь төрийн бүх тусгай сангуудын мэдээллийг нээлттэй зарлахгүйгээр мөн хаалттай үлдээх сонголт байсан.

Монгол Улсын эрх ашгийг хангуулах Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлж, Оюу Толгойн Дубайн гэрээг цуцалж, 34 хувьд ногдох 2.3 тэрбум ам.долларыг тэглүүлэх олон улсын шүүхийн асуудлыг эхлүүлэхгүй байх сонголт надад байсан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлуулж, стратегийн ордуудын 34 хувьтай холбоотой гал атгасан хэлцлийг ч эхлүүлж бас чадахгүй байсан нь үнэн юм.

Энэ бүхэн Улсын Их Хурлын эрхэм гишүүд, олон нийтийн дэмжлэгтэйгээр хийгдсэн зүйл бөгөөд гүйцэтгэх засаглалын тэргүүнээс чамгүй их хэмжээний сэтгэлийн тэнхээ шаарддаг ажил юм билээ.

Алдаа оноо, чадсан чадаагүй олон зүйл надад бий. Буруу, зөрүү ойлгогдсон олон асуудал байгааг ч хүлээн зөвшөөрч байна.

Том төсөлд хэт их цаг гарган нийгмийн асуудал, улс төрийн дотоод асуудалд анхаарал бага хандуулсан улс төрийн алдаа ч бас байна. Баримтлах ёстой зарчим дээрээ хатуу зогссоноос болж улс төрийн хүчний харьцааг алдагдуулсан зүйл ч бас бий.

Засгийн газар танхимын зарчмаар ажиллах үнэт зүйл Үндсэн хуулийн зарчмаасаа хазайсан асуудал ч бас байгааг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Гэхдээ л энэ бүх тэмцлийн үр дүнд Монгол Улсын экспортын орлого хоёр дахин өсөж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 37.4 их наядаас 80 их наяд төгрөгт хүрч, Монгол Улсын эдийн засаг хоёр дахин тэлсэн.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4128 ам.доллараас сүүлийн 3 жилд тогтмол өсөж, 6898 ам.долларт хүрсэн байна.

2024 онд Монгол Улсын зээлжих зэрэглэл нэг шат ахиж, “В” тогтвортой, “В+” тогтвортой ангилалд шилжсэн нь олон улсын санхүүгийн байгууллагын өмнө Монгол Улсын Засгийн газрын нэр хүндийг өсгөж, хөрөнгө оруулагчид Монгол Улсыг сонирхож эхэлсэн нь бас нууц биш юм.

Жилд дунджаар 5-аас 6 хувийн өсөлттэйгөөр хурдтай хөгжиж буй дэлхийн эдийн засагтай улс орнуудын нэг болж Монгол Улс чадсан.

Монголчууд Та бид энэ амжилтаа ухраах биш ахиулах учиртай.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 23 дугаар зүйлд Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасны дагуу Та бүхэн ард түмний төлөөлөх онцгой бүрэн эрхтэй билээ.

Ялалт бол мөнхийн зүйл биш, ялагдах ч бас сүйрэл биш юм. Гагцхүү үнэт зүйлдээ үнэнч үлдэх л жинхэнэ ялалт гэдэг үг бий.

Ард түмний элч болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэн энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлд заасныг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Үндэсний баялгийн сан, хөгжлийн 14 мега төсөл, эрчим хүчний салбарын реформ, бүсчилсэн хөгжил зэрэг томоохон зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, бодит үр дүнг бататгах, дэвшүүлсэн бодлого, зорилтоо хамтын хариуцлагын зарчимд тулгуурлан тогтвортой хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан хамтарсан Засгийн газрын бодлогыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд итгэл хүлээлгэх тухай асуудлыг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр “Итгэл үзүүлэх тухай албан бичиг”-т дурдсан үүссэн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэх дэмжлэг шаардлагатай байна гэсний утга, шалтгаан, улс төрийн нөхцөл байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Ерөнхий сайдын хүүгийн орлогоо нотлох асуудал яг ямар шатанд явж байгаа талаар, анх хувь хүний асуудал байсан “орлогоо нотлох” асуудал яаж улс төрийн “итгэл хүлээлгэх” асуудал болсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Ерөнхий сайд орлогоо нотлох шаардлагатай талаар, мөн “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” уриан доор байгуулсан хамтарсан Засгийн газрын гэрээг ил болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа ямар хуулийн үндэслэлээр итгэл хүлээлгэх санал гаргасан болон бодлогын ямар асуудлаар дэмжлэг хүсэж байгаа, мөн “орлогоо нотлох” асуудал яагаад бодлогын асуудал болсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Ерөнхий сайд бодлогын ямар асуудлаар итгэл хүлээлгэх хүсэлт гаргасан, мөн хамтарсан Засгийн газар гэдэг ойлголт Үндсэн хуульд байхгүй талаар, мөн Ерөнхий сайдын

хэлсэн “улс төрийн саад” гэдэг үгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа санал хураалтыг нууцаар биш, ил тод явуулах ёстой, ард түмний өмнө тангараг өргөсөн ёсоороо ил тод байр сууриа илэрхийлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Ардчилсан намаас томилогдсон сайд нар хариуцлагатайгаар үүрэг гүйцэтгэсэн байхад, тэднийг Засгийн газраас гаргах шийдвэр гаргасан нь хэр үндэслэлтэй талаар, Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн зорилго, зарчимтай нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал улс төрийн хямралын цаад шалтгаан, мөн Үндсэн хуулийн шинэчлэлийн зорилго, тогтвортой парламентын үйл ажиллагаа руу чиглэж ажиллах талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийлж, анх удаа итгэл үзүүлэх тогтоол гарч байгаа нь улс төрийн соёлын нэг илрэл гэж үзэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр улс төрчийн хувь заяанаас илүү төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал чухал талаар, мөн Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн айдас, барьцаанд биш, итгэл үнэмшлээрээ шийдвэр гаргах нь парламентын ардчиллыг хамгаалж, шударга, ил тод процесс явуулах нь иргэдийн итгэлийг хадгалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Засгийн газрын сайд нар Улсын Их Хурлын гишүүний ажлаа муу хийсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүд, сайд нар хуралдаанд идэвхтэй оролцох ёстой, төрийн ажилд хариуцлагатай хандах, мөн Ардчилсан нам Засгийн газраас гарах нь төрийн хяналтыг сайжруулах, парламентын тогтолцоог эрүүлжүүлэх алхам болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар сөрөг хүчин байх нь парламентын тэнцвэрт тогтолцооны суурь боловч өнөөгийн байдлаар хамтарсан Засгийн газар, цөөнхийн үүрэг бүдгэрсэн байдал нь асуудал дагуулж байгаа, мөн өнөөгийн улс төрийн хямрал нь бодлогоос бус улс төрийн тохироо, шийдвэрээс шалтгаалж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Ерөнхий сайдыг огцруулах асуудал нь Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан тодорхой бодлогын асуудлаар гэсэн яг ямар тодорхой бодлогын асуудал гэдэг нь тодорхойгүй байгаа, мөн сөрөг хүчин байх нь парламентын тэнцвэрт тогтолцооны суурь боловч өнөөгийн байдлаар хамтарсан Засгийн газар, цөөнхийн үүрэг бүдгэрсэн нь асуудал дагуулж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2016 оноос хойш төр барих хугацаандаа үр дүнтэй бүтээн байгуулалт хийсэнгүй, Ардчилсан нам Засгийн газраас гарч сөрөг хүчин болох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал тогтворгүй Засгийн газар, том төслүүд урагшилдаггүй байдал нь өмнөх алдаануудыг давтах эрсдэлтэй, мөн байгалийн баялгийн шударга хуваарилалт, том төслүүдийн хэрэгжилт, Үндэсний баялгийн сан зэрэг асуудлаар бодит шийдвэр гаргах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг улс төржилтөөс болж том төслүүд зогсож, Монгол Улсын нийтлэг эрх ашиг хохирч байгаа бөгөөд шийдвэрүүдийг ил тод, парламентын зарчимд нийцүүлэн гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ төр тогтвортой байх нь хамгийн чухал асуудал гэдгийг онцолж, намууд хоорондоо

ойлголцож, хамтран ажиллах, мөн гишүүд зарчмаа баримтлан, нээлттэй байдлаар шийдвэр гаргах нь зүйтэй гэж тус тус үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу тооллогын комиссыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулах Байнгын хорооны тогтоолыг баталсан бөгөөд уг комисс нууц санал хураалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлаар нууц санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 73.9 хувь нь дэмжиж, “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ. Тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна.

Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өөртөө итгэл үзүүлэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 92.9 хувийн ирцтэйгээр хэлэлцэж, нийт гишүүдийн олонхын саналаар Ардчилсан намын гишүүд чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцохгүй гэж шийдвэрлэлээ.

Санал хураалтад оролцохгүй байх нь Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд итгэл үзүүлэхгүй гэсэн улс төрийн шийдвэр юм. Үндэслэл нь:

Нэгдүгээрт нь, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ өөрийнхөө болон хамаарал бүхий этгээдүүдийн хэрэглээ, хууль, ёсны орлогоо нотлохыг шаардсан иргэдийн шаардлагад хариулахын оронд өөрт итгэл үзүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хуралд оруулж байгаа нь ард иргэдийг төөрөгдүүлж, парламентыг талцуулж буй зарчимгүй үйлдэл гэж үзлээ.

Хоёрдугаарт нь, Монгол Ардын намын Бага хурлаас Ардчилсан намыг Засгийн газраас гаргах шийдвэр гаргасан нь хамтарсан Засгийн газар байгуулах улс төрийн намуудын төлөөллийн байгууллагын гаргасан шийдвэр, хамтран ажиллах гэрээг бүдүүлгээр зөрчсөн үйлдэл юм.

Ардчилсан намын бүлэг хамтарсан Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн бодлого, мега төслүүд, түүний дотор Гашуунсухайтын хил холболтын төмөр зам, баялгийн сан, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилт зэрэг томоохон бодлого, төслүүдийг бүхэлд нь дэмжиж ирсэн.

Иймд дээрх үндэслэлээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаарх Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцохгүй байх шийдвэр гаргасныг мэдэгдэж байна.

Цаашид Ардчилсан нам иргэдийнхээ итгэлийг хүлээсэн хариуцлагатай төр засаг байгуулж тогтвортой ажиллах чиглэлээр хууль дээдлэх ёс Үндсэн хуулийн зарчмын хүрээнд идэвхтэй хамтран ажиллана.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна.

Асуулт асуух гишүүд нэрээ өгье. Үг тусдаа. Нийт 52 гишүүн нэр өгсөн байна.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асуух юм байна. Ирцээрээ.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Бид 1992 оноос хойш батлагдсан Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тухай Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх гэж анх удаагаа бид итгэл үзүүлэх тухай ярих гэж байна.

Нэгэнт Ерөнхий сайдын өөрийнх нь хэлж байгаа зүйл дээр сонгодог парламентын асуудлыг нэлээдгүй ярьж байгаа. Тэр ч утгаараа би бас энд сонгодог парламент гэдэг утгаараа бид ер нь энэ санал хураалт, асуулга энэ тэрээ нэлээн дэлгэрэнгүй, нээлттэй ярих хэрэгтэй гэж бодож байгаа юм.

Ер нь бидэнд байгаа нэг чухал зүйл бол бид ард түмний төлөөлөл. Ард түмний төлөөлөл. Бид ард түмэндээ дүнгээ тавиулах ёстой. Сонгогдсон тойргийнхоо иргэдтэй очоод уулзахдаа бид яаж саналаа өгсөн юм бэ гэдгээ ил тод ярьдаг ийм соёлд сурмаар байгаа юм.

Дандаа ордны хөшигний ард явдаг улс төр хийдгээ больцгооё. Илэн далангүй, хэн, ямар гишүүн, өөрийн ямар байр суурьтай байгаа гэдгээ ил тод ярьж сурдаг баймаар байгаа юм. Энэ бол улс төрийн нэг том соёл болох байх аа гэж бодож байна. Тэр ч утгаараа би Ерөнхий сайдын ахалсан Засгийн газартай холбоотой зарим шүүмжилмээр зүйлүүд зөндөө байна.

Тухайлах юм бол эрүүл мэндийн салбар өнөөдөр ямар байдалтай болчихоод байна. Би Ерөнхий сайдад бодлогын олон баримт бичгүүдийг бас танд хэлж ярьж, шүүмжлэлтэй хандаж байсан. Шударга ёс тогтоох том үйлс нь эрүүл мэндийн салбарт л лав тогтоогдоогүй. Авлигачныг авлигачнаар солих, эрүүл мэндийн салбарын сан хөмрөг хоосорсон, эмч, эмнэлгийн ажилчид цалин хөлс нь хүрэхээ больсон, квот тогтоодог, иргэд эмнэлэг дээр очоод эмчилгээ хийлгэх боломжгүй болсон. Энэ бүхэн бол ерөөсөө л энэ тогтолцооны том алдаа байлаа.

Одоо таны Засгийн газарт байгаа Шадар сайд хүртэл хэлж байна шүү дээ. Дамын наймаачдаасаа салаагүй цагт эрүүл мэндийн салбар өөрөө эрүүл болохгүй ээ гэж үг хэлж байна шүү дээ. Энэ нөхцөл байдлыг арилгах гэж би өөрөө хүртэл эмийн сонсголыг ахалж ажиллаж, эрүүл мэндийн салбарын өвчнийг нь оношлоод, эмчлэх жорыг нь хэлээд өгсөн шүү дээ. Хэрэгжүүлсэн юм байхгүй. Одоо ингээд байж байгаа байдал. Нөгөө баахан эмийн чанаргүй байдал.

Тэр битгий хэл хөлдүү шингэнээр хүртэл дусал хийсэн ийм байдалтай байж байгаа явдал бол энэ эрүүл мэндийн салбарт үнэхээр шударга ёс тогтсон уу гэдэгт эргэлзэхэд хүргэж байгаа юм.

Тийм учраас бид ер нь энэ салбарын, ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарыг. Том мега төслүүд ярьж болно. Тэгэхдээ энэ том хоёр салбараа бид хаяж яагаад ч болохгүй. Эрүүл хүн байж байж Монгол Улс маань хөгжинө.

2025 оны төсөв ярьж байхад зарим нэг албан тушаалтнууд эрүүл мэндийн салбарт дэмий хөрөнгө оруулалт хийж байх ер нь хэрэг байна уу гэдэг үг хэлж байсан шүү дээ. Таны кабинетад ажиллаж байгаа зарим албан тушаалтнууд.

Эрүүл хүн хөдөлмөр хийж байж татвар бүрдүүлж Монгол Улсын төсвийг бүрдүүлж байгаа шүү дээ. Хээвнэг эрүүл мэндийн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт нь хэдэн цемент байшинд оруулж байна. Үр өгөөжгүй байна гээд хээвнэг хэлээд сууж байсан. Энэ бол арай хэтэрсэн дэндүү тийм зүйл ярьж байсныг би зориуд сануулж хэлмээр санагдаж байна.

Тийм учраас би бас өөрийнхөө сая хэлсэн үгэндээ сонгодог парламентыг бүрдүүлэх тал дээр Их Хурлын гишүүд, манай 126 гишүүд бол нэг их тийм айж ичээд, эмээгээд, үзэл бодлоо хэлэхээс айгаад байгаа зүйл байхгүй гэж бодож байна. Шударга хэлэх улсууд зөндөө байгаа.

Тийм учраас би бас одоо энэ сонгодог парламентын нэг үлгэрлэл болоод санал хураалт нээлттэй байгаасай. Би итгэл үзүүлэхгүй гэдгээ шууд хэлчихье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя. Асуулт, үг тусдаа явж байгаа шүү.

С.Эрдэнэболд: Ер нь анх асуудал бол орлого нотол гэж гарсан.

Энэ асуудал дээр Монгол Ардын намын Бага хурал шийдвэр гаргасан. Ерөнхий сайдаас асууж байгаа нь энэ ер нь хэр үндэслэлтэй болсон юм бэ? Өнөөдрийн энэ асуудлын ярианы дийлэнх хувь нь хамтарсан Засгийн газар буруу байсан, муухай байсан гэдэг сэдэв рүү орлоо.

Зассаг байгуулахдаа буюу намууд хамтрахдаа 578 зүйл, заалттай байгуулсан. 4 жилийн хугацаанд тодорхой зорилтуудыг тавьж, “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэдэг уриа бүхий засгийн мөрийн хөтөлбөрийг байгуулсан.

Ардчилсан нам, Ардын нам хоёрын мөрийн хөтөлбөрийн ижилсэл, сонгуулийн ижилсэл энэ засгийн мөрийн хөтөлбөр дээр 85.9 хувь буюу бараг 86 хувиар нийцэж байсан учраас Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага хамтрах нь зүйтэй гэдэг шийдлийг гаргасан. Нэг.

Хоёрдугаарт, 126 гишүүнтэй парламент болсон нь цаашдаа ер нь бид улс орны хэмжээний томоохон асуудлуудыг шийдвэрлэхийн тулд талцаж, улс төржиж, популизмдаа идэгдэж, доороо хийрхэхээс илүү нийтлэг язгуур ашиг сонирхлын төлөө хамтраад явъя гэсэн эрмэлзэл дээр тулгуурласан. Магадгүй 2028, 2032 онуудад ч гэсэн 126-тай парламентын илүү олон суудал авсан нам нь бусдадаа урилга тавиад хамтраад асуудлаа шийдэх ийм Герман маягийн соёл тогтоно гэж харж байгаа.

Тэр утгаараа өнөөдрийн хэлэлцэх асуудал дээр ер нь хамтарсан Засгийн газрыг нэг удаагийн хэрчмээр нь биш урт хугацаандаа улс төр, эдийн засаг, төрийн онолын зүй тогтлоор нь бид асуудалд хандмаар байгаа юм.

Ардчилсан намаас засагт ажилласан Тэргүүн Шадар сайд Лу. Гантөмөр эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг алсын хараатай харж гал атгаж ажилласан.

Ц.Туваан сайд олон жил гацсан байгаа олон асуудлууд дээр хувийн нэр хүндээ золиосолж энэ талбарт ажилласан.

Цэндийн Баатархүү мэдээлэл технологийн салбар нь өөрөө төрийн хүртээмжийг ахиулах боломж гэдэг утгаараа иргэдэд хүртээмжтэй төрийн үйлчилгээг сайн байлгахын төлөө ажилласан.

Ж.Батсуурь сайд барилгын салбарт бас шинэ платформ, шинэ реформуудыг хийхийн төлөө зоригтой ажилласан.

Р.Эрдэнэбүрэн сайд төдийлөн ил гараагүй ч гэсэн асар нухацтай бодлого барьж ажилласан.

С.Одонтуяа сайд ганцхан асуудлыг нь хэлэхэд Эгийн голын олон жил гацсан төслийг явуулж чадаж байгаа.

Э.Одбаяр сайд үнэхээр төрд царцанги байдалд бас хяналт хэрэгтэй юм аа, цэвэр агаар хэрэгтэй юм аа гэдгийг дотоод хяналт, энэ зүйлийг засагт сайн ажилласан. Энэ нь ч эхнээсээ гал аваад эсэргүүцэлтэй тулгараад эхэлсэн.

О.Алтангэрэл сайд шударга ёсыг сахиулах том том санаачилгуудыг гаргаж, хүний эрхийн багц хөтөлбөрүүд, хуулийн төслүүдийг оруулж ирсэн.

Тэгэхээр Ардчилсан нам засагт хамтрахаараа улс оронд сөрөг үр дагавар бий болголоо гэсэн Пи Арыг та юу гэж харж байна вэ? Монгол Ардын Бага Хурлаас Ардчилсан намыг гаргах шийдвэр гаргасан нь хэр шударга ёсонд нийцнэ гэж Та үзэж байгаа юм бэ?

Эцэст нь хамтарсан Засгийн газар түүний эсрэг дангаараа олонх болсон нам нь Засгаа байгуулна гэсэн логик бол би түр хугацааных гэж харж байгаа.

Тийм учраас эдгээр зүйлүүдэд ул суурьтай хариулаач.

Төгсгөлд нь сая та Төрийн байгуулалтын байнгын хороон дээр үг хэлэхдээ хэрвээ энэ зөвхөн орлогоо нотлох асуудал байсан бол би гараад уулзах байсан. Харин томоохон асуудлууд байгаа учраас гэсэн одоо таны хэлдгээр амаргүй нөхцөл байдлын тухай ярьж байна.

Тэгэхээр яг одоо Их Хурлын чуулган дээр яг тэр шалтгаануудаа тайлбарлаж өгөөч. Орлогоо нотлохоос өөр ямар ямар тодорхой үндэслэлүүд байсан юм бэ? Эдгээр асуултуудыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайдын микрофон.

Л.Оюун-Эрдэнэ: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Ер нь хамтарсан Засгийн газар байгуулагдаад ажиллахад давуу болон сул тал гардаг юм билээ. Үүнийг би бүлэг дээрээ ч, Бага хурал дээр ч бас ярьсан.

Давуу тал нь яг сая таны хэлдгээр үнэхээр Ардчилсан нам болон бусад намаас томилогдсон сайд нар бүгдээрээ л кабинетын зарчмаар нэг баг болж ажилласан.

Ингээд том асуудлууд явдгийн жишээ бол саяын дурдагдсан энэ том төслүүд. 10 сарын дотор бид 5, 6 гацаж байсан шийдлүүдийг хийж чадсан. Зарчмын, идеологийн, үзэл бодлын маш их тийм ялгаатай олон шийдвэрийг хамтарсны үр дүнд гаргаж чаддаг.

Сул тал байна. Сул тал юу вэ гэхээр аль аль нам дотор сайд болоогүй хэсэг дээрээ асар их хэмжээний далд гомдол зангирдаг юм байна. Энэ нь өөрөө улмаар том асуудлууд болж, хяналт боллоо гэхэд орон нутагт ийм асуудлууд үүсээд байна. Томилгоон дээр тэрийг халсан байна. Ийм агентлаг дээр байгаа хүн ийм мэдээллүүдийг аваад байна. Энэ нь өөрөө дараа дараагийн асуудал дээр сөрөг янз бүрийн улс төрийн үр дагавар дагуулж болзошгүй байна. Таны хувьд Ардчилсан намд арай илүү хөтлөгдөж байна. Зөвхөн л хоёр, гурван намын дарга л шийдвэр гаргадаг болж байна зэрэг ийм олон асуудлууд үүсдэг юм билээ. Энэ бол суурь шалтгаануудын нэг.

Олон олон асуудлууд, олон ч улс төрийн үйл явдлууд болж өнгөрсөн. Энэ бүх зүйл бүлэг дээр байнга л би хамтарсан Засгийн газрыг хамгаалахын төлөө ажилласаар л байсан.

Сүүл рүүгээ яг үнэнээ хэлэхэд жоохон ганцаардаж эхэлсэн. Барахаа больж эхэлсэн. Тайлбарлаад тайлбарлаад нэмэргүй болж эхэлсэн. Ийм зүйлүүд болдог юм байна лээ.

Тийм учраас би өнөөдөр итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг ярьж байгаа нь ч гэсэн би дараа дараагийн Засгийн газар, дараа дараагийн парламентын гишүүдэд сургамж болж үлдээсэй.

Тийм учраас нуугаад байх зүйл байхгүй. Илэн далангүй ярих нь өөрөө төрийн протоколд ингээд үлдэх нь зүйтэй байх аа гэж бодсон.

Орлого нотлохтой холбоотой асуудлыг би 05 сарын 23-нд Авлигатай тэмцэх газар өгсөн. Энэ бүх асуудлуудыг өнөөдөр ч гэсэн би нээлттэй дэлгэрэнгүй хариулахад бэлэн байгаа. Сая Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ч асуусан.

Д.Амарбаясгалан: Нэмэлт авах уу? Нэмэлт 1 минут өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Гэхдээ энэ асуудлыг яг аваад үзэхэд 23 настай тусдаа амьдарч байгаа хүү нь хэн нэг хүнд хайр сэтгэлтэй болоод бөгж авч өгсний төлөө Засгийн газар огцорвол цаашдаа энэ их олон геополитикийн сорилт дундуур тогтворгүй байдал үүснэ.

Тийм учраас би өргөдлөө өгөөгүй. Үүний цаана суурь өөр асуудлууд байсан. Өнөөдөр одоо энэ олон асуултын дунд илэн далангүй л бас асуудлуудыг ярина. Тэгээд бодитой ийм дүгнэлт нийгэмд ч бай, парламентад ч бай дотор үлдэх нь дараа дараагийн зүйлд чухал сургамж болно оо л гэж би бодож байгаа юм.

Тийм учраас хариулахад ийм байна. Ардчилсан намын сая нэр дурдсан сайд нарт би бүгдэд нь талархаж байгаа шүү гэдгээ бас хэлье.

Д.Амарбаясгалан: Тогмидын Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Баярлалаа.

Хамтарсан Засгийн газарт ороод 10 сарын дараа анх удаагаа энэ чуулганы микрофон дээр асуух гэж байна. 10 сарын дараа.

4 жил яг тэнд сууж байгаад сөрөг хүчний ажил хийсэн юм. Харин хамтарсан Засгийн газарт ороход асуудал нь өөр юм билээ. Гүтгүүлдэг, харлуулдаг, тэгэхдээ шүдээ зуугаад ачаагаа үүрээд явдаг. Монголын төр маш их сорилттой.

Харин өнөөдөр эрх чөлөөгөө эдэлж байна. Тэгээд тийм болохоор шулуухан асууна. Шулуухан ярина. Манайхан бүгд мэдэж байгаа. Надад айж ичээд байх юм байдаггүй. Тийм ч байсан. Тийм л хэвээрээ байна.

Тэгэхээр Ерөнхий сайд, Ардын намын дарга Л.Оюун-Эрдэнийг өргөдлөө өгч болохгүй ээ. Харин Их Хурал дээр асуудлаа оруулаад нээлттэй ярилц аа. Итгэх үү, үгүй юу гэдгээ оруул гэж шахсан хүн нь би байгаа юм. Үнэн. Яагаад гэвэл надад эрх нь байгаа.

Яагаад вэ гэхээр манай ХҮН намынхан 3 жилийн хугацаанд бид Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг, нийтдээ 170 гаруй сумаар тойрч явж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг иргэдэд ойлгуулсан юм. Өвөл, зунгүй явсан юм. Амархан биш.

Үр дүнд нь 48 гишүүн өнөөдөр энд сууж байгаа. Яах гэж байна. Энэ хүмүүс популизмаа сөрдөг байгаасай, эр зоригтой байгаасай, улс төрч

байгаасай, институцийнхээ талд байдаг байгаасай. Ийм агуулгаар бид маш итгэлтэйгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.

Энэ дээр манай Л.Оюун-Эрдэнэ болон Д.Амарбаясгалан нар манлайлж ажилласан. Тухайн үед манай Ардчилсан намынхан дэмжихгүй байсан юм. Үнэн. Ганцхан С.Одонтуяа гишүүн дэмжиж байсан. Бас үнэн. Харин намын удирдлага нь өөрчлөгдсөн. Л.Гантөмөр дарга орж ирсэн. Багаараа орж ирсэн. Дэмжсэн. Ингээд хамтдаа үүнийг хийсэн. Үнэн. Яах гэж хийсэн юм.

Яах гэж вэ гэхээр Монгол Улс маань хөгжихгүй байсан юм аа. Болохгүй байсан юм. Хоёр талдаа гараад хэрэлдээд байсан. Үүнийг өөрчилье. Америкийн Нэгдсэн Улсын тэр 90 онд оруулж ирсэн энэ загвар чинь болохгүй юм байна гээд Америкийн Нэгдсэн Улс өөрсдөө бүх судлаачид нь болохгүй юм байна гээд дүгнэлтээ гаргачихсан. Нобелийн шагналтай 14 хүн, нийтдээ 80 эрдэмтэд салбар салбараараа хөгжсөн орнууд дундаа манайх үзүүлэлтээрээ унаад байна гээд.

Ингээд 2018 онд Засгийн газартаа зөвлөмж өгсөн байдаг юм. Энэ болохгүй байгаа юм байна. Тийм болохлоор бид баруун Европын загварыг оруулж ирье гээд. Ингээд энэ хамтарсан Засгийн газар үүсэн байгуулагдах энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн юм. Энэ бол Монголын түүх.

Одоо асуулт нь юу байна гэхээр Л.Оюун-Эрдэнэ сайд аа, та бол бид нарыг тогтвортой Засгийн газар байгуулахын тулд, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийхийн тулд ХҮН нам ямар их ажиллалаа. Тийм болохоор та нар орж ирж ажиллаач ээ гэж урилга өгсөн. Бид хоёр өдөр бодсон. Тэгээд орж ирсэн. Орж ирэхдээ ямар нэгэн санал суудал гэж хараагүй юм.

Ямар ч байсан энэ тогтолцооны өөрчлөлтийг Монгол Улсын соёл болгох ёстой юм байна, үр дүнг нь иргэддээ өгөх ёстой юм байна гээд орж ирсэн байдаг юм. Өнөөдөр засгаас гарч явахад маш амархан. Ажлаа өгөхөд бүр амархан. Тантай санал нэг байна.

Гэхдээ улс маань яах билээ. Би гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцаж байгаа. Гаднын хөрөнгө оруулалт 2012 оноос илүү бид луу хандаж байгаа. Яагаад вэ гэхээр та нар тогтвортой болсон байна. 126 парламент нь 118 чинь та нар нэг талдаа гарсан байна. Дахиад 4, 8, 12 жил тогтвортой байдлыг үүсгэх боломжтой юм байна гээд энэ агуулгаар маш том хэмжээний хөрөнгө оруулалтууд наашаа харсан байсан. Одоо энэ яах юм. Нэг.

Хоёрт нь, би Африкийнын 40 улсаар явж ажиллаж байсан Латин Америкийн 10-аад улсаар явж ажиллаж байсан. Ажиллаж байсан. Дандаа хөгжиж байгаа орнууд... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Т.Доржханд: Хөгжиж байгаа орнуудын зовлон нь юу байдаг юм бэ гэхээр зарим нь баялагтай юм. Нийт 200 улсын 40 нь баялагтай байдаг юм.

Энэ баялагтай улсын зовлон нь юу байна аа гэхээр бизнесүүд нь нэг л хүнтэй харьцдаг юм. Олон хүнтэй харьцдаггүй юм. Ийм болохлоор тэнд авторитар дэглэм байдаг юм.

Зарим миний хайрлаж байсан Франко-Африкан улсуудад авторитар дэглэмтэй улс хөрөнгө оруулалт хийснээс болоод бас нэг хүний засаглал руу шилжсэн байдаг юм.

Үүнийг манай Валютын сан, Дэлхийн банкны эдийн засагчид бүгдээрээ ярьдаг юм. Гэтэл Монгол Улс маань яг ийшээгээ яваад байна. Бүр яваад байна. Монголын бүх том бизнесменүүд бүгдээрээ тэнд нэг хүнтэй л харьцсан нь дээр гэдэг дээр бооцоо тавьсан байна гэдэг нь харагдаад байна.

Асуулт нь Ерөнхий сайд аа, та өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ярьж байлаа. Наашаа ирэхэд Засгийн газар зурагдсан байсан. Тэгээд маш том эрх ашиг тэнд явсан гээд. Одоо үүнийгээ эр зоригтойгоор хэл ээ. Ийшээ бид явах юм уу, явахгүй юм уу? Таны хувьд нэг хүний засаглалтай байх ёстой юм уу, эсвэл парламентын засаглалтай байх ёстой юм уу гэдэг дээр. Тэгвэл цаашаагаа юу... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: 76-тай парламент бас чадавхаа нэлээн шахсан. Бид бүгдээрээ мэдэж байгаа. Парламентын нэр хүнд нэлээдгүй унасан. 76 хулгайч гэдэг нэртэй болсон. Олон ч асуудлууд үүссэн.

Үүнийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Парламентын засаглалаа хамгаалж үлдэх том агуулгаар 126-тай холимог тогтолцоотой парламентыг бид хийх нь зүйтэй гэж үзсэн.

Ер нь дэлхий дээр мажоритар тогтолцоо энэ цаг үед их хүндэрч байгаа юм билээ. Санал гээгддэг учраас.

Ингээд 126 гишүүнтэй парламентыг бид бүрдүүлсэн. Энэ агуулга энэ идеологитой би хүндэтгэлтэй хандаж байгаа учраас ч би өнөөдөр ингээд нээлттэй ярилцах нь зүйтэй гэж үзээд итгэл үзүүлэх агуулга дэгийн хувьд ч тэр хамгийн нээлттэй ярилцах индэр юм гэж ойлгож ийм шийдвэрийг гаргасан юм.

Ганцаараа шийдвэр гаргаж бас болдоггүй юм билээ. Хамтарсан Засгийн газар байдаг. Олон асуудлууд байдаг.

Тийм учраас дүгнэлт үйлдэх нь өөрөө дараа дараагийн асуудалд хэрэгтэй гэдэг агуулгаар.

Тийм учраас 126-тай парламент бүрдээд энэ 4 жил, дараа дараагийн Засгийн газрууд дээр ямар асуудал байх вэ гэдэг дээр бид туйлын хариуцлагатай хандах ёстой. 126 болоод дордчихлоо. 126 болоод төрийн ажил гацлаа. 126 болоод асуудал үүслээ гэдэг ийм агуулга явбал Т.Доржханд даргын яриад байгаа зүйл рүү ороход маш ойрхон байгаа. Судалгаа ч тийм байдаг.

Тийм учраас бид долоо хэмжид нэг огтлох ёстой. Аливаа асуудлуудыг бид том агуулгаар нь бас харах учиртай.

1991 онд Үндсэн хууль дээр Ерөнхийлөгчийн парламентын засаглалыг санал хураахад 48, 48 хувиар тэнцсэн байдаг. Ийм протоколыг бид бүгдээрээ мэднэ.

Тийм учраас нийгмийн сэтгэл зүй өөрөө ийм л байдаг. Тэгээд ардчиллын том дархлаа бол парламентын засаглал. Бид хоёр том гүрний дунд байгаа. Ардчилсан үнэт зүйл хаа сайгүй нэлээдгүй тийм түвэгтэй сорилтод орж байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тийм учраас засаглалын тогтворгүй байдал, хэт улс төржилт, энэ агуулга бол парламентын засаглалын асуудалд ноцтой хор хөнөөл авчирч магадгүй ээ гэдэг эрсдэл байгаа. Үүнийг Ерөнхий сайдын хувьд би хэлэх үүрэгтэй. Хэлэх үүрэгтэй. Өнөөдөр ярилцаад бидний дүгнэлт болж үлдэх учиртай.

Тийм учраас би энэ агуулга дээр 126-г геополитикийн хувьд амжиж хийсэнд талархаж байгаа юм. Одоо бид хамгаалах учиртай.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Ер нь нэг жилийнхээ босгон дээр Засгийн газар маань яагаад ийм том сорилтод орчхов. Ерөнхий сайдын итгэл үзүүлэх огцрох асуудлын түвшинд хүрчхэв гэдэг энэ өөрөө нэг хүүхдийн цүнхний төдий асуудал уу? Яг уг шалтгаан нь арай том шалтгаан байх уу гэдэгт бид бас хариулт хэлэх ёстой байх. Нэг цүнхний төдий асуудал мөн үү, биш үү?

Миний бодлоор яг өнгөрсөн жилийн 6 сард бид Монгол орон даяар сонгуулийн уухаа хадаагаад тал нутгаар давхиж байсан. Тэгэхдээ бид иргэн, бизнесүүдэд илүү том орон зай, боломж олгоноо гэдгийг гурван нам гурвуулаа хэлж байсан.

Тэгээд сонгуулийн дараа хамтарсан. Хамтарсан Засгийн газрын энэ өнгөрсөн хугацаанд мэдээж бүх зүйлийг буруу гэхгүй. Тэгэхдээ явж ирсэн чиглэл ард иргэд, эдийн засагтаа оролцож хэрэггүй ээ. Дарга нар хөгжүүлнэ ээ. Засгийн газар хөгжүүлнэ ээ. Та нар зүгээр байж бай гээд л явсан. Үүний үр дүнд ядуурал буураагүй. Үүний үр дүнд юмны үнэ өссөн. Иргэдийн бодит орлого, худалдан авах чадвар, амьдрал доройтсон.

Энэ шалтгаан л өнөөдөр яг нэг жилийн босгон дээр илэрч гарч ирж байна гэж би хувьдаа тийм дүгнэлт. Бодлогын алдаа байсан гэж. Яагаад гэвэл иргэн нь оролцдоггүй, бизнесүүд нь оролцдоггүй нийгэм, эдийн засгийн тогтолцоог зөв гэж л зурсан. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, ер нь өнгөрсөн хугацаанд Ардчилсан намаас 8 сайд орж ажилласан. Үнэхээр Ардчилсан намынхаа 8 сайдыг асар хүнд нөхцөлд ажилласан гэдгийг энд заавал хэлэх ёстой. Засагт ороод ажилласан. Дэврүүн сайхан сэтгэлээр баахан том том ажил хариуцаад авчихсан. Ар талд нь намын нөхдүүд нь, бүлгийн тодорхой хэсэг нь, гишүүд нь, ард түмний тодорхой хэсэг нь ялагдчихаад та нар юу хийж явж байгаа юм бэ. Та нар ялагдчихсан шүү дээ гэдэг байр суурин дээр шүүмжилдэг.

Гэтэл манай хэд чадахаасаа аваад чадахгүй хүртлээ бүх тэр галтай бүхий л асуудлуудыг манай 8 сайд үнэхээр барьж ажилласныг Монгол даяараа ардчиллын сайд нар ажлын төлөө явдаг гэдгийг бүгдээрээ харсан.

Өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын бүлгийн зүгээс тодорхой шүүмжлэлтэй асуудлуудад байр сууриудаас хандаж байсан ч гэсэн засгаас орж ирсэн, Улсын Их Хурлаар орж ирсэн гол томоохон бодлогын бүх шийдвэрүүдийг 100 хувь дэмжсэн байдаг. Мега төслүүд.

Түүн дотор хил холболт, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилт, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд Үндэсний баялгийн сангийн үзэл санаа, энэ бүгдийг дэмжсэн. Энэ том бодлогуудаас яг үнэндээ нэгийг ч унагаасан зүйл байхгүй. Энэ том бодлогын асуудлуудаас нэгийг ч унагаасан зүйл өнгөрсөн хугацаанд байхгүй. Бүгдийг нь бүлэг дээр санал хураагаад дэмжээд оролцож байсан. Том асуудлууд дээр мэдээж өөр байр сууриуд, бусад зарим хуулиуд дээр янз бүрийн зүйлүүд л байдаг.

Тэгэхээр үүнийг заавал тэмдэглэж хэлэх хэрэгтэй байх.

Тэгээд энд бид нарын хувьд нэг ийм маргаантай ч юм шиг нэг ийм хуулийн, онолын маргаан ч юм шиг нэг ийм зүйл яригдаад байгааг цаашдаа бас бид ярилцах шаардлагатай юм болов уу л гэж боддог.

Үндсэн хуульд яг үнэндээ эвслийн Засгийн газар гэж байгаа болохоос биш хамтарсан, аль нэг нь олонх болсон үед хамтарсан Засгийн газар байна гэсэн үг өгүүлбэр бас байдаггүй.

Бид үүнийг стандарт бус Засгийн газар гээд өөрснөө тайлбарлаад л явдаг. Тэгээд цааш цаашдаа хууль эрх зүйн тодорхой бас нэг, хууль эрх зүйгээс гадна агуулгын энэ нэг асуудал дээр бид тодорхой шийдэл гаргаж. Энэ нь өөрөө бас тодорхой байр сууриудыг илэрхийлэхэд төвөгтэй болгодог тал өнгөрсөн хугацаанд ажиглагдаж ирсэн.

Тэгээд эцэст нь хэлэхэд яг одоо өнөөдөр тэгээд Ардчилсан намын бүлгээс гаргаж байгаа шийдвэрийг ингээд үзэхэд нэг тоглоом тоотой нь дээр гэдэг нэг үг байдаг. Тэрэнд л нийцсэн ийм шийдвэр л гарч байна. Урьж оруулчихаад гэрээ хийгээд, гэрээгээ дүгнэлгүй урьдчилж хөөж гаргачхаад араас нь нөгөө гэрээний.

Уг нь энгийн харилцаанд нэг гэрээ хийсэн бол тэрийг дүгнээд тоо тавиад шаардлага хангаагүй болбол гэрээгээ цуцалдаг ёстой байх. Гэтэл Ардчилсан намын бүлгээс энэ бүхнийг үндэслээд ер нь тоглоом тоотой нь дээр гэдэг шийдвэр гаргасныг хэлье. Надад тодорхой тийм асуулт алга.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Тэгэхээр бид бас цаг хугацааны хувьд их хүнд цагт энэ улс төрийн үүсээд байгаа нөхцөл байдлыг шийдэх болчихоод байгаа юм. Дэлхий нийтээрээ Трампын тарифын бодлогоос болоод тодорхойгүй нөхцөл байдал үүссэн яг энэ цаг үед бид бас хоёр том нам нь овоо эвлэрээд ингээд бас нэг томоохон юмнуудаа хийчихье гээд явж байсан энэ бодол нь байхгүй болж байгаа юм л даа.

Тэгээд бид дэлхийн хямралтай зэрэгцээд өөрсдийгөө хямраах ийм юм руу явчхав уу гэж.

Тэгээд энэ итгэл үзүүлэх асуудал чинь Үндсэн хуульд орсон өөрчлөлтөөр нэг бол төсвийн асуудлаар, нэг бол тодорхой бодлогын асуудлаар гээд байгаа юм. Тэгээд итгэл үзүүлэх бичгийг харахаар бодлогын асуудал, тэр дотроо Баялгийн сан, 14 мега төслийг явуулах эсэх дээр итгэл үзүүлээч ээ гэж байгаа юм. Итгэл үзүүлэхгүй ээ гэвэл энэ том төслүүд, баялгийн санг байгуулахгүй ээ гэсэн гишүүн болно.

Тийм учраас би бол итгэл үзүүлнэ ээ гэдэг дээр нь байгаа. Тэр Баялгийн сан нь яваасай, энэ 14 төсөл нь яваасай гэж.

Нөгөө талаар яг Оюу Толгойн гэрээний энэ ашиггүй алдааг засах боломж бий болсон цаг үе байгаа байхгүй юу. Онтрэ гоулдын талбай руу өнөөдөр Рио Тинто орох тухай яриад байна шүү дээ. Гэтэл тэд Канадад манай баялгийн ашгийг яаж хуваах тухай арбитрын шүүхээрээ шийдсэн байна. Энэ чинь манай баялаг шүү дээ. Гэтэл яг үүнийг шийдэх гэж байгаа энэ цаг үед бас энэ болж байгаа юм.

Н.Алтанхуягийн Засгийн газрыг бид бас ингэж байгаад л аваад л хаясан. Дараа нь юу явсан. Дубай явсан. Дубай шиг Онтрэ гоулдын юм болчих вий гэдэг нь надад болгоомжлол бас байна.

Нөгөө талаар сонгуулийн үеэр ард түмэн Л.Оюун-Эрдэнэ гэж хүний мөрийн хөтөлбөрт энэ нь хэрэгтэй юм аа гээд олонх болох саналаа өгсөн.

Тийм учраас мөрийн хөтөлбөр, энэ Оюу Толгойн гэрээний асуудал, энэ том төслийнхөө асуудлыг шийдэх ёстой. Тэр хариуцлагаас ерөөсөө зугтаж болохгүй.

Түрүүн О.Цогтгэрэлийн ярьж байгаа ч үнэн. Энэ бол нэг жижигхэн цүнхний асуудал биш. Энэ бол улс орны хувь заяаны асуудал. Өөрөө үүрэх ёстой. Тэр ард түмэнд өгсөн амлалтаа биелүүлэх ёстой. Тэрнээс зугтаж ерөөсөө болохгүй. Нөгөө талаар энэ цаашаа хаана хүртэл явах юм бэ, юунд хүргэх вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу.

Бид хамгийн сүүлд Үндсэн хуулийн өөрчлөлтөөр. Яг үнэн. Тэр Европын тогтвортой улс төртэй орнуудын засаглалын тогтолцоог авсан. Би тухайн үед хэлж л байсан. Манайхан надад юу гэсэн гэхээр энэ гудамжинд жагсаж хэрэлдэж байхаар наашаа оруулаад ирье ээ л гэсэн. Би гудамжны хэрүүлийг битгий төрд оруулаач ээ л гэсэн. Тогтворгүй байдал үүснэ ээ л гэсэн. Тэгээд цаг хугацаа харуулах байх.

Би зүгээр явж явж одоогийн энэ нөхцөл байдал нь ужгираад энэ парламент нь ажиллаж чаддаггүй байдал руу орох вий. Засаг төр нь хэд хэд солигддог юм руу явах вий. Тэгээд нэгэнтэй нь хамтраад л, нөгөөдөхтэй нь хамтраад л, хамтраад гарсан нь нөгөөдхөө дахиж унагаад л ингээд нэг тийм гинжин засгаа огцруулдаг юм руу явж эхлэх вий гэж. Энэ тогтолцоо аюултай.

Яагаад гэвэл бидний ёс суртахууны түвшин Европынхны түвшинд хүрээгүй байхгүй юу. Гэтэл бид тэдний загварыг авчихсан. Малгайгаа томдуулсан. Одоо цаашаа хаана хүрэхийг би хэлж мэдэхгүй.

Тэгээд санал гээхгүй гээд байгаа юм. Санал гээхгүй юм бол сонгууль явуулж яах юм. Хоорондоо тохироод тэгээд л. Одоо яаж байгаа юм. Мөрийн хөтөлбөрт Ардчилсан намынх тэдэн хувь байна, ХҮН намынх тэдэн хувь байна гэдэг сонгууль явуулаад байгаа юм уу?

Эцэст нь би нэг зүйл дээр гайхаад байгаа юм. Одоо ингээд энэ хамтарсан засаг явахгүй болъё гэж бодъё. Тэгвэл нөгөө Ардчилсан намын оруулсан хөтөлбөр, нөгөө ХҮН намын оруулсан хөтөлбөрүүд чинь яах юм? Санал гээхгүй гэсэн юм чинь яах юм? 1 минутаа авчихъя.

Тийм учраас энэ дээр хэдүүлээ бодолтой л хандах ёстой. Тэр санал гээхгүй гэдэг нь ч одоо хаашаа юм. Ер нь яах вэ, ийм цаг үед бас нэг хамтраад юмаа хийчихье гэж байгаа чинь зөв байх.

Би болбол ардчиллын зарчмаар олонх нь ажлаа хийгээд, цөөхөн нь хяналтаа хийгээд явах ёстой гэдэг дээр байдаг. Гэхдээ цаг үе өөрөө тэгэхгүй, бид нарын ёс суртахуун өөрөө тийм боломжийг олгохгүй байгаа учраас би энэ хамтарсныг хүлээн зөвшөөрөөд л явсан. Одоо хамтрахгүй болохоор цаашаа хаашаа явах вэ л гэдэг асуудал.

Тэгээд энэ дээр бид бодох хэрэгтэй. Явж явж энэ парламентынхаа тогтолцоог нураах, ард түмний тэр парламентын итгэл үнэмшлийг байхгүй болгох ийм зүйл рүү чирээд тэгээд нэг засаглалын хямралд орсон, эдийн засаг нь бүр шалдаа унасан ийм нөхцөл байдлыг бий болгож байна. Гишүүн болно гэдэг амар биш. Жагсаалтаар орж ирнэ гэдэг бол цаанаа ард түмний өмнө хариуцлага хүлээхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас бид ер нь энэ нийтийн өмнө, нийтийн эрх ашгийн өмнө хариуцлага хүлээх талаасаа бодож саналаа өгөх хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууя.

Б.Баярбаатар: Гишүүддээ оройн мэнд хүргэе.

Би бол парламентын засаглалыг төлөвшүүлэх тал дээр тултал явна. Өнөөдөр Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал парламентын засаглалтай шууд холбоотой.

Тэгэхээр парламентын засаглалыг төлөвшүүлэх тал дээр онцгой анхаарах ёстой. Би Ерөнхий сайдын Улсын Их Хуралд оруулсан итгэл үзүүлэх тогтоол дээр парламентын засаглалыг төлөвшүүлэх гэдэг зүйл дээр дэмжиж байгаа. Би итгэл үзүүлнэ. Нэг.

Хоёрт, магадгүй хамтарсан парламент, Засгийн газрын хамгийн бүтээмжтэй 10 сар байсан байж магадгүй л боллоо л доо. Цаашдаа. Одоо ингээд улс төржөөд, тэгээд дагаад эдийн засаг нь унаад, амьжиргааны түвшин доошлоод.

Бид шүүмжлэх амархан, шүүх амархан, эсэргүүцэх амархан, эв алдах бүр амархан. Овоо гайгүй ард түмэн итгэл үзүүлээд явах гэж байтал. Ер нь шулуухан л дээр шүү дээ. Маш том явцуу эрх ашиг хөндөгдсөн учраас өнөөдрийн асуудал орж ирж байгаа шүү. Энэ бүх юм хугацаатай. Парламентад сууж байгаа гишүүд ч хугацаатай, бүгд хугацаатай. Бид хойч үедээ ер нь юу хүлээлгэж өгөх юм.

Тэгээд бид эдийн засгаа өсгөнө гэж ярьдаг. Энэ түгжрэл, утаа гээд олон асуудалтайгаа нүүр тулаад ярьдаг. Бид энэ нийгмийн ёс суртахууныхаа асуудлыг ярихгүй юм уу? Өнөөдөр бид нарыг энэ сандал суудлын хэрүүл хийгээд сууж байхад тэр Баян-Өлгий аймагт өсвөр насны 3 хүүхэд автомашины ослоор амь алдлаа. Замын-Үүд дээр өнөөдөр тээврийн 2 том машин мөргөлдөөд 2 жолооч нь газар дээрээ амь насаа алдаж байна. Энд хайртай хүмүүсээ алдаад сууж байгаа гэр бүлийн хүмүүс нь өнөөдөр бид нарыг хараагаад зүхээд сууж байгаа. Тэгтэл бид энд нэг явцуу эрх ашиг яриад л, нэг цүнхний асуудал яриад л. Заримдаа бид яг ний нуугүй хэлэхэд өөрсдөөсөө ичих хэрэгтэй шүү дээ. Мундаг мундаг том том улс төрчид.

Одоо цаашаа бид үлдсэн 3 жилдээ улс төржсөөр байгаад л таарах уу? Би Ардчилсан намыг Засгийн газарт сайн ажилласан гэж бодож байгаа. Ер нь шулуухан хэлье. Ардын нам өөрөө гэрээгээ зөрчсөн шүү. Түрүүлж бид шийдвэр гаргасан шүү дээ. Нэг талын шийдвэр. Тэр гэрээн дээр чинь байгаа шүү. Юм үнэнээрээ байх нь дээрээ.

Тэгэхээр бид нарт цаашаа эв нэгдэл хэрэгтэй, бүтээн байгуулалт хэрэгтэй. Өнгөрсөн 30 жил бид энэ явцуу ашиг сонирхолд хөтлөгдөж олон Засгийн газрыг унагаж, олон ажлыг хойш нь тавьсныг бүгд л ярьж байгаа шүү дээ. Одоо тэгээд л явах нь, бүтэх нь. Одоо яг жилийн өмнө бид сонгуульд өрсөлдөөд л явж байсан шүү дээ. Одоо сарын дараа бид Засгийн газраа байгуулаад л, парламентад тангаргаа өргөөд л хийнэ, бүтээнэ гээд л. Одоо үүнийгээ бүгд ингээд мартчихаж байгаа юм уу.

Тэгээд бид өөрсдөө хариуцлагатай байх ёстой байх аа. Энэ жилийн өмнө хэлсэн ярьсан зүйлүүдээ, тэр байгуулсан гэрээ контракт олон зүйлүүд дээрээ бид өөрсдөө хариуцлагатай хандаж байж дараа дараагийнхаа хариуцлагыг ярьсан нь зөв байх гэж бодож байгаа.

Тийм учраас өнөөдөр би Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тал дээр би саналаа өгнө өө. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Ерөнхий сайдад итгэж байгаа. Тийм. Л.Оюун-Эрдэнэ гэдэг хүндээ ч биш Ерөнхий сайд, түүний ахалж байгаа баг Засгийн газрын мөрийн хөтөлбөр, цаашдын бодлогод нь итгэж байгаа учраас. Энэ бодлого маань хэрэгжээсэй, хамтарсан Засгийн газар тууштай, тогтвортой байгаасай гэдэг дээр үндэслэж би итгэлээ үзүүлнэ гэж илэрхийлж байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс зүгээр нэг ганцхан юм асуумаар байгаа юм. Та минь яагаад ингэж их удав аа гэж.

Хүмүүсийн одоо яг нэг ойлгомжгүй нөхцөл байдал үүсээд байгаа нь зөвхөн цүнхний асуудал болоод ийм итгэл үзүүлэх асуудал ороод ирэв үү гэдэг

дээр л хүн болгон л. Яах вэ, мэдэж байгаа хүмүүс мэдэж байгаа. Мэдэхгүй гэнэн хүмүүс нээрээ л цүнхнээс болж, орлогоо нотолж чадахгүй байгаад байгаа учраас огцрох гээд байгаа юм шиг ийм сонин нийгмийн уур амьсгалыг өдөөсөн бүлэг хүмүүс байгаад байна л даа.

Гадаад, дотоод хүний, өөрийн олон бүлэг эрх мэдэл, эрх ашиг, баялгийн зодоон, булаацалдаан болж энэ асуудлыг одоо бас дэвэргэж гаргаж ирж байна уу даа гэж харж байгаа. Энэ болбол зохион байгуулалттай технологи дээр суурилсан асуудал явж байгаа.

Гэнэт хүүхдийн гэдэг юм уу, одоо тэр залуугийн. Хүүхэд гэхэд ч одоо бас хэлэхэд хэцүү шүү дээ. 23 настай залуугийн найз охиндоо гэрлэх санал тавьж байгаа энэ асуудал өөрөө технологи дээр суурилсан. Асуудлыг хэн гаргаж ирж байгаа юм. Түүнийг хэрхэн яаж цааш нь давлагаалж гаргаж ирж байгаа юм. Нийгмийн хэрхэн яаж нөлөөлөл бий болгож байгаа юм гэдэг нь өөрөө цаанаа технологи гэж би үзэж байгаа.

Та ч гэсэн сая хэллээ. Энэ бол ер нь зүгээр нэг цүнхний асуудал биш ээ. Цаана нь тодорхой асуудал, бодлого байгаа гэж. Бид иймэрхүү төрлийн жагсаал цуглаанууд зөвхөн Монголд ч биш гадаад улс орнуудад ч гэсэн болдог. Нэлээд өргөн хүрээнд болдог. Монголд ч анхных нь биш.

Ковидын үед ч гэсэн бид хоёр, гурван ийм томоохон тэмцэл гэдэг юм уу, томоохон жагсаалуудыг даван туулсан. Ард нь дандаа л технологи байдаг. Яагаад энэ цаг үе дээр, яагаад яг одоо энэ асуудал гарч ирэв гэдэг нь бас анхаарах ёстой асуудал мөн.

Нэг асуудал байгаа. Ардчилсан нам үнэхээрийн хамтарсан засаг байх ёстой гэдэг дээр би ч гэсэн анхнаасаа л мөрийн хөтөлбөр дээр ч хамт суусан. Хамтрах нь зүйтэй ч гэж ярьж байсан. Магадгүй сайд яамыг толгойлж байгаа бол харьяа газруудаа ч гэсэн боловсон хүчнээ байршуулдаг ийм нэг бичигдээгүй хууль гэдэг ч юм уу, ийм явдал явсан. Энэ нь өөрөө эргээд Төрийн албаны тухай хуулийг ч нэлээдгүй зөрчсөн. Аймаг, сум, орон нутагт маш их халаа сэлгээ явсан. Ингэснээрээ нэг албан тушаалын ард бас л хүний амьдрал явж байгаа учраас манай намын гишүүд ч тэр мэдээж үүн дээр бухимдсан. Их Хурлын гишүүдээрээ дамжуулаад бүлэг дээр ч энэ байр сууриа илэрхийлсэн.

Тэгээд үүнээсээ улбаалж манай нам дээр Бага хурлын гишүүдийн хувьд ч гэсэн ер нь боловсон хүчний бодлого алдагдаж байна, маш олон хүн хэлмэгдэж байна гэдэг ийм асуудлыг дэвшүүлсэн учраас Бага хурлын шийдвэр маань гарснаараа гарсан. Бага хурлын шийдвэр гэхдээ Ерөнхий сайдыг огцруулах талаар нэг ч үг, өгүүлбэр байхгүй.

Тэгэхээр магадгүй өнөөдөр Ардчилсан намын 8 сайд өөрсдөө өргөдлөө өгсөн байна аа гэж өнөөдөр мэдээнээс харсан.

Тэгэхээр яг одоо Ерөнхий сайдын огцрох, огцруулах асуудлыг манай намын Бага хурал огт яриагүй байгаа шүү. Яриагүй байгаа.

Ковид, Орос, Украины дайн, Трампын худалдааны тарифын бодлого ар араасаа дараалаад маш хүнд геополитикийн нөхцөл байдлыг гаргасан. Ийм ч учраас нийгэмд бухимдал өндөр байгаа. Үүнийг далимдуулаад технологи дээр суурилсан яг энэ дотоод эрх мэдлийн тулаан явж байна.

Тэгэхээр та үүнийг өөрөө үнэхээрийн тийм юм байна уу, эсвэл үнэхээрийн л одоо энэ цүнхний асуудал байв уу гэдгийг бас нэг тодорхой хэлж, асуудлыг яг тодорхой ярихгүй бол болохгүй байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас хэлсэн.

Миний хувьд олон ч жагсаалтай нүүр тулж байсан. Ерөнхий сайдын хувьд хоёр ч том жагсаал дээр би талбай дээр гараад л жагсагчтай уулзаж байсан. Тэр бол ковидын үе байсан. Яагаад би тийм итгэлтэй жагсагчидтай нүүр тулж Төрийн ордон руу асуудал үүсэхээс урьдчилан сэргийлж байсан бэ гэхээр тухайн үе бол ордон нэгдмэл байсан юм.

Тийм учраас Ерөнхий сайдын хувьд зөвхөн талбай дээр байгаа залуучуудтайгаа, талбай дээр байгаа жагсагчидтай би шууд нүүр тулаад л уулзаад л ярилцаж байсан. Ийм хоёр, гурван ч үйл явдал болсон.

Энэ удаа харамсалтай нь энэ ордон өөрөө хуваагдмал ийм нөхцөл байдалтай байгааг би мэдэж байсан.

Тийм учраас суурь шалтгаан бол өөр зүйл байсан. Шалтаг мэдээж энэ зүйл байсан. Би гарлаа гээд нөхцөл байдал өөрчлөгдөхгүй байсан.

Тийм учраас үүнийг ярилцсан ярилцсан. Одоо яах вэ өнөөдөр бид нээлттэй ярихгүй л байгаа болохоос би намынхаа ч гишүүдтэй уулзахдаа, Ардчилсан намын гишүүдтэй ч уулзахдаа байнга л би үүнийг хэлж байсан. Ийм хэмжээний гомдол, буруу ойлголт маш их явж байна шүү. Би амаа асуулгаж байна гээд.

Би нэг их Ардчилсан нам, ХҮН намд хайртай болсондоо ч юм уу ерөөсөө тэгж их цаг гаргаад байсан юм биш. Ганцхан энэ ажлууд нь бүтчихээсэй л гэдэг л ганцхан бодол надад байсан.

Тэгээд тал талд л асуудлууд үүссэн. Энэ нь ингэлээ, тэгээд яачихсан юм, энэ чинь гэрээгээ зөрчөөд байгаа юм биш үү, тэр нь ингэлээ, одоо ингэххээд байгаа юм шүү гээд. Тухай бүр би дандаа л хариулт хэлж, ийм асуудлууд

болсоор л байсан, зузаараад л байсан, ярилцаад л байсан. Уг нь. Гуйж ч үзсэн, бухимдаж ч үзсэн. Тэгээд яалт ч үгүй олон ийм эрх ашгийн гомдлууд нийлж байгаад хамгийн том мега төсөл нь явж байгааг ч анзаарахаа больчихдог л юм билээ.

Яах вэ, үүнийг тэгээд бид доор доороо л харах ёстой. Жагсаалт дээр ч би нам дээрээ их л амаа алгадуулж байгаа. Уг нь намынхаа бодлогыг, гол агуулгыг дэмжих чиглэлээр нам сонгодог парламентад жагсаалт гаргадаг. Та одоо тэгээд үүнийг өөрөө л хийсэн. Одоо яая гэх вэ дээ гэж манай намынхан надад хэлж байгаа.

Үнэн. О.Цогтгэрэл дарга бас надад хэлсэн. Хэрвээ танай нам олонх болоогүй бол ийм зүйл болохгүй байсан юм шүү дээ гээд. Амаа алгадуулж байгаа ч гэсэн бас бодох л ёстой асуудал. Тухайн үед Их Хурлын дарга Ардчилсан намаас тавиад ингээд хамтрах нь зүйтэй гэдэг тийм санал яригдаж байсан. Олонх болсон учраас тэр боломжгүй байсан.

Цаашдаа энэ тогтолцоогоор шууд олонх болох их түвэгтэй тогтолцоо. Гэхдээ анх удаа явж байгаа учраас бид том агуулгаа бүтэн харахгүй л байх шиг байгаа юм. Би Шинэ Зеландын олон хүнтэй уулзаж байсан. Яах вэ, нэгээс хоёр тээрмийн ард ийм сургамжууд үлддэг л юм байна лээ л дээ.

Тийм учраас хэдүүлээ халгаад яах вэ. Доор доороо л дүгнэлт хийцгээе. Тэр нь юу вэ гэхээр надад албан тушаалд хоргодоод байгаа зүйл юу ч алга. Гагцхүү би зөв дүгнэлт үйлдэх нь өөрөө чухал юм. Энэ бол маш хариуцлагатай зүйл. Ц.Даваасүрэн сайдтай би санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ерөнхий сайдын микрофон.

Л.Оюун-Эрдэнэ: Ард түмэн энэ 126-г дэмжсэн. Анхныхаа сонгуулийг хийсэн. Наадмаар бид гадаад зураг авхуулахад баяр хөөртэй байсан. Энэ уур амьсгалыг л би бодож илүү тийм зөв агуулгаар цаашаа явчхаасай л гэж бодоод байгаа болохоос биш хувь хүнийхээ хувьд одоо тэгээд л энд хүн царай алдаад л, гуйгаад л, хойноос нь хөөцөлдөөд л нэг их тэгээд хоргодоод байгаа юм надад юу ч алга. Үнэнээ хэлэхэд.

Зүгээр яг энэ өөрөө итгэл учраас. Үүний дараах үр дагаврыг би Ерөнхий сайдын хувьд төсөөлөөд одоо байгаагаас дордох эрсдэл байгаа учраас л би өнөөдөр итгэл үзүүлэх асуудлыг Та бүхэн маань олон талаас нь бодолцооч ээ. Би хэн рүү ч уулзаж ингээд санал өгөөч ээ гэж хэлээгүй. Харин нээлттэй, ил тод яриад, зөв дүгнэлт үлдээсэй гэдэг дээр л би илүү байгаа. Бүлэг дээрээ ч ийм байр суурьтай байсан. Өнөөдөр Ардчилсан намын бүлэг дээр... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: А.Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Дан ганц цүнхний асуудал байгаагүй юм аа. Цаана нь хүний өөрийн гадаад, дотоод нийлсэн эрх ашиг болон баялгийн тэмцэл явж байгаа юм аа гэдгийг тодорхой, яг одоо юу гэдэг юм тод чанга бас хэлчихмээр байгаа юм аа.

Надад бас Ч.Лодойсамбуу гишүүнд хандаж нэг хэлэх үг байгаа юм. 2 триллион Улсын Их Хурлын гишүүдэд тараах гэж байгааг би сонссон гэж хэлсэн нь шүүлтүүргүй мэдээллийг авч байгаа иргэдэд маш хүндээр туссан.

Үүнийг ашиглаж хэвлэл мэдээллийн байгууллагууд ч гэсэн Улсын Их Хурлын гишүүдийг барьж ноцож, та энэ мөнгийг авсан уу, та үүнийг сонссон уу гэж асууж байгаа. Зарим хүмүүс итгэж байна.

Нэг гишүүнд энэ чинь 16 тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Би өнөөдөр тоолоод асуулаа. Өө.., нээрээ тийм үү. Хаана дансаа бүртгүүлэх вэ гэж.

Нэг ангид сууж байгаа Улсын Их Хурлын ангийн хүүхдүүддээ уучлалт гуйх хэрэгтэй. Бидний нэр хүндэд халдаж байгаа шүү. Улс төр улс төрөөрөө байж болно. Гэхдээ бас нэг жоохон ёс зүйтэй байя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ чинь надаас асуугаагүй л зүйл байна л даа. Тийм ээ. Эхнийх нь асуудал.

Өнөөдөр яах вэ дээ, олон гишүүдийн асуулт байна. Тэгээд би тодорхой тодорхой асуултад хариулаад л явна. Тийм асуудал үнэхээр бодитой байгаа. Байдаг юм билээ.

Зүгээр нэг цаг хугацаанд олон зүйлийг давхцуулах дэмий юм байна лээ. Цааш цаашдаа гал барих олон л улс төрчид энэ танхимд байгаа. Энэ дээр дүгнэлт хийх нь зөв өө.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр яг одоо энэ хурлын ирцийг иргэд олон нийт маш сайн хараасай гэж би хүсэж байна. Яагаад гэвэл энэ хуралд ирцээ бүртгүүлж ирээгүй гишүүд бол ацан шалаатай, аль ч талд гарч чадахгүй байгаа, ялсных нь талд орнооо гэсэн тийм алцганасан гишүүд байгаа гэдгийг нэгд цохон тэмдэглэмээр байна.

Хоёрдугаарт, би одоо энд орж ирсэндээ маш их харамсаж байна. Энэ танхимд орж ирсэндээ. Уг нь бол би энд орж ирвэл ёстой хийж бүтээгээд, алаад гайхуулаад, ядаж л хүүхэд эмэгтэйчүүдийнхээ төлөө гайхуулаад алчих юм байх гэсэн чинь энэ дотор чинь ерөөсөө л багцалчихсан. Энэ дотор чинь ерөөсөө л

энэ Монгол Улсаа тонон дээрэмддэг мафи бүлэглэлийн эрх ашиг болсон, тэдний хандив мөнгөөр орж ирдэг олонхтой ийм л газар байсан юм байна.

Тэгээд би өнөөдөр бараг л өдөртөө олдог нөгөө инфлюзерийнхээ цалинг сард хоёр хувааж авч байж одоо би ингээд хулгайч нарын нэг болоод ингээд дуудуулаад явж байна.

Одоо Монголын ард түмэн болоод энэ Их Хурлыг гурав хувааж болж байна. Миний ажигласнаар.

Эрх ашгийн талд үхэн хатан үйлчилж байгаа ард түмэн болоод Улсын Их Хурлын гишүүд, юу ч мэдэхгүй дунд нь эргэлзээд, гайхаад, тээнэгэлзээд аль нь зөв юм болоо гээд гайхаж байгаа иргэд болон Улсын Их Хурлын гишүүд, тэгээд засаг төр тогтвортой байгаасай гэсэн иргэд болон Улсын Их Хурлын гишүүд. Ийм л 3 төрөлд хуваагдаж байна.

Яг үнэндээ энэ бол одоо Та бүхэн Шанелийн цүнх хараад л гайхаад байх юм. Энэ дотор нэг их Шанелийн цүнх, цүнхгүй ядуурчихсан гуйлгачин амьтад хэн байгаа юм. Та нарын дунд.

Уучлаарай, Монголын төр засагт орсон хэнбугай нь ч баяжаад. Зүгээр би наад захын жишээ хэлье. Энэ Улаанбаатар хотын “А” бүсэд байгаа хамгийн том том энэ үнэтэй, метр квадрат нь 8, 9 саяар үнэлэгдэх энэ орд харш, хотхон таунууд чинь хэнийх юм бэ. Улсын Их Хурлын гишүүд та нарынх биш үү.

Хөдөө орон нутагт аймаг, суманд нь яваад очихоор 5 одтой аягүй аятайхан буудал байна гээд л яваад орно. Үгүй ээ, энэ манай Цагаан гуайн буудал, энэ манай тэр гуайн буудал, тэр гишүүний буудал гээд байж байдаг.

Үгүй ээ, энэ бүх юмны чинь мөнгийг нь тоолох юм бол уучлаарай, юун Шанелын цүнх, юун 17 саяын бөгж шүү дээ.

Тэгээд ийм байж нэг их мэдэн будилаад, мэдэхгүй гэнэн хонгорчуудын дүрд тоглоод байгаад та нарыг хараад би үнэхээр гутарч байна.

Би энд түрүүн орж ирээд харамссан гэдэг энэ үгийн гол шалтгаан бол яагаад харамссан бэ гэвэл аливаа зүйлийг үнэнийг бодитоор мэдэх ямар гачлантай байдаг юм бэ. Энэ үнэнийг мэдчихээд хэлж чадахгүй суух, хэлэхээр улам ард түмний хүмүүсийн дайсан болох бүр ямар гачлантай юм бэ гэдгийг л мэдэж сууж байна.

Тэгэхээр Монгол Ардын намынхан, өнгөрсөн хугацаанд та нар дангаараа засаглаж ирсэн. Та нар дангаараа засаглахдаа бүх ард түмний боломжийг урдуур нь орж хулгайлдаг. Бүх Хөгжлийн сан, ЖДҮ, Боловсролын сан юу байдаг юм. Концесс, тендер бүх юмаа та нар хувааж авдаг.

Өнөөдөр болж байгаа энэ хурал, энэ гадаа болж байгаа жагсаал бол ерөөсөө л Та нарын энэ атгаг санаа, үүнийг хувааж авах гэсэн.

Одоо худлаа биш шүү дээ. Та нар хэн чинь ажлын албаа гүйлгээд Боловсролын сайд, Соёлын сайд, Эрүүл мэндийн сайд. Тийм ээ. Уул уурхайн сайд болох гээд, хэн чинь Зам, тээвэр дээр очих гээд ингээд явж байгаа чинь хэнд ч илт байгаа шүү дээ.

Би үнэхээр энэ юу болоод байгааг нь мэдэхгүй байгаа ард түмэнд хэлэхийн тулд би энэ микрофоныг авсан юм.

Би нэгмөсөн 1 минутаа авмаар байна.

Тэгээд Монголын ард түмэн татвараа төлж чадахгүй зовж байхад “Эм Си Эс”, энэ том том Монголын орд баялаг, стратегийн ордуудыг хуу хамдаг газрууд яахаараа хуулийн хийдлээр НӨАТ-ын татварын орлогоос тэглүүлээд, хөнгөлүүлээд байдаг юм бэ? Тэгсэн мөртлөө өнөөдөр бүгдээрээ шахуу ил цагаандаа гараад энэ эрх ашгийг хамгаалаад сууж байж дандаа ард түмний нэрийг барина. Дандаа ард түмэн ядуурсан, доройтсон, уландаа хүрснийг гайхна.

Үгүй ээ, тэгээд хаана чинь та нарын тэр эрх ашиг байгаад байгаа юм. Би шударга хэлье. Би та нарын аль чинь ч биш учраас, хэний чинь ч дэмжлэгээр энд орж ирээгүй учраас надад ингэж хэлэх зориг байгаа юм.

Үгүй ээ, одоо тэгээд тэр төсөв мөсвөө хэзээ байтлаасаа бид 2 триллион төгрөг, 1 биллион төгрөг, 1 миллион төгрөг гээд яриад байдаг байсан юм.

Ч.Лодойсамбуу гишүүн ээ, би таны ачаар энэ англи, монгол тооны хэллэгийг бас сурч аваад байж байна. Гэхдээ уг нь триллион гээд л тэгвэл шууд л доллароор хөрвүүлчихдэг юм.

Тэгэхээр ер нь ард иргэд энд юу болоод байгааг ойлгоосой гэдгийг үнэхээр хүсэж байна.

Тэгээд энэ өөр өөрсдийнх нь том том эрх мэдлээр дулдуйдаад авсан том том орд баялгийнх нь ордууд, эрх ашиг нь хөдөлж байгаа бүх гишүүд энд нэгэн цул болоод, цөм болоод энэ нэг хүнээрээ туг дахиад буух гэж байгаа шүү.

Энэ хүн өнөөдөр буух суух нь ерөөсөө сонин биш. Гагцхүү ингэсний дараа, үүний дараа хэн энд гарч ямар үйл ажиллагаа явагдаж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Оройн мэнд.

Ерөнхий сайд сая та бүгд хэлж байна. Би өнөөдөр иргэддээ нээлттэй мэдээ өгье гэсэн энэ үүднээс энд ялангуяа байж байна.

Тэгэхээр сүүлийн үед олон нийтийн дунд баялгийн хөрөнгийн зарцуулалт, Ерөнхийлөгчийн засаглал руу шилжих гэж байна гэсэн, энэ далд санаархал гэсэн юмнууд Засгийн газрыг огцруулах том шалтгаан болсон гэж яриа гадуур их явж байна.

Тэгэхээр та үүнийг алиныг нь яг бодитой аюул гэж бодож байгаа юм? Таны хувьд та байнга амаргүй гэж яриад байгаа. Таны хувьд хамгийн амаргүй байсан бодитой аюул чинь юу юм бэ? Үүнийг та иргэдэд нэг хэлээд өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Ухаа худагтай холбоотой асуудлыг Улсын Их Хурал руу тогтоол болгоод Засгийн газар өргөн барьсан.

Энэ асуудал их тийм том доргилт өгдөг юм билээ. Одоо Их Хурал дээр байгаа та хэд маань хэлэлцэх байх. Яалт ч үгүй л улсын хэмжээний бярттай юм.

Өмнө нь Эрдэнэтийн 49 гээд Д.Эрдэнэбилэг гэдэг хүнтэй тулж байлаа. Ийм хэмжээний асуудал үүсэж байсангүй.

Гашуунсухайт, Ганцмодтой холбоотой асуудал дээр хоёр улсын Засгийн газар хоорондоо нэг компанийг оруулахгүйгээр тохирсон. Энэ том доргилт болсон. Том юм. Хүчтэй юм.

Энэ дээр нөлөө бүхий улс төрчид нийлээд блоклохоор ордон дотор яалт ч үгүй хүч алдаж байна.

Олон нийтийн анхаарал туйлын сул, зуны дэлгэр цагт энэ үйл явдал болж байна. Ингээд олон жил бугшсан энэ асуудлаа бидний хувьд бүтэн шийдвэрлэж чадахгүй ийм нөхцөл байдал руу улс төрийн зураг өөрөө орж байна. Харамсалтай.

Энэ л өөрөө дарангуйллын бий болгодог. Гишүүд мэдсэн ч хэлье гэсэн үгээ хэлж чадахгүй байх, асуудлыг мэдэж байгаа мөртлөө ард нь тохироо хийх ийм л асуудлаас урьдчилан сэргийлэх гэж уг нь парламентыг өргөтгөсөн. Мэдээж зөв, буруу хэсгийг цаг хугацаа харуулна. Буцаад л бид олигарх бүтэц, нэг, хоёрхон хүний дохиураар шийдвэр гаргадаг Монголын төр үүсвэл эд хөрөнгө, эрх мэдэл хэт цөөнхөд төвлөрөөд энэ өөрөө нийгмийн том донсолгоо болж хувирна.

Тийм учраас ийм асуудлууд байна. Энэ өөрөө парламентын засаглалыг хүчгүйдүүлнэ. Парламент өөрөө асуудлаа шийдэж чадахгүй хэмжээний бядгүй

болно. Гүйцэтгэх засаглал маш их хүчгүй болж хувирна. Энэ өөрөө парламентын засаглалыг хүнд байдалд оруулах эрсдэл болно.

Тийм учраас энэ дээр эрхэм гишүүд Та бүхэн маань өргөсөн тангарагтаа үнэнч, гал авч байгаа ганц хоёрхон хүнээ бас зэмлэхэд нь зэмлээд, дэмжихэд нь дэмжиж байх нь цаашдын Монголын ирээдүйд чухал шүү гэж л хэлье дээ.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Бүгдэд нь оройн мэнд хүргэе.

Тэгээд өнөө орой, өнөө шөнө Монголын ард түмэн нөгөө баялагтаа эзэн болох амны хишиг байна уу, үгүй юу гэдгийг л ер нь шийдэх гэж байна даа. Шулуухандаа бол.

Би хамтарсан Засгийн газрыг анхнаас нь л дэмжсэн юм. Яагаад гэвэл хамтарч байж юм явах юм билээ. Яг ийм том эрх мэдэл, мөнгө төгрөг, уул уурхай, ашигт малтмал, энэ асуудлыг нэг нам дангаараа явуулж чадахгүй юм байна гэдгийг би өнгөрсөн парламент дээр харсан.

Баялгийн сангийн хуулийг 64-тэй Ардын намын бүлэг байхдаа Ардчилсан намаас 4, 5 гишүүн оруулж байж нэг юм 40-ийн босго давуулж байсан түүх 2 жилийн өмнө шүү.

Тийм учраас бид 2024 оны сонгууль баялагтаа эзэн болгоно энэ тэр гэж ярьсан энэ амлалтаа биелүүлэхэд энэ 68-ын бүлэг бол бид чадахгүй юм байна.

Тийм учраас хамтраад явах нь зөв юм байна. Нөгөө талдаа ард түмэн сонгуулийнхаа үеэр та нар зодолдоод яваад сонгуулиас хойшоо ард түмнийхээ эрх ашгийг хангаж яваарай л гэж ярьдаг шүү дээ. Ер нь бол.

Тэгээд би энэ болгоныг бодож л хамтарсан Засгийн газрыг байгуулахад нь ч дэмжсэн, сая ганхаж эхлэхээс нь ч дэмжсэн, намын бага хурал дээр ч дэмжсэн, одоо ч дэмжсэн байр сууриа л хэлэх гэж байгаа юм.

Тэгээд яах вэ энэ парламентад орж ирээд 4 жил боллоо доо. Тэгээд энэ Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ болсон цагаас хойш ер нь Монгол Улсад энэ жагсаал маш ихээр боллоо.

Үнэхээр бодлогыг нь ард түмэн эсэргүүцээд байгаа юм уу гэхээр сонгуульд намаа манлайлж ороод энэ том бүсчилсэн сонгуульд намаа ялуулаад байдаг. Энэ жагсаалуудыг хараад байхад би ажлаа хийж жагсаалыг дэмжиж бүр постолж байсан.

Одоо ингээд хараад байхад нүүрсний хулгай гээд л Ерөнхий сайд өөрөө эхэлж ярьсан. Нүүрсний хулгайгаа зогсоо гэж байснаа л 2 хоногийн дараа огцор

болоод л явсан. Сая Гашуунсухайтын асуудал орж ирэх үед 2 сарын эхээр Харбинд гарын үсэг зурахад нь энд утааны жагсаал гэж болоод бас л утаа ярьж байснаа сүүлдээ огцор болсон. Сая яг энэ Гашуунсухайтын төмөр замыг холбох ажил нь яваад орлогоо нотол болсон. Ирээд хэлэхийн завдалгүй огцор болсон.

Тэгээд өнөөдөр огцрох амархан гэдэг ийм юм яриад залуучууд жагсаж байна л даа.

Би яах вэ, бүх юмаа ил болго гэдгийг бол дэмжиж байна. Дэмжиж байна. Ер нь одоо энэ бид Монгол төрийн асуудал, Монгол Улсын цаашдын үндэсний аюулгүй байдал, олон зүйлүүдийг бас давхар бодох ёстой, үүрэгтэй хүмүүс гэж бодож байгаа. Монгол Улсад сүүлийн үед зохион байгуулагдаж байгаа жагсаал цуглаанууд ямар нэгэн байдлаар зохион байгуулалттай санхүүгийн эх үүсвэртэй жагсаад байвал энэ төр засаг гэж ер нь. Одоо нэг цүнхний асуудлаас болоод өнөөдөр Их Хурал хуралдаад сууж байна. Ер нь цаашдаа төр засаг гэж байх ч юм уу, үгүй ч юм уу. Ийм байдлаараа бол.

Тэгэхээр Ерөнхий сайд өнөөдөр ний нуугүй ярина гэсэн. Энэ олон жагсаал цуглааны ард та хүн байдаг гэж ярьдаг. Үүнийхээ талаар мэдээллийг нь ард түмэнд өгөх хэрэгтэй. Би үүнийг монголчилж ойлгохдоо зөв сэдэв хөнддөг. Дагуулж тонгорох гээд байдаг юм байна л гэж би хардаг. Дагуулж тонгорох гээд байдаг юм байна. Тийм учраас энэ асуудал дээр.

Дараагийн нэг асуудал бол энэ санал хураалтыг би ил явуулах нь зүйтэй гэж бодож байна. Ер нь нэг нэгнийхээ нүүрийг даахгүй тэгээд л хойгуур урдуур нь үнэн худал яриад л, тэгж байгаа, ингэж байгаа гэж шивнэж гүйж байхаар ер нь зүгээр ил цагаандаа гараад тэгээд одоо яадгаа үзсэн нь дээр. Ер нь шулуухандаа. Тийм.

Хоёрдугаарт, Ардчилсан нам үндэсний хэмжээний том нам. Өнөөдөр энэ сонгуулиар Ардын нам, Ардчилсан нам хэн олонх болох гээд байгаа тэр сонгуулийн үе биш ээ. Энэ бол Монголын ард түмэн баялагтаа эзэн болох уу, үгүй юу гэдгийг шийдэх чухал орой, чухал шөнө.

Тийм учраас Та бүхнийг чуулганыхаа хуралдаанд би оролцооч ээ гэж. Би 1 минутаа авчихъя. Дарга аа.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Ц.Идэрбат: Би оролцооч ээ гэж бас уриалах гэж байгаа юм.

Сая тоглоом тоотой нь дээр гэж бас үнэн л үг. Үнэн л үг. Тэгэхдээ энэ бол улс орны том эрх ашиг. Энэ 3 сая ард түмэн баялагтаа эзэн болох нэг амны хишиг байна уу, үгүй юу гэдгийг шийдэх гэж байгаа ийм хурал дээр Та бүхэн маань битгий нэг айхтар улс төржөөч ээ гэж нэгдүгээрт хүсэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, дэгийн тухай хууль дээр 7.5 билүү, юу билээ. Тэр илтэд хууль зөрчсөн асуудал буюу Үндсэн хуультай холбоотой ч билүү, тийм юмнаас бусдаар хурал хаяж гарахыг хориглоно ч гэсэн нэг ийм хуулийн заалт бас байдаг.

Тэгэхээр хэдүүлээ одоо үндэсний эрх ашиг, энэ том юмаа бодож, энэ ард түмэн баялгийн тэгш хуваарилалтын тал дээр би зогсоосой л гэж бодож байна.

Сая би амралтын өдрүүдэд аймагтаа ажиллалаа. Захиж байгаа юм ердөө л баялгийн сангийн асуудлыг. Ард түмэн үүнийг бүгдийг нь хараад сууж байгаа. Баялгийн сан та нар хийж чадах уу, үгүй юу гэдгийг л онцгой... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын эдийн засаг өнөөдөр уурхайн салбараас шууд хамааралтай байгаа. Тэгээд эдийн засгаа бид төрөлжүүлэх хэрэгтэй гэж ярьдаг. Тэгээд төрөлжүүлэх гэхээр хөрөнгө мөнгө босгох хэрэгтэй болдог. Тэгээд төрөлжүүлэхийн тулд, хөрөнгө мөнгө босгохын тулд юу Монгол Улсаас шаардагдаад байдаг вэ гэхээр миний л харж байгаагаар нэгдүгээрт улс төрийн тогтвортой байдал шаардагддаг гэж хардаг.

Хоёрдугаарт нь, мэдээж уур уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд тогтвортой, бас амжилттай ажиллах ийм шаардлагатай нүүр тулж байгаа.

Тэгээд манай улсын эдийн засаг хүчирхэг болтол нэлээд олон жил энэ шаардлага бидний толгой дээр байна байх.

Өнгөрсөн хугацаанд бид их олон том боломжийг алдсан. Бид өнөөдөр зах зухаас нь ярилаа. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр. Тэгээд зах зээл сайн байх үед нь хэрвээ бид нүүрсээ их хэмжээгээр борлуулж чадсан бол буюу одоо байгаа хилийн боомтуудаа төмөр замаар холбосон байсан бол өнөөдөр манай улсын эдийн засаг арай өөр түвшинд байх байсан байх гэж бат итгэдэг.

Олон жил гацсан байсан Өмнөговь аймгийн нутагт оршдог Гашуунсухайт гэдэг боомт удахгүй төмөр замаар холбогдох гэж байна. Энэ асуудлыг гацаанаас гаргаад араас нь Шивээхүрэн гэх мэт бас л Өмнөговь аймагт байдаг энэ боомт төмөр замаар холбогдох энэ ажил хүлээгдэж байна.

Энэ ажлыг энэ засгийн үед хийж чадсан юм. Алдагдсан боломжоо бага ч болов нөхөх нөхцөл нь бүрдэж байгаа гэж харж байгаа. Даанч яг энэ үйл ажиллагаа идэвхжих үетэй зэрэгцээд л улс төржилт эхэлж байгаа байхгүй юу.

Тэгээд ер нь улс төржөөд л өнөөдөр бид энэ танхимд янз бүрийн зүйлийг ярилцаад сууж байхад цаана чинь шинэ технологиуд бид нарыг хүлээхгүйгээр гараад байна.

Тун удахгүй коксждог нүүрсийг орлох материал хэрэглээнд нэвтрэх гэж байна. Өндөр технологид ашиглагдаж болох өөр олон түүхий эдийг Монгол Улсаас худалдах бүрэн боломж байдаг. Уул уурхайн салбартай холбоотой асуудал гарангуут л маш их улс төржөөд явдаг.

Бас 20 илүү жил гацсан байсан ураны төслийг энэ Засгийн газар хөдөлгөж чадсан учраас итгэл хүлээлгэх ёстой гэж үзэж байгаа.

Бас нэг зүйлийг онцлоод хэлэх хэрэгтэй байна. Энэ нь мэдээж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 онд баталсан явдал. Уул уурхайн салбар нэлээн тийм эсэргүүцэлтэй тулдаг салбар гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Иргэдийн дэмжлэг маш их хэрэгтэй байгаа. Иргэдийн дэмжлэгийг олж авахын тулд бид Хуримтлалын сангаар дамжуулж бий болгоно гэж үзэж байгаа. Өнөөдөр e-mongolia платформ руу ороод харахад ер нь энэ уул уурхайн төслүүдээс эдийн засгийн үр өгөөж нь хүн болгоны нэр дээр хэр хэмжээгээр ирж байгаа нь харагдаж байгаа.

Яах вэ, хувь гишүүний хувьд Хуримтлалын сан яаж бүрдээд байгаа дээр шүүмжлэлтэй хандаад, хэд хэдэн судалгааг хийсэн юм. Тэгээд ер нь салбарт явуулж байгаа бүх үйл ажиллагаа шударга, ил тод байх дээр гарцыг боловсруулаад, гарцыг нь тодорхойлоод Ерөнхий сайдад болон засгийн зарим гишүүдэд тайлбарласан байсан.

Тэгээд хэрвээ засаг өөрчлөгдөхөөр тулах юм бол дахиад л их цаг хугацаа алдах гээд байгаа харамсалтай дүр зурагтай байна.

Тэгэхээр ер нь шинэ үеийн парламентад салбар бүрийн нийгмийн төлөөллийн бүлгүүд орж ирсэн. Тэгээд ард түмэн биднээс их хүлээлттэй байгаа учраас нэлээн тийм идэвхийлэн ажиллаж байлаа.

Тэгэхээр ерөнхийлөөд нэг асуултыг Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм.

Хэрэв Улсын Их Хурал өнөөдөр Засгийн газарт итгэл үзүүлэх юм бол ойрын 3-аас 6 сарын хугацаанд гэж хэлье л дээ. Ямар ажлуудыг хийхээр төлөвлөсөн байгаа вэ? Үүнийг тодорхой хэлж өгөх шаардлагатай байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газар төлөвлөж байгаа ажлынхаа дагуу л ажиллана.

Бид хамтдаа нийгмийн даатгал, татварын цогц реформыг бүлгүүдэд танилцуулаад эхэлсэн. Түүнд PROGRESSIVE TAX гэж нэрлэдэг. Илүү дэвшилтэт татвар.

Энэ бол нөгөө орлогын тэгш бус байдлыг бас багасгадаг ийм татварын асуудлыг бид эдийн засгийн зөвлөл дээр яриад, эдийн засгийн зөвлөл дэмжээд, бүлэг дээр яриад дэмжээд өргөн барихад бэлэн болсон байгаа зүйл.

Энэ бол их тийм чухал зүйл. Иргэдийн хүлээлттэй уялдсан их тийм чухал зүйл. Нэг үгээр хэлбэл орлого өндөр хэсгээсээ бас илүү татвар авдаг. Ингэснээр тэгш бус байдлыг багасгадаг Германы маягийн татварын систем рүү орох нь зүйтэй гээд.

Ингээд 3-аас 4 хувилбар танилцуулаад Сангийн сайд энэ дээр хэд хэдэн танилцуулгууд хийсэн. Хувийн хэвшлийнхэн бас хамтдаа дүгнэлтээ хийсэн. Сангийн яам хийсэн. Татвар хийсэн. Ингээд үндсэндээ зөвшилцлийн цэг дээр ирсэн. Тэгэхээр энэ асуудлаа ер нь хийнэ.

Нийгмийн асуудлын хувьд бид “БОЛОВСРОЛЫН ЖИЛ” болгоод зарласан. Ингээд явж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр ирэх жил боловсрол дээр нэлээдгүй их хэмжээний санхүүжилт тавигдахаар ер нь Засгийн газар дээр төлөвлөгдөөд явж байсан. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой хэд хэдэн тийм дэд бүтцийн асуудлуудыг бид бүсүүд дээр очоод Улсын Их Хурлын гишүүд болон аймаг, орон нутгийн удирдлагуудтай нь ярилцаад, ингээд энэ чинь хэд дэх бүс дээрээ явж байлаа. Бид. 4, 5. Сая бид говийн бүсэд ажиллаж байгаад ирэхэд ийм асуудал болж байгаа юм.

Тэгэхээр энэ ажлууд хийгдээд явахаар төлөвлөгдөөд. Нийслэл Улаанбаатар хотын хувьд Туулын хурдны зам улс төржихгүйхэн шиг байж байгаад явчихвал. Тэгээд 2 тойрог зам шийдэгдвэл түгжрэл шууд 50 хувиар буурахаар математик тооцоо гарсан. Бид хагас сайн өдөр бүхэн уулзсан. Их үр дүнтэй байсан.

Тэгэхээр ийм ажлуудаа хэдүүлээ тогтвортой авч явах нь туйлын чухал юм. Бодлогын тогтвортой байдлаа хадгалах нь гэж хариулъя.

Гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Тэр нь юу вэ гэхээр уул уурхайн салбарыг бид олон нийтийн дэмжлэгтэй, орон нутаг нь ойлгодог болох ёстой. Тэгэхийн тулд бид АМНАТ-ын асуудлыг яриад оруулж ирээд энэ бол Үндэсний баялгийн сангийн бүрэлдэхүүний хэсэг болох нь зүйтэй гээд. Энэ дээр хувийн хэвшил ер нь бүгдээрээ зөвшөөрсөн шүү дээ. Зөвшөөрсөн. Хөрөнгө оруулагчид зөвшөөрсөн. Одоо үүнийг бид зориглоод батлах нь зүйтэй ийм ажил.

Тэгвэл яах вэ гэхээр иргэд дэмжинэ. Орон нутаг ойлгоно. Сая би говийн бүс нутагт Ханбогд суманд очсон. Ханбогд сумын иргэдтэй уулзсан. Тэд хүртэл АМНАТ-ын талаар ойлголцогүй байна лээ.

Тийм учраас энэ асуудлыг бид шийдээд явах нь зүйтэй гэдэг ийм байр суурь дээр байгаа. Гэхдээ энэ бол төлөвлөгдсөн ажлууд. Тэгээд цаашаа явах нь л зүйтэй ийм ажлууд.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: 2024 оны сонгуулийн үр дүнгээр бид хамтарсан Засгийн газар байгуулсан. Жил хүрэхгүй хугацаанд хамтарсан Засгийн газраас олон жил гацсан томоохон төслүүдийг хөдөлгөж, тодорхой ажлуудыг шийдэж сайн ажилласан.

Хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө гар сэтгэл нийлж ажилласан Ардчилсан намын сайд нартаа баярлалаа гэж хэлье. Өнөөдөр улс орны маань дотоод гадаад нөхцөл байдал тийм амаргүй байгаа, хүнд байгаа. Эдийн засаг сайн биш байна, ард иргэдийн амьдрал хүнд байна, аж ахуй нэгжүүд маань татвараа төлөхөд хүндрэлтэй болж байна. Гадаад нөхцөл байдал, дэлхийн дэг журам өөрчлөгдөж байна. Хүчтэй нь хүчгүйгээ дээрхэлдэг, том нь жижигтээ бодлогоо тулгадаг, шахаж шаарддаг ийм ээдрээтэй, эгзэгтэй, эрсдэлтэй цаг үед бид бүхэн ажиллаж амьдарч байгаа.

Ийм цаг үед аль болох эв нэгдлийг барьж, зөвшилцөж, ойлголцож, асуудлыг шийдэж явмаар байгаа юм.

Тэгээд өнөөдрийн чуулганд олон гишүүд үг хэлэх байх. Хэлэх үгээ нэлээн сайн бодож болгоож, “хагацашгүй сайн нөхөртөө марташгүй муу үг битгий хэлж байгаарай” гэсэн үг байдаг. Түүнтэй адилхан тэр үгийг бодож, мөн “идэж байгаа тогоотой хоол руугаа нулимдаггүй” гэж үг байдаг. Үүнийг бодож болгоож саналаа хэлээсэй, үгээ хэлээсэй, субъектив байдлаар асуудалд битгий хандаасай гэж хүсэж байгаа.

Олон Засгийн газар огцорсон, олон зөрчилтэй асуудлууд бий болж байсан цаг үед ажиллаж байсан.

2012-2016 онд олонх, цөөнх болоод хоорондоо маргалдаад, мэтгэлцээд, үл ойлголцоод, үл ойлголцол нь үзэн ядалт болоод олон жилийн ужгирсан тэмцэл болж байсан. Энэ түүхийг бид марташгүй. Бүгд санаж байгаа.

2016-2020 онд Монгол Ардын нам 65 суудалтай мөртлөө 32, 33 болж хуваагдаж бас л хэдэн жилийг ардаа гарч арай чүү энэ шарх илаарьшиж байгаа.

Тийм болохоор өнөөдөр энэ үл ойлголцол маань үзэн ядалт болдог. Энэ нь эргээд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд ноцтой аюул занал

болох хэмжээнд хүрэх вий. Энэ парламентын засаглал маань эрсдэлд орох вий гэдгийг бид бүхэн бодож.

Эцсийн эцэст асуудал санал хураалтаар л шийдэгдэнэ. Санал хураалтаар. Тийм болохоор хэн нэгнийгээ доромжилсон, гүтгэсэн, гутаасан, субъектив байдлаар ч гэсэн дайрч доромжилсон иймэрхүү хандлага бидэнд тийм сайн зүйл авчрахгүй байх. Тийм болохоор нэлээн хүлээцтэй бодож болгоож үгээ хэлцгээе.

Эргээд бас нэг уулзах нүүртэй, энэ улс орныхоо эрх ашгийг нэгдүгээрт тавьсан, улс орныхоо эрх ашгийн төлөө хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэдийгээр Ардчилсан нам гарч байгаа ч гэсэн цаашдаа хийж хэрэгжүүлж, ард иргэдийнхээ амьдрал ахуйг өөд нь татахын төлөө бүгдээрээ бодогцооё. Монголын ард түмэн бид бүгдийг харж байгаа. 126-тай парламент хүлээцтэй асуудалд ханддаг юм байна. Олон талаас нь ярьдаг юм байна. Асуудал мэдээж маргаж, мэтгэлцэх зүйл байлгүй л яах вэ. Гэхдээ аль болох хэрэлдэж хэлэлцэхгүй, зөвшилцөж ойлголцож асуудалд бие биедээ хүлээцтэй хандах тал дээр л Та бүгдийгээ санал бодлоо хэлээсэй гэдгийг л захиж хэлье.

Тэгээд хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхийн төлөө парламент илүү ачаа үүрч, илүү ухаантай хандах ёстой шүү л гэдгийг дахин хэлье. Асуулт алга.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Сонгууль болоод жил хүрэхгүй хугацааны дараа овоо сүрхий хамтраад асуудлаа шийдэх гээд явж байснаа одоо засгаараа оролдож байгаа нь харамсалтай байна.

Өнөөдөр бид чухал чухал асуудал ярьж байгаа боловч нэг харамсалтай зүйл байна. Бид нарын бодож байгаа, энд ярьж байгаа, мэдэж байгаа зүйл гадуур иргэдийн ярьж байгаа, талбай дээр залуучуудын бодож байгаа, шаардаж байгаа зүйл тэмээ ямаа шиг болчихоод байгаа нь харамсалтай байна л даа.

Тэгээд Монгол Улсаараа нэг юмыг өөр өөр өнцгөөс өөр өөр юм хараад, тэгсэн хэрнээ хариуцлагатай том шийдвэр гаргах гээд сууж байна. Яг нөгөө зааныг сүүлнээс нь баривал нэг байдаг, хөлөөс нь баривал нэг байдаг, хошууг нь барьсан хүн өөр амьтан гэж хэлдэгтэй адилхан болоод байна.

Тэгээд гадуур жишээлбэл талбай дээр “Огцрох амархан” гээд явж байна, “Орлогоо нотол” гээд явж байна, цүнх ярьж байна.

Энд болохоор парламентын засаг солих гээд байгаа ч юм шиг юм яриад байх юм, эсвэл гаднын, дотнын янз янзын бүлэглэлүүд байгаа ч юм шиг юм яриад байх юм.

Тэгээд нэг юмыг маш хайнгаар сошиал дагаж халиурч байгаад бид засгаараа оролдож байна. Огцрох, огцрохгүй нь дараагийн асуудал. Хэн байх нь дараагийн асуудал. Хамгийн гол нь зөв, бодитой мэдээлэл байна уу гэдэг л хамгийн чухал байна л даа.

Тийм болохоор би Ерөнхий сайдаас нэг юмыг тодорхой асуумаар байна. Жишээлбэл, та яриандаа Гашуунсухайтын хил холболтын төслийг холбох үед, гэрээ хэлцэл хийх үед 3 удаа яг давтамжтайгаар ямар нэг довтолгоо ярьж байсан. Энэ бол санаатай зохиомол зүйл ээ гэж хэлж байсан. Энэ яг бодитой юм уу? Энэ яг цаана нь хэн байдаг юм бэ? Гадна, дотнын бүлэглэлүүд байдаг юм уу? Бизнесийн бүлэглэлүүд байдаг юм уу? Эсвэл зүгээр Монгол Улсыг хорлох гэсэн хүмүүс байдаг юм уу? Эсвэл нам дотроо, нам гадна янз янзын юм яг хэн байдаг юм бэ? Энэ талаар бодитой, бодитой бус мэдэгдэхгүй мэдээлэл байгаад байна лээ. Энэ дээр та яг тодорхой, ил тод мэдээлэл өгвөл түүний ярьдаг мэдээллийн зөрүүг ойлголцлын зөрүүг. Энэ цаашдаа ч гэсэн нэг иймэрхүү юм гарах магадлалтай.

Тэгэхээр энэ дээр цаашдаа Монгол Улсаараа алдахгүй байхад Та үүнд тодорхой хариулаач ээ.

Тэр Авлигатай тэмцэх газар дээр ч юм уу, хаана ч юм зарим гишүүдийн орлогыг нотол ч гэдэг юм уу, ямар нэгэн байдлаар, эсвэл хэн нэгнийг зодуулсан ч гэдэг юм уу нэг тийм чиглэл өгч байгаад зодуулсан юм шиг яриа гараад байгаа байхгүй юу. Энэ дээр таны тайлбар өгснийг би сонссонгүй.

Тэгэхээр үүнийг иргэдэд яг Та одоо чиглэл өгөөд сууж байдаг юм уу, эсвэл үгүй юм уу, эсвэл энэ зүгээр гүтгэлэг юм уу, тодорхой тайлбар өгөөч ээ. Ийм тодорхой мэдээлэл байхгүй болохоор улсаараа өөр өөр юм бодоод засгаараа оролдоод байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цаг 19 цаг 20 минут болсон байна. Өнөөдөр чуулган 18.00 цаг болж байхад эхэлсэн.

Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудлаа дуустал чуулганыг үргэлжлүүлье гэсэн саналтай байна. Гишүүд дэмжиж байна уу? Тэгвэл чуулган асуудлаа хэлэлцээд дуустал үргэлжилнэ. /алх цохив/

Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Гашуунсухайт, Ганцмод. Энэ их түвэгтэй сэдэв юм билээ. Амархан байсан бол тэгээд холбогдох л байсан байх.

Нэгдүгээрт, манайх төмөр замд тавигдахаар үнийн хувьд Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Баяннуур талд байгаа тодорхой компаниудын хувьд өрсөлдөх чадваргүй болох юм билээ. Нэг үгээр хэлбэл их овроор зөөгөөд эхлэхээр.

Сая бид очоод хил гарч тэр компаниудтай уулзсан. Энэ дээр аль аль намын л хүмүүс байсан. Нэгдүгээрт ийм шалтгаан байна.

Хоёрдугаарт, үүнийг бид болгоно, 10 жилийн өмнөх тэр гэрээгээ бид нарын хувьд хэвээр нь хадгалаад хийгээд явна, бид төр засаг болон улс төрд лобби хийж чадна гэдэг манай дотоодын компанийн ийм групп, нэгдэл байгаа. “Эм Эм Си”.

Эд нар тэр “Чайна Энержи” гээд байгаа компаниа ятгаад байдаг юм билээ. Үгүй ээ, бид чинь одоо ингээд бизнес төлөвлөгөө нь Тавантолгой хамт байх ёстой шүү дээ. Жижиг Тавантолгой хамт байх ёстой. Тэгээд хоёр улсын Засгийн газар шууд хоорондоо холбогдоод наадах чинь нэг тийм бүтэл муутай. Энэ ингээд нэг тийм эрх ашиг байна.

Дээрээс нь, автомашины бизнес эрхэлж байгаа манай улс төрчид байна. Яагаад гэхээр төмөр зам тавигдвал автомашины тэр тээврүүд чинь бүгд байхгүй болох юм билээ л дээ. Энэ их тийм томоохон эрх ашгийг хөндөх юм билээ.

Ингээд энэ гурван эрх ашиг хөндөгдсөн зүйлийг сая бид 90 хувьтай баталсан. Ингээд Харбинд очиход ч энд асуудлууд болсон. Сая ч асуудлууд боллоо.

Сая Гашуунсухайт дээр очоод ирэхэд нэг асуудлууд боллоо. Тэгээд үүнийг би бол зохион байгуулалттай л гэж үзэж байгаа. Зохион байгуулалттай л гэж үзэж байгаа.

Харин нэгэнтээ байгуулсан парламентын гэрээ Монгол Улсын хувьд бол ёстой “МОНГОЛЫН АНДГАЙ ЗА” л байх ёстой. Үүнээсээ бид буцвал ёстой шал утгагүй байдалд орно. Энэ чинь 15 жил, бараг 20-иод жил гацсан. Тэгээд Монгол Улсын парламент эрх өгөөд нэг удаа хийгээд, 10 жилийн өмнө тэгээд дахиад буцсан ийм зүйл шүү дээ.

Тэгэхээр үүнийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тал их анхааралтай ажиглаж байгаа, маш их санаа зовж байгаа.

Тийм учраас тогтвортой байх тал дээр парламент баталгаа өгөх нь зүйтэй байх.

Тэр юу бол худлаа шүү. Ингээд л цагдаа дээр нэг асуудал. Би О.Алтангэрэл сайд байвал хариулаасай гэж бодож байна. Би зориуд Ардчилсан намд яагаад Хууль зүй, дотоод хэргийн яам очих нь зүйтэй гэж үзсэн бэ гэхээр ийм хардалтууд их байдаг юм. Нэг тийм юм боллоо. Тэрийг Ерөнхий сайд мэдэж байгаа, ингэж байгаа, тэгж байгаа гээд.

Тэгээд жишээлбэл Ц.Нямдорж дарга ч гэсэн би ямар ч мэдээлэлгүй байж байна аа гээд байсан. Тухайн үед бүгдээрээ л шоолж байсан.

Би О.Алтангэрэлээс асууж байсан юм. Үнэн байгаа биз. Үнэн. Асуугаарай журмынхаа нөхрөөс. Одоо ингээд ажлаа өгөх гэж байгаа юм чинь бүр илүү тодорхой ярьж өгөх байх.

Тэгэхээр ийм зүйлүүд байдаг шүү. Жишээлбэл, одоо тэр Ноорогийн залуучуудтай Засгийн газар ингэсэн, тэгсэн гээд л. Тэр өдөр бид бүгдээрээ хамт чуулган эхэлж байсан. Чуулган эхлээд бид нэлээн их зүйл. Би Гашуунсухайт, Ганцмодыг л ярьж байсан. Тэрийг Та бүхэн санаж байгаа байх. Хамтдаа уулзаад. Өглөө босоход тийм зүйл болсон байсан. Тэрийг хамт байж байсан хүмүүс байгаа. Би бүр цочирдоод тэгээд би О.Алтангэрэл сайд руу ярьж байсан. Заавал чуулган эхлэх өдөр ийм зүйл давхцаад байхдаа яах вэ дээ гээд.

Тэгэхээр огт ийм мэдээгүй зүйлүүдийг... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ерөнхий сайдад нэмэлт 1 минут.

Л.Оюун-Эрдэнэ: Ийм зүйлүүд байдаг шүү.

Утааны асуудал болсон. Утааны асуудал яг тэр жагсаал болдгоос бараг 10-аад хоногийн өмнө болсон байсан асуудал байсан. Гэх мэтчилэн ийм асуудлууд байна.

Тийм учраас цаашдаа Монголын төр илүү дархлаатай, хоёр том гүрний дунд байгаа Монголын ардчилал илүү тийм дархлаатай байхын тулд асуудалд Их Хурлын гишүүд маань илүү тийм мэдээлэлтэй байх нь л зүйтэй гэж би бодож байгаа юм.

Би өнөөдөр энэ асуудлыг яриад, олон талаас нь ярьдаг нь ийм эргэлзээтэй зүйлүүд байгаа бол бүх зүйлийг надаас асуу гэж хэлээд байгаа нь тэр. Асуучих. Тэгээд би хариулъя. Шаардлагатай бол нотолгоо хийгээд. Тэгэхгүй бол яах вэ гэхээр ийм зүйл дээр, том хэмжээний асуудлуудыг буруу тайлбарлагдах, буруу ойлгуулах зүйлүүд их байдаг.

Тэгээд энэ нь явж байгаад засаглалын асуудал болж хувирдаг. Цаанаа маш их өөр зорилготой байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Нээлттэй асуудлаа ярьж байгаа нь зөв өө.

Ордны хажууд явж байсан хүүхдээс сэтгүүлч асуудаг бичлэгийг манайхан үзсэн байх. Ордон дотор ямар хүмүүс суудаг, юу хийдэг вэ гэсэн баахан дарга

нар хоорондоо хэрэлдээд, идэж уугаад л суудаг байх аа гээд нэг бага ангийн хүүхэд хариулж байсан.

Энэ бол өнгөрсөн 30 жил ард түмэндээ үзүүлсэн бидний легитм дүн л дээ.

Тэгээд буцаад л энэ рүүгээ орох гэсэн, ийм байдал руу явах нь уу гэдэг. Харамсалтай санагдаж байна. Алдаагаа засаад шинэ 30 жил өөр байгаасай гэж хамтарсан Засгийн газрыг тууштайгаар дэмжиж ирсэн. Өнөөдөр ч гэсэн энэ байр суурь дээрээ байгаа.

Тэгээд саяын хэлж байгаа гишүүдтэй би санал нэг байна. Бид маш их вакумжиж байна. Яг залуучуудын жагсаалын цаад мөн чанарыг ерөөсөө ойлгохгүй байгаад байна. Хэн нэгэн хүнийг огцруулах, эсвэл аль нэгэн цүнх савтай холбогдолтой асуудал гэхээсээ илүүтэй 30 жил яг бидний үеийн ардчилалтай хамт төрсөн залуучуудын нийгмийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа, өдөр тутам тохиолдож байгаа нийгмийн шударга бус байдлыг өөрсдийнхөөрөө илэрхийлж байгаа байдлыг бид их буруу ойлгоод байна.

Яах вэ, илэрхийлж байгаа арга барил нь, үүнийгээ зохион байгуулж байгаа байдал нь бид нарт ойлгомжгүй байдаг юм уу, энэ байдал нь өөр байж болно. Гэхдээ үүний цаана үнэхээрийн нийгэмд болж бүтэхгүй байгаа олон асуудлууд байна гэдгийг янз бүрийн байдлаар илэрхийлдэг нэг хэсэг залуучууд шинээр гарч ирээд байгаа юм. Үүнийг нь янз янзын явцуу байдлаар ашиглаж байгаа зүйлүүд байгааг үгүйсгэхгүй.

Тэгэхээр бид ер нь цаашдаа нийгмийн хуваагдал руу, ялангуяа залуучуудаа ойлгодоггүй, сонсдоггүй ийм төр, нөгөө талдаа төр, засгийн хувьд тогтвортой явж байгаа энэ байдлуудаа ойлгуулж чаддаггүй ийм байдал цаашдаа үргэлжилсээр байх уу гэдэг эхний асуулт байгаа юм. Тэгээд нээлттэй ярьж байгаа боловч нэлээн тодорхой асуултуудад Ерөнхий сайд хариулт өгөхгүй байгаад байна. Дахиад би гишүүдийн адилаар асууя.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа гол асуудлын цаад мөн чанар нь сонгодог парламентын тогтолцоог авч үлдэх тухай асуудалд тодорхой аюул занал учраад байгаа тухай бид бүхэн дурдаад байна. Тэгвэл үүний цаана яг ямар бүлэглэл, ямар хүмүүс байгаад байгаа юм бэ? Үүнийхээ тухай илүү тодорхой болгож ярьж олон нийтэд нээлттэй байя гэдэг дээрээ байх ёстой бус уу гэж бодож байна.

Өмнөх 30 жилийн улс төрийн хямралын гол алдаа нь институт хоорондын зөрчлийн асуудал байсан. Үүнийг бид бүгдээрээ мэддэг, бүгдээрээ ярьдаг. Цаашдаа яаж энэ Засгийн газар илүү тогтвортой байх, Монгол Улсын улс төр илүү тогтвортой байх, энэ тогтолцоогоо авч үлдэх вэ гэдэг энэ агуулга дээр илүү тодорхой хариултыг гишүүдтэй адилхан авахыг хүсэж байна.

Мөн дээрээс нь залуучуудын жагсаалыг бид өөрөөр харах хэрэгтэй байна. Тэгээд хамтарсан засгийн үйл ажиллагааг цаашдаа үргэлжлээсэй гэсэн

байр суурь хэвээрээ. Санал хураалтыг илээр явуулаасай гэсэн зарчимтай байгаа. Олон нийт, иргэдийн судалгаагаар ч гэсэн харагдаж байх шиг байна.

Тэгээд байгаа асуудлуудаа нээлттэй яриад, тодорхой асуултуудад нь хариулт өгөөд, зоригтой... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Би өнөөдөр гишүүдийн асуултад тодорхой, тэгээд нэг их айхтар тийм эмоци байхгүйгээр бодитой зүйлийг сэтгэл хөдлөлгүйгээр ярих нь зөв гэж бодоод байгаа шүү.

Залуучуудын жагсаалттай холбоотой асуудлыг би маш эергээр ойлгож байгаа. М.Ганхүлэг ээ, залуучууд юу вэ гэхээр энэ орлогын тэгш бус байдал үүсээд байна. Төр, засаг ер нь биднийг сонсохгүй байгаад байна. Өдөр тутмын татвар, нийгмийн даатгалын дарамт их байгаад байна.

Тийм учраас бид дуу хоолойгоо илэрхийлж байна. Шинэ үеийнхний хүсэл эрмэлзэл өөр болоод байна. Үүнийг төр ер нь анхаарч байна уу, үгүй юу гэдэг л ийм асуудал байгаа. Нөгөө талаараа тэд тэгш бус байдал, мөн ил тод байдлыг шаардаж байгаа. Би бүгдтэй нь санал нэг байгаа.

Тийм учраас залуучуудын жагсаалттай холбоотой яг энэ дуу хоолойгоо илэрхийлж байгаа энэ зүйл дээр миний хувьд маш эерэг талаас нь харж байгаа гэдгийг хэлье. Маш эерэг талаас нь харж байгаа.

Гэхдээ нэг харамсалтай зүйл юу вэ гэхээр бид залуучууддаа ойлгогдохгүй хэлээр яриад буруу л болж байгаа юм. 14 мега төсөл гээд байхаар хүмүүст энэ нэг тийм ойлгогддоггүй юм билээ л дээ. Уг нь амьхандаа бид татварыг багасгах, нийгмийн даатгалыг багасгах, мөнгөтэй л болох гээд байгаа шүү дээ.

Тийм учраас бид нүүрсээ экспортлох нь зөв, зэсээ экспортлох нь зөв л гэж хараад байгаа юм. Үүнийгээ бид тийм энгийн хэлээр ойлгуулж чадахгүй байгаа нь алдаа л даа. Үнэн үнэн. Тэгээд энэ нь өөрөө нэг л тийм том төслүүд ярьсан. Үгүй ээ, тэгээд тэр нь бидний амьдралд ямар хэрэгтэй юм, залуучуудад яг ямар хэрэгтэй юм, технологи, инновац гээд олон асуудал дээр яг юу хийж байгаа юм гэдэг ийм асуудал руу ордог.

Сая хүүхдийн байгууллагын 100 жилийн ой болсон. Тэнд хүмүүстэй уулзахад бүгдээрээ л тийм зүйл ярьж байна лээ. Намайг бүр тэгж байсан. Та ч одоо уг нь “Дэлхийн зөн” олон улсын байгууллагад ажилладаг, харьцангуй хүүхдүүдийг ойлгодог хүн. Одоо тэгээд л ярьж байгаа чинь нэг л тийм мега төсөл гээд л хөндий юм ярьдаг болж гээд. Уг нь яг л тэр зүйлийг хийхийн төлөө л. Энэ төслүүд нь явах ёстой болоод байдаг.

Тэгэхээр энд шийдэгдэж байгаа асуудал дээрээ илүү төвлөрөөд энэ юмаа яриад байхаар бас нийгмийн олон сегментүүдэд тэгээд нэг л тийм том том төмөр зам, нэг л тийм ачаа тээвэр, логистик, боомт гээд л яриад байх юм. Яг үнэндээ яг юу өөрчлөгдөж байгаа юм гэдэг ийм асуудал байгаа. Үүнийг би хүлээн зөвшөөрч байгаа, ойлгож байгаа.

Гэхдээ ийм органик хүсэл эрмэлзлийг улс төрийн зорилгоор ашиглах гэж байгаа зүйл ч байна. Үүнийг Та бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа.

Тэгээд энэ нь залуучуудын маань хүсэж мөрөөдөж байгаа тэр хугацааг дөтлөх үү, эсвэл бүр холдуулах уу гэдгийг л бид анхаарч байгаа учраас үүнийг олон талаас нь яриад сууж байна л гэж ойлгож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Өмнөх 30 жилийн улс төрийн хямралын гол үндэс нь институц хоорондын асуудал байсан гэдгийг Та нэлээн илэрхийлж ирсэн.

Үүнтэй холбоотойгоор ер нь цаашдаа сонгодог парламентын тогтолцоогоо авч үлдэхтэй холбогдолтой энэ асуудал дээр ер нь цаашдаа бид ямар өөрчлөлтүүдийг хийх вэ? Илүү хамтарсан Засгийн газар, тогтвортой Засгийн газрын ажлыг цаашдаа үргэлжлүүлэх чиглэл дээр яг ямар асуудлууд тулгараад өнөөдрийн асуудал үүсэж байна вэ гэдэг дээрээ боломжтой бол нэмэлт хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Үнэн үнэн. бид Ерөнхийлөгчийн ч юм шиг, парламентын ч юм шиг засаглалтай улс шүү дээ. Ер нь бол.

Ард түмнээс сонгогдог Ерөнхийлөгчтэй. Мөрийн хөтөлбөр дэвшүүлдэг. Би үүнийг 2019 онд ярьж л байсан. Парламент Засгийн газар томилдог. Мөрийн хөтөлбөртэй.

Ингээд хоорондоо ажил үүргийнх нь хуваариуд давхцах, ингээд буруу, зөрүү ойлголт төрөх зүйлүүд байна. Үүнийг бид парламентын засаглалтай бол нэг талд нь гаргах ёстой. Ерөнхийлөгчийг цаашдаа парламентаа сонгодог байх нь зөв. Үүнийг би байнга л илэрхийлж ярьсан.

Тийм учраас энэ асуудлыг олон талаас нь парламент яриад, ер нь 2027, цаашдын сонгуульд энэ агуулгыг нэлээн ярих нь зүйтэй. Хэрвээ парламентын засаглалтай байа гэвэл.

Өөх ч биш, булчирхай ч биш байснаас үүнийг аль нэг талд нь гаргах нь зүйтэй. Ерөнхийлөгчийн засаглалыг бүр буруу гээд байгаа зүйл байхгүй. Байдаг

л зүйл. Үүнийг нээлттэй, бүх л Ерөнхий сайдууд, парламентын гишүүд ер нь яриад, тэгээд үүнийг аль нэг талд нь гаргахгүй бол нэг ийм замын голоор яваад байгаа юм шиг нэг ийм асуудлууд бүх л Ерөнхийлөгчид ч таарч байгаа, Ерөнхий сайд ч таарч байгаа ийм асуудал байгаа.

Үүнийгээ парламент илүү ярьж, илүү олон талаас нь шүүн хэлэлцэж, аль нэг талд нь гаргах нь ирээдүйд илүү их тийм чухал байх зүйл гэдэгтэй би 100 хувь санал нэг байдаг.

Би хэлсэн шүү дээ. 1991 онд санал хураалт болсон. Ерөнхийлөгчийн гэдэг дээр 48 хувь, парламентын гэдэг дээр 48 хувь. Тэгээд санал хэлэлцээд зөвшилцөөд зарим нэг чиг үүргүүдийг нь аваачаад давхцуулаад хийчихсэн. Тэгээд ийм асуудлууд байна. Үүнийгээ бид ил тод нээлттэй яриад, мэтгэлцээд явах нь зүйтэй.

Миний хувьд хоёр том хөршийн дунд байгаа Монгол Улсын хувьд парламентын засаглалтай байх нь зөв гэж боддог. Төгөлдөржүүлнэ гээд байгаа маань энэ л дээ. Тийм ээ. Гишүүдээ бид өргөтгөлөө, олон намын төлөөлөлтэй боллоо. Нэг алхам. Мөн үү мөн.

2019 оны Үндсэн хууль бол бас энэ дээр ийм том саналууд хийсэн шүү дээ. Тэгээд энэ асуудлуудаа хийгээд л дараа дараагийн сонгууль дээрээ намууд маань мэтгэлцээд л явах нь зөв өө л гэж бодож байгаа.

Тогтворгүй байдал үүсвэл парламентын засаглал хүнд байдалд орно. Үүнийг өнөөдөр би Ерөнхий сайдын хувьд нуугаад яах вэ. Хэлэх л хэрэгтэй шүү дээ. Хэлж байхгүй яасан юм бэ гэж дараа нь асуудал үүснэ шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас болзошгүй үр дагаврыг урьдчилан сануулах нь Ерөнхий сайдын үүрэг.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би яг энэ өнөөдрийн энэ хуралдааны тэмдэглэлд хоёр зүйлийг зориуд тэмдэглэж үлдээмээр байна.

Мөн Ерөнхий сайдаас хоёр асуулт байгаа.

Нэгдүгээрт, энэ танхимаас ямар ч шийдвэр гарсан бай Монголын ард түмэн итгэл найдвараа битгий алдаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Учир нь гэвэл бид өнөөдрийн 126 гэхээсээ илүүтэй ардчилсан Үндсэн хуультай улс гэдгээ бид ямагт санаж, бид энэ Үндсэн хуульдаа хамаг итгэл найдвараа өгч байгаа гэдгээ бүгдээрээ эргэж нэг санаасай. Тэгэхээр бид итгэл найдвараа битгий алдаасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамгийн гол амин сүнс нь үзэл бодолтой байх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудал байдаг. Илэрхийлэхээсээ илүүтэй гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр энэ эрх чөлөөг хэн ч хязгаарлаж чадахгүй, хэн ч шүүх боломж байхгүй ийм эрх чөлөө байдгаараа онцлог.

Гэтэл энэ танхимаас гарах үр дүнгээс илүүтэй өнөөдрийг хүртэл явж ирсэн процесс дээр бид ер нь анхаарах ёстой байжээ гэж би илүү бодож сууна. Энэ хүртэл явж ирсэн процессыг бид ерөөсөө хүлээн зөвшөөрч, ойлгож, хүлцэн тэвчиж, хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа олон зүйлүүд ажиглагдлаа.

Залуучууд бүгдээрээ үзэл бодолтой байна. Түүнийгээ илэрхийлж байна. Намын гишүүд бүгдээрээ үзэл бодолтой байна. Түүнийгээ илэрхийлж байна. Гэтэл үүнийг нь бид ерөөсөө ойлгох ухаан байхгүй, түүнийгээ заавал мөнгө санхүү, эдийн засгийн нэг ийм зүйлтэй холбодог л болоод байна л даа. Энэ нь өөрөө бид нарын итгэл найдварыг бөхөөхөд маш их сөрөг нөлөөтэй гэж харж байна.

Тухайлбал, Ч.Лодойсамбуу гишүүн бусад гишүүдийгээ кнопоо худалддаг гээд л мэдэгдэл хийлээ. М.Нарантуяа-Нара гишүүн гадаа жагсаж байгаа жагсаал хийж байгаа залуучуудыг 50 сая төгрөгөөр багцлагддаг гээд л хэллээ. Яагаад бид энэ бүх процессыг хүлээн зөвшөөрч, ойлгож, бие биедээ итгэж чадахгүй байгаа юм бэ. Үүнийгээ ер нь бүгдээрээ харах ёстой байх гэж бодож байна.

Тэгэхээр та хоёр маань ингэж хэлсэн энэ үгээ нотолж чадахгүй бол бас уучлалт гуйх ёстой гэж бодож байна. Би энэ танхимд байгаа бусад бүх 126 гишүүддээ итгэж байна. Гадаа жагсаал хийж байгаа бүх залуучууддаа би бас итгэж байна. Тэнд органик, өөрсдийнхөө хүсэл зоригоор очиж жагсаалд оролцож байгаа маш олон залуучууд, маш олон хүмүүс байгаа. Тэнд миний 22 настай охин ч гэсэн байгаа.

Тэгэхээр үүнийг бид ямар нэгэн шүүлтүүр тавьж бодож болохгүй байх гэж бодож байна.

Тэгэхээр цаашид парламент, Засгийн газар ил тод байдал дээрээ анхаарах ёстой том дохио боллоо гэж би хувьдаа дүгнэж байна.

Хоёр асуулт. Монгол Ардын намын Бага хурлын 303 гишүүн санал өгч нууц санал хураалтаар шийдвэр гаргасан.

Тэгэхээр Та өнөөдөр энэ танхимаас Бага хурлын гишүүдэд хандаж үг хэлээч ээ гэж хүсье.

Хоёрдугаарт, “ёс зүйн хариуцлага”, “хууль зүйн хариуцлага”, “улс төрийн хариуцлага” гэсэн энэ гурван хариуцлагын асуудал дээр Та байр сууриа тодорхой илэрхийлээч ээ гэсэн ийм хоёр асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Бага хурлын хуралдааныг би зарлаж хуралдуулсан нь л бас ийм зорилготой байсан. Та бүхэн мэдэж байгаа.

Олон талаас нь асуудлыг ярья. Ганцаараа шийдвэр гаргах шиг амархан юм байхгүй. Яг суурь асуудал нь юу юм бэ гэж бид ярьсан. 11 цаг. Тийм ээ. 11 цаг хуралдсан. 11 цагийн дүгнэлтийн дараа суурь асуудал бол бас ийм томоохон гомдлууд, орон нутаг, ингээд парламентын гишүүдийн дунд үүсжээ гэдэг нь ойлгомжтой л болсон. Ойлгомжтой болсон. Суурь шалтгаан энэ байна гээд.

Бага хурлын гишүүдийн хувьд Та намын дарга, Ерөнхий сайдын хувьд яаран шийдвэр гаргаж болохгүй шүү гэдэг ийм зүйлийг надад маш их олноороо хэлсэн.

Тийм учраас би өнөөдөр парламент дээр ч гэсэн нээлттэй ярьж байгаа нь миний хувьд үзэл бодол, идеологийн хувьд бууж өгөхгүй ээ гэж бодож байгаа. Тэр нь юу вэ гэхээр би хамтраад засаглах нь энэ цаг үед зөв өө гэж бодож байгаа.

Мэдээж үүнийг хүлээн зөвшөөрөхгүй том асуудал үүссэн байна гэж үзэж байгаа. Л.Оюун-Эрдэнэ байх, үгүй нь тэр нэг их тийм чухал асуудал биш гэж би бодож байгаа. Цаашдаа энэ улс орны өмнө тулгамдсан асуудлуудыг айхтар маргалдахгүйгээр шийдээд парламентын засаглал бүрэн бүтэн байх нь нэг номерын эрх ашиг гэж бодож байгаа.

Тийм учраас л итгэл үзүүлэх энэ асуудлыг хөндсөн юм. Яагаад гэхээр Бага хурал бол та бол ажлаа өгч болохгүй ээ гэдэг ийм зүйл дээр маш хатуу. Над руу ч манай Бага хурлын гишүүд, орон нутгийн удирдлагууд маань бүгдээрээ л бичиж байгаа.

Тийм учраас миний хувьд парламентаар шийдүүлэх нь зүйтэй юм гэдэг шийдэлд хүрсэн. Итгэл үнэмшил дээрээ хатуу итгэл үнэмшилтэй байна. Тэр нь юу вэ гэхээр хамтраад асуудлуудаа шийдвэрлээсэй гэдэг энэ идеологи битгий бөхөөсэй гэж бодож байна. Яг өөрөө хэллээ. Бид Үндсэн хуультай, эрх зүйт төртэй ард түмэн. Бидний итгэл найдвар юу гэхээр ирээдүйн хөгжил, ирээдүйн асуудлаа шийдэх чадамж битгий алдраасай, зөв дүгнэлттэй үлдээсэй.

Өнөөдөр одоо энэ асуудлыг миний хувьд заавал ингэж ил тод ярихгүй байж болно. Гэхдээ энэ нь өөрөө парламентын гишүүдэд, Монголын ард түмэнд сургамж болох нь зүйтэй, дүгнэлт болох нь зүйтэй, мэдээллийг өгөх нь зүйтэй

гэдэг агуулгаар Бага хурал дээр ч гэсэн, энд ч гэсэн ингэж хандаж байгаа нь зүйтэй юм.

Санал нэг байна. Тэр нь юу вэ гэхээр нийгэмд бид олон сегментүүд байна. Тийм л учраас бид энэ сегментийг оруулж ирэхийн төлөөлөл пропорционал тогтолцоо хийсэн. Анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл парламентад орж ирсэн, багш нарын төлөөлөл орж ирсэн, хуульчдын төлөөлөл орж ирсэн, олон экспертүүд орж ирсэн. Одоо энэ төлөөллийнхөө үүргийг бид хийж, нийгмийн консенсус буюу зөвшилцлийг л үүсгэх ёстой. Энэ бол өөрөө 126-тай парламент.

Энэ механизмаа бид илүү ажиллуулах тийм шаардлага байна. Нийгэм, цахим ертөнц, технологи, хиймэл оюун ухаан гээд маш их өөрчлөгдөж байна. Энэ хурдыг Монгол Улсын төр өөрөө гүйцэхгүй байна.

Парламентын хувьд шинэчлэл болчихлоо. Төрийн анхан, дунд шатад шинэчлэл болох, шүүх дээр шинэчлэл болох ийм олон асуудлууд бидний өмнө тулгамдсан асуудал болж байгаа нь ойлгомжтой байна гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Хоёр дахь асуулт. Тодруулж асуух уу? Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хоёр дахь асуулт дээр ёс зүйн хариуцлага, хууль зүйн хариуцлага, улс төрийн хариуцлага гурав дээр Та байр сууриа илэрхийлээч ээ гэсэн.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ёс зүйн хувьд хэрвээ орлогоо нотолж чадахгүй бол энэ огцрох нь зүй ёсны асуудал. Гэхдээ энд нотлогдохгүй байгаа орлогын асуудал огт байхгүй.

Тийм учраас үүнийг би 23-тай манай хүүхэд хүнд хайр сэтгэлтэй болоод бөгж бэлэглэснээс болоод. Бусад нь бүгд худлаа. Энэ цагийн явцад удахгүй тодорхой болно.

Тэгэхээр үүнийг ёс зүйн хувьд мэдээж бухимдуулсандаа би уучлалт гуйж байгаа. Хүүхдэдээ цаг гаргаагүй нь аав хүний буруу байж магадгүй. Гэхдээ энэ бол аль ч нийгэмд амьдарч байгаа 23 настай залуу хүнд хайр сэтгэлтэй болоод бөгж авч өгөх нь энэ ёс зүйн асуудал биш гэж бодож байгаа. Энэ бол хайр сэтгэлийн асуудал.

Улс төрийн хувьд би өнөөдөр... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Улс төрийн хувьд Монгол Улсын Засгийн газар парламент дээрээ асуудлаа ярьдаг. Тэгээд шаардлагатай бол хариуцлага тооцуулдаг байх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тэгэхгүй бол энэ цааш цаашдын тогтвортой байдалд их нөлөөлнө өө. Би энэ агуулгыг ярьж байгаа.

Улс төрийн хувьд мөн би Бага хурал дээр энэ асуудлыг ярьдаг нь ганцаараа шийдвэр гаргахад хэтэрхий хүнд асуудал байна.

Тийм учраас хамтын шийдэл гаргах нь зүйтэй. Тэр дундаа парламент энэ асуудлыг өөрөө шийдэх нь зүйтэй юм л гэж үзэж байгаа. Ерөнхий сайдын хувьд юу вэ гэхээр би итгэл үнэмшилдээ одоо ч хатуу хэвээрээ байгаа. Тэр нь юу вэ гэхээр энэ шийдвэрээс болоод нийгэм, эдийн засгийн байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлт ухарчихвал яана гэж би айж байгаа.

Тийм учраас өнөөдөр би энд Та бүхний асуултад хариулаад сууж байгаа. Түүнээс өргөдлөө өгөх шиг амархан зүйл байхгүй.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Оройн мэнд.

Ардчилсан нам гэрээгээ огт зөрчөөгүй шүү. Харин ч гурван намын хамтарсан, байгуулсан энэ гэрээг эрхэмлэн дээдэлж, ажил хэрэг болгох, түүнийхээ төлөө манай сайд нар цаг наргүй сайн ажилласан.

Би харин нэг зүйлд итгэлтэй байна. Монгол Ардын намын Бага хурлын 303 гишүүн энэ гэрээг уншиж дүгнэлт гаргасан гэдэгт итгэхгүй байна. Эхнийх нь.

Хоёрдугаарх нь, хамтарсан Засгийн газар “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гээд мөрийн хөтөлбөрөө батлаад маш олон том бүтээн байгуулалтын ажлуудыг нэгэн зэрэг шуурхай эхлүүлсэн. Одоо эхэлсэн байгаа 5-ынх нь 4 нь жишээ нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр байна. 1 нь Байгаль орчны яамны сайд дээр байна.

Тэгээд би бас энэ чуулганы асуудал. Манай сайд нар засгаас гарч байгаа учраас би сайд нараа магтмаар байгаа юм.

Ардчилсан намаас томилогдсон 8 сайд үнэхээр сэтгэл зүрх, бие хаа, чадал, оюун ухаан бүх зүйлээрээ тултал явсан шүү. Яагаад гэхээр 14 мега төсөл дээр 15, 16 жил гацсан төсөл ч байна, Эгийн голын усан цахилгаан станцын 60 жил гацсан төсөл ч байна.

Энэ бүгдийг өмнө нь яадаг байсан бэ гэхээр бие биеийнх нь нэрээр овоглоод, жадлан эсэргүүцээд, энэ төсөл явах юм бол тэдний тал томорно, энэ

төсөл явах юм бол тэдний талын нэр хүнд өснө гэдэг байдлаар маш ихээр улс төржөөд энэ төслүүдийг гацаадаг байсан байдал энэ Засгийн газарт байгаагүй. Тийм ч учраас 11 сарын хугацаанд хамтарсан Засгийн газар үнэхээр ажлыг хийж чадсан.

Тэгээд ер нь цаашдаа ч ийм байх байх гэж ер нь ойлгож байсан. Ер нь томоохон төсөл, хөтөлбөрүүдийг явуулахын тулд хамтарч байсан тохиолдлууд ч манай урьд урьдын Засгийн газрын түүхэнд байна.

Мөн Баялгийн сан ярьдаг, Ирээдүй өв сан ярьдаг. Баялгийн тэгш бус хуваарилалтыг ярих үед Засгийн газрууд огцордог ч бас ийм түүхүүд байна.

Тэгээд бид өмнөх түүхүүдээсээ сургамж авах ёстой. Уг нь. Тэгээд харамсалтай нь дахиад ийм юм боллоо л доо. 6-хан сарын настайд Засгийн газар хүртэл хоёр, гурван удаагийн байж байсан тохиолдол байгаа шүү дээ. Энэ ерөөсөө улс төржилтөө давахгүй унадаг байсан гэсэн үг.

Тэгээд яах вэ, сүүлийн үед ярьж байна. Яагаад сайд нар ярьж байна вэ. Жишээ нь, манай Хяналт үнэлгээний сайд Э.Одбаярын газраас Дархан-Уул аймгийн сүүлийн 4 жилийн тендер, худалдан авалттай холбоотой бүх баримтын шалгалт хийж гаргасан юм билээ. Тэгээд 64 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн юм билээ.

Тэгээд тэр акт бичгээ Дархан-Уул аймгийн иргэдийн Хурал нь иргэдийн Хурлаар хэлэлцүүлдэггүй. Ийм асуудлууд их байна л даа. Бас их олон байна л даа. Тэгээд энэ бас магадгүй Монгол Ардын намын Бага хурлын гишүүдийн дургүйг хүргэсэн байх л даа. Тэгээд үзээгүй гэрээн дээрээ дүгнэлт хийсэн байх гэж би бодож байгаа юм.

Би Монгол Ардын намын Бага хурлын 303 гишүүнийг 300 гурвуулаа энэ хамтарсан Засгийн газрын гэрээг үзээд л “а”, “б”-гүй дүгнээд л байсан гэдэгт бүр итгэх ч үгүй байна. Бараг царайг нь ч хараагүй байгаа.

Тэгээд гурван намын улс төрийн шийдвэр гарсан байхад нь нэг намынх нь Бага хурлын гишүүд нь нийтээрээ хэлэлцээд сүүлдээ улс оронд тогтворгүй байдал, эргэлзээтэй байдал, мөн цаашид ойлгомжгүй байдлуудыг бий болгож байна л даа. Тэгээд одоо үүнийгээ өнөөдөр нэг талтайгаар эцэслэгдэх байх.

Гэхдээ ер нь цаашдаа юу ч болсон бид энэ улс орон чинь хөгжмөөр байна, урагшаа явмаар байна, алхмаар байна, том том төслүүдээ хөдөлгөмөөр байна, түүний төлөө ажил хиймээр байна шүү дээ. Ийм байдлаар нэг талын асуудалд хэт хандаж болохгүй ээ гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгээд ер нь бид нарт одоо тогтвортой, тодорхой, ойлгомжтой байдал хэрэгтэй байгаа шүү дээ. Тийм байж гадна, дотнын хөрөнгө оруулагчтай хамтарна. Тийм байж гадна, дотнын улс орнуудтай бид байгуулна.

Өнгөрсөн хугацаанд Орано явлаа, Гашуунсухайт явлаа, Эгийн гол явлаа. Бас л бид чамлахааргүй ажилласан шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь оройн мэнд хүргэе.

Тэгэхээр бүгдээрээ энэ том асуудал боллоо. Олон талаас нь нухацтай ярьж байна. Аль болохоор давтахгүйг хичээе гэж бодож байна.

Би өөрөө иргэний нийгмийн байгууллагад, олон улсын байгууллагад олон жил ажилласан хүн. Тэр утгаараа “САЙН ЗАСАГЛАЛ”-ын асуудлыг хөндмөөр байна.

Ээлжит бус хурал 8 сард өнгөрсөн онд болсон. Тэр үед эдийн засгийн тэлэлт ярьсан, 14 мега төсөл ярьсан, том том зорилго тавьж ярьсан. Ерөнхий сайдаас асууж байсан. Санаж байгаа бол. Итгэлцэл, олон нийтийн, иргэдийн итгэл маш доогуур болсон. Судалгаагаар Та хэнд итгэдэг вэ гэсэн. Ойрынхоо хамаатны хэдэн хүнд цөөн хэдэн найз нөхдөдөө л итгэдэг буюу

- ▶ улс төрийн намуудад итгэдэггүй,
- ▶ төр, засагтаа итгэдэггүй,
- ▶ шүүх засагтаа итгэдэггүй

гэдэг судалгаануудын үр дүн гараад байсан учраас хамгийн түрүүнд ийм том зорилгыг биелүүлэхэд ард олны итгэл чухал шүү, итгэлийг бий болгоход анхаараарай гэж нэг хэлсэн.

Хоёрдугаарт, дараа нь нэг чуулганы үеэр 126 гишүүний түүхэндээ бахархалтайгаар үлдэх нэг том ажил нь авлигаас салах гэж хэлсэн.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ авлигаас сална гэдэг ийм том уриатайгаар сүүлийн олон жилүүдэд сонгогдоод ажилласан гэж үзэж байгаа. Гэтэл бид эргээд харсан чинь тэр ямар нэгэн байдлаар өнөөдөр итгэлийг сэргээх байтугай алдагдсан байсан тэр итгэл дээр бүр нэрмээс боллоо шүү дээ. Зөвхөн Ерөнхий сайд, Засгийн газар биш энэ 126 гишүүд ч гэсэн хамтаараа живж байна.

Тэгэхээр яагаад ийм байдал болов. Тэр үеэ сануулж хэлсэн ноцтой сайн анхаарахгүй яав гэж харамсаж байна.

Хоёрдугаарт, нэгэнт нэг нөхцөл үүслээ, кэйс үүслээ. Залуучууд гадаа 21 хоног жагссан байна шүү дээ. Тэгээд орлогоо нотолчихоо гээд гишүүд ч гэсэн саналаа хуваалцсан. Аль болохоор л энэ том зорилгыг дэмжихийн төлөө явсан.

Яагаад цаг хугацаа алдав аа? Хугацаа алдана гэдэг чинь нөгөө талдаа итгэл улам алдарна. Алдагдсан боломжийн өртөг буюу үнэ зардал илүү өснө өө гэсэн үг. Энэ тал дээр хариулт авъя.

Хоёрдугаарт, онолоороо нэг ийм зүйл байна. Итгэлцэл ярихын тулд тогтвортой Засгийн газар гэж юу вэ? Тогтвортой Засгийн газрын тэр шинж чанарыг агуулахын тулд олон хүчин зүйлс яригдахын нэг нь PUBLIC TRUST, олон нийтийн итгэл, итгэлцэл. Яг миний яриад байгаа зүйл байхгүй юу.

Олон нийтийн итгэлцлийг яаж бий болгодог юм бэ? Итгэлийг яаж бий болгодог, үргэлж авч явдаг вэ гэхээр “САЙН ЗАСАГЛАЛ”. Сайн засаглал гэж яг юуг хэлж байгаа вэ гэхээр

- ил тод байдал,
- хариуцлага хүлээх чадвар,
- хуулиа дээдлэх ёс.

Тэр байх тусмаа иргэдийн итгэлийг татдаг гэж байгаа юм. Энэ дээр л түрүүний миний хэлсэнтэй холбоотой энэ асуудлыг хөндөөд, хариулт авмаар байна.

Хоёрдугаарт нь, би бас хэлмээр байгаа юм. Ирээд ирц бүрдүүлэх бол өөр. Гараад явах бол өөр. Янз бүрийн энэ системээ мэдэж байгаа.

Энэ чухал асуудал дээр ирэхгүй байгаа, ирц бүрдүүлэлт дээр анхаарах. Байнгын хороодын, ажлын хэсгийн хурлууд, чуулганы асуудал байгаа гэдэг энэ асуудал дээр би санал нэг байгаа.

Гуравдугаарт, улс төрч болно гэдэг бол маш их зориг. Бүх юм нүдэн дээр. Сайн, муу улс төрчдийн ч нүдэн дээр, иргэдийн ч нүдэн дээр.

Тэгэхээр үнэн байна гэдэг бол зориг. Зоригтой байхын цаана хүн өөрөө үнэн байх ёстой. Юу гэдэг юм. Зорилго нь нийтийн төлөө байх ёстой. Үүнийг иргэд сайн олж хараарай. Түүнээс Пи Араар, сошиалаар гоё үг бичдэгт хууртаж болохгүй шүү залуучууд минь.

Гадаа байгаа залуус дотор миний ч гэсэн итгэдэг залуучууд байгаа. Намайг ч гэсэн өдөр тутам... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Яах вэ, энэ орлого нотлохтой холбоотой асуудлыг би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хэлсэн.

05 сарын 23-нд бүрдүүлээд л Авлигатай тэмцэх газар өгсөн. Хөрөнгө орлогын мэдүүлэг жил бүхэн л бид нэг сард гаргаж өгч байгаа шүү дээ. Түүнийгээ гаргаад ингээд өгсөн.

Энэ бүгдээрээ OPEN DATA болон Авлигатай тэмцэх газрын сайт дээр бүгд л ил байгаа.

Тэгээд 30 хоног шалгадаг юм билээ. Шаардлагатай тохиолдолд 30 хоног сунгадаг юм билээ. Тэгээд дүгнэлт гаргадаг. Тэр нь хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлыг хийгээд явдаг.

Би уулзсан. Хүүтэйгээ. 17 сая төгрөгөөр бөгж авч өгсөн нь үнэн. Тэр материал нь Авлигатай тэмцэх газар дээр очсон байгаа. 500 мянган төгрөгөөр бугуйвч авч өгсөн. Найз охин нь бие давхар болсон. Түүнд сэтгэл хөдлөлтэй хандсан. Ийм л зүйл болсон.

Аав, ээжтэй нь уулзаж амжаагүй явж байгаа. Яах вэ, энэ асуудлууд нэг талдаа гарсны дараа бас нэг уулзъя л гэсэн ийм бодолтой байж байна. 23 настай ийм залуу.

Тэгэхээр энэ зүйлүүдийг яах вэ, би тайлбарласан. Зүгээр юу вэ гэхээр нэгэнтээ ийм нягтлан шалгах ажил явж байгаа учраас урдуур нь ороод хэвлэлд яриад ингэсэн тэгсэн гээд яриад байх нь зохимжгүй болов уу л гэж би бодсон. Яагаад гэхээр тэр чинь хараат бусаар асуудлыг шийдвэрлээд, өөрөө тэр байгууллага шалгаж мэдээлэх тухай ийм л асуудал. Тийм байна гэдгийг хэлье.

126 гишүүнтэй холбоотой итгэл найдварын асуудал. Үнэн үнэн. Мэдээж бид ковид, дайн, тэгээд тариф гээд. Одоо Та бүхэн мэдэрнэ. Нөгөө муулаад байдаг нүүрсний үнэ буураад эхлэхээр экспорт доголдоод, төлбөрийн тэнцэл хүндрээд, ханш алдаад нийгмийн бухимдал өсдөг.

Тийм учраас ийм асуудал эдийн засгийн хувьд бид нарт ирж байгаа юм.

Тийм учраас ийм үед бид бүр л илүү нэгдмэл, бүр л илүү нягт байж байж л давж гарна. Би их талархдаг. Ковидын үед би ажиллаж байсан. Тухайн үед хил хаалттай. Бас л нэг ийм төвөгтэй үе байсан. Инфляц дээшлээд ирэхээр аяндаа жагсаал болдог.

Тэр үед Монгол Улсын төр маш нэгдмэл байсан. Маш нэгдмэл байсан. Тэгж байж тэр цар тахлын түвэгтэй байдлыг давж байсан.

Одоо олон улсын нөхцөл байдал. Сая С.Бямбацогт сайд хэллээ. Маш их адармаатай болж байгаа. Энэ үед Монгол Улсын төр илүү л нэгдмэл байхыг шаардаж байгаа. Гадаад нөхцөл байдал.

Харамсалтай нь бид өнөөдөр илүү тийм салангид, илүү хагаралтай байх ийм л асуудал. Тийм ч учраас үүнийг шийдүүлэх нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм.

Дараа дараагийн асуудлууд дээр бид шуурхай ярилцаад явах нь зүйтэй. Яах вэ, мэдээж би улс төрийн намын удирдлагуудтай уулзсан. Энэ тарифтай холбоотой ч юм уу, энэ асуудал дэлхий дээр тодорхойгүй байх үед би хамтраад явах нь зөв өө л гэдэг тийм байр суурьтай байгаа. Одоо хүртэл.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яах вэ, зүгээр хэлэх гэж байгаа санааны эхэнд гол санаагаа хэлье гэж бодож байна.

Өнөөдрийн Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлыг ил тодоор санал хурааж өгөөч ээ гэдэг зарчмын саналыг гишүүд маань дэмжээсэй. Үүнийг горимын санал гаргаж, янз бүрийн байдлаар нууц санал хураалт, цаасаар ч гэдэг юм уу ийм зүйл рүү битгий оруулаарай.

Үндсэн хуулийн 41 дүгээр зүйл дээрээ илээр хураахаар байгаа шүү. Үндсэн хууль дээр илээр хураахаар бичсэн байдаг юм. Өөрөөр хэлэх юм бол Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх уг асуудлыг нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуулийнхаа агуулга, зарчмын дагуу шийдье. Үндсэн хуульд зааснаас өөрөөр шийдэх юм бол энэ харин цаашдаа үр дагаврын хувьд өөр зүйл рүү явна шүү.

Сая Төрийн байгуулалтын байнгын хороо энэ асуудлаа, дэгээ унших ёстой байсан. Энэ Үндсэн хууль дээр заасан зүйлийг нууц санал, горимын санал гаргаж байгаад нууцаар хураалгаж байгаа байхгүй юу. Буруу шүү дээ. Үндсэн хуулиас давсан дэгийн хууль гэж байхгүй. Би үүнийг бүр хатуу анхааруулж хэлмээр байна.

Тэгээд юу гэж бодсон гэхээр энэ Их Хурал дотор орж ирээд, энэ дотор зоригтой байгаад, шударга байгаад ёстой Монгол Улсыг хөгжүүлэхийн төлөө бүх юмаа хийгээд говьдоо ус татаад, говийн ард түмнийг баярлуулаад ингээд явчихна гэсэн чинь 30 гэр бүл биш 3-хан гэр бүл л байдаг юм байна.

Эм Си Эсийн Ж.Оджаргал, Ж.Од бусад гэж. Одоо яг энэ хүмүүс энэ Засгийн газрын аминд хүрч байгаа юм л даа.

Ер нь баялгийн төлөөх дайн явагдаж байгаа юм. Ж.Наранцацралтын Засгийн газар, Н.Алтанхуягийн Засгийн газар мөн л ингэж өрлүүлж байсан.

Тийм учраас энэ дээр нэгдүгээр зүйлийг хэлье.

Хоёрдугаарт, манай Ардчилсан намын бүлгийн улс төрийн байр суурь, шийдвэрийг ойлгож байна. Тэгэхдээ дэгийн тухай хуулийн 7.5 дээр Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудлыг хэлэлцсэн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэнээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг, гишүүд хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно гэдэг заалт байгаа.

Ямар нэгэн байдлаар орж ирээд энэ дэгийн хуульдаа захирагдаж шийдвэрээ саналаа өгөөсэй гэж бодож байгаа юм. Дэмжих, дэмжихгүй нь тусдаа асуудал. Хэдүүлээ яах вэ улс төрийн соёлын хувьд зөв болов уу гэж бодож байна.

Тийм учраас эхний байр сууриа тодотгоод, Үндсэн хууль дээр заасан илээр хураалгах энэ саналыг дэгийн тухай хуулиар Үндсэн хуулийн заалтыг гажуудуулж нууц санал хураалт руу оруулж болохгүй гэдэг заалтыг би хуульчныхаа хувьд хэлмээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Ерөнхий сайд нарыг харахаар их хэцүү юм. Яах вэ, илжиг нэг зодуур даадаг, ачаа даадаг гэдэг шиг л байдаг хүмүүс юм байна. Зарим нь ч яах вэ зодуураа даахгүй тэгээд ажлаа өгдөг. Аргалж байгаад нэг жоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гэж үздэг. Тэгээд шантардаг, хаядаг л юм билээ.

Маш олон мега төслүүд гэж нэрлээд байгаа. Сүүлдээ ч үүнээсээ уйдаж байх шиг байна.

Ер нь Монгол Улсын хөгжлийн төслүүд гээд нэрлээ. Хөгжилд боомилчхоод байгаа, гацаачхаад байгаа төслүүд хэн нэг сайдын сейфэнд, тоосон дараатай байсан зүйлүүдийг өнгөрсөн 4, 5 жил хөдөлгөсөн юм.

Би яагаад үүнийг баттай хэлээд байна гэхээр би өөрөө бас энд мэргэжилтнээс нь эхлээд төрд зүтгэж байгаагийн хувьд энэ дээр итгэл найдварыг нь даагаад, магтаал, шүүмжлэлийг нь сонсоод зүтгэж явсан хүний хувьд хэлж байгаа юм.

Өнөөдөр би 40 настай гэхэд 1984 оноос хойш эрчим хүчний төсөл нэгийг ч хөдөлгөөгүй байсан юм шүү дээ. Харамсалтай нь. Тэгээд Монгол Улсын хөгжлийг ярих бололцоогүй. С.Цэнгүүн гишүүнтэй нас чацуу ураны төслийг ярилаа шүү дээ. Хэдүүлээ. Энэ парламент. Та нар тэгээд л бод.

Би тэгээд гишүүдэд нэг зүйлийг хэлмээр байна. Нэг их итгэл найдвар алдах гээд байгаа зүйл ерөөсөө байхгүй шүү. Энэ ерөөсөө тийм сигнал, мессежийг бид өгөөгүй. Хэн ч өгөөгүй гэж бодож байна. Монгол Улсын хөгжил итгэл найдвар алдаагүй хэвээрээ. Харин бид хэдийн зүгээр доороо хий эргэсэн цаг хугацаа л жоохон уртсах гэж байна.

Тэгээд хүрч чаддаггүй. Асуудлыг аваад Улсын Их Хурлын чуулган дээр дэнс хагалуулаад, дэнсэн дээр тавьж байгаад хагалаад шийдвэрээ гаргуулж чадах ийм хэмжээний улс төрийн эр зориг, ад үзэгдэх гэдэг юм уу. Заримдаа магадгүй хожим нь энэ LEGACY болж үлдэнэ. Тухайн цаг үе дээрээ энэ ад үзэгдэх тийм хэмжээний байдаг.

Үүнийг бариад ороод ирэх улс... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: П.Сайнзориг гишүүнд 1 минут.

П.Сайнзориг: Ийм шийдвэр гаргах Ерөнхий сайд ховор байх.

Тэгээд би яах вэ, нэг их долигоноод байгаа юм биш. Дараагийнх нь тэгээд болчихоогүй байна. Тэгэхдээ зүгээр та хэдийн кнопоор шийднэ. 126 гишүүн маань. Энэ дээрээ бодолтой өгөөрэй.

Хоёрдугаарт, ерөнхийдөө татвар, нийгмийн даатгал, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, төрийн албаны реформууд үндсэндээ улс төрийн намууд ойлголцож чадахгүй бол хэцүүднэ.

Тэгээд 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлт бол бид хуулийг 50 дээр нэмэх нь 1 гэдэг квотоор батална гэдэг бол баруун, зүүн жигүүрийн намууд буюу энэ танхимд сууж байгаа намууд хамтрахаас өөр аргагүй байдал руу оруулсан юм.

Ингэж олонхын засаглалыг цөөнхдөө барьж өгдөг Үндсэн хуулийн заалтыг би тухайн үедээ эсэргүүцэж, хууль зүйн үр дагаврыг нь хэлж байсан юм.

Органик хуулийг 66 хувиар баталж болох боловч ердийн хуулиудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор баталж байх ёстой юм. Энэ заалтыг эвдэж байгаа нь парламент ёсоо эвдэх гэж байгаа шүү гэдэг зүйлийг би хэлж байсан. Тэгээд ийм учраас энэ удаагийн индэр дээрээс протоколд энэ үгийг үлдээж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Анх энэ Засгийн газрыг байгуулахад анхнаас нь дэмжиж байсан хүн.

“ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэдэг нэр орж ирэхэд ямар ч сүржин нэр юм бэ дээ гэж бодож байлаа.

Одоо бол энэ яг оносон нэр байж л дээ. 30 гэр бүл гээд л бид ярьдаг байлаа. Сүүлийн 15 жил ярьж, бичиж, үүний төлөө мөн ч их нэвтрүүлэг хийж явсан хүн дээ.

Том төслүүд хөдөлж байсан. Баяртай байсан. Дахиад цаашаа явах байсан. Баялгийн санг 18 жил гацсан. 2007 онд Улсын Их Хурлаар батлагдсан тогтоолыг өнөөдөр хэрэгжүүлэх гээд оруулаад ирсэн.

Гашуунсухайт, Ганцмодны хил дамнасан төмөр замыг холбох гээд Монголын төрийн өмнөөс Хятадын компанитай очиж найраа хийж байсан “Энержи Ресурс” компанийг илрүүлсэн. Шууд зарласан.

Энэ бүхний өсөнд Монголын төрөөс яасан ч их өс авч ханадаггүй юм. Яасан ч их дуусдаггүй юм.

Тэгээд Ерөнхий сайдаас нэг асуулт байна. Төрийн дээр нам байна гэж бид их олон жил ярилаа. Залуу халуун наснаасаа ярьж, бичиж явлаа. Дахиад нөгөө төрийн дээр чинь нам шийдвэрээ гаргалаа. Ардын намын Бага хурал. Ардын намын Бага хурлын шийдвэрийг өнөөдөр энд хэлэлцээд сууж байгаадаа гутаж байна.

Гэхдээ шууд огцроогүй. Өнөөдөр энд оруулж огцрох эсэх, итгэл үзүүлэх асуудлаа оруулж ирж байгаа хүний хувьд Танаас асууя “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” чинь хэвээрээ үлдэх үү?

Хэрвээ танд итгэл үзүүлэх юм бол Та Монголын ард түмний өмнө амлаж байсан энэ том олигархуудтай үүсгэсэн дайн аа, тэр Ухаахудгаа, тэр Цагаан суваргаа энэ олигархуудын савраасаа тавихгүй байсан баялгийн төлөөх дажинд Та ялалт байгуулах зориг чинь хэвээрээ юу? Энэ байр сууриасаа ухрах уу?

Итгэл үзүүлэхгүй ээ гэх юм бол Та яах вэ?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Би сая хэлсэн үгэндээ дурдсан. Тийм ээ.

Тэр нь юу вэ гэхээр ялалт ба ялагдал аль аль нь нэг их тийм чухал биш. Гагцхүү үзэл бодол, үнэт зүйлдээ үнэнч үлдэх нь л өөрөө жинхэнэ ялалт юм.

Тэгэхээр яах вэ, мэдээж аль ч шийдвэр гарсан миний хувьд сэтгэл зүй бүрэн бэлэн байгаа. Харин энэ тэмцлээсээ би ерөөсөө ухрахгүй. Ерөөсөө ухрахгүй.

Төрийг худалдаж авсан. Төрийг тэр чигт нь блок үүсгэж контролдсон ийм олон асуудлууд байна. Зарим гишүүд надтай уулзаж байсан. Анх орж ирэхэд ийм зүйл ярихад чинь худлаа байлгүй дээ гэж боддог байсан. Орж ирээд дотроос нь харсан үнэн юм байна гэж байгаа залуу гишүүдтэй би таарч байгаа.

Тийм учраас миний итгэл үнэмшил, миний Монголын нийгэм илүү баялгийн энэ асуудал илүү иргэддээ хүртээмжтэй байх, илүү ил тод байхтай

холбоотой энэ тэмцэл энэ албан тушаалтай тушаалгүй үргэлжилнэ. Энэ бол хувь хүний шийдэл. Хувь хүний шийдэл.

Нэг зүйлийг би зүгээр парламентын гишүүддээ уриалж хэлэх нь зүйтэй. Мэдээж энэ яах вэ уриалж хэллээ гээд бүтэн шийдэгдэхгүйг ойлгож байна. Бид эрх ашгийн эрэмбийг том агуулгаар нь дэнслэх дээр дандаа алддаг.

Тийм ч учраас би Санжаасүрэнгийн Зоригийг нь хэлсэн улсын эрх ашгаа эхэнд нь тавиач ээ, намын эрх ашгийг хоёрдугаарт нь тавиач ээ, хувийнхаа эрх ашгийг гуравдугаарт нь тавиач ээ гэдэг тэр зүйлийг эхэнд нь бичсэн юм.

Яг л энэ дээр бид алдаж байгаа юм. Яг л энэ дээр алдаж байгаа юм. Жижиг сажиг томилгооны асуудал. Сайд болсон хүн нь нэг ийм бяраа ороод дуугарахгүй байгаад байгаа ч юм шиг алхаа гишгээ. Тэгээд эд нар чинь ингээд яваад байвал ингэнэ, тэгнэ гэдэг асуудал. Дараагийн сонгууль, дараагийн намын даргын эрх ашиг. Ийм л зүйлүүд нэгдэж байгаад мэдсээр байж энэ асуудлаа зогсоох түвшинд хүрсэн.

Тэгээд үүнийг бид эрэмбэлэхгүй бол яах вэ, нэг удаа асуудал ингээд шийдэгдчихнэ. Дараагийн удаа энэ асуудал чинь яг хэвээрээ л байж байна. Дахиад л дараагийн сайд нар чинь дургүй хүрмээр харагдана. Дуудахад нь ирэхгүй байна. Ингээд л дахиад л асуудал болно. Ингэж явж байгаад яах вэ гэхээр бүхэлдээ төрийн нэр хүнд, парламентын засаглалын нэр хүнд, намуудын нэр хүнд унана. Энэ нь өөрөө одоо тийм том засаглалын хямралыг авчирч бас болзошгүй.

Тийм учраас эрх ашгаа эрэмбэлэх зүйл дээр одоо бид, ялангуяа 126-тай парламент илүү их тийм дүгнэлттэй байгаарай. Би залуу парламентын гишүүдтэй ч гэсэн уулзах болгондоо л учирлаж хэлдэг зүйл нь энэ.

Яах вэ, миний нэг зовлон байх шиг байгаа юм. Нэлээн залуудаа Ерөнхий сайд болсон. Одоо ингээд үеийнхэнтэйгээ уулзахаар үгүй ээ, одоо чи чинь надаас насаар л насаар ах биз дээ. Яагаад учиргүй сургаал айлдаад байгаа юм гээд. Нэг ийм асуудлууд болж байгаа юм. Үнэн. Манай үеийнхэн одоо л парламентад орж ирж байна.

Гэхдээ үүнийг би хэлэх үүрэгтэй. Тэгж байж бид илүү их тийм том агуулгаа харахгүй бол жижиг... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Болох уу. Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан:

► Баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх гээд,

- Монгол хүн орлоготой болох гээд,
- Монгол хүн баялагтаа эзэн суух гээд,
- Монгол хүн хийж бүтээдэг болох гээд,
- Монгол хүн хаанаас ч асуухгүй шийдвэр гаргах

болоод ирэхээр ингээд засгаараа тоглодог.

1996-2000 онд 4 Засгийн газар огцорсон. Нууцаар санал хураадаг байсан. Тэгээд үүнийг болиулсан юм.

Тийм учраас нууцаар санал хураана гэдэг бол хуйвалдаан л гэсэн үг. Итгэл үнэмшил нь байхгүй гэсэн үг.

Тэгээд энд байгаа эрхэм гишүүдэд сануулж хэлэхэд бид яг энэ индэр дээр тангараг өргөхдөө аль нэг намын дүрэм дээр гараа тавьж тангараг өргөөгүй шүү. Бид Монгол Улсын Үндсэн хуульд, Монгол Улсын улсын төрийн тугт Монголын ард түмний эрх ашгийг дээдэлнэ гэж тангараг өргөсөн.

Тийм учраас тангаргаа санаад энд шийдвэр гаргах эрхэм гишүүд, төрийн түшээд нэг удаа Монголоо бодож шийдвэр гаргахыг уриалж байна.

Д.Амарбаясгалан: Б.Баасандорж дарга ажлын хэсгийн 1 дүгээр микрофон аваад гишүүдэд Үндсэн хууль зөв тайлбарлах тал дээр анхаарахгүй бол бас буруу тайлбар, ойлголтууд яваад байх шиг байна. 44 дүгээр зүйлтэй холбоотой.

Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Б.Баасандорж. Гишүүдийн асуултад хариулъя.

Түрүүн П.Сайнзориг гишүүн энэ асуудлаар дурдсан.

Тэгэхээр П.Сайнзориг гишүүний хэлсэн зүйл бол энэ Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд ерөнхий зарчмыг тусгасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Гэхдээ Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсвэл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулна. Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг сая би уншлаа.

Ерөнхий сайдтай холбоотой Ерөнхий сайдыг

- чөлөөлөх,
- өөрийн хүсэлтээр огцруулах,
- итгэл үзүүлэх

гэсэн 3 асуудал байгаа.

Өмнө нь Ерөнхий сайдыг бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө 4 удаа “чөлөөлөгдөх” асуудал яригдаж байсан. Бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө 5 удаа “огцрох” асуудал яригдаж, шийдвэрлэгдэж байсан.

Тэгэхээр энэ яг дэгийн тухай хуульд заасны дагуу энэ “чөлөөлөх”, “огцрох” хоёр асуудлыг “илээр санал хураана” шүү гээд дэгийн тухай хууль дээр маш тодорхой заасан байгаа.

Харин “итгэл үзүүлэх” эсэх асуудлыг “илээр хураана” гэж заагаагүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол чуулганы хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд нь олонхоороо “нууцаар хураах уу”, “илээр хураах уу” гэдгээ шийдвэрлэх бүрэн боломжтой.

Сая Төрийн байгуулалтын байнгын хороо үдээс өмнө хуралдахад яг энэ Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн зарчмын дагуу горимын санал гаргаад, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний олонх нь дэмжээд нууцаар санал хураалт явагдсан.

Тэгэхээр энэ дээр Үндсэн хуулийн ямар нэгэн зөрчилтэй зүйл байхгүй болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Оройн мэнд. Ерөнхий сайдаас асуулт асуух гээд байна.

Парламентын гишүүд бид яг юун дээр шийдвэр гаргах гээд байгаа юм бэ? Логикийн хувьд ерөөсөө ойлгомжгүй байна.

Олон нийт орлогоо нотлохыг шаардсан. Ил тод байдлыг хүссэн. Намын Бага хурлаар хэлэлцсэн асуудал хамтарсан засагт Ардчилсан намтай байх эсэх улс төрийн шийдвэр гарсан. Гэтэл Засгийн газрын буюу Ерөнхий сайд таны өргөж оруулж ирсэн тогтоолын төсөл бодлогын дэмжлэг хүсэх дээр итгэл өгөх асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ гурав хоорондоо ямар ч уялдаагүй байгаа.

Тэгэхээр парламент бид өнөөдөр Авлигатай тэмцэх газрын ажлыг хийх гэж биш, орлого нотолж байгаа асуудлыг ярьж байгаа биш, Ардчилсан нам хамтарсан засаг байх гэж байгаа асуудал биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Бид бодлогын дэмжлэг дээр итгэл үзүүлэх гэж байгаа юм байна гэж ойлгож байна.

Гэхдээ бид энэ бодлогын дэмжлэгийг чинь өгөөд л Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаад, түүнийхээ хүрээнд төсвийн хүрээний мэдэгдэл, төсвөө батлаад л явж байгаа.

Тэгэхээр энэ гурван асуудал гурвуулаа хоорондоо хольж хутгагдаж гэж ойлгогдоод байна.

Таны тогтоол дээр “улс төрийн нөхцөл байдлын үүднээс” гэж байгаа юм.

Тэгэхээр та сая өөрөө итгэл хүлээлгэх асуудлыг нээхдээ ярьж байна. Ардчиллын үнэт зүйл, парламентын дархлаа хөндөгдөж байна. Үүнийгээ Та бүхэн бодоорой гэсэн.

Тэгэхээр энэ дөрвөн асуудал боллоо. Энэ дөрвөн асуудал хоорондоо ямар ч логикийн хувьд хоорондоо уялдахгүй, өөр өөр утга санаатай, тодорхойгүй, нийгэмд болон Их Хурлын гишүүд бид бүхэнд тодорхойгүй байна.

Хэрвээ Их Хурлын зарим гишүүдийн ярьж байгаачлан, ялангуяа Х.Тэмүүжин гишүүний ярьж байгаачлан үнэхээр засаглалын төрийн тогтолцооны асуудал хөндөгдөж байгаа юм бол тэр мэдээллийг ил болгох хэрэгтэй.

Тэгэхгүй бол бид парламентын гишүүд юун дээр үндэслэж өнөөдөр итгэл хүлээлгэх, хүлээлгэхгүй асуудлаа ярих ёстой юм бэ?

- Бид өнөөдөр ёс зүйн асуудал яриагүй.
- Бид өнөөдөр улс төрийн шийдвэр яриагүй.

Хэрвээ парламентын дархлаа, парламентын төгөлдөршлийг ярьж байгаа бол Та бүхэн өөрсдөө санаачлан хэрэгжүүлсэн 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, холимог тогтолцоо, салбарын экспертүүд, улс орны макро асуудал, ганц тойргийн төлөөлөгчдөөс илүү улс орны том үзэл бодлыг хангасан энэ боломжийг нээсний үндсэн дээр өнөөдөр бид 5 намын төлөөлөлтэй парламенттай, хамтарсан засагтай, олон ургалч парламентын тогтолцоог бүрдүүлээд олон жил гацсан төслүүдээ явуулаад, анх удаагаа 1992 оноосоо хойш огт хэрэглээгүй Үндсэн хуулийн зүйл, заалтаа амилуулаад олон асуудлуудыг хэлэлцэж байгаа.

Хэрвээ энэ үнэхээр ийм үнэт зүйл, парламент, ардчиллын тогтолцооны үнэт зүйлийг хөндсөн цаад улс төрийн акц байгаа юм бол Та бидэнд яг тодорхой хариулмаар байна.

Бид яг юун дээр шийдвэр гаргах юм бэ? Баялгийн болон бүлэглэлийн асуудал биш. Бид парламентын дархлаа, парламентын төгөлдөршил,

тогтолцооны асуудал яриад байгаа юм уу? Үүнийг тодруулах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол одоо өнөөдөр олон нийт болон гадуур байгаа олонд хүргэгдсэн мэдээлэл дотор таны хариултуудаас хариулт ерөөсөө олж авч чадахгүй байна.

Тэгэхээр яг ямар асуудал байгаа юм? Тогтолцооны хувьд. Үүн дээрээ хариулт авахыг хүсэж байна аа, Ерөнхий сайд аа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Би зарим зүйл дээр яг асуусан асуултын дагуу л хариулж байгаа. Тодорхой.

Энэ үйл явдлууд юу болсон бэ гэхээр нэг дэх өдөр манай бүлгийн хурал болсон. Үүнийг манай намын бүлгийн гишүүд бүгдээрээ мэдэж байгаа. Бүлгийн хурал дээр Ардчилсан намтай холбоотой асуудлууд ийм ийм асуудалд хүрлээ. Энэ дээр улс төрийн шийдвэр гаргах нь зүйтэй гээд нэлээдгүй олон гишүүд нэгдсэн.

Энэ асуудлыг тайлбарлаад, заримтай нь өрөөндөө уулзъя гээд ийм хүсэлтийг тавиад ингээд байж байхад Ерөнхийлөгч бүлгийн хурал руу орж бас тодорхой хэмжээний мэдэгдлийг хийх нь зүйтэй гэдэг зүйл яригдсан.

Тэгээд тэр нь би зохимжгүй байх гэж бодоод орсон. Ингээд олон нийтийн сэтгэл зүй ийм байна. Ажлаа өгөх нь зүйтэй гэдэг ийм байр суурийг илэрхийлсэн.

Мэдээж олон талаас нь ярилцсан. Ажлын хувьд өгөхөд асуудалгүй гэдгээ миний хувьд хэлсэн.

Гэхдээ энэ бол хамтарсан Засгийн газрын асуудал учраас намын Бага хурал дээр ярих нь зүйтэй юм гэдэг ийм шийдлийг гаргасан миний хувьд.

Ингээд бүлгийн уур амьсгал яваад намын бага хурал дээр очсон. 10 цаг ярьсан. Зөндөө л олон асуудлыг ярьсан. Ингэсэн, тэгсэн. Нэг талдаа эрх баригч хамт хийгээд байгаа мөртлөө нөгөө талдаа сөрөг хүчин хийгээд байна. Ингээд ингээд ийм асуудлууд байна гээд.

Үүний өмнө Х.Тэмүүжин гишүүн гарын үсэг цуглуулсан зэрэг асуудлууд болсон. Тэр үед Засгийн газрын гишүүд уулзаж ярилцаж байсан. Тийм зүйлүүд бол байгаа.

Би түүнд нь хамтарсан Засгийн газар яг энэ асуудлыг бид яриагүй ээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх, ард нийтийн санал асуулга хийхтэй холбоотой асуудлыг бид албан ёсоор гэрээнд тусгаагүй.

Тийм учраас энэ дээр санаа битгий зовоо гэсэн. Л.Гантөмөр даргыг Ардчилсан намынхан дахиад Ардын намд Ерөнхийлөгчийн сонгуулийг өгөх гээд байна гэж хардсан юм байна гэж би ойлгосон.

Ингээд ийм асуудлууд болсон. Энэ нь бас нэлээдгүй тийм хардалт янз бүрийн л асуудлууд дагуулсан.

Дээрээс нь тэр Тусгай хяналтын хорооны бас нэг хяналтын ч билүү чиг үүргийн асуудал дээр манай Б.Энхбаяр гишүүн, Х.Тэмүүжин гишүүн хоёр санал зөрсөн.

Ингээд Засгийн газрын хурлын дундуур Төрийн байгуулалтын билүү, Хууль зүйн байнгын хорооны санал хураалт болсон. Засгийн газрын гишүүд хурлаасаа гараад санал хураалт дээр багцалж өгөх асуудлууд болоод анх удаа хамтарсан Засгийн газрын сайд нар нам намаараа багцалж санал өгөхөөс өөр аргагүй байдалд орсон. Энэ нөхцөл байдал байдлыг нэлээдгүй дэвэргэсэн. Байдлыг нэлээдгүй дэвэргэсэн.

Тийм тийм асуудлууд өнөөдрийн яригдаад байгаа ийм асуудлуудын бас нэг ийм ордон дотор явж байгаа хэл амны нэг зүйл болоод байна уу гэж би хувьдаа бодож байгаа юм. Ийм л асуудлууд болсон.

Тийм учраас энэ дээр олон хардалтын асуудлууд байгаа. Ерөнхийлөгчийн ч гэсэн байр суурь олон нийтийн нийтлэг шүүмжлэл өөрөө... /минут дуусав/

Х.Булгантуяа: Минут нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Олонх нь олонх шиг цөөнх нь цөөнх шиг байх шаардлага байна.

Манай Б.Энхбаяр гишүүний хувьд ч гэсэн энэ зарчмыг тавьсан. Ардчилсан нам ч гэсэн ийм шаардлагыг тавьсан юм байна гэж би ойлгосон шүү дээ. Зарим гишүүд нь.

Өнөөдөр ч бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ярьж байна лээ. Тийм ээ. Үүнийг бид бүгдээрээ сонссон. Нэг үгээр хэлбэл олонхыг бүрдүүлэхээд байгаа мөртдөө яагаад хамт засаглаад байгаа юм бэ. Энэ чинь асуудал болоод байгаа юм биш үү. Хяналт тэнцэл алдагдаад байгаа юм биш үү. Цөөнх болоод байгаа юм биш үү гээд ийм зүйл байгаа.

Ерөнхийлөгчийн хувьд надад ах хүний хувиар зөвлөгөө өгсөн. Тэр нь юу вэ гэхээр олон нийтийн уур бухимдалтай байна. Бас нэлээдгүй асуудлууд болж байна. Наадах чинь асуудал болох вий дээ гээд.

Тэгээд цуг хоёр ч удаа уулзсан. Энэ нэлээдгүй тийм янз бүрийн өнцгөөс хардалтууд явсан байгаа. Ийм л зүйл болсон.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж микрофон өгье. Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Тэгэхээр өнөөдрийн парламент бид олон ургалч үзэлтэй, энэ шинэ байгуулагдсан парламентад нь 126 гишүүн Монгол Улсын хууль тогтоох төрийн дээд байгууллага болох Их Хурлын дархлаа, төгөлдөршлийн талаар цаашдын үр дагаварт нь суурилсан санал өгөх гэж, итгэлцэл хүлээлгэх гэж байна гэж ойлгож болох уу? Ерөнхий сайд аа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм учраас би итгэл үзүүлэх саналыг Их Хурал руу оруулж ирэх нь зүйтэй л гэж үзсэн. Үүнээс гарах олон шууд болон шууд бус үр дагаврууд үүсэхийг үгүйсгэхгүй.

Тийм учраас Ерөнхий сайдын хувьд энэ асуудлыг олон талаас нь ярилцаад Улсын Их Хурал өөрөө шийдэх нь хамгийн зөв шийдэл юм л гэдэг агуулгаар оруулж ирж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Шинэ парламент анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал. Энэ удаагийн парламент төлөөллийн ардчилал хэрхэн зөв явж ажиллаж болохыг харуулахаар зорьж байгаа гэж ойлгож байгаа.

Энд бид үйл хэрэг, хууль тогтоох ажлыг үр дүнгээр нь хянаж хэмждэг байх ёстой.

Ерөнхий сайдын хувьд сонгуулийн холимог тогтолцоог хамтран шийдвэрлэж, бусад намуудын Ардчилсан нам, ХҮН намд Засгийн газрыг хамтарч байгуулах санал тавиад намын мөрийн хөтөлбөрийн онцлох заалтуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөө болгон ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

2025 оны төлөвлөгөөг ч бид Улсын Их Хурлаар батлаад өнөөдөр хэрэгжүүлээд явж байгаа.

2026 оны төлөвлөгөөг ч мөн адилхан хамтарсан Засгийн газрын гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөг бид хэлэлцээд батлахаар ажиллаж байгаа.

Олон төсөл, хөтөлбөрүүд явж байна. Жишээлбэл, эрчим хүчний төслүүд, Гашуунсухайтын төмөр зам холболт, худалдааны боомтын нээлт, бүсчилсэн хөгжил.

Миний хувьд салбараа төлөвлөж орж ирсэн хүний хувьд хөдөө аж ахуйг эдийн засгийн эргэлтэд оруулах томоохон төслүүд гараан дээрээ ирсэн байна.

Эдгээр төслүүдээ бид шийдэмгий хэрэгжүүлмээр байна. Үр дүнг нь хармаар байна. Гадна, дотнын хөрөнгө оруулагчдад тодорхой байдлыг бид бий болгож, амлалтаа биелүүлдэг баймаар байна. Бид овоо зоригтой эхэлсэн томоохон төслүүдээ хэлэлцээр хийж дуусаад л Засгийн газрыг огцруулдаг нэг муу жишигтэй боллоо.

Сүүлийн 20 жил бид Засгийн газар 1.5-аас 1.7 жилийн л настай байна. Бид ажилд ороод 6 сар болоход нэг учраа олдог шүү дээ. Гэтэл учраа олоод яг ажил руугаа орох гэж байтал Засгийн газар нь тардаг.

Ийм тогтворгүй засагтай байхад бид яаж хөдөө орон нутгийг ажлын байртай, орон нутгаа эрчим хүчээр хангасан, худалдаа арилжаа цэцэглэсэн, утаа, гэр хорооллоосоо салах юм бэ? Энэ богино настай Засгийн газар явж ирснээр иргэдийн амьдрал яг ер нь яаж сайжирсан юм? Үүнийг бид ерөөсөө ярихгүй байгаа байхгүй юу.

Ямар том төслүүд ер нь яг хэрэгжсэн юм? Сүүлийн 20 жил. Яг тодорхой хэл л дээ.

Одоо эрчим хүч гэдэг чинь бидний цусны эргэлт. Зөндөө ярилаа. Үгүй ээ, тэгээд эрчим хүч чинь зогсоод ирэх юм бол бид яах юм бэ? Өрх бүрт эрчим хүчний хомсдол байхгүй, эрүүл мэнд, боловсрол байхгүй, эмнэлгүүдийн амь насыг аврах өнөөдөр амь тэмцэж байгаа хүний амь эрсдэх аюултай. Төмөр зам ч үгүй, аж үйлдвэр ч үгүй, худалдаа наймаа ч байхгүй. Цаашлаад бид үндэсний аюулгүй байдлын асуудал хүртэл хөндөгдөж байгаа.

Тэгэхээр энэ ардчиллын нэр барьсан үймээн самуун ерөөсөө л улс орныг л доройтуулдаг. Хэрвээ жагсаал эмх замбараагүй байдалд хүрэх юм бол энэ хүний эрхийн асуудал, эдийн засгийн асуудал, төрийн зохион байгуулалт гээд бүх түвшинд доройтно.

Тэгэхээр би хэлмээр байна. Үүнийг далимдуулж.

Ч.Лодойсамбуу гишүүний тэр мөнгө төгрөг тараасан гэдэг асуудлаа ч өөрөө хариуцлагатайгаар энд илэрхийлээрэй. Тийм мөнгө төгрөг авсан юм байхгүй.

Ийм үймээн самууныг ингэж өөгшүүлмээргүй байгаа юм.

Засгийн газар үргэлж зөв гэсэн үг биш шүү дээ. Шаардлагатай бол бид хяналт тавина, шүүмжилнэ. Шахалтыг ч гэсэн хуулийн хүрээнд ардчилсан зарчимд бид тулгуурлаж үргэлжлүүлж тогтвортой явах дээр анхаарч ажиллана.

Тэгээд би Ерөнхий сайдаас асуумаар байна. Одоо ингээд хамтарсан засаг байхгүй боллоо. Хамтарсан засгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бид үргэлжлүүлж хэрэгжүүлэх юм уу? 2025 онд бид баталсан. Хэрэгжүүлээд явж байгаа. 2026 онд бид хамтарсан засгийн мөрийн хөтөлбөрөөс гарч байгаа үйл ажиллагааг бид хэрэгжүүлээд явах уу?

Шинэ Засгийн газар Та бүрдүүлээд явахад маш их дайралтууд ирнэ. Үргэлжилнэ. Үүнтэй сөрж давна. Үүний цаана зарим нэгэн механизм хүртэл ажиллаж байна гэж хэлж байгаа. Үүнийг та сөрөн даван туулж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Мэдээж өнөөдөр хоёр шийдвэрийн нэг нь л гарна шүү дээ.

Мэдээж парламент итгэл үзүүлбэл би улс төрийн намуудтай дахиж зөвшилцөх асуудал зайлшгүй байх ёстой гэж үзнэ. Нэг үгээр хэлбэл гэрээ болон бусад асуудлуудаа бид яриад аль аль намууд өнөөдрийг хүртэл явсан энэ асуудлуудаа, улс төрийн хүрээнд ч гэсэн үл ойлголцол үүсгэсэн олон асуудлууд байгаа.

Нэгэнт парламент итгэл үзүүллээ. Энэ тохиолдолд энэ асуудлыг бид шинэ түвшинд гаргаж чадах уу, үгүй юу гэдэг энэ асуудлыг зайлшгүй дахиж ярих ёстой болно. Нэг үгээр хэлбэл улсын эрх ашиг нэгдүгээрт гэдэг энэ агуулгаар.

Энэ асуудал боломжтой. Намуудын их хурлууд хийгдэх боломжтой. Одоо байгаа удирдлагуудын хувьд, миний хувьд ч гэсэн жишээлбэл солигдох боломжтой. Гэхдээ яах вэ гэхээр хамтрах энэ идеологио авч үлдээч ээ гэж би уриална.

Хамтраад илүү хариуцлагатай явах энэ форматаа авч үлдэх нь зүйтэй биш үү.

Дангаараа засаглаж болно. Асуудалгүй. Мэдээж хэдэн сайдын суудал, хэдэн агентлаг, компаниудын томилгоо чухал байж болно.

Гэхдээ цаг нь мөн үү, биш үү гэдэг энэ асуудлыг дахиж ярилцах ийм асуудлуудыг тавьж зөвшилцөлд уриалах ийм л зүйлийг хийхээс өөр гарцгүй болно. Гарцгүй болно.

Энэ хүнд ч гэсэн зөв зүйл болно. Хүнд ч гэсэн зөв зүйл болно.

Олон нийтэд олон асуудлуудыг тайлбарлан таниулах асуудлууд гарна. Энэ байдал боломжгүй ээ гэдэг зүйл рүү явбал угаасаа ер нь улс орны эдийн засаг яг одоо байгаа шиг байхгүй. Би шулуухан хэлье. Бараг оны өмнө нэлээдгүй хүнд нөхцөл байдлуудтай тулахыг үгүйсгэх аргагүй.

Яагаад гэвэл нэгдүгээрт хамгийн энгийнээр 120 орчим доллароор худалдаад авсан нүүрс Ганцмод талд овоолгоотой байж байна. 80 доллар болсон. Нөгөө компаниуд нь алдагдалтай болсон. Үүнийг Их Хурал дээр бид хамтдаа л ярилцаж байж шийдэл гаргах ёстой том сорилт байгаа.

Үүнийг улс төржүүлбэл энэ шийдэгдэхгүй асуудал. Шийдэгдэхгүй асуудал.

Онтрэгийн асуудал. Онтрэгийн асуудал хөрөнгө оруулалтын гэрээ одоо хийгдэх ёстой. Хамтарч байх үед нэлээдгүй улс төртэй явж байсан энэ асуудал хамтраагүй ийм улс төрийн өнцгөөс харж байгаа тохиолдолд Онтрэ шийдэгдэхгүй. Тэр нь юу вэ гэхээр гүний уурхай Онтрэ дээр очоод зогсно гэсэн үг. Хэдэн ч жил хүлээх юм. Бүү мэд.

Ингээд Риогийн хувьд Яков солигдож байгаа юм билээ. Ойлголцол үүсгэх гэж дараагийн CEO[Chief Executive Officer]-тэй нь нэлээдгүй удаан хугацаа алдана.

Игээд нүүрсний үнэ бууж байхад уг нь бид зэсийн баяжмалаа экспортлох ёстой. Ингээд ийм асуудал гарна.

Энэ хоёр шийдэгдэхгүй бол яах вэ гэхээр төлбөрийн тэнцэл шууд хүндэрнэ. Ингээд ханшаа алдана. Ийм ийм эрсдэлүүд байна. Одоо улс орны хувьд.

Даанч харамсалтай нь сайдын суудал зүүдэлж байгаа хүмүүс маань, тэгээд ер нь Ардчилсан намыг гаргачих нь ер нь зүйтэй гэдэг блок маань. Тэгээд ер нь яах вэ, Засгийн газрыг солиод ингээд ингээд явах нь зүйтэй гэж бодож байгаа хүмүүсийн маань тоо энэ эрх ашгаасаа илүү тийм хүчтэй болчихоод байна л даа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Гудамжинд жагсаж байгаа залуучуудын жагсаалыг тэгш бус байдал гэж ойлгож байгаа. Баялагтаа эзэн байх, тэгш бус харилцааны асуудал гэж ойлгож байгаа юм.

Яг ний нуугүй хэлэхэд ард нь байгаа уул алтаар дүүрэн байхад урд нь амьдарч байгаа иргэд жорлонгоосоо өвчин авч, өвчин зовлонгоо үзүүлэхийн тулд 100 гаруй километр нэгдсэн эмнэлгийг зорьж, утаатай ангид хүүхдүүд нь суралцаж байгаатай л холбоотой асуудал.

Бид өнөөдөр улс төржилтийн золиос нь ард түмэн, эх орон болоод байгаа. Улс төржилтөөс хожиж байгаа бүлэг нь авлигачид болсоор өнөөдрийг хүртэл ирж байгаа юм.

Өнгөрсөн 35 жилийг бид ингэж л туулж ирлээ. Энэ бодит үнэн.

Өнөөдөр бидний өмнө хоёр асуудал байгаа.

- Нэг нь, бид байгаа баялгаа яаж хамгаалах юм бэ.
- Нөгөөх нь, бид байгаа баялгаа яаж зөв зарцуулах юм бэ

гэдэг асуудал гэсэн үг.

Бид хүссэн хүсээгүй энэ хоёр бугшсан асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай болж байгаа. Үүний тулд өнөөдөр би асуудал үүсэж байна гэж харж байна.

Үүнийг шийдвэрлэхийн төлөө, ард түмнээ баялагтай байлгахын төлөө баялгийн тэгш хуваарилалтыг хийхээр тэмүүлж байгаа бүх хүмүүсийг миний хувьд би дэмжинэ. Өнгөрсөн хугацаанд үүнийг хэлсээр л ирсэн.

Өнөөдөр Африкийг бид муу муухайгаар нь хэлдэг. Зааны ясан эрэг Кот-д'Ивуар гэдэг улсад би 2022 онд очиж байсан. Алмаз илэрснээсээ болоод, баялгийн тэгш бус хуваарилалтаас болоод, авлигачид нь тэрийг авснаас болоод тэр улс ядуурсан.

Ийм улс орны араас очихгүйн тулд манай Монгол Улс явж байгаа гэж би итгэж байгаа. Үүнийг бид ард түмэндээ маш сайн ойлгуулах ёстой.

Нөгөө талдаа бид Онтрэгийн асуудал. Сая маш олон гишүүд хөндөж байна. Оюу Толгойн бүлэг орд. Толгой бөгс хоёрыг нь тасалчихсан.

Бид өнөөдөр энд Засгийн газар байх уу, үгүй юу гэдэг асуудал, Ерөнхий сайддаа итгэл үзүүлэх үү, үгүй юу гэдэг асуудал ярьж байхад Торонтогийн хөрөнгийн бирж дээр 475 сая канад доллар болчихсон явж байна.

Энэ 1.2 их наядын асуудал. Монгол Улс 3.5 сая хүнтэй. Айл өрхөд хуваавал 986 мянган хүн айл өрх байгаа. Айл өрх болгонд нь хуваагаад үзэх юм бол нэг айлд хамгийн багадаа 1.2 сая төгрөг ногдох хэмжээний орлоготой холбоотой асуудлыг бид хөндөж байгаа.

Гашуунсухайт, Ганцмод, Шивээхүрэн, Сэхээ, Ханги, Мандал. 40 сая тонн нүүрс экспортлох асуудлыг бид өнөөдөр хөндөж ярих ёстой.

Энэ эдийн засгийг сайжруулах асуудал байхгүй юу. 40 сая тонн нүүрс гэдэг бол өнөөдөр хамгийн багадаа 14.4 их наяд төгрөг. Айл өрх болгоноор тооцох юм бол 14.6 сая төгрөг ногдох хэмжээний их мөнгөний асуудал энд яригдаж байгаа.

Гэхдээ өөрийнх нь бизнес зогсох гээд байгаа учраас, магадгүй өөрт нь орж байгаа мөнгө хоосрох гээд байгаа учраас ард түмний талд биш авлигачдынхаа талд явж байгаа хүмүүс байгааг би үгүйсгэхгүй.

Үүний эсрэг зогсоосой гэж парламентын гишүүдээсээ би хүсэж байгаа юм.

Ардчилсан нам юундаа гомдоод байгаа юм. Ардын нам нь юундаа ихэрхээд байгаа юм.

Өнөөдөр та нар ард түмний төлөөлөл болоод сонгууль хийгээд орж ирсэн юм байгаа биз дээ. Ард түмнээ сайн сайхан амьдруулъя гэж хэлээд өнөөдөр энэ танхимд сууж байгаа шүү дээ.

Тэгээд нэг л их гомдсон, ххэрхсэн хүмүүс. Ард түмнийхээ амьдралын төлөө бүгдээрээ тангараг өргөөд Үндсэн хуулиар баялгийн тэгш хуваарилалтыг хийж өгнө гэж хэлээд өнөөдөр бид тангараг өргөж энэ нэг танхимд сууж байгаа нь үнэн биз дээ.

Аж ахуйн нэгжүүд чинь хэцүү байна шүү дээ. Татварын реформоо хийхгүй юм уу. Нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын реформоо хийхгүй юм уу. Данхайсан төрөө... /минут дуусав/

1 минутаа авчихъя. Дарга аа.

Х.Булгантуяа: 1 минут нэмж өгье.

Б.Бат-Эрдэнэ: Энд данхайсан төрийг байхгүй болгохтой холбоотой асуудлууд төсвийн асуудлуудаа бид нэг талд нь гаргаж шийдэхгүй юм уу?

Энэ баялагтаа эзэн ард түмнийг бий болгохын төлөө бүгдээрээ санал нэгтгэйгээр өнөөдөр саналаа өгөхгүй юм уу?

35 жилийн хугацаанд бид улс төржлөө шүү дээ. Бие биеийнхээ эд хөрөнгийг харж гайхаж биширлээ шүү дээ. Одоо хангалттай юм биш үү. Сайдын суудлаар ард түмнийхээ эрх ашгаа наймаалцдаг энэ хэлбэрээ болихгүй юм уу?

Улсын Их Хурлын гишүүд шинээр сонгогдсон 81 гишүүн байна. Би 81 гишүүнийг ард түмнийхээ талд байгаасай гэж би хүсэж байгаа. Ний нуугүй хэлэхэд.

“Баялагтаа эзэн Монгол” гэдэг энэ уриаг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Монгол Ардын нам гаргаж ирсэн шүү дээ. Үүнийгээ бид үргэлжлүүлээд хийх ёстой гэж харж байгаа.

Ерөнхий сайд татварын реформ, нийгмийн даатгалын реформ, данхайсан төрийн асуудал, баялагтаа эзэн монголын асуудлыг үргэлжлүүлнэ биз дээ гэдгийг би Ерөнхий сайдаас өөрийнх нь амнаас сонсьё.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хариулъя. Микрофон өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газар боломжит хамгийн дээд потенциалаараа л ажиллаад тэгээд 20 жил гацсан төслөө хийсэн өдрөө л огцрох боллоо л доо. Бодитой байдал энэ шүү дээ. Ер нь.

Бөөн юм болж Ораногийн ард гараад, бөөн юм болж Гашуунсухайт, Ганцмодоо хийгээд. Тэгээд л огцрох асуудал яригдаж байна. Зүгээр том агуулгаараа. Мэдээж шалтаг шалтгаанууд зөндөө байна. Ойлгож байна.

Зарим асуудал маань одоо тэгээд бараг хамтраад хийх ёстой зүйлүүд чинь бараг хийгдсэн шүү дээ гэж байгаа юм. Үгүй шүү дээ. Бид нарт дахиад хийх маш их олон асуудлууд байна.

Харамсалтай л санагдаж байна. Надад. Зарим улс хэлж байгаа. Чи 2027 онд нэр дэвшихэд нас чинь хүрэхгүй шүү дээ. Тэгээд л наад ажлаа өгчих нь зөв шүү дээ гэж байгаа юм. Том эрх ашиг. Улс төр талаасаа зөв байх. Ийм дунд нь насны гар_[насны ялгаа] гараад байгааг би ойлгож байгаа.

Гэхдээ энэ яах вэ, зүгээр миний бодлоор. Бид хамтдаа асуудлаа л шийдэх ёстой шүү дээ. Бид иргэдийн амьдралыг сайжруулах энэ хүнд цаг үеүдийг туулах нь л зүйтэй. Хамтдаа итгэл үнэмшлээр бид үүнийг даван туулах ийм итгэл үнэмшилтэй байх нь уг нь хамтарсан засаг, хамтын ажиллагаа, шинэ 126-гийн инерц байх ёстой гэж би маш их итгэж байсан. Ер нь. Маш их итгэж байсан.

Шинээр орж ирсэн залуучууддаа би маш их итгэж байсан. Яг энэ дээр илүү их тийм бодлогын дэмжлэг үзүүлэх болов уу. Шинэчлэгдээд явж байгаа зүйлүүдийн эерэг талыг олж харах болов уу гэдэг ийм итгэл үнэмшил надад байсан.

Харамсалтай нь яг энэ шинэ урсгалтайгаа бараг мөргөлдөж байна. Тэгээд цагийн зүүг нэлээдгүй хугацаагаар хэдүүлээ хойшлуулах зүйлийн өгөөшид орчихлоо. Хамтдаа. Үүнийг цаг хугацаа нотолно. Цаг хугацааны дараа явах бүх үйл явдлууд нотолно.

Нэлээн дэвшилттэй явж байсан Монголын улс төрийн нөхцөл байдал өөр тийшээ явах тал руу орчихлоо. Жагсаал дахиж хэзээ ч ингэж орохгүй. Жагсаалтад буцаад хуучин ахмад туршлагатай улс төрчид л орж ирэх болчихлоо.

Хэнээс болов. Биднээс өөрсдөөс маань л болчихлоо. Өөрсдөөс маань л болчихлоо. Бид бие биетэйгээ барьцах гэж байгаад магадгүй улс төрийн цаг хугацааг 12 жил лав хойшлуулах хэмжээний эрсдэл рүү ирчихлээ.

Тийм учраас бид доор дороо л дүгнэлт хийх ёстой. Энэ ганц Л.Оюун-Эрдэнийн асуудал биш. Энд байгаа хүмүүсийн асуудал ч биш. Энэ бол бүхэл бүтэн нийгмийн инерцийн асуудал юм. Харамсалтай нь зөндөө тайлбарлах гээд чадсангүй. Итгэдэггүй юм байна.

Нөгөө албан тушаал гэдэг чинь ийм төвөгтэй байдаг юм байна. Атаархал гэдэг ядаргаатай юм байна. Энэ суудал дээр сууж байгаа нь тийм муухай харагдаад байдаг юм байна. Би үүнийг ойлгож байгаа юм.

Тийм учраас бид өнөөдөр үүнийг нэг тийм дүгнэлт хийгээд авах нь зүйтэй байх. Манай намынхны хувьд ч гэсэн бас л том дүгнэлт хийх л ёстой л ийм зүйл болж байгаа юм даа. Ер нь бол. Тэгээд үүнийгээ хэдүүлээ доор доороо л ярих нь зүйтэй байх.

Тэгээд өнөөдрийн мэдээж шийдэл аль нэг талдаа гарна. Аль ч... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ордлогоо нотол гэдэг асуудал зөвхөн Ерөнхий сайд дээр учирч байгаа асуудал биш шүү дээ. Ганцхан Л.Оюун-Эрдэнэ гэдэг хүнтэй ч учирсан гэж би ойлгохгүй байгаа.

Энэ бол нийгэм та нар ил тод, шилэн бай л гэдэг үг, сахилга баттай л бай гэдэг үг. Хэн нэгний орлоготой холбоотой асуудал дээр нийгэм тэр чигээрээ бухимдаад байгаа гэж үзээгүй. Хувь хүнийхээ хувьд би ойлгохгүй байгаа.

Дараа жил Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилтийн конвенцын 17 дугаар бага хурлыг Монгол Улс зохион байгуулна.

10 сар алдлаа. 196 орон Монгол Улсад ирнэ. Энэ ажлыг бид хийж, тэрбум доллароор тоологдох хэмжээний мөнгийг бид босгож байгаль орчныхоо салбарыг өөд нь татах хэрэгтэй. Байгаль орчны өөд нь татах хэрэгтэй.

Өнөөдөр бид баялагтаа эзэн гэдэг энэ уриа лоозон Монгол Ардын намаас эхэлсэн юм шүү. Үүндээ тууштай байх хэрэгтэй. Энэ дээр Ерөнхий сайдыг тууштай байгаасай гэж хүсэж байгаа. Ардчилсан намынхан... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Ж.Золжаргал: Ерөнхий сайдын бичиг дээр парламентын тогтолцоог төгөлдөржүүлэх гэж байгаа.

Тэгээд гишүүдийн яриаг сонсоод байхад ер нь аль аль тал нь парламент бэхжих ёстой гээд байна. Тэрийг сонсоход их таатай байна. Би бас тэгж боддог, итгэдэг хүн.

Гэхдээ нэг ялгаа байна. Парламент явал бэхжих вэ, хэзээ бэхжих вэ гэж.

Миний ажигласан, дүгнэснээр 90 гаруй хувь нь нийлээд Засгийн газар хамтраад байгуулахаар парламентаа захирдаг, чиглүүлдэг болдог юм байна. Нэлээн л олон өнцгүүд хүмүүс ярьсан.

Миний хувьд гол анзаарсан зүйл нь юу вэ гэхээр нөгөө бартерын тухай асуудал. Энэ байр сууриа тодотгож хэлэх нь зөв байх.

Хил холболтыг маш өндөр хувиар дэмжсэн, парламент. Үнэхээр Монгол Улсад чухал. Ойлгож байгаа. Тэгээд түүнийг дагаад хил холболтын төлбөрийг төлөхдөө нүүрсийг зөвхөн биржээр биш тусгай нөхцөлөөр нийлүүлнэ гэдэг өөрчлөлтийг хуульд оруулж ирэх ёстой байсан. Тэр Уул уурхайн тухай биржийн хууль дээрээ хил холболт биш нийгэм, эдийн засагт ач холбогдолтой төслүүдийг төрөл бүрийн ашигт малтмалаар бартердаж болно гэдэг санаа орж ирээд нэлээн шуугиан болоод буцсан юм.

Тэгээд энэ нь дараа нь бас өөр байдлаар гишүүд яриад бариад яваад байгаа юм.

Тэгэхээр үүнийг юу гэж харж байна вэ гэхээр бүсүүдээ хөгжүүлнэ, тэр бүсүүд дээр хөгжүүлэх мега төслүүд тодорхойгүй томьёололд нь нийлүүлээд бодох юм бол Монгол Улс чинь 30 гаруй их наяд төгрөгийн төсөвтэй. Тэр төслүүд маань мэдэхгүй, магадгүй 100, 200 их наяд болно.

Ийм хэмжээний янз бүрийн үр ашигтай, ашиггүй нь мэдэгдэхгүй бүтээн байгуулалтуудыг том дүнгээр бартердаад, хэдэн төгрөгөөр юу хийлгээд, хэдэн төгрөгөөр түүхий эдээ зараад, хэн тэрийг нь хийж бүтээгээд, тэгээд тэр нь Монголын нэгдсэн төсөвтэй улсын сангаас хамаагүй том юмнууд хяналтаас гадуур явах эрсдэл байна гэж харсан.

Энэ бол Монголд хэрвээ энэ чигээрээ явах юм бол аюултай. Гэтэл үүнийг серьёзны ярьж мэтгэлцэх ийм талбар хангалтгүй болсон байна. Яагаад гэхээр зэрэг 90 хувь нь хамтарсан засаг доор. Зарим нь санаатай, зарим нь санаандгүй ярьж чадахаа байсан.

Тийм учраас ер нь асуудлыг ярих цаг нь болсон байна гэдэг итгэл үнэмшлээр огцрох шаардлагад нэгдэж гарын үсэг зурсан байгаа.

Тэгээд одоо 120 гишүүнтэй парламент анх удаагаа Монголын түүхэнд. Тэгээд холимог парламент. Би бол энэ 120 гишүүнтэй парламент тийм сул. Одоо хэрвээ хамтарсан засаг байхгүй л бол хямралд орно гэж ерөөсөө бодохгүй байгаа.

Ерөнхий сайд өөрөө манлайлж мэргэжлийн хүмүүсийг жагсаалтад оруулж ирсэн. Би тэр хүмүүсийг шал өөр өнцөгтэй ярьж байгааг ч анзаарч байгаа. Тэгээд энэ бол амьд мэтгэлцээн ингээд цаашдаа үргэлжлээд явна гэж бодож байна.

Энэ өөрчлөлтийг хийхийн тулд зөндөө л юм болсон. ХҮН намын залуучууд ч бид зөндөө л өвөл идэр есийн хүйтнээр хүмүүст тайлбарлаад л гарын үсэг цуглуулаад л хаа сайгүй ажилласан. Тэгээд үр дүнд нь ийм үр дүн хүрсэн. Би үүнийг цаашдаа ажиллана гэж бодож байгаа.

Зөвхөн нэг жишээ хэлэхэд 2024 оны хаврын чуулганаар 240 хууль баталснаас талыг нь нэг өдөр 28 бие даасан хууль, тэгээд 100 гаруй хууль нэг өдөр баталсан байгаа. Тэгээд хэдхэн минутад нэг хууль батлаад байсан байгаа юм. 06 сарын 05-нд.

Тэгэхээр ийм тохиолдол энэ парламент дээр гарахгүй ээ. Гарахгүй. Тэгээд ч цаашдаа тэр жишээ болгоод бид ярьж байсан Шинэ Зеланд байна уу, Европын Улсуудын парламентын тэнцвэртэй, баланстай, хүчний балансууд нь хоёр хуваагдаж нийлж, салдаг, асуудлаа шийдүүлэхийн тулд араас нь явдаг. Энэ рүүгээ л явсан нь дээр.

Х.Булгантуяа: Ж.Золжаргал гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: 10 сарын өмнө бид парламентын түүхэнд 23 цаг хуралдаж хамтарсан Засгийн газрыг шөнө дөл хүртэл хуралдаж байж байгуулсан. Тэгээд эргээд жил хүрэхгүй хугацаанд эргээд сөхөгдөж байгаа нь зүгээр харамсаж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, түрүүн хэлдэг эрх ашгийн эрэмбэ гэдэг зүйл дээр бид их анхаарах ёстой болжээ. Улсын эрх ашиг дээр нэгдэж нийлж, болохоо байсан цаг үе бас болоогүй байх гэж би бодож байна.

Ер нь сонгуульд ард түмэн юу гэж бид санал өгсөн бэ. Хоорондоо хэрэлдээд уралцаад мөнхийн дайсан мэт Монгол төрд ажилла гэдэг ийм байдлаар би өгөөгүй байх гэж бодож байгаа. Зарим хүмүүст мөнхийн хэрүүлтэй байж байвал их сайхан, бие биеэ хянаад шүүмжлээд байгаа болов уу гэж харагддаг байх.

Хоёрдугаарт, 126 парламент. Ер нь энэ 126 бүтэхгүй. 76-аасаа ялгаа алга гэдэг ийм мессежийг бас алс далдуураа өгөөд байгаа хүмүүсийг би харахад, хэн

хаанаас өгөөд байна вэ гэдгийг би харахад их сонин дүр зураг харагдаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл 80 гаруй шинэ гишүүн ороод ирсэн. Үгэнд ордог нь их цөөхөн байна. Эд нарыг ухаад үзэхээр ашиг сонирхол гэдэг зүйлд барьж авах нь их цөөхөн л байгаа юм байна гэдэг байдлаар.

Гуравдугаарт, Ерөнхий сайдын өгсөн өргөдлөөс харахад хамтарсан мөрийн хөтөлбөрөө бид чинь сая батлаад удаагүй байгаа. Энэ мөрийн хөтөлбөр магадгүй манай Ардчилсан нам маань бид нэгэнт хамтрахгүй юм чинь гараад бид санал өгөхгүй гээд ийм байдалтай харагдаж байгаа юм. Би харамсаж байна.

Яадаг ч бай юм ер нь аливаа зүйл эхлэхдээ биш ер нь дуусахдаа байдаг. Тэр утгаараа хамтарсан мөрийн хөтөлбөрөө ер нь яах болж байна аа? Ерөнхий сайдаас ч гэсэн би үүнийг тодруулж хэлээсэй гэж бодож байна.

Энэ мөрийн хөтөлбөрийн бараг 4 жилийн мөрийн хөтөлбөрийн 50 орчим хувь нь Ардын намынх, 30 гаруй, 40 орчим хувь нь Ардчилсан намынх, 20 орчим хувь нь ХҮН нам гээд хамтраад зураад. Бусад намууд ч гэсэн санал өгч байсан.

Тийм учраас энэ тал дээрээ бид эргээд бодох ёстой. Энэ бол тоглоом биш. 90 гаруй хувийг шийдсэн.

Гуравдугаарт, бид ер нь баялаггүй ч байсан болоосой гэж би бодох үе ирж байна. Нөгөө баялгийн хараал гэж үүнийг хэлдэг юм гэсэн. Хэт их баялагтай байгаад байхаар түүнийг нь эрхшээх гэсэн хүмүүсийг нь зодоон эцэстээ төр улсыг ард иргэдээс нь холдуулдаг. Төрийнх нь эрх мэдлийг оролцож эхэлдэг.

Тийм учраас саяын асуусан, хариулсан хүмүүсээс харахад би ноцтой зүйлүүд яригдаж байна гэж бодож байна.

Монголын баялгийн зодооноос болоод, төрийн тогтвортой байх, байхгүй асуудал сүүлийн 30 жил явж ирсэн байна. Одоо бүр хурцдах ийм байдал маань эргээд ирлээ гэж. Уг нь яах вэ, бас их итгэж байсан. Хамтраад бид аль аль талдаа зөв зүйл дээрээ их нийлж байна даа. Танхимын уур амьсгал Засгийн газрын ч гэсэн ажлууд урагштай явах нь дээ гэж бодож байсан. Тэгээд харамсалтай нь ийм зүйл боллоо.

Тийм учраас улс төр, бизнес хоёр хоорондоо жоохон зайтай байсан нь дээр биз дээ. Зарим талаар хэт ойрхон. Бүр алсуураа бол бүр хэт их айхтар оролцдог юм байна гэж би дүгнэлтэд харах гээд байна.

Би Монгол Улсын Ерөнхий сайдыг номер нэг мэдээлэлтэй байдаг хүний хувьд зарим зүйлийг улсын нууцтай холбоотой асуудал учраас бүрэн хэлж чадахгүй байх шиг байна. Зарим зүйлийг шууд л хэлж байх шиг байна.

Тийм учраас цаашдаа ийм байдлаар, ийм эрх ашиг гэдэг байдлаар төр засаг маань иймэрхүү байдалтай байвал ер нь тун хэцүү болно.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Харин тийм учраас л би хамтарсан Засгийн газрын асуудал дээр итгэл үзүүлэх эсэх гэдэг ийм агуулгаар оруулж ирж байгаа юм л даа.

Намуудын сайн хөтөлбөрүүдийг аваад, урт хугацааныхаа бодлогын төлөвлөлтөд яаж хийх вэ гэдэг аргачлалаа хийгээд, ингээд явж байгаа инерцээ алдуулахгүйгээр явах нь цаг хугацаа л хожно л доо. Цаг хугацаа хожно.

Өнөөдөр Монголд болохгүй байгаа зүйл зөндөө байгаа. Бусад улсууд ч гэсэн бүтэн болсон зүйл бага. Аль ч улсад шүүмжлэлтэй л байгаа. Гол нь бидний хувьд тууштай, төлөвлөгөөтэй явж байж л “А” цэгээс “Б” цэгт хүрнэ үү гэхээс биш бүх зүйлийг үүнийг ч ингэчихье, тэрийг ч тэгчихье гэснээр асуудал шийдэгддэггүй юм билээ. Шийдэгддэггүй юм билээ. Тогтворгүй байдал сайн зүйлийг авчирсан улс орон маш бага.

Тийм учраас бидний хувьд адаглаад нийслэл дээр явж байгаа Туулын хурдны зам, тэгээд энэ хэдэн төслүүдээ хэдүүлээ улс төржүүлэхгүй ямар ч байсан үр дүнг нь үзэх нь зөв байгаа юм. Бодлогын залгамж чанар гэж үүнийг л хэлээд байгаа юм.

Хүн байснаар заавал бодлогын залгамж чанар хангагдах зүйл биш л дээ. Тэр төслүүд дээр байгаа итгэл үнэмшлээрээ хийгдэх л ийм л зүйл.

Тийм учраас үүнийгээ илэн далангүй ярьж байгаа нь бид бодлогын тогтвортой байдал дээрээ эргэж буцахгүй байх нь туйлын чухал юм. Туйлын чухал юм.

Түрүүн Ж.Золжаргал гишүүн ярьж байна. Монгол Улс уул уурхайн төслүүдийг хөдөлгөөд, эдийн засгаа солонгоруулаад, тэгээд хэрэгцээтэй байгаа дэд бүтцээ шийднэ гэвэл багадаа дахиад 15-аас 20 жилийн хугацаа орно.

Тийм учраас бид яах вэ гэхээр баялаг солилцох байдлаар адаглаад нийслэл Улаанбаатар хотоо тойрсон 2 тойрог замтай, гол асуудлуудаа холбох ийм зүйл рүү цаг алдахгүй явахгүй бол Монгол Улсын хувьд л цаг алдана. Наад Энэтхэг, Пакистан эд нар чинь бүгдээрээ тэгээд хөгжчихсөн байгаа.

Манай улсын хувьд болохоор төсвөө алдагдалтай баталж болохгүй ээ. Бүх зүйлийг бидний хувьд заавал асуудлыг, одоо жишээлбэл бид бүтээгдэхүүнийг солиод дэд бүтцээ хийж болохгүй ээ. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хамтарч ажиллахаар эдийн засгийн төрөлжилт нь болохгүй байгаад байна гээд л. Оросын Холбооны Улстай хамтарч ажиллаж болохгүй ээ гэдэг

иймэрхүү агуулгуудыг бид мэдээж тавьж болно. Гэхдээ маш прагматик хандахгүй бол бид хугацаагаа л алдаад байна. Хугацаагаа л алдаад байна.

Тийм учраас бидний хувьд явж явж бидний зорилго юу юм. Улсаа хөгжүүлэх шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ л бид эхэндээ тавиад энэ асуудлуудаа. Мэдээж шүүмжлэл байгаа. Асуудал ойлгомжтой. Маргааш өөр Засгийн газар бүрдсэн ч тэнд шүүмжлэл байна. Нөгөөдөр дахиад өөр Засгийн газар бүрдсэн ч тодорхой хэмжээний шүүмжлэл байнга байна. Дэлхий бол диваажин биш шүү дээ.

Бидний хөгжихсөн гэж боддог Америкийн Нэгдсэн Улсад ч асуудал байна, Солонгос Улсад ч асуудал байна, Японд ч асуудал байна. Хаа сайгүй л засаглалын хямрал болж байна.

Харин ч манай улс энэ ковид, Орос, Украины дайны дундуур бас их аятайхан гарсан шүү. Чамлахаар чанга атга гэдэг шиг. Одоо харин энэ цаг үе дээр жоохон тийм тайвшрах мэдрэмж ороод ирэхээр, тэгээд сорилтууд багасаад ирэхээр л албан тушаалын ийм зүйл рүүгээ орж байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр 2024 оны 7 дугаар сард яг энэ хамтарсан Засгийн газарт орно уу гэсэн ийм урилга Монгол Ардын намаас ирээд. Тэр үед ХҮН нам дотроо бужигнаан болсон. Үнэхээрийн маргалдаад, сөрөг хүчний үүргээ гүйцэтгэх ёстой гэсэн олон хүн байсан.

Тэгээд маргалдаж маргалдаж нэлээн хүчтэй хоорондоо ярилцсаныхаа эцэст бид шийдээ гаргасан. Оролцёё гэж.

Яг ингээд гаргасан шийдвэрээ ягштал баримталдаг хариуцлага бидэнд бий л дээ. Тэгээд энэ нь дараах хэд хэдэн үндэслэлтэй байсан юм. Үүнийг нэг хэлчихье.

Нэгдүгээрт, бид 126 гишүүнтэй парламентын холимог тогтолцоогоор бүрдсэн 48 сонгогчид нь нийт сонгогчдын дуу хоолойг амилуулж байгаа юм. Саналыг нь амилуулж байгаа. Жагсаалтаар орж ирсэн хүмүүс байгаа. Энэ бол Үндсэн хуулийн өөрчлөлтийн төлөө ХҮН нам хамтдаа зүтгэсэн. Энэ улс төрийн хүчнүүдийн идэвх чармайлтын дүн байсан, үр дүн байсан гэдгийг нэгдүгээрт хэлэх ёстой.

Хоёрдугаарт, бид холимог тогтолцоогоор сонгогдсон гишүүд учраас өгсөн саналуудаа бүгдийг нь амилуулаад, хамтарсан Засгийн газарт оролцоод,

өөрсдийнхөө сайн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэе л гэж бодсон. Түрүүнд Ерөнхий сайд үгэндээ хэлж байна.

Тийм учраас Ерөнхий сайд таны яг хэлж байсан улс орны эрх ашгийг нэгдүгээрт, улс төрийн намуудын эрх ашгийг хоёрдугаарт гэсэн энэ үг бол бидэнд их нөлөөлсөн шүү.

Гуравдугаарт нь, холимог тогтолцоогоор сонгууль олон дахин явах тусмаа цаашаа ер нь аль нэг нь олонх болж чадахгүй юм билээ л дээ. Онолоороо.

Тэгэхээр шийдэж чаддаг, улсынхаа эрх ашгийг уландаа гишгэсэн, утга учиргүй гацаанд ордоггүй, иргэндээ алдаагаар бужигнадаггүй тогтвортой л Засгийн газрыг байлгахын тулд сонгуулиар суудал авсан намууд эвсэж ингэж явдаг ийм улс төрийн соёл бүрдэнэ гэж бид харсан.

Ийм бүрдүүлэхийн тулд бид Европын жишиг нь зөв юм байна гэж харсан. Германд очиж туршлагыг нь судалсан.

Ингээд хамтарсан Засгийн газар байгуулагддаг. Тэр нь их тогтвортой ажилладаг юм байна. Дан ганц мажоритараар явахаар өнөөдөр Трампын Засгийн газар Америкийн Нэгдсэн Улс тарифаар яаж дэлхийг чичрүүлж байна. Та бүхэн харж байгаа шүү дээ. Бодлого нь ямар ч юугүй. Савлалттай. Ийм байгаа ийм үед бид зөв шийдвэр гаргасан гэж. Одоо энэ 14 мега төсөл хөдөлж байна. Хамтарсан Засгийн газар богино хугацаанд ямар ямар шийдвэрүүд гарлаа. Үүнийг Та бүхэн харж байгаа.

Ерөөсөө л парламент, Засгийн газрыг өөрөөсөө төрүүлдэг.

Парламентын ардчилал, парламентын зарчимд бид хатуу итгэдэг учраас бид энэ Засгийн газарт оролцсон юм.

Ингээд эрхэм Ерөнхий сайдаас асууя. Та бол улс төрийн ардахыг харж байгаа. Хөшгийг ярах бүрэн эрхтэй ийм хүн. Бүгдийг нь тольтой харж байгаа.

Тийм учраас Та түрүүн Төрийн байгуулалтын байнгын хороонд нэг хэлсэн үгэндээ Гашуунсухайтаас буцаж ирэхэд л дараагийн Ерөнхий сайдыг хэдийн шийдсэн байсан гэсэн үгийг Та хэлсэн.

Тэгэхээр энэ Ерөнхий сайдыг томилох бүрэн эрх бол зөвхөн Улсын Их Хуралд байдаг. Энэ үгээрээ яг Та юуг хэлэх гээд байсан юм? Улсын Их Хурал гэдэг энэ институтийг давсан шийдвэр гаргадаг засаглалын ямар гажуудал манайд нүүрлэхээд байгаа юм? Үүнийг Та нэг хэлмээр байна.

Ам нээвэл уушги нээ гэдэг. Түрүүн ярьж л байна л даа. Дахиад хэлсэн ч болно. Таныг орлогоо нотол гээд шаардахаар Монгол Ардын нам Ардчилсан

намыг Засгийн газраас гарга гэсэн ийм шийдвэр гаргасан. Одоо бид Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг ингээд яриад сууж байна.

Яг юу болоод байгааг Та олон нийтэд маш тодорхойгоор ойлголт өгмөөр байна. Ингээд хөшгийг нь цэлийтэл нээгээд цаана юу болоод байгаа, тогтолцооны ямар гажуудал үүсээд байгааг та нэг ярьчихмаар байна.

Засгийн газрууд богино настай болоод шийдэж чаддаггүй. Утга учиргүй гацаанд ордог. Цаг ямагт бужигнаж байдаг ийм Засгийн газарт иргэд дургүйцээд энэ нь цаашид тогтолцооны шинэчлэл, тодорхой хэлбэл Үндсэн хуулийн өөрчлөлт рүү түлхэх юм биш байгаа гэсэн айдас байна шүү дээ.

Тийм учраас Ерөнхий сайдын хувьд Та энэ асуултад маш тодорхой хариулаад өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм зүйл яригдсан нь бодитой бодитой.

Уг нь кабинет бол нам харгалзахгүйгээр кабинетын зарчмаар ажилладаг л даа. Тийм ээ. Ажиллах ёстой. Энэ удаагийн кэйс болохоор кабинетын гишүүд маань Засгийн газрынхаа эсрэг ажиллаж байгаа ийм дүр зургийг Та бүхэн бүгдээрээ харж байгаа байх. Энэ бол өөрөө их түвэгтэй зүйл юм билээ.

Сонголтдоо мэдээж яах вэ, Ерөнхий сайд илүү хүчний харьцаа, тэгээд илүү тогтвортой байдал, олон зүйлийг л бодолцож кабинетынхаа гишүүдийг томилдог. Томилж байгаа.

Яг үнэндээ Ерөнхий сайд өөрөө хүссэн хүнээ нэг их томилоод байж чаддаггүй юм даа. Аль болохоор л илүү тийм тогтвортой байх ийм агуулга.

Гэтэл кабинетын итгэл үнэмшил алдагдаад, кабинет дотроос ер нь энэ асуудал анх үүссэн. Анх үүссэн. Ингээд тэр хүмүүс маань бүлгийн нөлөө бүхий гишүүдтэй очиж нэгдсэн. Мэдээж олон нийтийн асуудал болсон. Надад Ерөнхийлөгчийн дэмжлэг байхгүй болсон. Ингээд асуудал үүсдэг.

Тэгэхээр Ерөнхий сайд бүхэн, ер нь энэ асуудал дээр өнгөрсөн 30-аад жилийн бүхий л түүхийг хараад, хэрвээ Ерөнхий сайдууд бодитой үнэнийг хэлбэл дандаа л ард нь нэг ийм л асуудал байгаа. Түүнээс Засгийн газар нэг их парламент дотроосоо огцорч байсан тохиолдол цөөхөн шүү дээ. Яг үнэндээ. Нийгэм талаасаа ч огцорч байсан тохиолдлууд маш бага. Энэ үл ойлголцол явдаг. Энэ үл ойлголцол олон талаас гардаг.

Дунд нь эрх ашиг, албан тушаал бодсон янз бүрийн хүмүүс самардаг. Буруу, зөрүү мэдээллүүд өгдөг ийм зүйлүүд болно.

Тэгэхээр яах вэ, үүнийг бид ер нь нэг талд нь яваандаа гаргахгүй бол цаашдаа тэгээд гүйцэтгэх засаглал энэ хэвээрээ л байна. Энэ хэвээрээ л байна. Ер нь энэ тогтолцооны асуудлыг аль нэг талд нь гаргаж шийдэхгүйгээр бид энэ засаглалын хямралаасаа гарахгүй юм билээ. Энэ ерөөсөө хувь хүмүүсийн асуудал биш. Би зүгээр тогтолцоо ярьж байгаа байхгүй юу. Тогтолцоо ярьж байгаа.

Өнгөрсөн бүх цаг хугацаанд үл ойлголцлууд үүсэж байгаа тохиолдол хувь хүнээс ерөөсөө байгаагүй. Дахиад хэлье. Жишээлбэл, У.Хүрэлсүх дарга бид хоёрын дунд хувь хүний хувьд ямар ч асуудал байхгүй.

Энэ өөрөө тогтолцоо. Тэнд одоо жишээлбэл зориуд мэдээлэл өгдөг янз бүрийн хүмүүс байна. Дунд нь янз бүрийн байдлаар зохион байгуулдаг тусгай албад байна. Ингээд дабл буюу параллель бүтэц аль аль талдаа үүсдэг.

Ийм асуудлууд байна. Үүнийг бид аль нэг талд нь гаргаад шийднэ гэдэг нь ер нь Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог болох ёстой. Эсвэл хэрвээ бид парламентын засаглалтай бол, нэг үгээр хэлбэл парламент дангаараа ард түмэн нь сонгогддог цорын ганц субъект байх ёстой.

Тэгээд нэг л гүйцэтгэх засаглалтай байх ёстой.

Д.Амарбаясгалан: Нэмж өгье. Минут нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Эсвэл бид муу нуухаар сайн илчил гэдэг шиг тэр нөгөө Ерөнхийлөгчийн засаглал руу гэдэг нь ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч Засгийн газраа өөрөө бүрдүүлэх эрхийг нь өгөх хэрэгтэй.

Сонгочхоод байдаг. Юм хиймээр байдаг. Засгийн газар нь тусдаа яваад байдаг. Ард түмэн шаардаад байдаг.

Манайх болохоор чинь ингээд нэг ийм яг дундуур нь хоёр гүйцэтгэх засаглалтай ч юм шиг нэг ийм асуудлууд байна. Тэгээд яг энэ орон зайн дунд хүмүүс асар их тийм шургуу, шургаа хийдэг асуудлууд бас болдог юм билээ.

Тэгээд яах вэ, парламент. Ер нь яах вэ дээ, Засгийн газар чинь хөөрхий нэг тийм юутай шүү дээ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Минут нэмье.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газар яг бодитоор ер нь их тийм эмзэг байгууллага.

Тэгээд ийм асуудлууд гарахаар Ерөнхий сайд яах вэ гэхээр улс орны өдөр тутмын амьдралыг хариуцдаг учраас ер нь л тэгээд бууж өгдөг. Парламентаар асуудал гараад, төр улс донслоод, ийм асуудал гараад байхаар,

за за.., одоо тэгээд энэ нь эдийн засагт хортой байх болов уу, за.., яршиг энэ нь ингээд нөгөө асуудал үүсгэх болов уу гээд ингээд л ер нь л Ерөнхий сайд л бууж өгдөг.

Тэр нь нөгөө өдөр тутмынхаа ажил, улс орны асуудлыг боддог.

Парламент бол маш хүчтэй институц. Улс төрүүд гарна, Засгийн газраасаа шаардана. Ингээд Засгийн газар, парламент, Ерөнхийлөгч, шүүх засаглал, ингээд намууд гээд... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдах: Бүгдэд нь оройн мэнд хүргэе.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад болж байгаа үйл процесс бид бас дүгнэлт хийх ёстой. Нарийн деталь руу ороод байх юм бол дуусахгүй. Гэхдээ хамтарсан Засгийн газар байгуулагдаад жил ч болоогүй өнөөдөр итгэл хүлээлгэх асуудал болж таарч байна.

Тэгээд засаглалын асуудлууд байгаа. Гэхдээ олон улсын жишгийг бид заавал хамтад нь авч үзэх ёстой юм. Бид нарын тулгамдаад байгаа энэ асуудал ганцхан манайд тохиолдож байгаа биш шүү дээ. Маш олон оронд тохиолдож байгаа. Засаглалын ч гэсэн янз бүрийн хувилбартай орнуудад яг л адилхан асуудал тохиолдож байгаа.

Энэ өөрөө онолтой л доо. Өөрөө угаасаа энэ талаар бичсэн олон ч ном, тэр битгий хэл эдийн засгийн Нобелийн шагнал авсан эдийн засагчид ч хүртэл байгаа юм.

Тэгээд нэг агуулга яримаар байгаа юм. ELITE CAPTURE гэж байгаа юм. Юу гэсэн үг вэ гэхээр байгалийн баялгаас хэт хамааралтай байхаар тэрийг улс төр, эдийн засгийн цөөхөн бүлэглэл түүний хяналт дээр л байдаг байхгүй юу.

Тэгчхээд олон нийт рүү урсах урсгалыг нь боочихдог юм. Эндээсээ салахгүйн тулд улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэдэг. Засгийн газруудыг шил дараалан унагаадаг.

Өнөөдөр бид ингэж хармаар байна Засгийн газар унаснаараа, эсвэл Ерөнхий сайд итгэл хүлээлгэхгүй байснаараа, эсвэл улс төрийн тогтворгүй байдал үүссэнээрээ яг хэн хожоод байгаа юм бэ? Хэнд энэ нь ашигтай болчхов?

Ингээд харах юм бол ер нь ийм илүү ойлгомжтой харагдана даа.

Хэдхэн сарын өмнө Үндэсний баялгийн сан өөрөө тэр олон нийт рүү урсах ганц урсгал нь мөн байхгүй юу. Бид цоо шинээр бодоод олсон ч юм биш. Бусад орнуудад яг ингэж л явдаг юм.

Гэхдээ үүнийг хийх нь өөрөө энэ чинь буцаад тэр элитүүдийг хийж байгаа тэмцэл байхгүй юу. Үүнийг хийж чадахгүй бол, эсвэл явахгүй бол энэ нь өөрөө буцаад улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэж байж үүнээс гардаг. Энэ дээр дотоод гэлтгүй, гадаад дотоод, ялангуяа уурхай хэрэглэдэг компаниуд энд угаасаа Монгол гэлтгүй бусад орнуудын жишиг дээр бүгдээрэнд нь байгаа.

Энэ ганцхан жишээлбэл Монгол Улсад ганц Рио Тинто том уурхайтай биш шүү дээ. Яг энэ том уурхайнууд дээр ч гэсэн ажиглагддаг.

Баялгийн сан өөрөө яаж амилах вэ гэх юм бол тэр өөрөө мөнгөжиж байж л амилна. Тэр баялгаас орж ирж байгаа орлогын тодорхой хувь нь тэр баялгийн сангаар дамжаад олон нийт рүүгээ эрүүл мэнд, боловсрол болж байж л энэ асуудал урт хугацаандаа шийдэгдэх байхгүй юу.

Тэгэхээр яг энэ асуудал мөнгөжүүлэх болоод ирэхээр. Яах вэ, урд нь зүгээр яриа хэлбэрээр л явж байсан. Тийм ээ. Яриа хэлбэрээр маш олон жил явсан. Яг мөнгөжих болоод карманд нь тулаад, түрийвчинд нь тулаад ирэхээр яг өнөөдрийн асуудал үүсэж байгаа юм.

Энэ бол мэдээж засаглалын асуудал, нэг хэсэг нь байх л даа. Гэхдээ бүр том зургаар бол энэ байгалийн баялгийн шударга хуваарилалт, байгалийн баялгийн хуваарилалтын төлөөх л тэмцэл байхгүй юу. Олон оронд явж байгаа шүү. Олон оронд ч явж байгаа. Одоо хүртэл ганцхан Монгол гэлтгүй ээ.

ChatGPT-ээс ингээд та нар асуугаарай. ChatGPT ашигладаг хүмүүс байгаа байлгүй. Монгол аль түрүүн жишээнд нь орсон явж байна л даа. Монгол нэг жишээнд нь, миний ChatGPT дээр шууд л гарч ирж байна.

Тэгэхээр үүний ард гарахгүй бол бид буцаад энэ чөтгөрийн тойргоосоо гарахгүй ийм нөхцөл байдалтай л байгаа юм л даа. Энэ баялгийн санг бид яаж ийгээд л ард нь заавал гарах ёстой. Хэдэн Засгийн газрын нүүр үзэх юм бүү мэд.

Энэ шударга хуваарилалт руу бид тэмүүлэхгүй л бол буцаад муу жишиг... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

О.Батнайрамдал: Үүнийг хийж чадахгүй бол муу жишиг дэндүү олон.

Яах вэ өнөөдөр бид зүгээр ганц нэг жагсаалаар ч юм уу, эсвэл өнөөдөр бидний нүдэн дээр болж байгаа үйл процессууд яг үнэнийг хэлэхэд цаана нь маш том санхүүжилт, маш том зурсан Пи Ар Стратеги явж байна л даа. Энэ Монголд болоод байгаа юм биш. Бусад орнууд дээр ч гэсэн л яг өндөр санхүүжилттэйгээр ингэж явдаг.

Тэгэхээр үүнийг 196 гишүүн бид их нухацтай, том агуулгаар нь, том зургаар нь харах ёстой. Нэг жижиг детальд төөрчихгүй байх ёстой. Том зургаараа харж энэ дээр бид илүү хэрсүү шийдвэр гаргах ёстой.

Яяагаад гэх юм бол энэ дээр олон нийтийн маш том хүлээлт байгаа шүү. Яг тэд, олон нийт, ард түмэн бүгдээрээ нүдээ цавчихгүй яг ширтээд л харж байгаа.

Тэгэхээр тэр хүмүүсийн нүдний өмнө бид бүх үйл процессоо ил тод явуулаасай л гэж чин сэтгэлээсээ эцэст нь хүсье.

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Оройн мэнд хүргэе. Гишүүд ээ.

Би асуулт асуухгүй. Үг хэлнэ ээ. Төрийн дээр нам гарчээ гэж хүмүүс ярьж байгаа.

Тэгэхээр яг ямар асуудлууд яригдаад байгаа юм бэ гэдэг талаас нэг товчхон мэдээлэл өгөх нь зүйтэй гэж бодож байна.

Өнөөдөр 5 намын 126 гишүүн намынхаа төлөөллийн төв байгууллагын шийдвэрээр нэр дэвшиж, сонгогдоод энэ танхимд сууж байгаа.

2024 оны сонгуулийн үр дүнгээр олонх болсон Монгол Ардын нам хамтарсан Засаг байгуулах шийдлийг төлөөллийн төв байгууллагаараа гаргуулаад, ингээд Ардчилсан нам, ХҮН намд урилга өгч хамтарсан засаг байгуулагдаад явж байгаа юм.

Хамтарсан Засгийн газрын гэрээнд улс төрийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд талуудын намын төлөөллийн төв байгууллагаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ гэж заасны дагуу Монгол Ардын намын Бага хурал 05 дугаар сарын 21-нд шийдвэрээ гаргаж, хамтарсан Засгийн газрын гэрээг зөрчсөн улс төрийн намыг оролцуулахгүйгээр Засгийн газраа бүрдүүлэх шийдвэрийг гаргасан.

Тэгээд манай энэ Бага хурал, ер нь бусад намуудын төлөөллийн төв байгууллагад дандаа дарга нар байдаггүй. Нийгмийн сегмент, салбар бүрийн төлөөлөл, жирийн гишүүд, дэмжигчид гээд олон хүмүүс бий.

Тэгэхээр энэ шийдвэрийг ингэж гаргаад явж байгаа юм. Тэгтэл өнөөдөр Их Хурал дээр орж ирж байгаа тогтоол нь өөрөө хамтарсан Засгийн газрыг дэмжих, итгэл үзүүлэх гэж орж ирж байгаа юм. Хамтрал байхгүй болсон. Ардчилсан нам засгаас гарна гэдгээ Ардчилсан намын дарга нь албан ёсоор мэдэгдсэн. 8 сайд нь өргөдлөө өгсөн байгаа.

Тэгэхээр энэ чинь яг одоогийн нөхцөл байдалд ойлгогдохгүй болчхоод байгаа юм.

Хамтарсан Засгийн газрын бодлогыг дэмжиж тогтоол гаргах гээд байна шүү дээ. Наана чинь хамтрал байхгүй болсон. Ардчилсан намынхан гарна гэсэн байна. Сайд нар нь өргөдлөө өгсөн.

Хэрвээ хамтарсныг дэмжээд санал өгөх юм бол нөгөө дургүй байгаа ламд дарж байгаа сахил хүртүүлсэн шиг юм болох нь л дээ.

Үүнийг юу гэж ойлгох нь бүү мэд байна. Яг үнэндээ.

Хоёрдугаарт нь, бас нэг мессеж их явж байна. Хамтрал байхгүй бол бүх юм байхгүй болох юм шиг. Яг үнэндээ хэдэн жилийн өмнө хил холболтын төмөр замыг барьж байгуулж байхад нарийн царигийн төмөр зам оруулж ирье гэхэд нарийн царигийн төмөр зам барьж байгуулах юм бол танк ачигдаж орж ирээд Монгол Улсыг эзэлнэ гэдэг шиг. Уучлаарай. Тийм зүйл байхгүй.

Энэ намуудын мөрийн хөтөлбөрийн 80 орчим хувь нь давхацсан. Зарим нэг онцлог намуудын мөрийн хөтөлбөрт орсон заалтуудыг оруулаад Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориг зүрхтэйгээр дэмжиж ажиллах эх орон гэж боддог олон гишүүд байгаа гэж би харж байгаа.

Тийм учраас үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон гишүүд цаашлаад дэмжиж ажиллах боломж байгаа гэж харж байна.

Харин энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж чадахгүй гэж яриад байгаа хүмүүсийг би ойлгохгүй байгаа. Яагаад тэгж дүгнээд байгаа юм. Тэдэнд ямар эрх ашиг байгаа юм. Цаана нь. Бодох л ёстой асуудал шүү. Үүнийг. Тэгээд л бүх зүйлийг байхгүй болгоно, харлуулна. Ерөөсөө л ийм л байхгүй бол болохгүй гэсэн ойлголт байж болохгүй шүү дээ.

Энэ дотор чинь эрүүлээр сэтгэдэг. 1 минутаа авчихъя дарга аа.

Эрүүлээр сэтгэдэг олон гишүүд байгаа. Эх орноо гэсэн бодолт сэтгэлтэй олон гишүүд байгаа шүү. Энэ жагсаалтаар орж ирсэн гишүүд дотор ч гэсэн өөр өөр өнцөг ярьдаг олон авууштай зүйлүүдийг ярьж хэлдэг, эх орны төлөө гэж бодож сэтгэдэг олон гишүүд байна гэж харж байгаа.

Аягүй бол ингэж явсаар байгаад Улсын Их Хурлыг муухай харагдуулах нь л дээ. Энэ Улсын Их Хурал ерөөсөө бүтэхгүй гээд. Ийм зүйл рүү түлхэх гэж байгаа хүмүүсийг бол бас болиорой л гэж хэлмээр байна. Эртхэн шиг.

Энд сууж байгаа 126 гишүүн биш юм гэхэд дийлэнх олонх нь энэ олон том мега төслүүдийг, энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө санал нэгдээд нягтраад ажиллаж ирж чадна гэж би харж байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн алга байна. Чинбатын Номин гишүүн.

Ч.Номин: Гишүүддээ оройн мэнд хүргэе.

Өнөөдөр бидний хэлэлцэж байгаа асуудал дан ганц нэг хүн, тэгээд нэг Засгийн газарт итгэл үзүүлэх асуудал биш гэж харж байна. Энэ бол улс эх орны эдийн засаг, улс төр, нийгмийн тогтвортой байдлын асуудал гэж үзэж байгаа.

Бид 10-хан сарын өмнө энд бүгдээрээ нийлээд сууж байгаад Засгийн газраа бүрдүүлсэн. Уригдаж орж ирсэн ч байгаа гэж байна. Чирэгдэж орж ирсэн байгаа ч гэж байна. Эдгээр хүмүүс Засгийн газраа бүрдүүлж байх үедээ хэрхэн ажиллах вэ гэдгээ хамтдаа суугаад тайлагнаж байсан бол одоо ч мөн хамтдаа суугаад яаж ажилласан гэдгээ тайлагнах нь мэргэжлийн ёс зүй болов уу гэж бодож байна.

Тэгэхээр бүх сайд нараа өнөөдөр итгэл үзүүлэх энэ асуудал дээр өөрийнхөө асуудлыг тайлагнах ёстой болов уу гэж үзэж байгаагаа илэрхийлье.

Мөн үүнээс гадна гадаа жагсаж байгаа залуучуудын хувьд дан ганц засаг, дан ганц нэг хүн гэхгүй энд байгаа бүх хүмүүсийг нээлттэй, мөн үүнээс гадна энд гарч байгаа шийдвэрүүдийг нээлттэй байгаасай гэж үзэж байгаа болов уу гэж харж байна.

Тэгээд мөн судалгаагаар ч гарсан. Нийт хүн амын 80 гаруй хувь нь энэ итгэл үзүүлэх саналыг нээлттэй байгаасай гэсэн байна гэдэг судалгаа гарсан. Тэгээд энэ ч утгаараа зарчмын хувьд санал асуулга нээлттэй байх нь зүйтэй гэж үзэж байгаа гэдгээ илэрхийлье.

Өнгөрсөн хугацаанд Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдаар манлайлуулсан Засгийн газрын хувьд маш сайн ажилласан гэж үзэж байгаа. Мэдээж бид цар тахал, дээрээс нь дайн, үүнээс гадна худалдааны зөрчил гээд энэ геополитикийн олон асуудлуудтай байхад бид өнөөдөр эдийн засгаа хоёр дахин өсгөж чадсан. Дотоодын нийт бүтээгдэхүүнээ 4600-аас 6800 болгоод өсгөсөн байгаа.

Тэгээд ард иргэдийн хувьд Баялгийн сангийн энэ олон жил яригдсан зүйлээ илүү амь оруулж ажиллахыг мөн шаардаж байгаа. Үүнийгээ ч илэрхийлсэн судалгаа гарсан байна.

Тэгээд энэ ч утгаараа тогтвортой байдлыг үргэлжлүүлж явах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Өнөөдөр бид дан ганцхан хэрэглээнээс үүдсэн эдийн засагтай, дээрээс нь цөөхөн төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн дээр тулгуурласан экспорттой. Ингээд байж байтал геополитикийн, худалдааны, дээрээс нь олон төрлийн нөхцөл байдлууд үүсэж байгаа энэ үед энэ жижигхэн улсын хувьд бид хамгийн гол зүйл болбол тогтвортой, дээрээс нь олон улсад нээлттэй хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг бий болгох нь хамгийн чухал байгаа.

Тэгээд Ерөнхий сайдаас асуух асуулт байна. Өнөөдөр энэ үүсээд байгаа улс төрийн ойлгомжгүй байдал үргэлжлээд энэ нь засаглалын тогтворгүй байдлыг бий болгож, цаашлаад эдийн засгийн хямрал үүсгэх нөхцөл байдал үүсвэл яах вэ?

Бидний хувьд хамгийн түрүүнд энэ асуудал дээр өртөх хүмүүс бол ард иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгч нар. Эдгээр хүмүүст тодорхой хямрал үүсэх нөхцөл үүсэх үү гэж харж байна уу та? Тэгвэл бид яаж үүнийг шийдэх вэ? Энэ хүмүүсийн амьдралд хамгийн түрүүнд нөлөөлнө. Та үүнийг юу гэж харж байгаа вэ гэдэг асуулт байна.

Тэгээд мөн цаашлаад дахиад хэлэхэд бид бүхэн энэ санал хураалтыг ардчилсан парламент, цаашлаад түрүүн та өөрөө хэлсэн. Сонгодог парламентыг төгөлдөршүүлэх. Дээрээс нь бэхжүүлэх нь чухал гэж үзэж байгаа бол энэ санал хураалтыг нээлттэй явуулж, ардчилсан байдлаар иргэдэд ойлгомжтой байлгах нь чухал гэж үзэж байна. Тэгээд үүнийг танд анхаарч үзнэ үү гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгөх үү? Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын түүхэнд маш чухал асуудал хэлэлцэж байгаа тул гишүүд маань нэлээн нухацтай хандаж, нэгийг бодож, хоёрыг тунгааж байгаа байх гэж бодож байна.

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монголын төр засаг тогтворгүй хэврэг явсаар ирсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газрын дундаж нас 1.8 жил, 17 дахь Ерөнхий сайдтайгаа ажиллаж байна.

Тэгээд Монголын төр засаг тогтворгүй хэврэг байснаар хэн хожсон бэ? Монголын ард түмэн л лав хожоогүй. Үүний цаана ихэнхдээ гадаад, дотоод том ашиг сонирхлууд хүслээ гүйцэлдүүлсээр ирсэн.

Тэгэхээр бид энэ өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд бий болсон төр засагт байгаа асуудлуудыг дүгнэж олон талаас нь. Сүүлийн 3 жилийн хугацаанд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тогтолцооны өөрчлөлтийг хийх гэж бас

хамтарч ажилласан. ХҮН нам энэ дээр улс төрийн манлайлал үзүүлж. Би ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд 21 аймаг, 9 дүүрэг, нийт 160 гаруй сумаар намын даргатай, намынхаа нөхөдтэй хамт ажилласан. Ард иргэддээ энэ ойлголтыг өгч.

Энэ тогтолцооны өөрчлөлт хийгдсээр Монгол Улс дараагийн 30 жилд томоохон төслүүдээ явуулах, хөгжлийнхөө дараагийн шатад орох ямар боломжууд нээгдэх юм бэ гэдэг асуудлыг бид яриад, ингээд явсны хүчинд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өнгөрсөн 76 гишүүнтэй парламент баталж хийсэн.

Одоо энэ шинэ 126-тай парламент уг нь энэ том ололтыг бид цааш нь бататгаад аваад явах үүрэгтэй гэж харж байгаа.

Тэгэхээр ХҮН намын хувьд хамтарсан Засгийн газарт орохдоо анхнаасаа Монгол Улсынхаа эрх ашгийг нэгд тавьж, үнэхээр өнгөрсөн хугацаанд хөгжлийг боомилж байсан томоохон төслүүдээ хөдөлгөө хамтарч. Ард түмнийхээ амьжиргааг өөд нь татъя. Намынхаа эрх ашгийг хойш нь тавья гээд.

Ингээд намын гишүүд дэмжигчдэд тодорхой эргэлзээ, тээнэгэлзээ төрсөн хэдий ч улс орныхоо эрх ашгийг нэгд тавиад ингээд нэр төртэйгөөр зүтгээд ажиллаж байгаа.

Манай намаас Засгийн газарт ажиллаж байгаа 2 сайд ч гэсэн ажил үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэж байгаа гэж харж байгаа.

Шадар сайд Т.Доржханд хамгийн галтай асуудал энэ эрчим хүчний реформ. Өнөөдөр бид гаднаас эрчим хүч, нефть гээд олон зүйлээр хараат байна. Энэ хараат зүйлээсээ салах гээд томоохон зорилтууд тавиад ажиллаж байна.

Боловсролын салбарт ч гэсэн томоохон өөрчлөлтүүд хийх гээд боловсролын тэгш хүртээмжтэй байдал, чанарыг нэмэгдүүлэх, багш нарын үнэлэмжийг нэмэгдүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх гээд ийм олон зүйлүүдийг зорилтоо болгоод ажиллаж байгаа. Монгол Улсын Засгийн газраас ч гэсэн 2026 оныг боловсролыг дэмжих. Үүнтэй холбоотойгоор жил болгон зарласан.

Тэгэхээр одоо ийм байдлаар Засгийн газар ажиллаж байгаа. Үр дүн гарч байгаа. Эхнээсээ. Гадна, дотноос ч гэсэн хөрөнгө оруулалтууд орж ирэх эхний ингээд алхмууд хийгдэж байгаа үед энэ Засгийн газарт, Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудал хэлэлцэж байгаа нь энэ бол утга агуулгын хувьд нэг их уялдаа холбоогүй харагдаж байгаа.

Тэгэхээр энэ тогтолцоонд учраад байгаа, одоо энэ хамтарсан Засгийн газар хэрвээ ингээд огцорсон тохиолдолд дараагийн Засгийн газар тогтвортой явна гэдэгт эргэлзээтэй байна.

Дангаараа ч явахгүй, хамтраад ч явахад хэцүү. Энэ талцлууд. Өнгөрсөн хугацаанд ч гэсэн зарим нэг хууль батлагдахдаа 64-өөр гарахад бас хүндхэн байсан юм шүү дээ.

Тэгэхээр энэ засаглалын хямрал руу орох эрсдэл байна.

Тэгэхээр Ерөнхий сайд Та яг энэ дээр өөрийнхөө байр суурийг хэлээч ээ. Цаашдаа парламентын ардчилалыг бэхжүүлэх, төр засгийг тогтвортой байлгах, Монгол Улсыг дараагийн шатад нь гаргана гэсэн үзэл санаан дээрээ баттай байх уу? Энэ яг таны өөрийн байр суурь уу? Нэгд. Танай намын байр суурь уу гэдгийг тодотгож асууя? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм учраас би нухацтай хандах ёстой гэж үзээд л энэ итгэл үзүүлэх асуудлыг оруулж ирж ингэж ярьж байгаа нь энэ.

Яагаад гэхээр ингэж бөөнөөрөө ярихгүй бол тэгээд л ёстой нөгөө түрүүн заан ярьдаг шиг зарим нь 4 хөлийг нь тэмтрээд, зарим нь гэдсийг нь тэмтрээд, зарим нь хошууг нь тэмтрээд, зарим нь сүүлийг нь тэмтэрдэг гэдэг шиг байж байгаад л нэг шийдэл гаргана.

Тэгээд шийдэл гаргах амархан байдаг. Шийдлийн дараах үр дагавар өөрөө бараг засагдталаа тэгээд 4, магадгүй 8, 12 жил ч болох ийм тохиолдол байна шүү дээ. Байна. Бусад улс орнуудын туршлага ийм.

Тийм учраас л би ганцаараа шийдэл бүтэн гаргаж чадахгүй. Парламенттайгаа ний нуугүй л тал талаас нь ярьж, доор бүрнээ нэг дүгнэлт хийгээд.

Тэгээд энэ шийдэл маань дараа дараагийн эдийн засгийн болон засаглалын хямрал руу явахгүй байх, тэр дотоод мэдрэмжтэй үлдэх, мэдээллийн нэгдсэн байдал руу орох, улс төр энэ ашигтай даа гэж харж байгаагаасаа хойш татах л ийм асуудал дээр л бид хүрч чадвал зөвшилцөж чадна л даа.

Түүнээс яах вэ, өнөөдөр ингээд шийдвэр гаргавал дараагийн сонгуульд хэрэгтэй дээ. Ингэвэл ер нь яах вэ, улс төрийн хувьд бол гоё оноо доо гэж л хараад эхлэхээр тэгээд л бид том агуулгаараа ер нь алдаад л байдаг юм билээ.

Том агуулгаараа улс нь алдахаар бүгдээрээ л ер нь алддаг. Цаг хугацаагаа алддаг иймэрхүү л зүйл болдог юм билээ.

Зүгээр яах вэ, үүнийг би нөгөө 2050-ийг бичиж байх үед олон эрдэмтэн, судлаачидтай уулзаж байсан, олон улс төрчидтэй уулзаж байхад тухайн үеийнх

нь шалтаг нэг тийм сонин шалтгаанаас болоод замаасаа гарч яваад, тэгээд л тэр нь явсаар байгаад засаглалын тийм гүнзгий хямрал руу орсон. Хайран цаг хугацаа алдсан.

Тэгээд бүр сүүлд нь хэдүүлээ уулзангуутаа шал дэмий юмнаас болоод хайран юмаа баллаж дээ л гэж бодоод сууцгааж байдаг юм билээ.

Тийм учраас үүнийг хэдүүлээ талаас нь ярилцах ёстой гэдэг нь дүгнэлт үлдээсэй л гэж би бодоод байгаа юм.

Би дахиад хэлэхэд одоо жишээлбэл надад ингээд л энэ албан тушаалд хоргодоод л, тэгэнгүүтээ нэг ийм асуудал гарангуут нь тэрийг учиргүй нэг их тийм бүх хүнд нялзаагаад л, тэгээд л нэг ийм асуудлаас бэмбэгнээд л ийм байгаад байгаа юм бол огт байхгүй.

Би зүгээр дараагийн гарах үр дагаварт л санаа зовоод байгаа учраас тал талаас нь хэдүүлээ ярья, хамтын шийдэл гаргачихъя л гэж байгаа юм шүү. Тийм. Үүнийг парламентын эрхэм гишүүд маань зөвөөр ойлгоорой.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Оройн мэнд. Миний хувьд “Огцрох амархан” залуусын жагсаал дээр очиж гарын үсэг зурсан гишүүдийн нэг.

Тэгээд надад 3 шалтгаан, дээрээс нь 3 ярих зүйл байгаа юм.

Нэгдүгээрт нь, 126 гишүүнтэй энэ парламентын залуучуудын төлөөлөл буюу “Gen Z”-ийг төлөөлж байгаа хүний хувьд би залуучуудынхаа дуу хоолой болох нь миний үүрэг.

Тэгэхээр Ерөнхий сайд хэн байхаас үл хамаарч орлогоо нотол гэдэг шаардлагыг тавих нь зүй ёсны хэрэг юм гэж би үзэж байгаа юм.

Хоёрдугаарт, Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газар Ардчилсан намтай хамтарсан энэ хамтралын үр дүнд томоохон төслүүд хөдөлсөн нь үнэн юм. Ардчилсан намын сайдууд маш үр дүнтэй, бас хурдтай ажиллаж чадсан.

Тэгэхээр үүнд талархахаас өөр аргагүй.

Гэхдээ өөрийн чинь эсэргүүцдэг нэгээхэн том бүлгүүдийн нэг нь миний харж байгаагаар Монголын нийгмийн оюун санаа гэж хэлэгддэг хүмүүс өөрийн чинь асар ихээр эсэргүүцдэг. Учир шалтгаан нь юу вэ гэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Халтмаагийн Баттулгыг Та өөрийнхөө зөвлөхөөр авч байсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор түүний баримталдаг улс төрийн бодлогууд буюу уул уурхайн салбарт, тэгээд дээрээс нь эдийн засгийн чухал ач холбогдолтой төслүүд, тэгээд хувийн өмчид халдах, халамжийн

бодлогууд гэх мэт бодлогуудтай өөрийн чинь адилхан байр суурь илэрхийлж явдагт нь энэ хэсэг хүмүүс ихээхэн дургүйцэж явдаг.

Тэгэхээр энэ маань буцаагаад энэ хамтарсан засгийг эсэргүүцэхдээ биш энэ бодлогыг чинь эсэргүүцдэг хэсэг нь байгаад байгаа гэдгийг хуралд би бас өнөөдөр хэлье гэж бодож байгаа юм.

Дээрээс нь энэ дээр хэрвээ, би бол хувь хүний талаар ярих гээгүй. Энэ маань бол та хувийн өмч, чөлөөт зах зээлийг хамгаалж ажиллаж чадах хүн үү гэдэг асуултад л хариулах нь өөрөө энэ хүмүүс чухал байгаа юм гэж би үзэж байгаа юм.

Гурав дахь асуудал маань урьд шөнө ТЭЦ-3 дээр маш том хэмжээний осол гарсан. Үүний үр дүнд харамсалтайгаар нэг ашиглалтын инженер залуу маань амь насаа алдсан байгаа. Өглөө 09.00 цагийн үеэс эхлээд би Б.Чойжилсүрэн сайдаас мэдээлэл авъя гэж хэлэхэд одоогоор ямар нэгэн байдлаар холбогдож мэдээлэл өгөөгүй. Албан бичгээр холбогдсон. Албан бичгээ явуулахад мэдээлэл өгөөгүй.

Тэндээс ажилладаг хүмүүс нь надтай холбогдож байгаа. Тухайн шөнө ээлжинд гарсан ажилчдыг тухайн станцаас гаргахгүйгээр утсыг нь хурааж аваад энэ талаар мэдээлэл гаргах юм бол ажлаас чинь хална гэж сүрдүүлэг байдал гаргаж байна гэж надад мэдээллүүд ирсэн.

Тэгээд Эрчим хүчний яам хэр удаан энэ асуудлыг хав дарах зорилготой байгаа вэ? Миний хувьд үүнийг өглөө мэдэж байсан ч гэсэн гарч ирж яриагүй нь үүнийг улс төрийн сенсаци болгоод ч байдаг юм уу, эсвэл хүний амиар би улс төр хийхийг хүсээгүй учраас өнөөдрийг, оройг хүртэл хүлээлээ. Гэтэл Эрчим хүчний яам одоо хүртэл хариу өгөхгүй байгаа нь үүнийг гаргаж ирж ярихаас өөр аргагүй байдал үүсэж байна.

Тэгэхээр Та Эрчим хүчний яамны Б.Чойжилсүрэн сайдыг хэр ажилласан гэж дүгнэж байна? Энэ дээр эрчим хүчний реформыг бид хийж чадсан гэдэгт.

Би Улсын Их Хурлыг маш сайн ажиллаж чадсан гэж харж байгаа. Улсын Их Хурал дээр бүх бодлогууд дэмжигдсэн. Гэтэл гүйцэтгэх буюу засаглал дээрээ бид очоод, засаг дээр очоод ажлууд маань унасан.

Хамгийн сүүлийн асуулт бол Ардчилсан нам чөлөөт зах зээл, хувийн өмчид тулгуурласан бодлого хэрэгжүүлдэг нам. Танай нам бол зүүний нам. Тэгээд энэ хоёрын хооронд үзэл баримтлалын маш том ялгаа байгаа.

Тэгээд статистикаас хараад үзэхээр сүүлийн 12 жилийн хугацаанд халамжийн төсөв маань улсын төсөвт эзлэх хувь нь 10 дахин нэмэгдсэн. 2012 онд 3.7 байсан бол 2023 онд 9.4 болж халамж нэмэгдсэн байна.

Тэгэхээр үүний үр дүнд нь манай Монгол Улс ямар ч өрсөлдөх чадваргүй болсон.

Тэгэхээр таны тэргүүлсэн өмнөх Засгийн газар, одоогийн Засгийн газар халамжийг хавтгайруулсаар байгаа. Халамж хавтгайрсан.

Тэгэхээр Монгол Ардын нам ер нь цаашид энэ халамжийг бууруулж, хөдөлмөр эрхлэгч нараа дэмжиж, татварыг бууруулж чадах юм уу? Цаашид ч гэсэн. Хэн Ерөнхий сайд байхаас үл хамаарч Та Монгол Ардын намын даргын хувьд үүнийг хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Нэгдүгээр асуулт.

Х.Баттулга гэдэг хүнтэй бас нэг ийм харддаг гэх юм уу, ийм асуудал улс төрийн хүрээнд их явдаг юм шиг байгаа юм.

Яг бодитой үүссэн асуудлыг зүгээр эргээд бодвол Х.Баттулга гэдэг Ерөнхийлөгч Ерөнхийлөгчөөр ажиллаж байх хугацаанд энэ 6 жилээр нэг удаа гэдэг Үндсэн хуулийн энэ асуудал яригдаж байсан.

Парламентын танхимд 2 удаа унаад, 3 дахь удаад нь би үг хэлж энэ асуудлыг нийт гишүүдээр дэмжүүлэх асуудлыг тухайн үед би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх үедээ хийж байсан юм. Энэ протоколд байгаа.

Тэгэхээр, хэрвээ би жишээлбэл тэр хүний бодлогыг дэмждэг ч юм уу байсан бол 6 жилээр нэг удаа гэдэг энэ заалтыг тухайн үед сөрөн сөрөн хийхгүй байх ёстой. Юм фактаар л яригдах ёстой. Түүнээс биш ямар нэгэн байдлаар ховоор ч юм уу биш.

Хоёр дахь зүйл. Танай бүлгийн дарга Д.Ганбат дарга мэдэж байгаа. 6 жилээр нэг удаа гэдэг заалттай холбоотойгоор дэвших эрхтэй юу, үгүй юу гэдэг асуудал үүссэн.

Энэ асуудал намайг Ерөнхий сайд болсны дараахан болсон. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ерөөнд манай Д.Тогтохсүрэн дарга, Д.Ганбат дарга нарын хажууд бид хоёр нэлээдгүй юм болж байсан юм. Үүнийг Д.Ганбат дарга маш сайн мэдэж байгаа. Манай Д.Тогтохсүрэн дарга ч мэдэж байгаа.

Тухайн үед нэг нь Зэвсэгт хүчин дээр очоод цэрэг хөдөлгөх, нэг нь Батлан хамгаалах яаман дээр очоод хамгаалах тухай асуудал яригдаж байсан. Энэ л яах вэ, төрийн л нэг ийм түүхийн л нэг процесс.

Хэрвээ би хамтарч ажиллах байсан бол Ерөнхийлөгч байх үед нь л хамтарч ажиллах байсан.

Хамгийн сүүлд Ерөнхийлөгч байсан хүмүүс парламентад орж ирэхийн би хатуу эсрэг байр суурьтай байдаг.

Манай өрөөнд Л.Гантөмөр дарга, Т.Доржханд дарга, Д.Амарбаясгалан дарга, Г.Занданшатар дарга гээд уулзаж байсан. Тэр нь юу вэ гэхээр Үндсэн хууль яваад, жагсаалт шийдэгдэж байх үед. Дараа нь бүсчилсэн, томсгосон тойрог баталж байх үед.

Миний хувьд ганцхан хүсэлтийг тавьж байсан. Х.Баттулга Ерөнхийлөгчийг дэвшүүлэхгүй шүү гэдэг. Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийг дэвшүүлэхгүй шүү гэдэг. Жагсаалтад оруулахгүй шүү. Тэгвэл наад жагсаалт чинь шал утгаа алдсан юм болно.

Бид бүгдээрээ хамтдаа гар барьсан. 5, 6 хүн байсан. Гэтэл харамсалтай нь энэ асуудал болсон.

Тийм учраас хүн биш, илүү тийм зарчимтай л байх ёстой. Миний хувьд жишээлбэл 2019 онд ярьж байсан байр сууриасаа өөрчлөгдөх боломжгүй шүү дээ. Яагаад гэхээр протоколд байж байгаа. Би тэр байр суурин дээрээ л байгаа.

Би ер нь буурин дээрээ л байгаа. Бичсэн ном дээрээ байгаа, ярьж байсан үг дээрээ байгаа, зогсож байсан зарчим дээрээ л байгаа. Тийм байна.

Эрчим хүчтэй холбоотой асуудал дээр С.Цэнгүүн гишүүн маш том дэмжлэг үзүүлсэн. Би маш их талархаж байгаа.

Гүйцэтгэх засаглал талд хурд дутсан асуудлууд байгаа. Би хүлээн зөвшөөрч байгаа. Гэхдээ хэдүүлээ эрчим хүчний үнийг чөлөөлж чадсан. Энэ ч бас өнөөдрийн нийгмийн бухимдалд нэлээн нөлөөлж байгаа юм байгаа. Судалгаагаар. Гэхдээ л үүнийг хийхээс өөр аргагүй л байсан зүйл. Үүнийг өөрөө мэдэж байгаа.

Залуучуудтай холбоотой асуудал дээр талархаж байгаа. Энэ асуудлыг гаргаж ирээд тавьж байгаа. Очсон ч гэсэн миний хувьд тэр бол зөв зүйл гэж бодож байгаа. Улсын Их Хурлын гишүүн өөрийнхөө л бүрэн эрхийн дагуу хийх ёстой зүйлээ л хийх ёстой.

Яах вэ, энэ зүйл манай нам дотор сэдэл болсон уу болсон. Тэр нь өөрөө юу вэ гэхээр үгүй ээ тэгээд хамтарчхаад ийм ийм зүйл дээр энэ чинь хоёр, гурван удаа давтагдлаа шүү дээ гэдэг зүйл манай нам дотор асуудал үүссэн.

Тийм учраас зүгээр цаашлаад би энэ сүүлийн хамтрал гэж ерөөсөө бодохгүй байгаа. Хамтрах байх. Олон зүйлийг ярих байх. Гэхдээ энэ маань бас их тийм том сургамж болж үлдэх ёстой байх. Тэгээд цаашдаа илүү бид магадгүй

бие биедээ мэдээлэл дамжуулах, ил тод, нээлттэй байх, асуудлыг яаж тайлбарлах вэ гээд олон асуудал дээр ярих нь зүйтэй байх.

Хоёр өөр үзэл бодолтой, гурван өөр үзэл бодолтой намууд хамтрах бол бас нэлээн сорилттой байдаг юм байна. Ингээд шийдвэр гаргах гэхээр бас л сорилттой. Яагаад гэхээр энэ харах өнцгүүд өөр. Гэхдээ бас давууч талтай байдаг юм байна. Тал талын өөр өнцгөөс хараад шийдлүүдийг гаргаж чаддаг.

Тийм учраас илүү Эдийн засгийн яамыг Ардчилсан нам аваад илүү тийм либералчлах бодлогыг хийх зүйлийг би тууштай дэмжсэн. Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой, бас ингээд энэ хууль хяналтын байгууллага, Лодойгийн ч гэсэн бас ярьж байсан тэр сэтгүүлчидтэй холбоотой эрх чөлөөг хамгаалах асуудлыг би бүрэн дэмжих эрхийг О.Алтангэрэл сайдад өгч л ажилласан. Та бүхэн асууж болно.

Гэхдээ О.Алтангэрэл сайдаас өөрөөс нь үл хамаарсан асуудлууд бас зөндөө байсан. Та хэд үүнийг яриарай. Тэр нь юу вэ гэхээр Хууль зүйн сайд болсноор бүх зүйлийг шийдэх боломж байдаггүйг Та бүхэн олж харна.

Тэгээд хэдүүлээ эндээ дүгнэлт хийгээд явах нь зүйтэй юм гэдгийг л хэлье.

Тэгээд талархаж байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Бүгдэд нь энэ оройн мэндийг хүргэе.

Ер нь явж байгаа үйл процесс, энэ асуултад авч байгаа хариулт, мэдээлэл дээрээ тулгуурлаад хувь хүний хувьд дүгнэлт хэлэхэд энэ асуудал нийгэмд бодит мэдээлэл дээр тулгуурласан, яг юу болов. Энэ хоёр, гуравхан долоо хоногийн дотор юу, яагаад ингээд ийм болов гэдэг ийм бодит дүгнэлтийг тунгаан бодож хийх орон зай ч байсангүй, цаг хугацаа ч байсангүй ээ гэдгийг л би хэлмээр байна.

Тэгээд яах вэ, энэ асуудлыг манай гишүүд маань ярьж байна. Ер нь цаана нь өөр учир шалтгаан байсан юм биш үү гэдэг асуудал байгаа.

Тэгээд энэ итгэл үзүүлэх Ерөнхий сайдын тогтоолыг орж ирэхэд миний хувьд маш анхааралтай харсан зүйл нь мэдээж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт баталсан төслүүд байгаа.

Тэгээд сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэхэд тууштай хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг шаардлагатай байна гэдэг үг нь маш анхаарал татсан.

Хуульч хүний хувьд үүнтэй холбоотой асуудлууд Үндсэн хуулийн цэц дээр яаж явж байгаа гэдгийг анхаардаг.

2023 оны 06 сарын 21-нд нэр бүхий иргэдээс Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13.1.1-ийг цэцэд өгчихсөн байгаа. Үүгээр нь цэц маргааныг нь үүсгээд шийдвэрлэсэн байгаа.

Хэзээ нэгэн цагт энэ шийдвэрлэгдэх юм бол Үндсэн хуульд 2019 онд өөрчлөлт орсон асуудлаар ч гэсэн дахин өөрчлөлт орох боломж, үүд хаалгыг нээх боломж тэнд харагдаж байсан.

Ер нь бид бас их богинохон ой санамжтай байна. Бид 2019 онд парламентын ардчиллаа илүү бэхжүүлье. 2023 онд олон намын оролцоотой парламентыг төгөлдөршүүлье гээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хийсэн. Үүгээрээ ч бид дандаа хамтарсан засагтай байх нь. Олон дуу хоолой, олон өнгийн дуу хоолойгоо бид парламент дээрээ хэлэлцэж, энэ дээрээ шийдвэр сайн гаргаж байя гэдэг шийдэл рүү явсан.

Тэгээд одоо ингээд хамтарсан Засгийн газар үүнийхээ дагуу байгуулаад 10-хан сар болж байхад ерөөсөө дангаар засаглах ёстой гээд ийм асуудал руу чирч байгаад хувь хүний хувьд дараа дараагийн засаглалын хямрал руу очих вий гэсэн үнэхээр болгоомжлол байна.

Тэгээд засаглалын хямрал хоёр жилийн өмнө бид улс төрийн намууд юу хийж тохирлоо. Одоо ингээд хоёр жилийн дараа дөнгөж хамтарсан засгаа хөл дээр нь босоод үр дүнгээ эхнээс нь гаргаад явж байхад ийм юм руу түлхэж байгаад бид Улсын Их Хурал анхааралтай хандах ёстой болов уу л гэж бодож байна.

Ер нь сүүлийн үед харж байхад Улсын Их Хурал руу, парламентын 126-тай жагсаалт. Тийм ээ. Салбар салбарын төлөөлөл орсон энэ тогтолцоо руу санаатай санаандгүй дайрах юмнууд үзэгддэг.

Улсын Их Хурлын нэг гишүүн нь сарын 20 сая төгрөгийн цалинтай л гэнэ. Худал мэдээлэл сэвнэ.

Одоо ингээд Улсын Их Хурлын гишүүн нь өөрөө тооны баримжаагүй юм шиг байгаа юм. 2 их наядыг Улсын Их Хурлын гишүүдэд өнөөдөр тарааж байна гэдэг мэдээлэл байна гээд 05 сарын 16-нд мэдэгдсэн. Гишүүд үүнийгээ нотол гэж шаардсан. Чуулган дээр байр сууриа илэрхийлнэ гэж Ч.Лодойсамбуу гишүүн хэлсэн боловч одоо хүртэл загас мэт дуугай байна.

Тэгээд энэ мэтчилэн Улсын Их Хурлынхаа, парламентынхаа нэр хүндийг өөрсдөө унагадаг, эсвэл ийм сошиал харлуулалт, гүтгэлэг дээр яваад байх юм бол бид энэ засаглал маань үнэндээ иргэд ч гэсэн итгэх итгэлцэл нь байх уу гэдгийг бид хаана хаанаа бодолцох ёстой гэж бодож байна.

Би хамтарсан засгийг дэмжсэн. Одоо ч дэмжиж байгаа. Хамтарсан засгийн үед шийдэж чадаагүй олон юм явсан. Би энэ цохон бас Ардчилсан намын Л.Гантөмөр, ЦТуваан сайд гэх мэтчилэн юмыг хийчихье, бүтээчихье гээд сайн ажилласан сайд нартаа баярлалаа гэж хэлмээр байна.

Залуучууд, аж ахуйн эрхлэгчид ч гэсэн надад хэлсэн. Танай намын ах сайд нар чинь эс үйлдэхүй гаргадаг. Юу ч шийддэггүй. Дандаа эс үйлдэхүй. Ардчилсан намынхан бол юм шийдчихье гэсэн хүсэл зориг, эрмэлзэл харагдаж байна шүү, шийдэж байна шүү гэдэг юмыг хэлж байгаа.

Тэгэхээр сайн сайн асуудлуудаа бид нэгтгээд ард иргэддээ хэрэгтэй л юмаа үүгээрээ хийе ээ гэдэг... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: О.Номинчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: Хүсэл зорилго аль аль талдаа байсан болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр бид Улсын Их Хурлын хувьд дахиад 3 жилийн л хугацаа байгаа. Эндээ ард иргэдийнхээ хувьд хамгийн бодитой, ер нь бол эдийн засгийн өсөлтийн хамгийн шударга хэмжүүр бол иргэн Баяраагийн карманд хэдэн төгрөг байна вэ л гэдэг асуудал шүү дээ.

Тэгэхээр ийшээгээ чиглэсэн бодлогоо үр дүнтэй, хоорондоо зөвшилцөж, тэгээд үүнийгээ шийддэг байхын төлөө л хамтарсан засаг байх ёстой гэж бодож байна. Үгүй бол бид дахиад л засаглалын хямрал, дараа дараагийн бусад янз бүрийн нөлөөлөл гарах вий дээ гэсэн болгоомжлол байгаагаа би бас яг энэ мөчид протоколд хэлж тэмдэглүүлмээр байна.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Бүгдэд нь энэ оройн мэндийг хүргэе.

Би Ерөнхий сайдаас асуух асуулт маань өмнө ч гэсэн сурвалжлагчийн асуултад хариулж байсан. Гол нь орлогоо нотол гэдэг асуудал байсан.

Тэгээд орлогоо яагаад нотлох боломж олгохгүй ийм яаралтайгаар нэгдүгээрт Бага хурал зарлагдаад, Бага хурал нь шал өөр асуудал авч хэлэлцээд, дараа нь Их Хуралд орж ирэхдээ бүр өөр гуравдагч асуудал болж орж байгаа юм.

Үнэхээр би логик, дэс дараал бол хоёрыг нь ойлгож амжаагүй. Ойлгохгүй байсан.

Өнөөдөр Ерөнхий сайд нээлттэй, ил тод, шууд асуултад хариулаад явж байгаад талархаж байна. Хэд хэдэн асуултад энэ тодорхой болж байна гэж би ойлголоо.

Ийм учраас эдгээр асуултууддаа хариулт авсан гэж үзээд хэдэн өөр асуултыг тодруулъя гэж бодлоо.

Хамтарсан Засгийн газрыг энэ парламент дэмжсэн. Ардчилсан намын сайд нарыг сайн ажиллаж байсан гэдгийг бүх намын гишүүд нь ярьж байна. Хүлээн зөвшөөрч байна.

Хурдтай асуудлуудыг шийдлээ. Зориг гаргаж ажиллалаа. Амаргүй ажлуудыг амжууллаа гэж хэд хэдэн удаа ярьсан.

Та ярьсан асуудал бол юу ч гэсэн эдийн засгаа тэлчихье. Том эдийн засагтай болчих юм бол нийгмийн асуудал шийдэгдэнэ. Дараа жилээ боловсролын жил болгоё. Боловсролын жилийн дараа заавал эрүүл мэндийн жил болдог юм.

Тэгэхээр Та бодож байсан, ярьж байсан, хэлж байсан тэр реформоо хий.

Нийгмийн эрүүл мэндийн асуудал бол 50 хувь нь эрүүл мэнд, тусламж үйлчилгээнээс гадуур байдаг, салбар дундын асуудал байдаг юм гэж ярьсны дараа салбар хоорондын уялдааг хангах гэж Үндэсний хороо байгуулаад энэ дээр нь над шиг хүмүүс салбар салбарын төлөөллийг оруулж ажилласан.

Тэгэхээр Та энэ ажлаа үргэлжлүүлэн ажиллах тэр итгэл, зориг, хүч, эрч байна уу? Тэгнэ гэж бодож байгаа бол ямар байдлаар энэ ажил явж байж энэ асуудлууд шийдэгдэх болно гэж харж байна аа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, та өөрөө ярьсан, төлөвлөсөн ажилдаа итгэлтэй байгаа бол Та сая хэллээ. Засаглал тогтворгүй болж, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, намууд зөвшилцөж чадахгүй бол парламентын засаглалын талаар олон нийтийн санаа бодлыг эргэлзээнд оруулж, улмаар ардчилсан парламентын засаглалыг мөхөлд хүргэх эрсдэлийг дагуулж байна гээд ярьчихлаа.

Энэ Засгийн газар тэгэхээр дотоод улс төрөө давж гарч чадахгүй бол цаашид засаглалын тогтвортой байдлыг хэрхэн хангах вэ? Гаднын нөлөөллөөс яаж үүнийг хамгаалах вэ? Яаж Та оруулж ирсэн энэ LEGACY эмэгтэйчүүдийн квотыг ихэсгэсэн тоо, салбар салбарын төлөөлөл, энэ жагсагчид, энэ залуучуудыг, энэ итгэл үнэмшлийг нь Та яаж төрүүлж, яаж цааш нь үргэлжлүүлж явъя гэж бодож байна аа?

Эдгээр асуултад Та хариулсны дараа би саналаа хэлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ парламент 126-тай болж бүрдсэн нь Монгол Улсын ардчиллын түүхэнд тодоос тод бичигдэх ийм алхам болсон гэдэг ийм хатуу итгэл үнэмшилтэй би байгаа. Маш их бахархаж байгаа.

Зөвхөн тойргоос сонгогдсон гишүүд биш нийгмийн сегментийг төлөөлсөн олон дуу хоолой орж ирсэн нь энэ парламентын хамгийн онцлог зүйл.

Тийм учраас мэдээж дөнгөж 10-хан сар болж байна. Парламент өөрөө хэлбэршин төлөвшиж байгаа ийм цаг хугацаа гэж би бодож байгаа.

126-тай парламентад маш их хүндэтгэлтэй хандаж байгаа учраас миний хувьд өнөөдөр илэн далангүй ярих энэ зүйл маань өөрөө парламентын ардчилалд оруулж байгаа миний өчүүхэн хувь нэмэр гэж би бодож байгаа. Түүнээс учир битүүлэг, чимээгүй, ингээд нэг ийм ингээд гээд явчихыг би бас хүсээгүй юм.

Тийм учраас парламентын хувьд олон сорилт ирнэ. Дэлхий маш их хуваагдмал боллоо. Дэлхийн том гүрнүүд өөрийн бодлогоо эрээ цээргүй тулгадаг боллоо.

Тэгэхээр өнөөдөр байтугай л сорилтыг Монголын парламент даван туулах өдөр ирнэ.

Тийм учраас бид асуудлаа юу ч болсон ил тод шийдлээ гаргадаг л байх ёстой. Парламентын хувьд мэдээж Ерөнхий сайдын хувьд хамтарсан Засгийн газар зөв гэдэгт би хатуу итгэл үнэмшилтэй байгаа. Яагаад гэвэл эдийн засаг нь хүнд байгаа учраас би тэгж бодоод байгаа юм шүү. Парламентын хувьд олонх нь олонх шиг, цөөнх нь цөөнх шиг байж мэтгэлцээн болж, хяналт тэнцэл байж, асуудлыг шүүмжилж, тэр асуудал нь өөрөө ил тод байдлыг хангаж явах ийм алтан дүрмийг би үргэлж дэмждэг.

Тийм учраас Д.Батлут гишүүний хэлээд байгаа үнэн. Хамтрахгүйгээр бүх зүйл болохгүй болох гээд байгаа тийм зүйл байхгүй. Адилхан л тоотой парламент аль ч улсад зөндөө байгаа.

Тийм учраас амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилнэ, мэтгэлцээн явдгаараа л явна.

Тийм учраас парламентын ардчиллын хувьд энэ илүү тийм шинэ соёл болж цаашдаа бид илүү парламентын мэтгэлцээнээ төгөлдөржүүлээд ингээд л явах нь л хамгийн чухал.

Тийм учраас энэ бол Та бүхний хувьд цаг хугацаа эхэлж байгаа зүйл юм. Үүнийг бид доор дороо бодох ёстой.

Миний өнөөдөр орж ирж тайлбарлаж байгаа энэ зүйл юу вэ гэхээр шинэ 126-тай парламентын нөгөө анхны бүрдүүлсэн Засгийн газар нь нэг жил болоогүй учраас би жоохон санаа зовж байгаа юм. Санаа зовж байгаа.

Дээрээс нь энэ маань өөрөө нийгэмд бас буруу зөрүү ойлголт өгөөд, цаашдаа та хэд маань өнөөдөр ямар ч шийдвэр гардаг бай Засгийн газраа илүү нэг ингэсэн, тэр тэгсэн, тэр мэндлэхгүй өнгөрлөө, орж ирсэнгүй, ингэсэнгүй, тэгсэнгүй гэдэг ийм деталиас илүү том зургаар нь энэ бол бидний бүрдүүлсэн Засгийн газар, ийм агуулгаар ингэж хандах нь зүйтэй гэдэг яг энэ зүйлийг нь дэмжих нь нэг үгээр хэлбэл бид хамтдаа нэг завин дээр байгаа шүү гэдгийг би хэлэх нь зүйтэй болов уу гэж бодсон юм.

Хэн нэгэн нь сайд болно. Сайд болсон хүн завгүй болно. Бүх хүнтэй уулзаад яваад байх цаг сайдад байдаггүй. Ингээд л асуудал эхэлдэг. Энэ нь өөрөө парламентын ардчилалыг жоохон тийм утгагүй харагдуулаад байх бас нэг зүйл энэ байдаг. Тэгвэл ингэнэ, ингэвэл тэгнэ гээд байдаг.

Тийм учраас экспертүүд, жагсаалтаар орж ирсэн олон залуучууд Та бүхнээс Би өнөөдөр намайг дэмжээч ээ гэж би ерөөсөө гуйхгүй.

Би ганцхан зүйлийг хүснэ. Тэр нь юу вэ гэхээр энэ жагсаалт зөв байсан гэдэг нийгмийн дүгнэлтийг л Та бүхэн 2028 он гэхэд үлдээж өгөхийг л би хичээнгүйлэн хүснэ.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Монгол Ардын намын Бага хурал дээр найтаасан. Улсын Их Хурал ханиад хүрлээ. Засгийн газар хатгаа аваад одоо хагалгааны ширээн дээр байж байна.

Өнөөдөр институц хоорондын энэ зөрчилдөөнөөс болоод улс оронд Засгийн газрууд тогтворгүй болоод асуудал үүсвэл Монгол Ардын намын 300 тэр дарга нар асуудлаа хариуцна гэдгийг албан ёсоор хэлье.

Энэ Үндсэн хууль зөрчиж байгаа. Та нар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг 100 хувь зөрчиж байна.

Улсын Их Хурал бол төрийн дээд эрх мэдэл. Түүний дээр Монгол Ардын намын Бага хурал сандайлсан. Бага хурал нь өөрөө баялгийн хэдхэн гэр бүлүүдэд сандайлуулсан байгаа байх. Энэ тэнэглэлийг бид зогсоох ёстой.

Монгол Улсын Ерөнхийлөгч үе үеийн Засгийн газарт нударгаа үзүүлж гайхуулдаг. Дарангуйлагч болох тэр амбиц нь их байдаг. Энэ Монголын 30 жилийн түүх шүү дээ энэ бол.

Тэгээд өнөөдөр Улсын Их Хурал дархлаагаа хамгаалах ямар ч чадваргүй. Үнэнийг ярьж чадахгүй. Явцуу эрхийг шууд онилоод ярьж чадахгүй. Бүгдээрээ Авлигатай тэмцэх газар дээр, шүүх дээр, прокурор дээр бөлдөгтэй юм шиг л ингээд таг дуугүй. Тойруулаад л байна.

Монгол Ардын намын Бага хурал ийм арчаагүй, нөлөөлж Засгийн газрыг өнөөдөр боомилж байгаад би харамсаж байна.

Би Засгийн газрыг шүүмжилдэг. Уран дээр, байгаль орчны хуулиуд дээр. Тэгэхдээ би асуудлаа ярьдаг. Хэзээ ч дарга, сайд, амбиц байдаггүй. Би зөвхөн асуудлыг ярьдаг. Тоо баримттай, үндэслэлтэй.

Хоёрдугаарт, энэ Засгийн газрын байгалийн баялгийг ард түмэнд хүртээлтэй болгоё гэдэг бол миний 20 гаруй жилийн хөдөлмөр, мөрөөдөл. Үүнийг анх удаа хийж байгаа Засгийн газар. Баялгийн эх оронч үзлийг анх удаа яг мото болгоод явж байгаа Засгийн газар.

Монгол оронд 2024 онд 11 их наяд төгрөгийн орлого уурхайгаас олсон. 36 хувь нь төсвийн 36 хувь. Манай ядуу ард иргэд гэвэл 28 хувь нь байгаа. 400 мянган өрх санхүүгийн дарамтад байгаа. Яагаад. Ийм их баялаг олчихоод яагаад. Хэдхэн гэр бүл хагартлаа баяжиж байна л гэсэн үг. Үүнийг ярьсны төлөө цөм цөм 20 жил зодууллаа л даа.

Үүнийг анх удаа ярьсан Засгийн газар. Баялгийн сангийн тухай.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч болгон Баялагтаа эзэн Монгол гэж гардаг. Гараад баялгийн эздийн карманд ордог. Монголоо хөсөр хаядаг. Үүний эсрэг явсан Засгийн газар одоо ингээд үндсэндээ хоногоо тоолж байх шиг байна.

Тэгэхээр улс төрийн үг байдаг юм л даа. Миний өрсөлдөгч гэдэг юм уу, эрх баригч нар унаж байхад саад болж болохгүй ээ гэдэг шиг. Би ийм арчаагүй, харалган нүдээр асуудлыг харах гээгүй байна.

Бидний хамтын дайсан бол Монголын ядуурал, ажилгүйдэл. Үүнийг шийдэх ганцхан боломж нь байгалийн баялгаасаа ард түмэндээ хувь хүртээх. Одоо бол баялгийг өмчилж авсан баялгийн эзэд хагартлаа баярлаж байгаа. Тэднийг баярлуулмааргүй л байгаа юм даа.

П.Жасрай гуайг их олон жилийн өмнө, 20 гаруй жилийн өмнө бөөн юм болоод, үүнээс 10 дахин илүү дарамтад учруулж, баахан шог зураг зурж зовоосон. П.Жасрай гуай нэг алдартай үг хэлж байсан. “За яах вэ, та нар намайг ширээтэй юмыг нь зөөгөөд гаргавал гарга. Би ажлаа хийнэ ээ.” гэж. Тэгээд Монголын ард түмэн... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

С.Ганбаатар: Үг хэлнэ дээ. Асуух юу байх вэ. Зүгээр нэг л юм хэлье дээ.

Институц хоорондын зөрчил дарангуйлагч бий болж байгаа гэдгийг бүгд мэдэж байгаа мөртлөө ярьж чадахгүй байна. Аймхай байна бид нар. Үнэхээр аймхай.

Баялагтай орон гэдэг юу юм бэ гэвэл их мөнгө, их алт эрдэнэсийн тухай ярьдаггүй юм шүү дээ.

Баялгийнхаа тухай ард түмний төлөөллийн байгууллага нь ард түмэндээ зориулж шийдвэр гаргах чадвартай байна уу, чадваргүй байна уу гэдгээс баялагтай орон шалтгаалдаг.

Яах вэ, Крис Рок /Chris Rock/ гэдэг хүний үгийг л зээдээд хэрэглэчихлээ шүү. Бас заавал тэгж хэлэх ёстой байх.

Манайх бол баялгийн хараал хүртсэн юм шиг ийм тэнэг байдлаасаа гаръя гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Бүгдэд нь энэ оройн мэндийг хүргэе.

Тэгээд юуны өмнө энэ асуудлыг парламентын танхимд ил тод, нээлттэй хэлэлцэж байгаад баяртай байна.

Энд байгаа гишүүд бид бүгдээрээ тангараг өргөхдөө улс орныхоо эрх ашгийг нэг тавина гэж тангараг өргөсөн. Энэ тангарагтаа үнэнч байх ийм цаг ирж байна гэж бодож байна.

Өнөөдөр Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх энэ асуудлыг ярихад би өнгөрсөн Ерөнхий сайдын зөвхөн энэ хамтарсан Засгийн газар төдийгүй өмнөх хоёр Засгийн газар хамтдаа бас хийсэн ажлуудыг бид ярих нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Яагаад гэвэл нэг бодлын 1992 оноос хойш хамгийн удаан засаглаж байгаа Ерөнхий сайд боловч түүнийгээ давсан хэмжээний ажлууд хийгдсэн гэж хэлэх нь зүйтэй.

▶ 2021 оны 2 сараас авхуулаад ковидын хүнд үеийг давж, насанд хүрсэн иргэдийн 90 хувь нь дархлаажуулалтад хамрагдаж, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийгээгүй биш хийсэн.

- 1.5 сая иргэн үнэ төлбөргүйгээр эрт илрүүлэгт хамрагдсан байна.

- 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт эрүүл мэндийн салбарт орсон байна.

▶ Цэцэрлэгийн сугалаа гэдэг зүйл үгүй болсон.
▶ Оюу Толгой Монголын талд ногдох 2.3 тэрбум долларын өрийг тэглэсэн байна.

▶ E-Mongolia цахимжилтаар нийтдээ 2 сая хэрэглэгчтэй болсон байна.

Энэ дээр хамгийн чухал гэж миний онцолмоор байгаа зүйлсүүд нэлээд их шударга бус зүйлсүүдтэй тэмцсэн.

- Хөгжлийн банкны өрийг ил болгож, эргэн төлөлтөд анхаарч, энэ “Самурай бонд”, “Евро бонд”, “Боловсролын зээлийн сан”-гийн асуудлыг ил болгож цэгцэлж, “Эрдэнэс Тавантолгой” дээр байж байсан асуудлуудыг ил болгож цэгцэлсэн.

Энэ асуудлуудын бараг нэг нь л гэхэд Засгийн газар унагаах хэмжээний их улс төртэй, нуун дарагдсан эрх ашиг хөндөгдсөн ийм асуудлууд.

Өнөөдөр бид 126 гишүүнтэй парламенттай байгаа. Үнэхээр өнгөрсөн жилүүдийн маш том ололт, гавьяа гэж бодож байна.

Ерөнхий сайд, Их Хурлын дарга, мөн бусад намын удирдлагууд маш их улс төрийн зориг гаргаж, энэ “Шинэ тогтолцооны өөрчлөлт”-ийг авчирч чадсан.

Нийгмийн төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр салбар салбарын чухал асуудлуудыг хөндөж ярьж байна. Асуудлуудыг маш өөрөөр хардаг олон намын тогтолцоотой, хамгийн олон намын төлөөлөлтэй парламент бид цаашдынхаа засаглалын асуудлыг ярьж байна гэдэг өнөөдөр энэ хэлэлцүүлгээс маш тодорхой болж байна гэж харж байна.

Үндэсний баялгийн сан. Энэ ямар чухал юм бэ гэдгийг зөвхөн Монголд төдийгүй дэлхийн жишээнүүд дээр бид хэлэлцэж байна.

Тэгэхээр би энэ өнгөрсөн ажлуудыг хийхэд гар бие оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлэх нь зөв байх гэж бодож байна.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын манлайлал доор зөвхөн энэ хамтарсан Засгийн газар гэхгүйгээр өмнө нь ч ажилласан баг, бүрэлдэхүүнд бид талархал илэрхийлэх ёстой байх.

Аль ч улс оронд удирдлагадаа 100 хувь, аль ч ардчилсан улс оронд удирдлагадаа 100 хувь сэтгэл хангалуун зүйл байдаггүй байх.

10 жилийн өмнө би жишээлбэл Дэлхийн банканд ажиллаж байхад өдөр болгон л Цагаан ордны хажуугаар явдаг байсан. Өдөр болгон л жагсагчид байдаг. Энэ бол ардчилсан улс орны зүйлс. Тэндээс бид сайжруулах ёстой юмнуудаа, доголдож байгаа юмнуудаа сонсож, ойлгож, мэдэж сайжруулах орон зай байх ёстой.

Энд бид магадгүй 126-лаа суучхаад “өө ёстой энэ дарга супер”, “энэ хүн мундаг”, эсвэл “энэ ийм байх ёстой” гэвэл энэ бол ардчилсан улс биш болох байх гэж бодож байна.

Тэгэхээр бид өнөөдөр яг л зөв тогтолцоогоороо, зөв хэлэлцүүлгийг хийж, зөв санал хураалтыг ил тод хийх гэж байна гэж найдаж байна.

Харин Ерөнхий сайдаас миний хувьд асуух зүйл. Хэрвээ өнөөдөр Улсын Их Хурал итгэл хүлээлгэвэл Та цаашдаа юу хийнэ гэж бодож байна? Яг юуг хамгийн түрүүнд авч, яаж илүү их эрч хүчтэй... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Түрүүн хариулсан даа. Гишүүний асуултад. Э.Болормаа гишүүн үндсэндээ үг хэллээ.

Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүдэд оройн мэнд хүргэе.

126 гишүүнтэй шинэ парламент бүрдээд хамтарсан засаг байгуулаад алдсан 30 жилийн алдаагаа давтахгүй, улс орноо хөгжүүлнэ гээд л. Би ч итгэж байсан итгэл маань талаар өнгөрч байх шив дээ.

Ер нь Засгийн газар, бүх сайдууд сайн ажилласан гэж бодож байгаа. Олон жил гарцсан төсөл, хөтөлбөрүүдийг эхлүүлж, гэрээ хийж, хөрөнгө оруулагчдаа хайж явсан.

Ардчилсан намынхан гарчихлаа гээд сая ярьж байна. Ардын намын Бага хурлын шийдвэрээр хөөсөн шийдвэр гаргаж байгаа юм чинь тэгээд гаралгүй яах вэ дээ.

Манай Ардчилсан намаас гарсан сайдууд сайн ажилласан гэж бодож байна. Дандаа хүнд салбарууд дээр. Уул уурхайн салбар Ц.Туваан сайд, барилгын салбар Ж.Батсуурь сайд, Байгаль орчны сайд С.Одонтуяа сайд, Ц.Баатархүү сайд, тэгээд Эдийн засгийн сайд Тэргүүн шадар сайд Л.Гантөмөр сайн ажилласан гэж үзэж байгаа.

Ялангуяа эмэгтэй сайд С.Одонтуяа 2026 онд Монгол Улсад цөлжилттэй холбоотой олон улсын хурлын хөрөнгө оруулалт, агаарын бохирдлын асуудал дээр өдөр шөнөгүй ажилласан.

Энэ Засгийн газрын гишүүд сайдууддаа баярлалаа гэж хэлмээр байна.

Та түрүүн ярьсан. Та Бага хурал дээр энэ гурван намын гэрээг танилцуулсан уу? Бага хурлын гишүүддээ.

Нөгөө талаар үүнийг ойлгуулах боломж байгаа. Та намын дарга. Нөгөө талаар Ерөнхийлөгч та хоёрын дунд яс хаяж байгаа залуучууд байна гэж ярьсан. Тэд нар чинь шинэ Засгийн газрын бүрэлдэхүүнд орох гээд зүтгээд байгаа залуучууд мөн үү? Энэ талаар хариулт авъя.

Хоёр дахь асуудал. Энэ эрүүл мэндийн салбарын асуудал байгаа. Г.Лувсанжамц гишүүн судалгаа гаргасан байна. Эрүүл мэндийн салбарт нийтдээ энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө дээр нийт 17.5 их наяд, нэмэгдсэн 1.6 их наяд. Үүнээс 3-хан хувь нь эмч, эмнэлгийн ажилчдын цалин бага учраас ажлаас ихээр гарч байна.

Хамгийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа асрагч нар өдрийн 8 цаг шөнийн ээлжийг хасаад ажиллаж байна. Хүнд. Хүний баас, шээс, цустай хутгалдаж байгаа. Эмнэлгийн дотоод халдвар өсөх нөхцөл бүрдсэн байна.

Гэтэл Эрүүл мэндийн сайд энэ талаар танд танилцуулсан уу? Энэ төсвийг нэмэх боломж байгаагүй юу? Бусад зам гэхэд 33 хувь, бусад нь гэхэд 41 хувь, эрчим хүч гээд 18 хувь. Боловсрол, эрүүл мэнд дээр хамгийн бага төсөв тавьсан байна. Энд салбарын сайдуудад танилцуулсан уу?

Одоогийн инфляцын нэмэгдэл, дулаан цахилгаан, цэвэр хохирсон нэмэгдлийг энэ эрүүл мэндийн салбарынхан ерөөсөө давах боломж тун муу болсон. 80 хувь нь цалингийн зээлтэй. Үнэхээр хүнд байдалтай. Хүүхдүүдээ сургах гээд л. Нөгөө талаар орон сууцын зээлтэй ийм салбар байгаа. Гэтэл үүний цалинг нэмэх боломж байгаагүй юу? Эмийн үнэ бас өндөр. Эм тариа авах байдал маш хүнд.

Одоо эмнэлгийнхэн бүгд хэвтэж байгаа өвчтөнүүд гаднаас эм авчирч байна шүү дээ.

Гурав дахь асуудал барилгын салбарын асуудал өнөөдөр 100 мянгаад барилгын салбарынхан гадаа жагсаж байна. Би 1 минутаа нэмээд авчихъя. Дарга аа.

Гэтэл сая тэд нар өргөх бичиг бариад явж байна. 2.4 их наядын 600 тэрбумаар нь 4 багц болгоод яагаад Хятадын 2 компани авч ажиллаж байгаа. Бид нарын хийх ажлыг гадаадынханд өгөөд л ингээд бид ажилгүй болж байна гээд ийм авч байна. Үүнийг танд танилцуулсан уу? Энэ 100 хувь Монголын улсын мөнгө төсөв л дөө. Энэ талаар танд танилцуулсан уу?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Нийгмийн асуудлын хувьд, ялангуяа манай зүүний чиг баримжаатай намуудын хувьд энэ үнэхээр чухал зүйл. Бид хүнийг капитал гэж үзэх ёстой гэдэг ийм үзэл санаатай. Хүн эрүүл боловсролтой байж тэр нь өөрөө Монгол Улсын үнэт зүйлийн капиталыг үүсгэнэ, хөгжлийн замыг олно. Хүний хөгжлийнхөө асуудал дээр бид нэлээн ийм том алдаа гаргажээ гэж ер нь бол үздэг. Би ч гэсэн бас тийм байдаг.

Тийм учраас эрүүл мэндтэй холбоотой энэ асуудал дээр түрүүн гишүүд ярилаа. Ковидын үед нэлээдгүй тийм том тоног төхөөрөмжийн, ялангуяа төрөх эмнэлгүүдийн том шинэчлэлийг бид хийсэн.

Эх, нялхас сая 06 сарын 01-нд дууссан байна лээ. Харамсалтай нь улс төрийн ийм нөхцөл байдлаас болоод очиж чадсангүй.

Төрөх эмнэлгүүдийн бүх тоног төхөөрөмжүүд өөрчлөгдсөн. Хөдөө орон нутагт бүсчилсэн лабораториуд байгуулагдана. Ингээд хөдөлгөөн болон бусад зүйл дээр нэлээн тийм том өөрчлөлтүүд хийхээр ингээд хийгдээд явж байгаа.

Олон ч эмч парламентын гишүүд байна. Дундаа яах вэ мэдээж жоохон идеологийн зөрүүнүүд байх шиг байна. Манай Ж.Чинбүрэн эмч, манай Т.Мөнхсайхан сайд нар гээд л хоорондоо жоохон асуудлууд байх шиг байгаа юм. Тэгээд том зургаараа л бид харахгүй бол тухайн салбар хохирно.

Ирэх жилийн хувьд бид боловсрол бүх зүйлийн суурь юм гэж үзсэн. Их тийм том хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ингээд “боловсролын жил” гэж зарласан юм.

Энэ маань ингээд хэрэгжвэл бид цэцэрлэгээс авхуулаад л их сургууль хүртэл хүний хөгжлийн асуудлууд дээр нэлээн тийм том зүйлүүдийг хийхээр ийм цуврал уулзалтууд хийгээд ингээд эхэлж байсан. П.Наранбаяр сайд үүнийг маш сайн мэдэж байгаа.

Зүгээр энэ бүх асуудлууд яагаад өнгөрсөн хугацаанд шийдвэрлэгдээгүй вэ гэхээр яг бодитой байдлаар манайх эдийн засгийн хувьд чадамж муутай. Тэгээд л улсын төсвөө ярьж ярьж хуваадаг. Хуваагаад л нэг тийм өөх ч биш, булчирхай ч биш болгочихдог. Яагаад тойргийг бүсчилсэн юм бэ гэхээр бүх санхүүгээ аваачаад сум даяар тарааж задлахгүйн тулд л үндсэндээ бүсчилж томсгосон тойргоор болоод, тойргийн гишүүдтэй юу ярьж байгаа вэ гэхээр илүү тийм томоохон дэд бүтцийн асуудлуудыг нь ярих юм сан л гэдэг ийм итгэл үнэмшлээр бүсчилсэн.

Тийм учраас энэ асуудлууд хийгдээд зөв тийшээгээ явж байгаа юм.

Тийм учраас л нөгөө мега төсөл гээд яриад байгаа минь энэ. Бид 3 жилийн өмнө бол 40 бетон устай байсан. 40 их наяд л байсан. Монгол Улсын эдийн засгийн нийт багтаамж. Одоо бол энэ 80 бочкитой ус болсон. Энэ эрчээрээ бид явбал уг нь 120 их наядаас дээш гарчих ийм боломж байгаа юм. Саяын төслүүд. Саяын эхлүүлсэн 5 төсөл хэрэгжээд эхлэхэд. Энэ тохиолдолд яах вэ гэхээр нийгмийн бүх асуудлууд үндсэндээ шийдэгдэнэ.

Тэгэхээр нөгөө GDP per capita 10 мянган ам.доллар гэж яриад байгаа нь өөрөө үүнийгээ шийдвэрлэх хэмжээний эдийн засгийн багтаамжтай болохыг хэлээд байгаа юм. Энэ байхгүй бол мянга бид хөтөлбөр дэвшүүлээд энэ бол зүгээр л ийм хоосон амлалт болно.

Тийм учраас энэ агуулгаар нь нөгөө эдийн засгийнхаа асуудлыг жоохон урд талд нь тавьж яваад, үүнийг хүмүүс ойлгохгүй. Тэгээд яах вэ дээ нөгөө том төслүүд чинь хугацаа орох юм л даа. Тийм ээ. Зарим нь 20 жил алдах ийм тохиолдлууд байгаа. Гэхдээ хэдүүлээ эхлүүлсэн энэ төслүүд дээрээ ингээд хатуу итгэл үнэмшилтэй байж чадвал, одоо энэ тариф марифын асуудал шийдэгдвэл GDP per capita 10 мянган ам.доллар бол нэг их хол биш.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Ингээд өнөөдөр яг энэ чуулганы танхимд болж байгаа энэ яриаг сонсож байгаа энд чих тавин хүлээж байгаа нийт ард иргэддээ, гадаа жагсаж байгаа сая тарж байгаа залуучууддаа Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, энэ танхимд байгаа гишүүддээ оройн мэнд хүргэе.

Тэгээд нөгөө ам нээвэл уушги нээ гэдэг шиг өнөөдөр бол маш сайхан бүгдээрээ илэн далангүй сайхан ярилцаж байна. Энэ бол энэ 126 гишүүнтэй парламентын хамгийн гол юм гэж бодож байна. Бүгдээрээ хэлэх үгээ хэлээд, ярих саналаа хэлцгээж байна.

Тэгээд үнэхээр шударга хэлж байгаа Ардын намын гишүүддээ баярлалаа. Хийснийг нь хийснээр нь, хийгээгүйг нь хийгээгүйгээр нь ярьж байна.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын асуудал мэтээр боловч энэ засаг тэр чигээрээ орж ирчхээд байгаа. Засгийн хийсэн ажил энэ юу явсан бэ гэдэг ажлууд, сайдууд юу хийсэн бэ гэдэг ажлууд орж ирж байгаа. Тийм болохоор энэ дээр бол маш өргөн хүрээний яриа явж байгаа.

Тэгээд Монгол Ардын намын Бага хурал дээр Ардчилсан нам шиг муу нам байхгүй болоод, Ардчилсан нам ажиллаж чадахгүй байгаа учраас энэ засгаас Ерөнхий сайдын асуудал үүссэн гэж бодож байгаа юм. Угаасаа тийм яриа ч байсан. Тэгсэн чинь өнөөдрийн энэ танхимд орж ирээд сонссон чинь Ардчилсан намын сайд нар шиг сайн ажилласан сайд байхгүй юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр Бага хурал нь худлаа яриад байгаа юм болов уу, эсвэл Их Хурал нь худлаа яриад байгаа юм болов уу? Аль нэг нь л худлаа ярьсан байж таарна.

Тэгээд дээр нь Ерөнхий сайдын хувьд хоёр асуулт байна. Та яг хариулаад өгөөрэй. Засаг муу байгаагүй ээ гээд түрүүнээс хойш хэллээ. Ярих болгондоо. Аль аль нам нь сайн байсан. Ардчилсан намын сайд нар маань сайн ажилласан. Тэрийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Энэ засаг сайн ажилласны хүчинд Ганцмод, Гашуунсухайт түрүүн бүгдээрээ хэлсэн. Маш олон төслүүд хөдөлж эхэлсэн. Одоо маш олон хуулиуд өргөн баригдсан.

Тэгэхэд тэр сошиалаар яваад байгаа нэг бичлэг байсан л даа. Бага хурал дээр таны хэлж байгаа. Ардчилсан намгүйгээр цаашаа явъя. Ардчилсан намыг хасъя гэдэг. Тэр таны хэлсэн үг мөн үү? Эсвэл энэ бас нэг тийм эвлүүлэг явчав уу? Энэ дээр та нэг хэлээд өгөөрэй.

Хоёрдугаарт нь, үнэхээр амаргүй байгааг бол ойлгож байна. 5 жилийн өмнө яг ийм байдалтай байсан. Тэмцээд л байсан. Тэмцэл бол шат шатдаа ахиж байгаа гэдгийг бас ойлгож байгаа. Гэхдээ өнөөдөр яг эзэн биетэй нэг яримаар байна. Тэгэхгүй бол бид ингээд яг нэг тийм хийсвэр юмнаас л айгаад байна. Нэг хадны мангаа л байгаад байна. Гэтэл яг тэр нь юу юм бэ? Ерөөсөө яг энэ. Би бол өнөөдрийн ингээд л гишүүдийн асуусан асуулт, таны хариулсан хариулт энэ дундаас сонсоод үзэхлээр Ухаахудагийг ярьснаараа, Эм Си Эсийг ярьснаараа энэ асуудал хөндөгдөөд гараад ирлээ гэж ойлгоод байна.

Тэгэхээр миний ойлголт зөв үү? Эсвэл энэ буруу юу? Энэ дээр яг та нэг товч бөгөөд яг тодорхой хариулаад өгөөч. Нийт энэ засаг ажилласан хугацаанд бол би л лав муу дүн тавихгүй. Ардчилсан намын гишүүд, тэр сайд болсон хүмүүсээ сайн шахсан. Сайд нар ч сайн ажилласан. Ялгаа байхгүй Монгол Ардын намаас би Л.Энх-Амгалан сайдыг хэлмээр байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талд маш их ажилласан.

Тэгэхээр энэ саяын миний хоёр асуултад л яг тодорхой та нэг хариулаад өгөөрэй. Бид тэр хадны мангаанаас биш 126 юутай тэмцэх вэ гэдгээ ойлгож... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Эхний асуулт Энержитэй холбоотой эрх ашиг зөрчигдсөн нь үнэн.

Тэгэхээр энэ Ухаахутагтай холбоотой энэ асуудлыг Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан байгаа юм билээ. Та бүхэн тэгээд дүгнэлтийг нь үзээд, том эрх ашгаа хараад шийдэл гаргах нь зүйтэй. Тэгээд тодорхой асуусан учраас тодорхой л хариулчихъя.

Гашуунсухайт, Ганцмод дээр Эм Си Эсийг гаргачихсан нь үнэн. Энэ асуудал Тавантолгойг хэн эзэмших вэ гэдгээсээ л болж маргаан болсон болохоос биш Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас нэг их тийм маргаан үүсгэсэн юм байхгүй.

Үүгээрээ би түрүүн С.Цэнгүүн гишүүний асуултад гүйцээгээд хариулахад үүгээрээ би хувийн хэвшлийг дэмждэггүй, чөлөөт зах зээлийг ойлгодоггүй огт биш шүү. Зөвхөн Монгол Улсад байгаа энэ том стратегийн гэж хэлэгдэж байгаа энэ ордууд эзэмшил болон ашиглалтынх нь лиценз зөв шилжсэн үү, буруу шилжсэн үү л гэдэг асуудал байгаа юм. Үүнийг Та бүхэн тэгээд цаас болгоод цаг хугацааны дараалалтайг нь хараад уншихад тэгээд л аяндаа ойлгогдоно доо.

Тийм учраас үүнийг Та судлаасай гэж би хүсэж байна.

Ардчилсан намын сайд нарыг сайн муу ажилласан гэдэг асуудал бол манай Бага хурал дээр бол огт яригдаагүй. Гол нь нэг талаараа одоо ингээд засагт хамтарчхаад байгаа мөртлөө нөгөө талаараа улс төр хийгээд ингээд энэ нь их тийм төвөгтэй байна. Та бүлэг дээр орж ирээд байнга л Ардчилсан намыг магтдаг. Гэтэл бас ингээд асуудлууд болоод байх юм. Тэгээд үүнийгээ та яаж тайлбарлах юм бэ л гэдэг ийм асуудлыг л надаас, одоо ч биш л дээ дандаа л яригддаг байсан асуудал.

Миний хувьд хэдүүлээ төслөө л бодъё. Бусдыг нь ингээд хойш нь тавьчих аа, хэдүүлээ энэ чинь бүрэн эрхийн хугацаа талдаа ч ороогүй байна. Энэ хүртэл төслүүдээ ингээд хийчих нь зүйтэй юм л гэдэг ийм агуулгаар ингээд л яваад байдаг байсан. Тэгээд яах вэ би нөгөө нэг тал талдаа сургамж байх ёстой гэдэг нь зүгээр дараа дараагийн удаа хамтрах асуудал яригдаж л таарна.

Тэгэхээр бид одоо байгаа энэ алдаануудаа аль аль талдаа л гаргахгүй байх, илүү том агуулгаа харах нь зүйтэй л гэдэг өнцгөөс санамсаргүй бодоод хийчихсэн улс төр өөрөө явж байгаад ямар үр дүнд хүрдэг вэ гэдгийн бас нэг сургамжийг нь олоосой л гэж би бодож байгаа юм. Илүү юмыг ингээд зөв өнцгөөс тайлбарлах гэж байгаа. Тэр нь өөрөө юу вэ гэхээр том өрөг өрчихсөн улс төрчдийн өгөөш болдог. Манай залуучууд тэр бүр туршлагагүй. Цаана нь яг ямар ийм том өрөлтүүд явж байгаа. Энэ нь яг ямар ямар үр дагавартай вэ гэдгийг нарийн тооцохгүй байх ийм асуудлууд болж байдаг. Тэгээд л яах вэ гэхээр хооронд нь мөргөлдүүлээд л энэ тэгсэн тэр нь тэгсэн, энэ нь тэгсэн гэж байгаад л дундаас нь юу болдог вэ гэхээр дундаас нь ийм том хэмжээний л асуудал үүсдэг. Ийм зүйл байна.

Тэгээд тэр бичлэгтэй холбоотой асуудал. Тэр дээр би их харамсаж байгаа юм. Ер нь яах вэ зүгээр нээлттэй ингээд ярьж байгаа зүйл бид 10 цаг хуралдсан зөндөө л юм ярьсан. Хамтарсан Засгийн газрын давуу талыг би зөндөө ярьсан. Сул тал дээр ийм гомдол, тэмцэл, янз бүрийн юм үүсээд байгаа юм байна гэдгийг ч ярьсан. Тэгээд яах вэ тэрний тийм хэсгийг нь аваад тавьсан. Энэ бол нэг тийм зохисгүй л үйлдэл. Ер нь бол.

Ардчилсан намын хурал дээр би ороод бас нэг бичлэг тавигдсан. Тэр бас их тийм дэмий л зүйл. Ер нь бол. Тэгээд нэг ийм жижиг сажиг хоёрын хооронд улс төрийг бол манай энэ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ийм зүйлүүдийг хэдүүлээ юу яадаг л болчих хэрэгтэй дээ. Нэг их тийм ойшоодоггүй бөгөөд тийм асуудал гарвал их тийм бие биедээ хатуу шаардлага тавьдаг л болчих нь зүйтэй.

Тэгвэл яах вэ гэхээр үнэн улс төр, үнэн байгаа байдал өөрөө илүү хүчтэй болно. Тэгэхгүй тэгээд л нэг юм гаргаад л тэрэнд нь бүгд итгээд л ингээд л явчихвал тийм санаатай л үйлдлүүд байдаг гэдгийг хэдүүлээ доор доороо харах нь зүйтэй. Ер нь төрийн ажил цаасан дээрээс л дүгнэгдэх учиртай. Ярианаас биш.

Тийм учраас өнөөдөр би бас ингээд нөгөө итгэл үзүүлэх асуудлыг ингэж олон талаас нь ярьж байгаа нь бол энэ бүх зүйл протоколд үлдэнэ. Энэ бүх зүйл протоколд үлдэнэ.

1990 он, 1991 оныг ойлгохын тулд тэр Үндсэн хуулийн тэр өөрчлөлт, Үндсэн хуультай холбоотой протоколыг уншиж байж л багцаа авна. Тэр үед яригдаж байснаасаа их олон хүмүүс өөрчлөгдсөн байдаг.

Д.Амарбаясгалан: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Гишүүддээ энэ оройн мэнд хүргэе.

Өнөөдөр бид Ерөнхий сайдыг сайдад итгэл үзүүлэх асуудлаар хэлэлцэж байна. Миний хувьд бүлгийн шийдвэрээ дагана. Санал хураалтад оролцохгүй. Нэг ёсондоо Ерөнхий сайдад итгэл үзүүлэхийг дэмжихгүй гэдэг дээр байр суурьтай байгаа.

Тэгээд Ерөнхий сайд нэг хэдэн юман дээр хэлчихмээр байна. Өнөөдрийн энэ үүсээд байгаа нөхцөл байдал бол бас энэ талбай дээр байгаа залуусын энэ бухимдал ер нь 2024 оны сонгуулийн үр дүнд үүссэн Засгийн газрын асуудал гэхээсээ илүү таныг сүүлийн 5 жил завсаргүй Ерөнхий сайд хийсний чинь хувьд эдийн засаг, энэ нийгмийн олон салбарт уналттай хямралтай байдал үүссэнтэй холбож асуудал ярьж байгаа гэдгийг танд сануулж хэлмээр байна.

Заримдаа энэ ярьж байгаа сэдвээсээ хэтэрхий халиад байх шиг байна л даа. Тийм. Тэгээд нөгөө талаасаа таны энэ удирдаж байсан өмнөх Засгийн газар болон энэ Засгийн газар бодлогын хувьд хангалттай сайн байгаагүй л гэж дүгнэж байгаа юм. Төр данхар байна. Төрийн өмчит компаниудын асуудлыг ил тод, нээлттэй, цомхон болгоно гээд, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байна гээд

ярж байснаасаа яг эсрэгээрээ энэ бодлогууд нь яваад байгааг л олон нийт ойлгохгүй байгаа.

Тэгээд хоёрдугаарт намын Бага хурал дээрээ Ардчилсан нам хамтарсан гэрээг ноцтой зөрчсөн гэж хэлж та Ардчилсан намыг засгаас гаргах асуудлаар шийдвэр гаргуулсан хүн нь та өөрөө.

Гэтэл өнөөдөр та Ардчилсан намын сайд нар маш сайн ажилласан, талархаж явдаг гэж хэлж байна. Энэ хоёр үг чинь ерөөсөө авцалдахгүй байгаа байхгүй юу. Угтаа бол бараг манай дотоод ардчиллаас зөрчлөөс болоод энэ Ардчилсан намыг засгаас гаргаж байгаа юм гээд та бараг үнэнээ л бараг хэлсэн бол бас ойлгомоор байгаа байхгүй юу. Гэтэл ийм илэрхий асуудал дээр гөлөг тойруулж байгаа юм шиг ингээд явж байгаад өнөөдрийг хүргэж байна л даа.

Тэгээд одоо маш олон бодлогын асуултуудыг асуумаар байвч би өнөөдөржин таны энэ хариулт өгч байгаа байдал дээр маш анхааралтай сонслоо. Өдөр тэр Байнгын хороон дээр хариулт өгч байгаагаас авхуулаад өнөөдөржин л таны хариултуудыг сонслоо.

Зарим гишүүд маш тодорхой асуугаад байна. Жишээлбэл, Баттөмөрийн Энхбаяр гишүүн өнөөдөр Байнгын хорооны хурал дээр маш тодорхой асуусан. Сая энэ Ч.Анар гишүүн асууж байна, Н.Наранбаатар гишүүн асууж байна, С.Цэнгүүн гишүүн асууж байна. Ж.Баясгалан гишүүн.

Маш тодорхой асуудлуудыг хариулт хүсэхээр яг ингээд гөлөг төөрүүлээд ингээд өөр юм руу аваачаад, хийсвэр юм руу аваачаад тэгээд нэг ийм үр дүн нь ийм айлгах, тийм сүрдүүлэх марктай болоод, хариултууд нь дандаа тийм болоод л яваад байна л даа. Ингээд гишүүдээр аягүй тодорхойгүй байдлаар шийдвэр гаргуулах гээд байна л гэж харж байна.

Тэгээд яг энэ олон энэ асуумаар байгаа зүйлдээ би бол хариулт авна гэсэн итгэлгүй байгаа учраас би танаас ийм юм асуумааргүй байна. Гэхдээ би зүгээр нийгэмд тэр бухимдал үүсгэсэн, ялангуяа тэр таны тэр Туулын хурдны замын нээлтийн үеэр хэлсэн тэр нийгмийн бухимдал дээр гал дээр тос нэмсэн тэр таны үгэн дээр би маш их эмзэглэсэн. Хэнийг яг яалаа гэж хэлээд байгаа юм. Одоо өөрөөс чинь урвасан Засгийн газрын гишүүдээ хэлээд байгаа юм уу? Өөрийн чинь эсрэг гарын үсэг зурсан гишүүдийг хэлээд байгаа юм уу? Эсвэл энэ талбай дээр цугласан залуучуудыг, Монголын нийгэмд энэ шүүмжлэл хэлсэн залуучуудыг хэлээд байгаа юм уу? Хэнийг та ялаа гэж хэлээд байгаа юм бэ гэдэгийг зүгээр асуумаар санагдчихлаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Гуйвуулаад байгаа болохоос би ард түмнээ хэлээгүй. Би тэр дээр хэлсэн. Улс төрийн ашиг хонжоо хайж энэ нөхцөл байдлыг өөрөөр эргүүлэх гэж байгаа улс төрчдийг хэлсэн. Нэгдүгээрт.

5 жил урт. Тийм ээ, тийм. Ийм уйдалт байгааг би ойлгож байгаа юм. Тэр дээр би нэг их тийм ингэсэн, тэгсэн гээд байх юм алга.

Тийм учраас бид ингээд тогтвортой засаглахаар удчихлаа гэдэг. Тогтворгүй байхлаар тогтворгүй байлаа гэдэг. Ийм асуудал байгаа. Хангалттай ажлууд хийгдээгүй ийм зүйл байгаа. Бодитой. Гэхдээ хийгдсэн зүйл бас байгаа. Бүх зүйлийг яг ид шидтэн шиг Засгийн газар өөрчлөх тийм боломжгүй байдаг. Та өөрөө анх удаа сонгогдсон. Цаг хугацаа туулаад ирэхээр аяндаа ойлгогдоно гэдэгт итгэлтэй байгаа.

Зүүн бүсээс залуу лидер гарч ирж байгаад талархалтай хандаж байгаа. Бас уулзаж ярилцаж чадсангүй. Тийм ээ. Уг нь энэ бүсийн уулзалт дээр уулзаад ярилцах болов уу гэж бодож байсан. Тэгээд нүүр тулж уулзаж яриагүй байж хувь хүний талаар дүгнэлт хийх бас тийм ч сайн зүйл биш. Өөрийн чинь ярьж байгаа энэ хувийн хэвшил, төрийн өмчит компаниудтай холбоотой шүүмжлэлийг би эрүүлээр хүлээж авч байна.

Залуучуудын хувьд ч гэсэн эрүүл мэнд, боловсрол гээд, татвар, нийгмийн даатгал гээд олон асуудлууд болохгүй байгаа зүйл байгааг би мэдэрч байгаа. Болгохын төлөө эдийн засагт хэлэх нь зүйтэй л гэдэг агуулгаас ярьж байгаа учраас биш тойруулаад байгаа зүйл огт байхгүй шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Сайн байна уу? Ерөнхий сайд аа. Нөгөө уулзаагүй улсуудын чинь нэг нь би шүү.

Тэгээд ер нь орлогоо нотол гэснийг л Бага хурал руугаа оруулаад Засгийн асуудал болгоод явчихав уу даа гэж би зүгээр өөрөө хувьдаа хараад байгаа шүү. Тэгээд 4 асуулт асууя. Тодорхой. Одоо энэ хүмүүсээс бас асуугаад байна л даа. Хариултаа авч чадахгүй л байгаад байх шиг байна.

Та энэ намын Бага хурал дээр Ардчилсан нам засгаас гарах юм бол би Засгийн тэргүүнээ хийхгүй ээ гэсэн утгатай зүйл. Одоо би яг юу гэж хэлснийг нь мэдэхгүй байгаа учраас тэгээд асуучихъя. Гэж ярьсан юм уу, яриагүй юм уу? Тэгээд арваадхан хоногийн дараа итгэл үзүүлээч ээ гээд ингээд ороод ирдэг. Ардчилсан нам чинь засгаасаа гарна гээд мэдэгдчихлээ. 8 сайд нь өргөдлөө ч өгчих шиг боллоо. Энэ нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь, та бол Монгол Ардын намын даргаар 4, 5 жил лав ажилласан байх. Тэгээд танай намд энэ төрийн бодлогын залгамж чанар гэж юм ер нь байхгүй юм уу? Тэгээд нөгөө ерөөсөө үүнийг цаашаа үргэлжлүүлээд явчих хүн байхгүй гэж үзээд та энэ итгэл үзүүлээч ээ гэдэг нэг ийм асуудлыг Их Хурал руу оруулаад ирэв үү гэдэг хоёр дахь асуудал.

Гурав дахид нь би гайхаад байгаа н нэг зүйл байна. Энэ гишүүд ч яриад байх юм. Та өөрөө ч яриад байх юм. Энэ Баялгийн сангийн асуудал, Ухаахудаг, Онтрэ эд нар ингээд цаашаа явахаа больчихлоо гээд яриад байгаа юм.

Тэгээд танд ер нь итгэл үзүүлэхгүй тохиолдолд үүнийг явуулахгүй дараагийн Ерөнхий сайд аа та мэдээд байгаа юм уу гэдэг нэг асуудал байна. Яагаад ийм итгэл үнэмшилтэй яриад байгаа юм. Энэ ерөөсөө ингээд зогслоо, болилоо гээд ингээд яриад байх юм. Энэ гишүүд ч яриад байна, та ч яриад байна. Энэ гуравдугаар асуулт.

Тэгээд дөрөвдүгээр асуулт нь энэ гадаа жагсаж байгаа залуучуудыг та яалт ч үгүй тэр жагсаал хийж байгаа ялаанууд гээд хэлсэн. Би тэрийг жагсаж байгаа залуучуудыг л хэлчихлээ гэж ойлгосон. Би бол таны яриаг хараад.

Тэгэхдээ ингээд асуудал үүсээд яриад ирсэн чинь үгүй ээ үгүй би цаад хүмүүсийг нь хэлсэн юм. Мэдэж байгаа л гээд байсан. Энэ Гашуунсухайтаас ирж байхад дараагийн Ерөнхий сайдын асуудал бараг яригдсан байсан гээд та түрүүн ярьчихлаа. Энэ маш ноцтой асуудал байх аа. Энэ чинь одоо нөгөө төрийн эрх гэдэг юм уу, засгийн эрхийг хууль бусаар авах руу орчихгүй юм уу. Тэгээд таны мэдэлд Тагнуулын ерөнхий газраа, Авлигатай тэмцэх газар ч гэдэг юм уу, Цагдаагийн газар гээд энэ хүчний байгууллагууд байгаа байх. Бодвол тэд нар мэдээлэл өгч байгаа болоод та тэгж ярьсан болов уу гэж би бодоод байх юм. Тэгээд хэрвээ тийм юм байдаг бол энэ Улсын Их Хурлынхаа чуулганыг хаалттай болгож байгаад ийм юм яригдаад байна энэ тэр гээд бас нэг мэдээллээ өгчхөж болохгүй юм уу гэдэг ийм дөрвөн асуулт байна. Би тодорхой л яг дөрвөн асуулт асуулаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Эхнийх нь Бага хуралтай холбоотой асуудал. Тийм ээ. Бага хурал дээр асуудлууд яригдсан. Тэгээд ийм асуулт хариултын л ийм байдалтай явсан. Тэнд Ардчилсан намын сайд нар ингэж ингэж ажилласан гэдгийг би яг л одоогийн байгаа байр сууриараа л илэрхийлсэн. Одоо манай намын хамт олон байж байна.

Давуу тал байна, сул тал байна гэдгээ л ярьсан. Тэгээд улс төрийн шийдвэр ийм ийм байгаа гэдэг бүлэг дээр гарсан уур амьсгалыг баталгаажуулж өгөх нь зүйтэй гэж үзсэн.

Бага хурал дээр Ардчилсан нам хэрвээ гарвал би Ерөнхий сайдынхаа ажлыг өгнө гэж би хэлсэн. Манай Бага хурлын гишүүд болохоор үүнийг заавал салгаж хураах ёстой гэсэн. Миний хувьд хамтарсан агуулгаараа ингэж явах нь бол зүйтэй юм гэдэг ийм асуудлыг ярьсан.

Хамгийн сүүлд нь би Бага хурлын санал хураалтыг Ерөнхий сайдын асуудал, энэ асуудал хоёрыг тусдаа шийдье ээ гэсэн. Ингээд шийдэл гараад

өнөөдөр би Ерөнхий сайдынхаа асуудлыг парламентаар шийдүүлэх нь зүйтэй л гэж оруулж ирж байгаа. Энэ дээр нэг их тийм ойлголтын зөрүүсээд байх юм байхгүй.

Тэр залуучуудыг тэгсэн, тэр мэдэгдлийг гуйвуулсан асуудал бол та буцаагаад ухраагаад үзээрэй. Би ард түмнээсээ уучлалт гуйж байна. Үүнийг улс төрийн ашиг хонжоо болгох гэж байгаа нөхдүүдтэй л гэж хэлсэн шүү. Тэгэхээр үүнийг гуйвуулаад хэрэггүй.

Гашуунсухайт болон бусад төслүүд баялгийн сан ингээд ухарчих гээд байгаа юм уу гээд байна. Ухрахгүй гэдэгт би итгэлтэй байгаа. Ухрахгүй гэдэгт итгэлтэй байгаа. Гэхдээ улсын Ерөнхий сайдын хувьд эрсдэлүүд гарч болзошгүй юм гэдгийг нээлттэй ярьж байгаа нь бол буруу биш байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Р.Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Яах вэ, яг л нөгөө нэг ингээд тойруулаад л хариулаад л өнгөрчихлөө л дөө. Би зүгээр асуугаад байгаа нь тэгээд байгаа юм. Гишүүд ч тэгж яриад байдаг, та ч тэгж яриад байгаа юм.

Энэ нэг хэдэн том том төслүүдтэй холбоотой ажлууд ч явахаа байлаа. Ухаахудаг нь ч явахаа байлаа. Эм Си Эсийн хэдэн юунууд, мафийн толгойлогч нар юм чинь засаг удирдаад таныг ингээд явуулчих гээд байна гээд яриад байгаа юм.

Тэгэхээр үүнийг явуулахгүй байх дараагийн Ерөнхий сайдыг нь Та мэдээд байгаа юм уу л гэж би асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт, яах вэ дээ, тэр эхний асуудал дээр тэр бодол бол өөрчлөгдсөн юм байна. Ардчилсан нам гарчихвал больё гэдгээ больсон юм байна. Хоёр хуваагаад саналаа хураалгасан юм байна гэж ойлголоо.

Тэгээд тэр Гашуунсухайтаас ирж байхад Ерөнхий сайдын асуудал яригдсан байсан гэдэг дээр нэг хариулт өгөөч. Тэр ямар хүн, ямар Ерөнхий сайд болчихсон байсан юм.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Кабинетын гишүүд дундаас энэ үйл ажиллагаануудад оролцож байгаа хэд хэдэн хүн гарсан. Би нэрийг нь хэлээд яах вэ.

Энэ бол тийм ноцтой бөгөөд харамсалтай үйл явдал болсон. Дундаа нэлээдгүй асуудлууд ярьсан. Кабинетын гишүүд итгэл үнэмшлээрээ нэг л байх ийм Үндсэн хуулийн зарчимтай. Ийм асуудал хийгдэж чадаагүй сонголтдоо харамссан зүйл байгаа.

Д.Амарбаясгалан: Тийм. Р.Батболд гишүүн, энэ гишүүдийн яриад байгаа энэ хамтарсан Засгийн газар бүрдээд олон жил гацсан том төслүүдийг хөдөлгөсөн өнгөрсөн цаг хугацааны асуудал 10 сарын хугацаанд байна.

Ер нь цаашид энэ томоохон төслүүдийг хамтрал бий болгоод хөдөлгөж чадах уу л гэдэг асуудал дээр их төвлөрч ярьж байгаа. Тэрийг нь тэр талаас нь ойлговол зүгээр байгаа.

Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Гишүүддээ оройн мэнд хүргэе.

Тэгээд би ч Ардын намын шүүмжилдэг нөхдүүдийн л нэг дээ. Уг нь энэ асуудал орлого нотол гэдэг залуучуудын хөдөлгөөнөөр эхлээд л үнэн худал нь мэдэгдэхгүй ингээд л бужигнасаар байгаад л тэгээд л нэг мэдсэн чинь манай намын Бага хурал зарлагдаад л.

Тэгээд манай намын Бага хурал гурван үндэслэлээр л зарлагддаг л даа. Бага хурлын гишүүдийн 25 хувь нь, эсвэл намын Удирдах зөвлөл, эсвэл намын дарга. Одоо манай намын даргын санаачилгаар зарлагдаад тэгээд манай Бага хурал хуралдсан. Хуралдаад ярьсан асуудал бол бид ер нь 100 гаруй жил явж байгаа нам хүний гутал хувцас яриад байхгүй л дээ. Цүнх яриад байхгүй л дээ.

Ер нь энэ хамтарсан засаг зөв үү, буруу юу гэдгээ л ярьсан шүү дээ. Ингээд улс орны зүүн төвийн үзэл баримтлалтай 300 гаруй мянган батлахаа өвөртөлчихсөн гишүүдтэй Монголын ард түмний нэг төлөөлөл байхгүй юу. Улс төрийн үзэл баримтлалаараа нэгдсэн. Ард түмний төлөөлөл. 300 гаруй дарга нар гэж яриад байх шиг байна. 300 гаруй юм уншиж чаддаггүй хүмүүс сууж байгаад шийдвэр гаргачихсан ч гэж яриад байх шиг байна. Тийм юм байхгүй л дээ. Жирийн малчин ч байгаа, тариачин ч байгаа, жолооч ч байгаа, тогооч ч байгаа, эрдэмтэн ч байгаа. Дарга нар ч байж байгаа. Бүгдийн төлөөлөл байгаа. Яг л танай Ардчилсан нам шиг. Яг л манай энэ ХҮН нам шиг, Ногоон нам шиг, Үндэсний эвсэл шиг.

Ард түмний л төлөөлөл шүү дээ. Итгэл үнэмшлээрээ нэгдсэн хүмүүс шүү дээ. Бие биеийгээ доромжилж байгаа бол энэ Их Хурлын гишүүдээ доромжил. Намуудыг нь битгий доромжил. Би 18 наснаасаа Ардын намын гишүүн болоод 25, 26 дахь жилдээ намын гишүүн явж байгаа юм. Тийм учраас өмөөрмөөр санагддаг юм.

Ингээд санал хураах болсон. Манай намын даргын л томъёоллоор бид ярьж байгаад ер нь тэгээд гэрээний үүргээ биелүүлээгүй Ардчилсан намыг гаргая гэдэг шийдвэрийг л бид Бага хурал дээр гаргасан шүү дээ. 60 гаруй хувиар.

Ингээд намын шийдвэр гарсан. Олон ч намын дарга солигдож байсныг би мэднэ. 25, 26 жилийн хугацаанд. Намын Бага хурлын шийдвэр гэдэг бол энд сууж байгаа 68 Улсын Их Хурлын гишүүдийг сонгож дэвшүүлсэн байгууллага байхгүй юу. Ерөнхий сайдыг, Их Хурлын даргыг, Ерөнхийлөгчид хэн дэвшихийг шийддэг албан ёсны байгууллага. Юу ч биш юм шиг яриад байж болохгүй байхгүй юу.

Үргэлж шийдвэр нь биелж байдаг улс төрийн зорилготой байгууллага. Ардчилсан намынхан, бусад намууд бүгдээрээ л яг намынхаа шийдвэрийг гаргаад л явдаг шүү дээ. Тэгээд л нэг их төр дээр нам гараад суучихлаа гээд яриад байх юм. Улс төрийн шийдвэрийг улс төрийн нам л гаргана. Ийм л юм.

2024 оны 07 сарын 04-нд гаргасан хамтарсан Засгийн газар байгуулах шийдвэрээ бид тэнд цуцалсан. Ардчилсан нам гараад явчихлаа. Манай нам цуцлаад хаячихлаа. Одоо гарна гэж хэлээгүй ХҮН нам л үлдсэн. Одоогийн энэ Засгийн газарт.

Улс төрийн хувьд одоогийн хамтарсан Засгийн газар байхгүй болсон. Улс төрийн хувьд бол. Намынхаа Бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байж байгаад Их Хурлаар асуудал шийдүүлэх болоод л ингээд л яваад байна л даа. Тэгээд яах юм байгаа юм. Мэдэхгүй.

Тэгээд өдрөөс өдөрт. Би нэмээд 1 минутаа авна шүү. Би зүгээр үг хэлж байгаа юм.

Одоо энэ өдрөөс өдөрт тоо нь нэмэгдээд байгаа залуучууд дотор миний ах дүү ч явах юм, найз нөхөд ч явах юм. Уурлаад бичээд байх юм. Их Хурал шившиг болно шүү. Та нарыг тараана шүү. Уучлаарай, чи миний найз чинь хамаагүй, чи миний ах чинь хамаагүй л гэж байна.

Энэ чинь Их Хурлын зовлон болж байна шүү дээ. Тэгээд сүүлдээ тэгээд Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед хийгдсэн том том ажлууд бий. Мундаг байсан. Үүний нэг болох Ораногийн төсөл, ураны төслийг улдан эсэргүүцэж байсан улс төрчид болон гудамжны босоо, хэвтээ хөхдөг, хөхдөггүй хүмүүс нь манай намын даргыг өмөөрөөд өлсгөлөн зарлахыг харж байна. Тэдний ар талд нэрлэгддэг Женко Баттулга гэдэг хүн өнөөдөр энэ доор ирчихсэн намын гишүүдээ энэ Засгийн газрыг авч үлд гээд даалгавар өгөөд байгаа хэл ам сошиалоор нэг явж байна. Тэгээд үзээгүй юмаа их л үзэж байна даа.

Хэдүүлээ тэгээд нэгэнт улс төрийн хувьд хоёр нам нь хоёулаа хоёр том нам нь. 118-ын бүлэг болсон. Ард түмэн нь сөрөг хүчин болсон. Энэ буруу байна гээд ард түмэн жагсаад байгаа энэ нөхцөлд тэгээд хоёр нам нь шийдвэр гаргасан байхад хэдүүлээ ямар шийдвэр гаргах гээд энд яриад байгаа юм. Би ер нь нэг л ойлгохгүй л байгаа. Ийм л үг хэлье дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Улсын Их Хурал 126 гишүүнтэйгээр тангараг өргөөд өнгөрсөн оны 07 сарын 02-ны өдөр тангараг өргөөд тэгээд Засгийн газар байгуулагдсан. Ерөнхий сайд, хурлын дарга нар томилогдсон, сонгогдсон.

Энэ үед хэлж байсан. Иргэний Зориг Ногоон нам улс төрийн шийдвэр гаргаж Засгийн газарт орох шаардлага байгаа алга байна. 126 гишүүний 118 нь буюу 93 хувь нь нэг Засгийн газар бүрдүүлж байгаа юм байна. Цөөнх, сөрөг хүчин юу гэж хэлнэ вэ. Ямар ч байсан хяналт тавих хэмжээгээр ажиллах нэг улс төрийн хүчин үлдэж хоцрох ёстой юм байна гэдэг үүднээс улс төрийн шийдвэр гаргаж байсан.

Тэгээд энэ 118 гишүүн, энэ 126 гишүүн Ерөнхий сайдыг томилоход хэдэн хүний саналаар томилогдож байлаа. Тэрийгээ бүгдээрээ санаж байгаа байх. 90-ээс дээш хувьтай. Бараг 100 хувь руу дөхөж очиж томилогдож байсан.

2007 онд Миеэгомбын Энхболд огцроод, Санжийн Баяр Ерөнхий сайд болох шийдвэрийг Ардын намын цагаан байранд гаргаж байсан. Элбэгдоржийг огцруулаад Энхболд Ерөнхий сайд болох шийдвэрийг Ардын намын цагаан байранд гаргаж байсан. 3 Ерөнхий сайд, 3 Их Хурлын даргын нүүрийг үзсэн.

Эцэст нь 07 сарын 01-нээр дууссан. Эцэст нь. Өнөөдөр ингээд Улсын Их Хурал дотор янз бүрийн зүйл яригдаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу 2 триллион буюу 2 их наяд төгрөгөөр Их Хурлын гишүүдийн саналыг худалдаж авах гэж байна гэдэг зүйлийг хэлсэн. Ийм зүйл байхгүй гэдгийг би мэднэ.

Энэ 20 жил улс төрд явах үедээ нэг ч удаа өөрийгөө худалдаж үзээгүй. Үзээгүй учраас Ардчилсан намаас хөөгдөөд энд сууж байгаа.

Би ойлгохдоо Ч.Лодойсамбуу гишүүн 2 их наядыг хэдэн хувьсагчид хуваагаад өөрийнхөө нэрийг лангуун дээр үнэ зарлаад тавьж байгаа юм байна гэж ойлгосон. Үүнийг юу гэж ойлгож байгаа юм? Ерөнхий сайд.

118 буюу энэ Их Хурлын 93 хувийг бүрдүүлээд, тоог эрхэмлэж үзээд, энэ тоо байхгүй бол Ерөнхий сайд хийх боломжгүй гээд итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганд оруулаад ирлээ.

Энэ тоо байхгүй бол цаашид энэ бүх ажлууд явахгүй юм уу? Тийм логик, тийм философиор асуудлаа ойлгож харж явж байгаа юм уу, үгүй юм уу. Энэ дээр хариулт сонсмоор байна?

Хамтарсан Засгийн газар гэж Үндсэн хууль, Их Хурал, Засгийн газрын тухай хуульд байхгүй. Гэхдээ бүх Ерөнхий сайд нар өөрсдөө өөрсдийнхөө

Засгийн газарт, тэргүүлсэн Засгийн газартаа ямар нэг нэршил өгдөг. Шинэчлэлийн Засгийн газар ч гэдэг юм уу. Янз бүрийн нэр өгөөд л явдаг. Үүнийг нь бол хуульд байхгүй нэр томъёо ашиглалаа гэж яриад байх нь дараагийн асуудал байх.

Тэгэхээр энэ хамтарсан Засгийн газар чинь дахиад энэ 118-аараа бүрдүүлэхгүй бол явахгүй гэж үзэж энэ асуудлаа оруулж ирсэн юм уу?

Орлогоо нотол гэдэг энэ уг нь бол хэрэглээгээ тайлагна гэдэг зүйл шүү дээ. Энэ хэрэглээг ямар орлогоос бүрдүүлсэн юм бэ гэдэг асуудал. Энэ төрийн өндөр албан тушаалтнууд бүгдээрээ энэ орлогоо нотлох, хэрэглээгээ тайлагнах ажлыг хийх ёстой. Үүнийг хэн хийх ёстой юм. Авлигатай тэмцэх газар тэр хөрөнгө орлогын мэдүүлэг дээр нь дүгнэлт хийгээд олигтойхон юм хийх ёстой юм уу? Нэг бол эндээсээ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Заавал энэ 118 гэдэг тоондоо биш. Хамтарсан байдлаар нэгэнтээ бүрдсэн учраас энэ төслүүдээ хийхийн тулд хамтраад явах нь ер нь бол зөв юм л гэдэг ийм агуулгыг хэлж байгаа юм.

Мэдээж асуудлууд байгаа. Сая Г.Дамдинням хэлж байна. Үнэн бодитой. Бүлэг дотор хэдэн ч удаа яригдсан. Энэ дээр аль аль нам нь л дүгнэлт хийх учиртай. Түүнээс зөвхөн Засгийн газарт орсон сайдуудын тухай би яриагүй. Улс төрийн акц хийгээд, тэр нь аль аль талдаа буруу ойлгогдоод итгэлцлийг байхгүй болгосон тухай би ярьж байгаа.

Гэхдээ улс төрчдийн итгэлцэл дээр тулгуурлаад улс орон ухрах хэмжээний эрсдэл гарч байгаа бол бид нээлттэй ярилцаад аль аль талдаа үүнийгээ дүгнэх нь зөв өө л гэж би ярьж байгаа юм.

Тийм учраас нөгөө 118 гэдэг тоондоо биш. Би хамтарсан гэдэг агуулгаараа ялангуяа энэ тарифтай холбоотой энэ нэг ийм төвөгтэй үеийг туулчих нь зүйтэй л гэдэг агуулгаар харж байгаа шүү.

Тэр орлогоо нотлохтой холбоотой тэр эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэдэг дээр бид санал нэг л байгаа. Авлигатай тэмцэх газар дээр мэдээлэл нээлттэй байгаа. Үүнийг миний хувьд бүтэн манлайлахад бэлэн байна. Шаардлагатай бол төрийн өндөр албан тушаалтнуудын орлогыг нотлох сонсгол ч хийж болно шүү дээ. Их Хурал нээлттэй л байгаа.

Тэгэхээр энэ эргэлзээг бид хамтдаа тайлах ёстой. Миний хувьд тайлна. Тэрэнд Та бүхэн санаа зовоод хэрэггүй. Харин бүх зүйл дээр тайлах ёстой гэдэг ийм манлайллын үзүүлэх ийм шаардлага юм байна гэж бодож байгаа. Тэгээд би үүнийг тайлна. Бусад төрийн өндөр албан тушаалтнуудын хувьд ч гэсэн үүнийг

эргэлзээг тайлах ийм манлайллааг үзүүлэх ёстой. Үүнийг хэдүүлээ хамтдаа үзүүлье ээ гэж уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Б.Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: 10 сарын өмнө 104 гишүүн санал хураалтад ороод, 103 гишүүн нь Ерөнхий сайдыг томилоход дэмжиж саналаа өгч байсан юм байна. Нэг хүнээс бусад нь.

Тэгж Ерөнхий сайдаар томилогдоод өнөөдөр Та бүхэн манай Ардчилсан намын бүлэг бол санал хураалтад орохгүй гээд мэдэгдэл гаргачихлаа шүү дээ. Бүлгийн шийдвэр гаргачихлаа гэж үзэж байна. Тэрийгээ олон нийтэд хэлчихлээ. Тэгээд энэ чинь нөгөө ярьдаг кабинетын зарчим, нөгөө санал хураалтад чи санал хураалтад орохгүй гэдэг чинь дэмжихгүй л гэдэг санал.

Тэгэхээр Та бүхний хамтрал бол явахгүй байгаа нь харагдаж байсан. Анх энэ засаг байгуулагдаж байх үед... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн алга байна. 3 гишүүний дараа үг хэлэх гишүүдийн нэр авна шүү. Гишүүдэд зар мэдээлэл хүргээрэй.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Өнөөдөр иргэд бухимдаад, залуус цөхөрч байгаа нь үнэн. Өнгөрсөн 30 жилийн алдаа оноог засахыг Ерөнхий сайдаас ч хүсэж байгаа байх. Олон жил Монгол Ардын нам засаглалаа гээд.

Тэгээд хамгийн том ер нь бухимдал нь бол яг үнэнийг хэлэхэд нэг хэсэг нь ерөөсөө мөнгөнд умбаж төрөөд л, баялгийг өвлөж аваад л, шударга бусаар баяжаад л, нэг хэсэг нь өнөөдөр татвар төлөөд ч яагаад ч үүнийг ерөөсөө энэ амьдралдаа гүйцэхгүй нь ээ гэдгийг дөнгөж 20, 30-хан насандаа ухаарна гэдэг чинь аягүй хэцүү байхгүй юу. Эхний гараа нь л амьдралдаа шударга бус байна. Авч байгаа нь боловсролоосоо авхуулаад л, амьдарч байгаа нөхцөлөөсөө авхуулаад л.

Тэгээд яах вэ, үүнийг хэдэн Засгийн газар огцруулаад ер нь шийдэгдэхгүй байх. Яг гол үндэстэй нь, суурьтай нь л хэдүүлээ тэнцэхгүй бол яг худлаа. Тэгээд 1.6 жилийн настайгаар олон л нэртэй өчнөөн л олон Засгийн газар өнгөрсөн хугацаанд огцрох шиг боллоо.

Тэгээд том эрх ашиг яригдахаар яг л нэг ингэдэг л дээ. Нэг тапочки, цүнх болж явж байгаад л, тэгээд л хамгийн сүүлд иргэдийн бухимдал дөрөөлж байгаад л засгаа огцруулаад л дараачийнх нь хоёрдугаар ээлжид хоолонд ордог бол энэ бол ерөөсөө бүр нэг гэм биш бүр сүүл рүүгээ бүр зам боллоо. Дараачийнх нь ч гэсэндээ бараг хүлээгээд л байж байх шиг байна. Та Ерөнхий

сайд өөрөө хэллээ. Энэ бол манай засаг дотроос гарсан. Харамсалтай байна гээд.

Тэгээд үнэхээр энэ мега төслүүд гэсээр байгаад нэг нийгмийн бухимдлын зарим асуудалд ерөөсөө Ерөнхий сайд анхаарал хандуулж чадсангүй. Тэгэхдээ уг нь бол үүнийг заавал Ерөнхий сайдыг өөрийг нь оруулахгүйгээр тэртээ тэргүй нийгмийн хөрс суурь нь их сайхан бэлтгэгдсэн. Ерөнхий сайд өөрөө дэмжлэг үзүүлнэ гэдгээ хэлсэн. Сайд нар нь хуулиа оруулаад л өнөөдөр батлуулсан байсан бол бодит өөрчлөлт хүмүүсийн нүдэн дээр яг харагдах байсан.

Яагаад гэвэл мега төслүүд бий болоод батлагдаад, иргэдийн амьдралд хүртэл цаг хугацаа нэлээн орно. Хүмүүсийн амьдрал тэрийг хүртэл хүлээхэд хэцүү байгаад байгаа юм.

Ардчилсан нам, ХҮН нам бас нэг юм ашиглагдсан юм шиг санагдаж байгаа нь аргагүй байх. Яагаад гэвэл хамтарч байгаад ураны гэрээ, Гашуунсухайтын гэрээ хэлцэл, эрчим хүчний реформ гээд олон ажлуудаа эхлүүлсэн.

Тэгээд сая Монгол Ардын намын Бага хурал дээр гол ярьсан асуудал бол ерөөсөө томилгоо, Ардчилсан намынхан улс төр хийж байна гэдэг асуудал ярьсан. Хийхээс ч өөр аргагүй л байх.

Ард түмний бухимдлыг нөгөө талдаа засагт орсон юм чинь гээд юу ч ярьж чадахгүй ч байна гэж юу байх вэ. Тэгэхдээ нөгөө талдаа энэ манай нам 8 жил өнгөрсөн парламентад 2 парламентад дийлэнх олонхоороо эрх барьсан. Хэнтэй ч ямар ч эрх мэдлээ хуваалцахгүй явсаар байгаад тэрүүндээ дасчихсан. Тэгээд хэдэн хүнд томилгоо өгөх хэдэн хүнтэй, хэн нэгэнтэй эрх мэдлээ хуваана гэхээр бүр яг үнэнийг хэлэхэд аягүй хэцүү байх шиг байгаа юм.

Тэгэхдээ яг амьдрал дээр бол ард түмэн хэн нь дарга байна уу, сайд байна уу уг нь ерөөсөө хамаа байхгүй. Амьдрал нь л сайжирч байх ёстой. Уг нь бол бид тийм нийгмийг бий болгох ёстой байхгүй юу. Жирийн Япон хүнд Зам, тээврийн сайд хэн юм, Ерөнхий сайд нь ч бараг хэн юм гэдгээ ч сайн мэддэггүй. Яагаад гэвэл тэртээ тэргүй амьдрал яг л явдгаараа явж л байдаг.

Тэгээд та түрүүнд хэллээ. Надаас нэг хэдэн сэтгүүлчид ийм хэдэн асуултыг тавьж өгөөч ээ гэсэн юм. Би тэгээд танаас бас асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, энэ Ухаахудаг болохгүй байна гээд байна. Гэтэл Ерөнхий сайдын Эдийн засгийн зөвлөлд Ж.Оджаргал байдаг. Энд хэвлэлийн мэдээнээс олонтоо л зураг нь харагдах юм. Одоо Ерөнхий сайд энэ засгийн асуудлаа Ухаахудагаас боллоо гээд байна. Энэ зөвлөл дээрээ ярьж ойлголцож болдоггүй юм уу? Заавал энэ Улсын Их Хурлаар Засгийн газрын асуудал болохгүй бол болдоггүй юм уу?

Ингээд ерөөсөө Ардчилсан нам гарах юм бол энэ Засгийн газар чинь үргэлжлүүлээд цаашаагаа явах уу? Ардчилсан нам гарна гэдгээ өргөдлөө өгчихлөө гээд тэгж байна.

Дээрээс нь нэмээд одоогийн энэ сайдуудтайгаа хамтарч ажиллах уу? Нээрээ л дотроосоо түгжилдээд Засгийн газраа ажлаа хийлгэж чадахгүй байгаа юм бол энэ сайд нартайгаа үргэлжлүүлж ажиллах уу гэдэг энэ хэдэн асуултыг нэлээн олон хүмүүс сэтгүүлчид асууж өгөөч ээ. Ерөнхий сайдаас өнөөдрийг болтол хүмүүс асуух болов уу гэж нэлээдгүй хүлээлээ гэж байна.

Тэгээд эцэс сүүлд нь би нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Уг нь энэ ачаагаа хамтдаа үрэлцээд явсан... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Кабинетын зарчим бариагүй сайд нартай бол хариуцлага тооцох нь бол зүй ёсны асуудал болж таарна.

Энд ер нь цаашдаа хариуцлагын хувьд яригдах л ёстой зүйл. Ардчилсан намтай том агуулгаараа энэ төслүүдээ хамтрах асуудлыг дахиж Их Хурлаараа ч юм уу яриасай гэж би чин сэтгэлээсээ бодож байгаа шүү.

Яах вэ мэдээж тэр бол аль аль талдаа л дүгнэлтүүдээ хийх ёстой асуудал. Тэр улс орны хувьд энэ нь илүү чухал гэж бодож байгаа. Нэг нь юу билээ Булгаа.

Тийм. Уулзаж ярьсан ярьсан. Бизнесийн зөвлөл дээр бид уулзаж ярьсан. 34 хувьтай холбоотой асуудлыг борлуулалтын орлогоор тооцъё. Баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулъя гээд түрүүн бид тав дахь өдөр нэг ярьдаг асуудал тэр шүү дээ. Тэгээд ингээд явах нь бол зүйтэй юм гэдэг дээр бол ярилцсан. Тэгээд зөвшилцөөд уулзсан зүйлүүд бол байгаа байгаа.

Гэхдээ тэр дээр бүтэн ойлголцоогүй ч асуудлууд байна. Баялгийн сантай холбоотой нэлээн хэд хэдэн газруудад ийм зөвшилцөл ер нь хийгдэнэ. Энэ тэгээд энэ Засгийн газар байсан үгүйгээс үл хамааран цаашдаа хийгдэх нийгмийн шахалт байгаа учраас хийгдэж л таарна.

- Нэг нь, 34 хувийг яаж хуримтлалын санд төвлөрүүлэх вэ гэдэг асуудал.
- Хоёрдугаарт нь, борлуулалтын орлогоор хэлцэл яаж хийх вэ.
- Гуравдугаарт нь, АМНАТ-ыг Үндэсний баялгийн санд яаж төвлөрүүлэх вэ, үүнийг яаж тодорхойлох вэ гэдэг ийм гурван асуудал яригдана.

Тэгээд энэ бол зөвшилцлөөр л хийгдэнэ гэсэн үг.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Яах вэ, бид аливаа асуудалд нийтлэг эрх ашиг, ерөнхий зарчмаа баримталж шийдвэр гаргах ёстой.

Тэгээд өнөөдөр Улсын Их Хурлаар энэ итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын асуудал өөрөө орж ирж байна. Үндсэндээ бараг хоёр долоо хоног орчим талбайд залуучуудын “орлогоо нотол” гэж жагссан энэ асуудал. Нөгөө талдаа магадгүй залуучуудын дунд энэ шаардлага маань хувь хүнийхээ үүднээс ч гэсэн таныг ажил албан тушаалтайгаа зууралдаж байна даа гэсэн ийм буруу ойлголт руу явж байна гэж хараад байгаа юм.

Би бол зарчмынхаа хувьд залуучуудын тавьж байгаа шаардлага, энэ ил тод байдал, хариуцлагын асуудлыг нэхэж байгаа зүйл бол зарчмын хувьд зөв асуудал гэж харж байгаа.

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийг нэлээн анхааралтай үзлээ. 6 цаг гаруй, бараг 50 орчим гишүүд асуулт асуулаа. Асуулт хариултаас харахад, бас дээр нь нэмж орлогоо нотол гэсэн залуучуудын жагсаалаас үүдэлтэйгээр нэг хэд хэдэн ноцтой асуудлууд хөндөгдөж байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр би энд та өөрөө тодотгож өөрөө асуудлыг нэмж хэлэх нь зөв байх. Тодорхойгүй зүйлүүд ч гэсэн үлдлээ гэж гишүүд өөрөө ярьж байна.

Би том зургаараа бол ер нь улс төрийн хүчнүүд 5 намын төлөөллөөс бүрдсэн Улсын Их Хурал өөрөө төрийн эрх барих дээд байгууллага. Улсын Их Хурал сая өнөөдрийн энэ чуулганаар хэлэлцэж байгаа асуудлууд дээр бодит дүгнэлт хийх нь зөв байх гэж хараад байгаа юм. Энд байгаа улс төрийн нам хүчтэнүүд ч гэсэн улс төрийн дүгнэлтийг би гаргах ёстой гэж хараад байгаа.

Өнөөдөр хүссэн ч хүсээгүй ч магадгүй өнөөдрийн энэ нөхцөл байдлаас өнөөдрийн энэ хэлэлцүүлгээс харахад засаглалын хямрал өөрөө нүүрлэж байна гэдэг бодит нөхцөл байдал бид нар дээр үүсэж байна. Дээр нь эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байгаа. Эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байгаа. Нүүрсний экспортын энэ шокоос үүдэлтэйгээр гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэл гээд төсөв, санхүүтэй холбоотой асуудлууд өөрөө нэлээн хямралтай нөхцөл байдал руу дагуулах л ийм зүйл байна.

Тэгэхээр энэ дээр нэмэх нь засаглалын хямрал нүүрлэх юм бол нэлээн бид төрийн хямралаас гадна, төсөв санхүү, эдийн засаг өөрөө их хүндрэх л ийм л асуудал руу л орж байна даа гэж хараад байгаа юм.

Би эндээс сая өнөөдрийн хэлэлцүүлгээс онцолж хэлэх гээд байгаа зүйл бол нэгдүгээрт нэг анхаарал татаад байгаа зүйл бол энэ парламентын засаглалд өөрөө эрсдэл учирч байна. Парламентын засаглалд илт эрсдэл учирч байна. Тэр дундаа улс төрийн өнөөдрийн үүссэн нөхцөл байдлаас шалтгаалаад

парламентын засаглалд дэмжлэг хэрэгтэй байна гэдэг асуудлыг яриад байгаа юм. Парламентын засаглалд. Улс төрийн дарамт саад их байна.

Тэгэхээр би энэ өөрөө магадгүй энэ өнөөдрийн яригдаж байгаа засгийн асуудал, засаглалын асуудал юм уу гэдэг нь өөрөө том асуултыг дагуулж байна.

Би тэгэхээр таныг зөвхөн зүгээр өөрийгөө зөвтгөх гэж гэдэг юм уу, ажил албан тушаалтайгаа зууралдаж гэдэг юм уу энэ асуудлыг би ерөөсөө гаргаж яриагүй байх гэж бодож байгаа.

Би хувь хүнийхээ үүднээс Улсын Их Хуралд дүгнэлт хийх ёстой гэдэг зүйл маань өнөөдөр үндсэндээ засаглалын хямрал үүсэж байгаа энэ нөхцөл байдал байгаа бол, эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байгаа энэ нөхцөл байдал дээр бид нэг бодит дүгнэлтийг хийх ёстой гэдэг энэ суурь зарчмыг Та бүхэнд хэлэх нь зөв байх гэж хараад байна.

Ямар ч тохиолдолд аливаа асуудал би Үндсэн хуулийнхаа дагуу явах ёстой. Үндсэн хууль, зарчим дээр бид үнэнч үлдэх ёстой. Хэрэв төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал юм бол бид энэ парламентынхаа ардчилалыг хүчтэй байлгах асуудал дээр хатуу зогсох ёстой. Энд ямар нэг юу гэдэг юм барьцаалагдсан улс төр гэдэг юм уу, ардчиллаас ухарсан алхам байх ёсгүй гэдэг асуудлыг хөндөх гээд байгаа юм.

Тэгэхээр би энэ дээр та нэг тодорхой хариултыг нийгэмд өгөх ёстой байх аа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Би хариулсан даа.

Г.Тэмүүжин гишүүний зурсан бичиг жоохон асуудал болсон. Энэ дээр Засгийн газрын гишүүд гарын үсэг зурсан ийм асуудал үүссэн. Хэд хэдэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлууд яригдсан. Энэ дээр Л.Гантөмөр дарга, Т.Доржханд дарга надад байр сууриа илэрхийлсэн. Миний хувьд зарчмын байр сууриа илэрхийлсэн. Их Хурлын дарга ч оролцсон ийм ярианууд болсон болсон.

Тэгээд тэр Тусгай хяналтын байнгын хороотой холбоотой ч тийм маргаан болсон. Энэ нь бас нэг тийм буруу зөрүү ойлголт их төрүүлсэн юм шиг байна лээ.

Тийм учраас цаашлаад энэ асуудалтай холбоотой янз бүрийн нөхцөл байдлууд үүсэж болзошгүй талаар над дээр хэд хэдэн гишүүд орж ирж асуусан зүйлүүд байгаа.

Ард нийтийн санал асуулгатай холбоотой асуудал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал, ямар үзэл санаатай байгаа тухай асуусан. Энд асуусан гишүүд нь ч сууж байх шиг байна.

Тэгээд энэ дээр бидний хувьд Үндсэн хуулийнхаа ерөнхий суурь зарчим дээр байна л гэдэг ийм хариултыг өгсөн. Үзэл санааны хувьд парламент хуваагдалттай энэ асуудал дээр байгаа нь бодитой. Бид бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа. Өнөөдөр зүгээр ярьж чадахгүй л байгаа болохоос. Тийм байна.

Миний хувьд зарчмын байр сууриа л илэрхийлсэн. Тэр нь юу вэ гэхээр 6 жилийн өмнө шийдсэн байсан асуудал өөрөөр явах нь зарчмын хувьд буруу асуудал. Үүнийг тойрсон бас их тийм олон л янз бүрийн асуудлууд яригдсан.

Г.Тэмүүжин гишүүнтэй би уулзаж ярьсан зүйл байхгүй. Тэгээд энэ нэг их тийм нэлээн хардлага дагуулсан ийм сэдэв болсон байна лээ. Тэгээд үүнийг хэлчих нь зүйтэй байх. Цаашдаа ч гэсэн миний хувьд энэ асуудал дээр зарчмын 6 жилийн өмнө илэрхийлж байсан, одоо Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа илэрхийлж байсан Үндсэн хуулийн зарчим дээр байна гэдгээ хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ үдшийн мэнд хүргэе.

Юун түрүүнд гишүүдийнхээ уур зэвүүцэл, эгдүүг санаа зовниулсан, эгдүүг хүргэсэндээ чин сэтгэлээсээ уучлал хүсэж байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын гишүүд монгол хэлээрээ зөв бичээд, зөв уншаад, зөв сонсоод сурчих хэрэгтэй.

Би маш тодорхой хэлсэн шүү дээ. Сураг шүү гэж анхааруулж хэлж байгаа юм. Монголд чинь хүн сургаар юм сонсоод тэрэндээ итгээд, тэрийгээ бусдад ярих эрх байгаа биз дээ.

Ер нь би өөрөө хэлчихье. Энэ сураг биш байлаа гэж бодъё. Чихэн дээр зүгээр салхилсан хий хоосон салхи байсан ч би энэ үгэнд итгэнэ. Яагаад гэхээр бид, одоо ялангуяа шинээр сонгогдсон манай залуу гишүүд эгдүүцэж байгаа харагдаж байна. Би ойлгож байна. Би өөрөө энэ улс төрийн мэдээлэлтэй их ойрхон арван хэдэн жил ажилласан учраас манай гишүүд зарим нь мартсан ч байх, зарим нь зориуд мартаж байгаа байх.

Би нэрээр нь зүгээр сануулъя. 60 тэрбумын хэрэг гээд л бид ярьдаг байсан. Хөгжлийн банкны асуудал. Одоо ЖДҮ. Энэ бүхэн юу болж байсан бэ гэдгийг бүгд мартсан. Хамгийн сүүлийн жишээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 900, 950-аар нь тэгш хуваарилаад зээл өгсөн байх тэр үед Монгол Улсад нэг ширхэг ч мега төсөл байгаагүй. Өнөөдөр улсын 14 мега төсөл,

хотын 24 мега төсөл. Хэчнээн триллион, хэдэн 10 триллион, хэдэн 100 триллионы асуудал яригдаж байгаа.

Би тийм учраас энэ сурагтаа итгэж байгаа. Итгэснийг минь уучлаарай гэж хэлж байгаа юм.

Тийм учраас манай гишүүд ингээд нэг ийм хэрвээ үнэхээр бичлэг энэ тэр үзээд ойлгодоггүй бол одоо жинхэнэ парламент муухай харагдана гэдэг чинь түүн дээр л харагдана шүү дээ. Сонссон үгээ ойлгодоггүй. Чуулган дээр хэлэлцэж байгаа асуудлаа ойлгодоггүй. Тийм.

Одоо намайг парламентыг муухай харагдууллаа гэж ярих гээд байх шиг байгаа юм. Парламентын тоогоо мэдэхгүй гишүүдийг харахаар л муухай харагдаж байгаа шүү дээ. Парламент ямар үед муухай харагдах вэ гэх хурал дээр хүн суухгүй байхад л муухай харагдаж байгаа.

Энэ эмэгтэйчүүдтэй хэрэлдээд байлтай ч биш дээ. Төвөгтэй ч юм аа даа. Ер нь сонссон үгээ ойлгож ярьчих аа. Би үгээ больчихдог юм билүү. Энэ чинь одоо ямар хэцүү юм бэ. Энэ хэсэг бол ийм байгаа шүү. Би Та бүхнээс уучлалт гуйсан. Зарчмын шаардлагаа тавьсан. Монголоор сонсож сур. Монгол хүн юм бол. Монгол Улсын Их Хурлын гишүүд эх хэлээрээ ойлголцдог байх хэрэгтэй гэдэг шаардлагыг Та бүхэн тавьж байна.

Ингээд энэ монгол хэлээр ярьсангүй гэж уурлах чинь би ерөөсөө үүнийг ойлгохгүй байна. Би асуултаа асууя. Та нар битгий ингээд нэг ийм. Би сураг сураг сонсоод. Больё больё. Би дараа нь үг хэлье. Яршиг. Асуултаа больё. Энэ чинь ерөөсөө ганц Нара биш бүгдээрээ ингээд хашхирчихдаг юм байна шүү дээ энэ чинь. Больё больё. Би яг ийм хэрүүлд ерөөсөө дургүй болилоо. Болилоо.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо холбогдох асуудалтай холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Ирцээр нь эрэмбэлж байна. Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяагаар тасалъя. Нийтдээ 32 хүн байна. Өнөөдөртөө одоо ингээд дуусгая.

Энэ чинь томилгоо хийх болохоороо үүр цайтал суудаг л юм байна лээ шүү дээ. Асуудлаа шийдэх болохоороо ахиад үргэлжлүүлээд хүмүүсээ бухимдуулаад байж болохгүй шүү дээ. Өнөөдөртөө ингээд дуусах юм. Үгүй ээ таных ирц нь байгаа юм уу. Д.Ганбат гишүүн ээ таныг ерөөсөө хасаагүй шүү дээ.

Д.Ганбат гишүүнийх ирчихсэн байгаа биз дээ? Тамгын газар. Хоёр дараад цуцлаад байх шиг байна. Д.Ганбат гишүүн ээ таных. Нэг л дарна шүү дээ. Ингээд 32 гишүүн. Ө.Шижир гишүүнийх ороогүй байна гэж байна. Ө.Шижир гишүүнийг нэмчихье. Д.Ганбат гишүүнийх орсон байна уу? Шалгаадхаарай. Д.Ганбат гишүүн, Ө.Шижир гишүүн, О.Номинчимэг гишүүн. Ингээд нийтдээ 35 хүн болж байна уу. Тийм ээ. Ингээд 35 гишүүнээр тасалъя.

Ирцийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Хамтарсан засаг байгуулагдаж 14 мега төсөл, 300 гаруй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Ардын нам өөртөө Эрүүл мэнд, моёл, боловсрол, Нийгмийн хамгаалал, Хүнс, хөдөө аж ахуйн яам зэрэг халамж тараадаг яамдаа авсан. Харин Ардчилсан намд Уул уурхай, Байгаль орчин, Хот байгуулалт, Хууль зүй, түгжрэл зэрэг хамгийн асуудалтай яамдаа өгсөн. Хэл амтай яамдаа. Гэвч манай сайд нар бол халуун чулуу атгаж, олон олон том том төслүүдийг хөдөлгөхийн төлөө зүтгэсэн. Олон өөрчлөлт хийсэн.

Ардчилсан намын энд сууж байгаа гишүүд маань энэ хамтарсан засгийн хөтөлбөрт манай намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 70 хувь нь орсон учраас Засгийн газрын оруулж ирсэн бүх зүйлийг дэмжиж байсан гэдгийг хэлэх нь зүйтэй.

Гэвч Ерөнхий сайдын орлогоо нотлох тухай асуудал асуудал болж, тэр асуудлаа Монгол Ардын намын Бага хурал руу чирч орж, тэгээд тэнд нь гол буруутан нь Ардчилсан намын сайд нар болж хувирсанд харамсаж байгаа.

Тэгээд энэ юунаас шалтгаалж байна вэ гэхээр ерөөсөө энэ ард иргэд дотор, бизнесийнхэн дотор үгүй ээ Ардчилсан нам л ажил хийдэг юм байна гэдэг ийм яриа маш их явсан учраас Ардчилсан намыг засгаас хөөж гаргах үндсэн шалтгаан болсон гэж би үзэж байгаа.

Нэгэнт та нар ингэж улс төржиж байгаа бол би ч гэсэн бид ч гэсэн улс төржинө. Бид ч гэсэн улс төржинө.

2012-2016 онд Ардчилсан нам засаг барьж байхдаа асар их ажил хийсэн. Үүнийг нь ард иргэд үнэлдэг. Гэвч эв нэгдлээ хангаж чадаагүй гээд сөрөг хүчнийг сөрөг хүчин болгосон байгаа.

Үүнээс хойш эв нэгдэл хангах тухай асуудал бүрэн явсангүй. Энэ юунаас болдог вэ гэхээр манай намын үе үеийн удирдлагууд, Ерөнхийлөгч байсан нөхдүүд Ардын намын удирдлагуудтай хавсаадаж хуйвалдаж, тэр хуйвалдааных нь үр дүнд Ардын нам хожиж Ардчилсан нам алддаг ийм л нөхцөл байдал руу орсон. Энэ хуйвалдаан өнөөдрийг хүртэл явж байгаа.

Би өнгөрсөн хугацаанд бүх л хуйвалдааны эсрэг байсан. Миеэгомбын Энхболдыг Их Хурлын дарга болоход, огцроход, Ж.Эрдэнэбатыг Ерөнхий сайд болоход, огцроход, У.Хүрэлсүхийг Ерөнхий Ерөнхий сайд болоход, огцроход, Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг хоёр удаа томилогдоход нь хоёуланд нь бүгдэд нь эсэргүүцэж би саналаа өгч байсан.

Тэр байтугай Монгол Улсын Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогдоод ирэхэд нь бүрэн эрхийг нь баталгаажуулах тэр юун дээр У.Хүрэлсүх Ерөнхийлөгчийн эсрэг гав ганцаархнаа санал өгч байсан. Нуруу руу хүйт оргиод их л эвгүй байдаг юм байна лээ.

Тэгээд энэ хуйвалдаан өнөөдрийг хүртэл явж байгаад харамсаж байгаа. Тэгээд өнөөдөр бүлгийн шийдвэр гарсан. Монгол Ардын намын дарга Ерөнхий сайдыг итгэл үзүүлэх тухай асуудал дээр Ардчилсан намын бүлгийн гишүүд хурлыг орхино гэж.

Тэгээд зарим нэг нөхдүүд санал өгөх гэж энд орж ирж суух гэж байгаа юм шиг байна лээ. Болд, Батзандан гэдэг хоёр хүн нөхрийг та нар хэчнээн их эсэргүүцэж, хэчнээн их үзэн ядаж улс төр хийж орж ирсэнээ мэдэж байгаа биз. Айн?

Тийм учраас өнөөдрийн энэ бүлгийн шийдвэр. Үүнийг хариуцлагаа дагах тухай асуудал Ардчилсан намын эв нэгдлийг цаашдаа харуулна. Энэ асуудал дээрээ хатуу байж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Парламентын засаглал бол Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх чөлөөт байдлын баталгаа.

Тусгаар улс өөрийнхөө зовлонг ч үүрнэ, жаргалыг ч эдэлнэ. Тэр утгаараа парламент ёсны нэгэн шалгуур өнөөдөр орой болж байна.

Ерөнхий сайдын Их Хурлын 30-аад гишүүдийн асуусан асуултад хариулахыг анхааралтай сонслоо. Энэ дотроос нэг зүйл гишүүдийн хэлж байгаа ч тэр, мөн сүүлийн үед хэвлэл мэдээллээр явж байгаа ч тэр, нэг зүйл маш ноцтой, асар их ноцтой үйл явдал дагуулж байна. Энэ цаашлаад ямар үр дүнд хүргэх нь тодорхойгүй.

Юу гэхээр Ерөнхий сайдын хэлсэн үгэнд засгийн тогтворгүй байдал нь багадаа 3 сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Монголын хөгжил хойшлох тухай ийм үг хэлж байгаа юм.

Хэд хэдэн Их Хурлын гишүүдийн үг дотроос ч тэр дарангуйллын тогтолцоо руу гулсан орох тухай харагдаж байна, яригдаж байна. Сүүлийн үеийн хэвлэл мэдээллээр явж байгаа зүйл бол улсын Ерөнхийлөгч, улсын Ерөнхий сайд, түүнийг дэмждэг цахим дэмжигчдийн хооронд тулаан өрнөж байна.

Энд ярьсан ярианууд дотроос нэг чухал аргумент бол Ерөнхийлөгч Үндсэн хуулийг сунгах гээд байна. Өөрөө дахин сонгогдох гээд байна. 2027 оны

Ерөнхийлөгчөөр дахин сонгогдохын тулд Үндсэн хуулийг өөрчлөх гээд цэц рүү хандах гээд байна гэдэг асуудал яригдаж байна.

Тэгэхээр энд бол бид абсолют утгаараа үнэн гэж байдаггүй ч гэсэн Их Хурал дээр хуульд нийцсэн үнэн гэж байх ёстой. Нэг талаасаа энэ сэрдлэг үнэн бол үүнийг нотлох ёстой. Үгүй бол энэ гүтгэлгийг няцаах ёстой.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2 удаа энэ асуудал дээр бичгээр мэдээлэл юм уу, мэдэгдэл хийсэн байна лээ. Тэр парламент бүрэн эрхийнхээ хүрээнд улсын Ерөнхийлөгчөөс энэ асуудлаар биеэр амаар тайлбар хийхийг бид шаардах ёстой.

Үнэхээр танд ийм итгэл үнэмшил байгаа юм уу? Үнэхээр ийм хүсэл зориг байгаа юм уу? Үнэхээр ийм режим буюу засаглалыг солих хэмжээний хүмүүсийн хардаж яриад байгаа шиг ийм санаархал байгаа юм уу гэдгийг бид асуух ёстой.

Энд дүгнэлт юм уу, хариулт өгөхгүйгээр хийсвэр айдас хүйдсийг энэ парламентад шийдвэр гаргахдаа аргумент болгож ашиглаж болохгүй. Зарчим.

Чарльз Дарвины “зүйлүүдийн хоорондох тулаанаас илүү зүйлүүдийн доторх тулаан илүү харгис” гэдэг үйл явцыг харж байна. Өнөөдөр Засгийн газрын огцрох асуудал дээр Ардчилсан нам хумсын төдий ч үүрэг гүйцэтгээгүй. Харин Монгол Ардын намын дотоод улс төрийн өрнөл, тэмцэл нь ийнхүү ил гарч байгаа юм.

Эрхэм Ерөнхий сайд та энэ зураглалд дүгнэлт хийж байгаа байх гэж бодож байна уу? Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг би 20 гаран жил мэднэ. Хүсэл тэмүүлэлтэй, эрмэлзэлтэй, алсын хараатай, наяд он дотроо цойлсон шинэчлэл өөрчлөлтийг авчрах эрмэлзэл төгс ийм хүн.

Гэхдээ өнөөдрийн нөхцөл байдал, улс төрийн мухардал, энэ сорилт гэдэг зүйл бол зөвхөн хувь хүнд биш улсын Ерөнхий сайд, цаашлаад парламентат ёс, гүйцэтгэх засаглалд томоохон сорилт болж байгаа.

Нэг зүйлийг онцлон хэлмээр байна. Мэдээж асуудал хүүхдийн хэрэглээтэй холбогдож өрнөсөн. Орлогоо нотлохыг эцэг, эхээс нь шаардаж байгаа. Энэ дээр орлогоо нотлох ёстой. Бид улс төржиж болно. Гэхдээ хүний хань ижил, үр хүүхэд рүү хэтэрхий хэрцгийгээр орж байгаа, түүнийг нь улс төрд хэтэрхий бүдүүлгээр ашиглаж байгаа зүйл... /минут дуусав/

Х.Булгантуяа: С.Эрдэнэболд гишүүн үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Монголчуудын ирээдүйд итгэх итгэл өдөр ирэх тусам алсарч байгаа. Иргэдийн төрд итгэх итгэл өдөр ирэх тусам суларч байгаа. Ийм цаг үед

бид Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна гэдгийг Та нарт дахин сануулъя.

Л.Оюун-Эрдэнэ та бол Монголын ардчиллын түүхэнд хамгийн удаан ажилласан, 5 жил ажилласан Ерөнхий сайд. Тэгэх тэгэхдээ Засгийн газрын сайд нараа өөрөө томилох гэх мэт урьд хожид байгаагүй маш их улс төрийн эрх мэдэлтэй байсан.

Танай кабинет дотор зөрчил гарсан бол таны л томилсон хүмүүс. Мөн эдийн засгийн хувьд та хамгийн их эрх мэдэлтэй байлаа. Ерөнхий сайдаар ажиллах хугацаандаа хамгийн их төсөв хөрөнгө зарцуулсан. 2021-2025 онд зөвхөн төсвийн зарлага 120 их наяд төгрөгт хүрсэн. Энэ бол татвар төлөгчдийн хуруу хумсаа хугалан байж олсон мөнгө. Монголчууд бидний байгалийн баялгаа заран байж олсон мөнгө.

Гэтэл энэ хугацаанд монголчуудын амьдрал ингэж сайжирлаа, ийм асуудал шийдэгдлээ, тэдэн ажлын байр бий боллоо, залуусын мөрөөдөл ингэж биеллээ гэж ам бардам хэлэх зүйл нэг ч байсангүй.

Тийм ч учраас Ардчилсан нам хамтарсан Засгийн газарт орсон. Алдагдсан он жилүүдийг сунгахгүй байхын төлөө, ажил хийхийн төлөө, бизнесийн орчныг сайжруулахын төлөө, иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэхийнхээ төлөө, залуусын мөрөөдлийг биелүүлэхийн төлөө Ардчилсан намын сайдаар хичээж ажилласан. Доор бүрнээ, салбар бүрдээ манлайлал үзүүлсэн. Тодорхой асуудлуудыг шийдсэн. Манай бүлэг ч дэмжиж ажилласан.

Гэтэл Засгийн газрын тэргүүн нь өөрөө орлогоо нотолж чадахгүй байгаа асуудлаа хамтарсан Засгийн газрын асуудал болгож байгаад харамсаж байна.

Та анх гарч ирэхдээ эрх мэдэлд хүрэхдээ шударга ёс тогтооно, авлигатай тэмцэнэ, ах нарынхаа алдаа завхралыг засна гэж амласан. Энэ амлалтыг танаас өнөөдөр талбай дээр жагсаж байгаа залуус нэхэж байгаа. Шалтгаан нь ердөө энэ. Түүнээс биш Үндэсний баялгийн сан энэ тэрийг дэмжихгүй байгаа нэг ч хүн алга. Дэмжихгүй байгаа, эсэргүүцэж байгаа нэг ч хүн алга. Ямар нэг ил далд хүч, хэн нэгэн бүлэглэл, эсвэл Ерөнхийлөгчийн институт, хэн нэгэн том ах, том өрөг гэх мэт айдсыг дэвэргэх ямар хэрэг байдаг юм бэ.

Өнөөдөр энэ танхимд ямар ч тодорхой зүйл яригдсангүй. Хуйвалдааны онол л яригдлаа. Нэг зүйл дээр цэг тавихад Ардчилсан намын бүлэг засаглалын тогтолцоог өөрчлөх Үндсэн хуулийн аливаа өөрчлөлтийг дэмжихгүй гэдгээ нотлоод шийдвэрээ аль хэдийн гаргачихсан байгаа.

Мөн өнөөдөр Ерөнхий сайдад итгэл үзүүлэх санал хураалтад оролцохгүй буюу итгэл үзүүлэхгүй гэсэн улс төрийн шийдвэрийг гаргасан. Энэ шийдвэрийг хүртэл таны хэвлэл өнөөдөр мушгиад сууж байна.

Монгол Улсад ардчилсан хувьсгалаас хойш төрсөн эрх чөлөөтэй, нээлттэй нийгмийн иргэд болж төлөвшсөн залууст нийт хүн амын 60 хувийг бүрдүүлж байна. Тэд дарангуйллын хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ. Эрх чөлөөгөө булаалгахгүй.

Харин та бид үеийнхнийхээ мөрөөдлийг, залуусынхаа мөрөөдлийг, тэдний итгэлийг хамгаалах үүрэгтэй. Монгол Улсын Ерөнхий сайд айдсаар бус итгэлээр улс орноо удирдах ёстой шүү дээ.

Тиймээс би залуусынхаа талд, иргэдийнхээ талд бат зогсоно. Цаашлаад парламентынхаа талд, Үндсэн хуулийнхаа талд бат зогсоно. Хэрэв та ардчиллын үнэт зүйлсийн төлөө хамтдаа тэмцэнэ гэвэл мөр зэрэгцээд тэмцэхэд бэлэн байна.

Харин одоо та парламентыг хуваалгүйгээр өргөдлөө өгөөд огцорчихвол Монголын ардчилалд бараг оруулах хамгийн том хувь нэмэр чинь байх болно гэж хэлмээр байна.

Яагаад гэвэл улс төрийн тогтвортой байдал улс орны хөгжил нэг хүнээс хэзээ ч хамаардаггүй юм. Би л ганцаараа бүх асуудлыг шийдэж чадаж байна, өөр хэн ч чадахгүй гэж бодож эхэлнэ ээ гэдэг аль хэдийн дарангуйлагч болсны шинж шүү дээ. Парламентдаа итгэ л дээ.

Тэгээд эцэст нь талбай дээр маш олон хоног тууштай жагссан иргэдийнхээ эрх ашгийн төлөө тэмцсэн залуустаа баярлалаа гэж хэлье.

Х.Булгантуяа: Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Ерөнхий сайдыг би ийм зориггүй байхыг ер нь харж байгаагүй. Үнэхээрийн зориг нь мохсон харагдаж байна.

Асуултуудад хариулахдаа ч гэсэн ер нь цаад үндсэн агуулгаа шууд хэлж чадахгүй. Нийт агуулгуудаас нь харахад засаглалын хямрал, засаг доторх хагарал, засаглал хоорондын хямрал зэргийг сонслоо.

Яагаад ийм удаан ямар нэгэн реакци үзүүлсэнгүй вэ, яагаад тэр доор нь аль асуудалд хариулсангүй вэ гэдэг асуултыг тавьсан. Яалт ч үгүй ямар нэгэн юм байна гэдгийг мэдрээд байгаа юм, мэдэгдээд байгаа юм. Угаасаа яавч зүгээр яг энэ орлогоо нотол гэдэг асуудлаас болж Бага хурал Улсын Их Хурал дээр энэ асуудал яригдах учиргүй. Цаана нь шатрын хэдэн нүүдлийн цаадах юмыг хараад яриад би өнөөдөр ажлаа өгч болно, би зууралдаагүй, дараагийн үр дагавар нь юу байх вэ гэдэг дээр бид ямар ч байсан энэ хамтарсан Засгийн газар, ямар ч байсан энэ сонгодог парламентын тогтолцоо маань цаашдаа явах ёстой юм гэдэг ийм үгийг л хэлээд байна.

Маш ноцтой юмыг бусад хүмүүст хариулж байгаагаас нь сонслоо. Аливаа асуудал бүх юм засаг дээрээс ер нь эхэлсэн шүү дээ гэж. Сайд нар маань засгийнхаа бодлогын эсрэг явсан. Ерөнхийлөгчийн дэмжлэг хүртэл надад байхгүй болсон гэдэг ийм асуудлыг хэлж байна. Харамсалтай байна.

Яалт ч үгүй манай улс өнөөдөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ тогтвортой байсан ч сайд нар нь тогтворгүй байсан л даа. Яамдыг толгойлсон сайд нар нь ажилтайгаа танилцаж амжихгүй байсаар нь байгаад ажлаа өгөөд байгаа нь яамны ажил явахгүй байгаа юм чинь яаж Засгийн газрын ажил сайн явах вэ дээ. Тэгээд гол асуудлын учир шалтгаан нь юу юм бэ гэхээр Ерөнхий сайд өөрөө сайд нарыгаа шийддэггүй юм байна. Үүнийгээ сая хэллээ.

Тэгэхээр манай улсын хувьд цаашид энэ тогтвортой бодлого гэдэг маань юу байх юм бэ гэхээр ердөөсөө л энэ сонгодог парламент байх ёстой юм байна гэж. Ерөнхий сайд, засаглал, засгийн тэргүүн өөрөө энэ Засгийн газрынхаа гишүүдийг сонгодог, хариуцлага тооцдог, зоригтой байх ёстой юм байна гэдэг асуудлыг ярьж байна. Өнөөдөр зовлонгоо бид нарт хэллээ. Итгэл үзүүлээч ээ гэдгийг ч гэсэн хэллээ.

Миний хувьд тууштай байна. Би хэзээд энэ асуудал эхлэхэд ч би зоригтой хэвлэлийнхэн асуулт асуухад зоригтой л мэдэж байгаа мэдээллээ хуваалцаад, байр сууриа илэрхийлээд явж байсан. Үүнийхээ төлөө зохион байгуулалттай ч бай, органикаар ч бай зөндөө л нүдүүлж байна. Зөндөө л асуудал болж байна. Одоо ч гэсэн өнөөдөр 200, 300 гаруй мессежүүд ирлээ.

Би зүгээр энэ гишүүд маань Ардчилсан нам бүлэг нь дахиж хуралдаад парламентын засаглалын талаар асуудал яригдаж байгаа юм бол энэ асуудлыг эргэж харж нэг саналуудаа өгч энэхүү санал хураалтад оролцвол яасан юм бэ? Энэ бол бас Улсын Их Хурал болоод цаашдаа ер нь Монгол Улсын хөгжлийн асуудал яригдаж байгаа учраас энэ дээр нэг эргэж харсан нь зүйтэй байх гэж хүсэж байна.

Гишүүд маань саналаа болж өгвөл уг нь нууцаар өгчихмөөр байна. Яагаад гэвэл над шиг ийм ад үзэгдэх, Нара шиг ад үзэгдэх ийм зоригтой хүмүүс цөөхөн л байх. Хөөрхий залуу гишүүд итгэл үнэмшилтэй байгаа ч гэсэн нийгмийн болоод энэ сошиалын дайралтуудаас л их мохох, айх, өөрийнхөөрөө байж чадахгүй байх ийм эрсдэлүүд гаргах вий. Ер нь улс төр гэдэг бол бас л хатуу тоглоом. Ад үзэгдэх, зоригтой байх ёстой гэдэг итгэл үнэмшилтэй яг бат зогсдог байх ёстой гэдэг их чухал зан чанар мөн. Гэхдээ залуу улс төрчдөд энэ анх удаа учирч байгаа, тулгамдаж байгаа асуудал учраас яг төдийлөн зоригтой байж чадах уу, үгүй юү гэдгийг хэлж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сонгобайн Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе.

Манай 126 парламентын гишүүд сонгогдоод жил гаруй хугацаа болж байна. Энэ хугацаанд Ерөнхий сайд маш том боломж байсан. Тэгээд хамтарсан намууд ч боломж байсан.

Оруулж ирсэн бүх тэр 14 мега төсөл, бусад том төслүүдийн бүгдийг нь бид ямар ч эсэргүүцэлгүйгээр аль болох хурдан баталж, дэмжиж өгсөн.

Тэгэхээр төр засагт орсон 118, тэрний гадна байгаа манай Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл эд нар бүгдээрээ дэмжсэн.

Тэгэхээр асуудал юунд байна вэ. Асуудал энд л байна. Өнгөрсөн 30 хэдэн жилд бол ард түмэн маш ядуу, зүдүү байдалд орсон хэсэг бүлэг хүмүүс баяжсан. Ард түмэн нь биднийг юу гэж харсан бэ гэхээр 126 парламентын гишүүд том эвслийн Засгийн газар, бидний амьдрал сайжирна гэж харж байсан.

Тэгсэн чинь одоо байдал яаж эргэсэн. Нөгөө халаалтын үнэ нь нэмэгдсэн, цахилгааны үнэ нь нэмэгдсэн, долларын ханш нь өссөн. Бүр сүүлдээ нөгөө шатахууны үнэ нь хүртэл нэмэгдээд ингээд ард түмний карма дэлхий байсан. Ард түмэн ажил албатай болж, төр засаг юунд хэрэгтэй вэ гэж. Төр засаг бол тэр улсын аюулгүй байдлыг, ард түмний аж байдлыг, дотоодын үйлдвэрийг өсгөж эдийн засгаа тогтвортой байлгах тал дээр үйл ажиллагаа явуулах ёстой.

Манай засаг төр бол том яг төслүүдийг санаачилж батлуулсан. Гэвч ард түмэн тэр чигээрээ орхигдсон гэж. Одоо жишээлбэл сая ярьж байна. Эмнэлэг сайхан тоног төхөөрөмжөөр хангагдсан гээд. Тэгэхдээ юу болж байна гэхээр нь Ерөнхий сайд аа, одоо хөдөөгийнх нь аймагт ирээд, аймгаас өвдсөн хүмүүс нь хотод ирээд, хотод ирсэн хүмүүс нь гадаадыг зорьж байна.

Өнгөрсөн ч 30 жил тийм байсан. Одоо ч тийм байгаад байна. Сургуулиуд зарим анги нь 50, 60 хүүхэд хүртэл ингээд нэг ангид сурч байна. Тэгэхдээ таны ярьснаар сая ярилаа даа. Та. Таны санал юуг би сайн дэмжиж байгаа, бодож байгаа. Юм хийе ээ гэсэн залуу хүн байна. Дэмжье ээ гээд яваад байгаа. Зөндөө олон ажлын хэсэгт ч ороод ажиллаж байгаа.

Тэгэхдээ таны ярьснаар сая ярьж байна шүү дээ. Нөгөө мега төслүүдийг хөдөлгөөд нэг хэдэн төсөл ингээд явж байна. Тэр төслүүд юунд орсны дараа сайхан мөрдөн өгсний дараа энэ бүх сайжирна гээд. Тэр хүртэл ард түмэн тэсэн гэж бодож байна уу даа.

Тэгэхээр энэ олон торгуулиа зогсох хэрэгтэй, энэ олон татвараа эргэж харах хэрэгтэй. Тэгээд Монгол орон үйлдвэрээ хөгжүүлэхийн төлөө гадаадаас зээл авах биш хөрөнгө оруулалт татах хэрэгтэй.

Тийм учраас би энд төр засаг тогтвортой байгаасай гэсэн үүднээс танд хандаж байна. Тэгэхдээ та бол нэг буруу юм сая хийлээ. Юу буруу гэхээр нь Засгийн газарт бий болсон хямралыг Их Хурал руу чирж ирээд тэгээд Их

Хурлаас бүр Ерөнхийлөгч рүү ингээд давуулаад хаячихлаа. Тийм байх ёсгүй. Энэ бүгдэд чинь нэгдсэн нэг бодлоготой байж, нэгдсэн нэг санаа оноотой байж энэ төр засаг, энэ Монгол Улс хөгжинө.

Тийм учраас зоригтой байж, ажлаа үргэлжлүүлэн хийгээд энэ ард түмнийг ядуурлаас аврах юмсан гэсэн би бодолтой байгаад байна. Тэгээд энэ талбайд жагсаж байгаа залуучууд хэний ч захиалгаар жагссан гэж би бодохгүй байна. Үнэхээр боломж нь алдагдаад байна шүү дээ. 30 жил алдсан... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Эхнээсээ эртлээд баяр наадмаа тэмдэглээд, ялалтын баяраа тэмдэглээд уугаад эхэлсэн гишүүд маань монгол хэлээ англи хэлээ мэдэхгүй болчихсон. Триллион төгрөгийг триллион гэдэг их наяд төгрөгийг монгол хэлээ гээд бид нарт заах юм гэнэ. Яах вэ, Лодой гишүүн маань баяраа эрт тэмдэглэсэн, хэтрүүлсэндээ юу, эсвэл үнэхээр тэр нөгөө түрээсээр амьдардаг Эм Си Эсийнхээ гадаадын тэр хөрөнгө оруулагч нартай Монголын баялгийг дэлхийн бирж дээр тавихдаа хэдэн триллион триллион доллароор нь ярьдаг тэр яриандаа ороод триллион гэсэн үү. Мэдэхгүй байна.

Тэгээд ер нь бол хэн ч энд гоё ярьж болно оо. Үг, үйлдэл нь өдөр шөнө шиг ялгардаг хүмүүсийг би энд харж сууж байна. Тийм. Үгүй ээ үнэнийг хэлэхэд тэгээд л барилгын компаниа ажилд оруулах гээд л, тендер хусчих гээд л Монгол Ардын намтай өдөр шөнөгүй хүзүү сээрээрээ холбогдоод л, өдөр болгон архи тамхи ханхлуулаад л явдаг манай зарим гишүүд ч гэсэн байна шүү дээ. Өнөөдөр л гэнэт мундаг хүмүүс болчихож гэнэ.

Тэгээд ер нь ийм байдаг юм. Үнэн хэдий хүчтэй ч цаг хугацааны боол байдаг юм. Тэгээд үнэнийг харамсалтай нь хожимдсон хойно нь мэдэж гасалдаг нь хүний муу зан байдаг юм.

Тэгэхээр өнөөдөр бол яах вэ, ингээд олонхоороо ингээд нэг хүнээрээ туг тахиад өөрсдөө ариухан гэгээхэн бурхны бүрэлбаанууд ард нь үлдэж байна. Хоёрдугаар ээлж нь хоолондоо орох гээд ялалтын баяраа тэмдэглээд ууж идээд тулгаад явцгааж байна.

Энд андашгүй хажуугаар нь гарахаар архи дарс, сэнгэнээд байгаа өчнөөн хүмүүс байна. За юу. Гэхдээ нэрийг нь хэлээд яах вэ.

Тэгээд байна шүү дээ. Тийм. Ийм байна. Эцсийн эцэст яг энэ өнөөдрийн энэ нөхцөл байдал бол та нар зүгээр л хожим мэдэрнэ. Би яагаад үүнийг хэлж байгаа вэ гэхээр энэ бүр протоколд үйлдэг. Доор хаяж 5 жилийн дараа, 10 жилийн дараа, 20 жилийн дараа энэ Нара гээд балай хүүхэн чинь ёстой үнэнийг хэлж байсан юм байна шүү гээд хар толгойгоо хага шаах нь холгүй иргэд тэр үед намайг дурсан санах болно. Би маш сайн мэдэж байна.

Тэр үед дундаж давхарга гэдэг юм хомсдоод, харин жинхэнэ монголын баялгийг хуу тоногсод болон тэдний баялгийн тэр эх үүсвэрээсээ босгосон архи, тамхи, ундааны үйлдвэрийг хөлжүүлдэг, тэд нарын хэрэглэгчид болсон иргэд гэсэн ийм хоёр төрөлтэй иргэдтэй байх юм байна шүү манай монголчууд.

Тэгээд нэг ээлж байна. Одоо сошиал дээр төсвийн мөнгө хоёр дахин нэмэгдсэн байна энэ тэр гээд байгаа. Орлого нэмэгдэнэ ээ гэдэг чинь сайн л зүйл шүү дээ. Яагаад урьд нь энэ орлого нэмэгддэггүй байсан юм. Зүгээр шат шатандаа хувааж цавчдаг байсан болоод л энэ орлого нэмэгддэггүй байсан байгаа байхгүй юу.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын алдаа бол зүгээр л шат шатанд нь чимээгүй цавчаад өгөхийн оронд үүнийг энд төвлөрүүлээд, энэ хэдэн их наядаар нь нэмэгдүүлсэн харагдуулаад, ингээд энэ улс эх орныхоо төлөө энэ монополуудтай, энэ мафиудтай тэмцсэнийхээ л горьг өнөөдөр амсаж байна.

Тэгээд эцэст нь хэлэхэд одоо энэ санал хураалтыг ил тод хийх ёстой. Үхсэнээсээ айгаад байдаг юм. Тэр хэн нь бүлэглэлийн талд кнопоо дараад, хэн нь худалдагдсан талдаа кнопоо дараад, хэн нь ад үзэгдэх зоригтой байгаа юм, хэн нь гирвэшиж гэмшээд байгаа юм. Тэрийг ард түмэн хараг. Тэр хууччуул, тэр хуучны архагчууд тэр чимээгүй дундаа хийгээд, нууцаар саналаа хураагаад энэ Монголын баялгийг монополуудад, мафиудад өгчихсөн байдаг юм байна. Тэгвэл тэгэхээ больё бүгдээрээ. Илээр саналаа хураая.

Иргэд олон нийт өөрсдийнх нь сонгосон төлөөлөл нь аль талд хэрхэн яаж өгч байгаа юм, тэр нь өнөөдөр зөв буруу нь туйлын байх албагүй. Гэхдээ цаг хугацаанд харагдана.

Тийм учраас ил санал хураалт явуулах ёстой. Тэр ад үзэгдэнэ үү, яана уу тэр ерөөсөө өнөөдөр сонин биш.

Тэгэхээр санал хураалтыг ил явуулах нь зарчмын асуудал шүү. Энэ дээр бол би үнэхээр зарчмын асуудлыг иргэд олон нийт ч гэсэн ил санал хураалтыг дэмжээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд үдшийн мэнд хүргэе.

Тэгээд хамтарсан Засгийн газарт бусад намуудаа урьж ажиллуулсан Монгол Улсын Ерөнхий сайд, Ардын намын даргад хандаж үг хэлье.

Өмнө таныг манай намын бүлэг дээр орж ирж байхад би яг таныг намын дарга учраас гэж байгаад үг хэлж байсан. Та санаж байгаа байх. Хувь хүнтэй холбоотой асуудал биш шүү гэдгийг онцолж хэлье.

Өнгөрсөн 2016-2024 оны хооронд 8 жил үнэмлэхүй олонх байсан Монгол Ардын нам авлигатайгаа маш муу тэмцсэн. Нөгөө талдаа яах вэ орлоготойгоо их сайн тэмцээд орлого их сайн оруулсан байж магадгүй.

Авлигатайгаа маш муу ажиллагчидсаны үр дүнд зөвхөн Монгол Ардын намынхан л баяжсан. Монгол Улс бол авлигалынхаа индексээр бүр хойшоо сүүл мушгиад явж байгаа. Үүнийг нотлох жишээнүүд нь бас байгаа. Монгол Ардын намын удирдлагууд нь бизнес хийж үзээгүй төрд ороод төрөөс өөрөө баяждаг. Өөрөө баяжаад зогсохгүй ах дүү нар нь баяждаг. Одоо бүр сүүлдээ үеэл хаяалууд нь төрөөс паразиталж баяжиж байна. Уулын аманд амьдарч байна. Бодитой жишээнүүд нь байгаа.

Үүнийг та болон эсвэл танаас хойш ажиллах танай намын дарга нар анхаарч ажиллаасай гэж бодож байгаа юм.

Бас нэг жишээ нь Монгол Ардын намын нэг томилогдсон хурган даргынх нь уулын аманд байдаг амьдардаггүй гэрийнх нь сейфээс хэдэн тэрбум төгрөг гарсан шүү дээ. Энэ л нэг авлигын жишээ.

Монгол Ардын нам дагасан нэг хэдэн хурган дарга нар дунд шатныхны авлигалаар одоо энэ төрөөс төрсөн тэрбумтнууд, брэндийн өвчин туссан хүмүүс өнөөдөр энд яригдаад байгаа тэр цүнх, бөгжний асуудал бүгдээрээ зүгээр л энэ авлигалын асуудлаас болж үүсэж байгаа гэдгийг маш сайн анхаараасай.

Тэгээд тэдгээр хүмүүс нь эсвэл эхнэр, хүүхэд нь, гэр бүлийнхэн нь ааг омгоо энэ сошиалд барьж дийлэхгүй аагирхаж омогшиж байгаад нь энэ нийгэм, энэ талбай дээр байгаа залуучууд уур бухимдлаа барьж дийлэхгүй гарч ирж жагсаж байгаа гэдгийг анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Одоо зүгээр энэ юу гэдэг юм энэ дунд шатны хурган дарга нарынхаа авлигалыг цэгцэлж чадахгүйгээс чинь болоод, шударга биш байгаагаас чинь болоод эд нарын эхнэр хүүхдүүдийг зөөх бензиний мөнгөний төлөө, эсвэл энэ дунд шатанд дарга хийж байгаа хүмүүсийн тансаг тавилга, одоо тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэж яриад байгаа энэ урсгал зардлыг төлөхийн төлөө л хувийн хэвшлийнхэн ажиллаад байна.

Монгол Ардын нам 8 жил засаг барьсан. Улайлгасан. Одоо бүр улаан хүрэн болоод энэ чинь түлэгдэх гээд байна гэдгийг маш сайн анхаараасай. Ер нь ирэх жилүүдэд эдийн засаг тийм сайхан байхаар харагдахгүй байгаа гэдгийг маш сайн анхаарч ажиллаасай гэж бодож байгаа.

Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь заалт олонх болсон нам дангаараа Засгийн газраа байгуулна гээд. Эсвэл энэ Ардын нам олонх биш юм байна. Эсвэл Ардчилсан нам олонх болсон юм байна. Үндсэн хуулиа бид зөрчиж болохгүй гэдэг энэ зарчмыг анхаарч ажиллаасай. Нийлээд ягаараад байж болохгүй гэдгийг маш сайн анхаарч ажиллаасай гэж бодож байгаа.

Ардчилсан намаас засагт орсон сайд нар сайн ажилласан. Яаж ажилладгийг харуулсан. Хянаж болдог юм байна. Хууль бус хөрөнгийг хураах хуулийн төслийг боловсруулж өргөн барьж болдог юм байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайгуулыг нь хийсэн стратегийн ордуудыг төрд авъя гэдэг саналыг гаргаж болдог юм байна. Үүнээс нь үхтлээ байсан Монгол Ардын намын удирдлагууд болон дунд шатныхан намынхаа Бага хурлыг хийлгэж байгаад дарга нараа шахаж байгаад одоо энэ засаг огцрох, Ерөнхий сайддаа итгэл үзүүлэх асуудлыг л оруулаад ирж байгаа энэ л үйл явц.

Ард түмэн энэ Ардчилсан намыг зөвхөн цөөнх болоод хяналтаа сайн тавиадах л гэж бид нарыг сонгосон. Түүнээс бид нарыг засагт хамт... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн үг хэлье.

Б.Найдалаа: Бид нарын яриа явсаар байгаад хамтаръя, нэгдье, асуудлаа шийдье биш, улсаараа урагшильъя биш, чи би танай манай руу орж байгаад харамсалтай байна.

Тэр нь зүгээр жоохон асуудлаа том зургаар нь хармаар санагдаад байна. Ялангуяа энэ танхимд. Гадаа талбай дээр жагсаж байгаа залуучуудыг би захиалгатай гэж бодохгүй байна. Энэ бол органик, цаанаасаа ямар нэгэн юм болохгүй байгаа болохоор жагсаж байгаа. Тэр нь цүнхээр илэрсэн байж болно. Орлогоор илэрсэн байж болно.

Гэхдээ бид цаана нь яг юу хүсээд байгаа, яах гээд байгааг нь ойлгох хэрэгтэй байна л даа. Ялангуяа энэ танхимд.

Монгол Улс сүүлийн 30 жил яг энэ засаглалынхаа хэлбэрийг бүрэн олж чадаагүй, түнтгэнэсээр байгаад улс төр нь ингээд тогтворжихгүй байгаа болохоор эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр ялангуяа энэ танхимд сууж байгаа гишүүд, тэгээд улс төрийн намууд энэ дээр арай өөр өнцгөөр бодоод яахгүй бол зөвхөн нөгөө цүнхийг тойроод, авлигыг тойроод жижиг асуудал руугаа орох юм бид улам асуудлаа задлаад, төрөө задлаад засгаа унагаагаад, жилд нэг засаг барьдаг, хэнд ч итгэдэггүй ийм улс болж хувирах нь.

Тэгэхээр энэ 126-тай парламент бид нарын шинэ засаглалаа олох гээд байгаа нэг эрэлхийлэл. Энэ дээр жишээлбэл манай гишүүд ч гэсэндээ нээрээ алдаа хийж эхэлж байгаа. Бид бүгдээрээ шинэ болохоор суралцаж байна шүү дээ. Энэ шинэ тогтолцоо, цоо шинэ тогтолцоо.

Хоёр тал болж байгаад сөрөөд явдаг байсан. Тэглээ гээд яг юу болсон. Асуудал шийдэгдсэн юм уу. Төсөл яваагүй, хөрөнгө оруулалт байхгүй, эдийн засаг өсөөгүй. Авлига буурсан юм уу. Буураагүй.

Тэгэхээр яахыг сөрөг хүчин гэх юм, яахыг хамтрах гэх юм гэдгийг өөр өнцгөөр харахгүй гайгүй бол нийлчхээд, үгүй бол бие биеэ чи би гээд явдаг энэ бол болохгүй.

Тэгээд өнгөрсөн сонгуулийн дараа Ардын нам ХҮН намыг Засгийн газарт хамтарч ажиллахыг урьсан. Бид бодож байгаад олуулаа ярьж байгаад шийдсэн. Яагаад гэвэл хэн нэгэн сайдыг ч юм уу, хэн нэг намыг дэмжиж байгаадаа биш. Энэ хамтрах ёстой. Энэ 126-тай шинэ парламентын тогтолцоог төгөлдөр зөв төлөвшүүлэх ёстой гэдэг үүднээс бид орсон.

Хамтарсан засаг сайн ажилласан гэж бодож байгаа. Аль аль намууд нь сайн ажилласан. Манайхаас жишээлбэл Шадар сайд Т.Доржханд, Боловсролын сайд П.Наранбаяр нар орж ажилласан. Сайн мэргэжилтнүүд. Маш шаргуу ажилласан. Эрчим хүчний реформыг эхлүүлсэн биз дээ. Тогоо таслахдаа хүрээд сууж байгаа шүү дээ. Бид 20, 30 жил хийж амжихгүй л байсан. Эхлүүлж чадсан. 2, 3 тэрбум долларын хөрөнгө босгосон. Одоо үүнийг оруулж ирээд дараагийн ажлыг нь хэн хийх юм. Ингээд тасалдах юм уу. Тэр түншүүд яах юм, хүлээлт яах юм гээд асуудал байна.

2026 онд боловсролын жил болж зарлуулсан, зарласан. Энэ дээр асар олон ажил хүлээгдэж байна. Сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалтууд байна. Багшийн хөгжил, цалин нэмэх. Энэ ажил яах юм. Одоо хаягдах юм уу, чи би гээд бүгдээрээ нураагаад дуусах юм уу.

Нам хожиж болно. Улс төрчид хувьдаа хожиж болно. Гэхдээ эцсийн дүндээ Монгол Улс хохирох гээд байна. Энд л хамгийн санаа зовж байна. Хамгийн аюултай нь нэг Засгийн газартаа биш, нэг хүндээ биш, нэг сайддаа биш. Бид ерөнхийдөө засаглалаа олоогүй хэвээрээ, талцсан хэвээрээ, тэгээд 126 болчхоод талцах юм бол бүр аюултай шүү. Тэгээд энд санаа зовж байна.

Тэгэхээр миний энд гишүүдээсээ, улс төрийн намуудаас уриалмаар байгаа зүйл бол энд жоохон хариуцлагатай хандаач ээ. Зүгээр нэг салж нийлж байна. Нийлэхдээ зүгээр нийлчхээд салахдаа чи би гээд салаад бүх юмаа нураагаад явмааргүй байна.

Төрөө ямар ч байсан засгаа тогтвортой байлгамаар байна. Ингэж байж гадаад улс бидэнтэй ярина биз дээ. Гол гол төслүүдээ, реформын чанартай юмандаа аль нам ч байсан хамаагүй явуулмаар байна.

Хамгийн чухал нь 126 гишүүнтэй энэ шинэ парламент хамтрахтай хамтраад, хамтарсан ч гэсэндээ бие биеэ хянаад, сөрөх нь сөрөөд нэг ийм үр бүтээлтэй ажиллаж сурдаг энэ тогтолцоог бүрэн нэвтрүүлэхгүй хоёрын хооронд ийм олон намтай ийм парламент байгаад хуучин арга барилаар ажиллах юм бол бүр аюултай шүү.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Юуны түрүүнд нээлттэйгээр асуудлыг ярьж гэж.

Тэгээд Монголын ард түмэнд 126 гишүүд нээлттэйгээр өөрсдийнхөө саналыг хэлж, зөвхөн хувь хүний асуудал гэхээсээ илүүтэй институт хоорондын асуудал. Мөн дээрээс нь цаашдаа бид ер нь юуг анхаарах вэ гэдгийг нэг томоохон дүгнэлт хийж байгаа ийм хурлыг хийх санаачилгыг гаргасанд талархалтай байна.

Бүсчилсэн хөгжлөөр үр дүн нь байгуулагдсан 126 гишүүн дунд салбар салбарын тодорхой төлөөллүүд орж ирсэнд би туйлын их талархалтай байгаа. Таны хувьд энэ санаачилгыг эхлүүлж, өнөөдөр тэр зарчимдаа үнэнч байж энэ гишүүдийн дунд нээлттэйгээр асуудлыг ярьж байгаа энэ жишиг цаашдаа Монголын улс төрд томоос том үлгэрлэл болж үлдэнэ ээ гэдэгт би итгэлтэй байна.

Хувь хүнийхээ хувьд асууя гэж бодож байсан хэд хэдэн асуултдаа хариулт авсан. Ялангуяа залуучуудын болон нийгэмд болж байгаа энэ асуудал дээр яг үнэхээрийн хувь хүнийхээ хувьд мөн чанарыг нь ойлгож ингэж харж байгаа тухай би хариулт хэлсэнд талархалтай байна.

Миний хувьд би ойлголцлын хүсээд байгаа юм. Хамтын тодорхой илүү хурдтай үр дүнг бий болгох энэ санаачилгыг дэмжээд байгаа юм. Анхнаасаа л би хамтарсан Засгийн газрын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх энэ хөтөлбөрүүдийг дэмжсэн байр суурьтай байсан.

Өмнөх 30 жилийн бидний алдаа бол хоор хоорондоо юуг ч байсан бусад өөр намын санал бол буруу юм гэдэг ийм агуулга дор хэт их улс төржсөн энэ байдал өмнөх 30 жилийн маань алдаа байсан. Тэгээд энэ алдаагаа засахын төлөө олон эрх ашгуудыг давж хамтарсан Засгийн газар томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, өнөөдөр тодорхой үр дүн гаргасан нь олон гишүүдийн хэлж байгаа энэ саналаас харагдаж байна.

Тэгээд би сонгодог парламентын тогтолцооны төлөө өнөөдрийн хэлсэн энэ гишүүдийн үгэнд талархалтай байна. Таны хувьд ч гэсэндээ энэ байгаа байдалдаа, үзэл санаандаа үнэнч байж тодорхой ирээдүйд болж магадгүй энэ асуудлуудыг олон нийтийн анхаарлын төвд аваачиж, өнөөдөр олон гишүүдийн байр суурийг хадгалан үлдээж байгаад би баяртай байна.

Хувь хүнийхээ байр суурийг би тодорхой илэрхийлсэн. Хамтарсан Засгийн газар, Ерөнхий сайд итгэл үзүүлэх асуудал дээр бол би хатуу итгэл үнэмшилтэйгээр дэмжиж байгаа.

Мөн дээрээс нь ард түмэнд нээлттэй, ил тодоор явуулаасай гэсэн ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

10 сарын өмнө бид сонгогдож ард түмний өмнө тангараг өргөж, илүү хурдтай хөгжлийг бий болгохын төлөө ажиллана гэдэг энэ амлалтыг өгсөн. Ингээд жил хүрэхгүй хугацааны дараа бид энэ санаанаасаа ухарч болохгүй ээ.

Ардчилсан намын гишүүддээ хандаж хэлэхэд тодорхой асуудлуудаа ч одоо гэсэн ярихад оройтоогүй ээ гэж би хэлэх байна. Хамтдаа хийж хэрэгжүүлэх олон ажлууд үүний цаана үлдэж байгаад харамсалтай санагдаж байгаа юм.

Тэгээд зөвхөн миний үг биш байгаад байх шиг байна. Гишүүдийн сая яриад байгаа 28-наас 30-ны өдрүүдэд энэ гарсан хөндлөнгийн судалгаагаар нийт ард иргэдийн 63 хувь нь энэ хамтарсан засгийн үйл ажиллагааг Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудлыг, баялагтаа эзэн байх асуудлыг дэмжиж байна гэдэг саналыг илэрхийлснийг энэ судалгааг гишүүддээ сануулж хэлье.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Тамын тогоонд монголчуудыг байлгах гэсэн улс төрчдийн чөтгөрийн тойргоос гаргахгүй гэсэн ийм үзэл бодол, ийм лобби бүлэглэл ялж байх шиг байна.

Худалдаа үнэнээр тэмцэж дийлдэггүй юм байна. Бүр том худал ялдаг гэж үнэн үг байна. Монголчууд баялагтаа эзэн байх гэж, монголчууд эв нэгдэлтэй байх гэж зүтгэсний чинь үсийг авч байх шиг байна харж сууна. Кноп дарах эрхгүй байна.

Монголд хууль биш, Монголд шударга ёс биш, Монголд мөнгө засагладаг юм байна. Тэр мөнгө нь хэдхэн хүмүүст байдаг юм байна. Төрөхдөө долларын саятан, төрөхдөө долларын тэрбумтан болсон тэр хүмүүсийн эрх ашиг өнөөдөр энэ Монголын парламентад, Монголын төрийн дээр гарч суусныг яг дотор нь мэдэрч байгаадаа харамсалтай байна.

Мөнгөөр Монгол Улсыг эзэмддэг, мөнгөөр монгол төрийн бодлогыг худалдаж авдаг, мөнгөөр монгол төрийн эв найрамдлыг устгадаг энэ эзэрхийллээс бид гарахгүй юм байна.

Тэгэхээр яах вэ, Дэлхий дахин надаас урвахаас өмнө би дэлхий дахинаас урвах ёстой гэдэг үгээр явах уу. Эсвэл хууль засагладаг Монгол Улсын төлөө явах уу. Ардчилсан Монгол Улс олон намын тогтолцоотой. Нам болгон дотроо фракцтай. Фракц болгон дотроо эрх ашигтай. Тэр болгоныг нь худалдаад авчихсан. Монголын газрын баялгаар монголчуудын саналыг худалдаж авдаг. Монголын газрын баялгаар Монгол Улсын эрх ашгийг худалдаж авдаг. Бүр сурчихсан.

Одоо дараагийн сайдууд нь эрх ямбаа хуваарилчихсан, инээд алдчихсан. Чи тэгнэ, би ингэнэ гээд явж байгааг бид дотроос нь харж байна. Маш их харамсалтай.

Тэгэхдээ ийм зүйл дараагийн их тэмцлийн галыг өдөөдөг гэдэгт би итгэдэг. Монголын ард түмэн зөв зөн совинтой гэдэгт итгэдэг. 21 аймгийг хөр цаснаар идэр гурван есийн хүйтэнд туулсан, 300 гаруй мянган санал цуглуулсан. Энэ санал бол монголчууд байгалийн баялагтаа эз эзэн байя, монголчууд эв нэгдэлтэй байя, монголчууд орлоготой байя, монголчууд ядуурлаас гаръя гэж өгсөн хөөрхий ард түмний санал байсан.

Үүнийг өнөөдөр хогийн сав руу хийгээд, үүнийг өнөөдөр хэдхэн хүмүүс мөнгөөрөө эзэрхийлж аваад ингэж Засгийн газрыг унагаадаг юм. Ингээд та нар эв нэгдэлтэй бай, ингэж хамтарч засаг барьдаггүй юм гэдгийг бид нарт харуулж байгаа юм. Бид харж байгаа юм.

Тэгэхдээ монголчууд зөн совинтой, ард түмэн зөн совинтой гэдэгт итгэж байна. Нэг юм унтрахад дараагийн гал асдаг. Тэр гал хурдан асах болтугай.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн үг хэлье.

Д.Энхтүвшин: Өнөөдөр бид бүхэн Үндсэн хуулийн 44.1 дүгээр заалтыг хэлэлцэж байгаа. Тэгээд энэ заалт дээр уг нь их тодорхой. Бодлогын асуудал дээр л Ерөнхий сайдад итгэл үзүүлэх. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын баталсан бодлогоос зөрүүтэй ч юм уу, эсвэл шинээр бодлого танилцуулаад тэр нь эрсдэлтэй гэж байгаа үед бол энэ асуудлыг хэлэлцэхээр заасан ийм хуулийн заалттай байгаа.

Гэтэл өнөөдөр одоо хэлэлцэж байгаа байдлаас харахад бид бүгдээрээ яг юу хэлэлцэж байгаагаа бараг мэдэхээ больтлоо хамтарсан засгийн асуудал болоод явчхаж байна, Үндсэн хуулийн Ерөнхийлөгч эрх мэдэл хуваалцаж байна, булаалцаж байна гэдэг асуудлууд ярих ийм бүр төөрөөд үндсэн асуудлаасаа ингээд гажаад явчхаж байна

Тэгэхээр хэрвээ энэ асуудал дэмжигдээд, санал хураагдаад энэ нэг тал руугаа шийдвэл дэмжигдсэн дэмжигдээгүй бол энэ хоёулаа Үндсэн хуулийн энэ 44.1 гэдэг заалтын агуулгатай нийцэхгүй учраас Үндсэн хууль зөрчих, бид нарын Улсын Их Хурлын гишүүдийн өргөсөн тангараг байгаа. Нийт иргэн, улсын эрх ашиг, тэгээд Үндсэн хуулиа дээдэлнэ гэсэн энэ зарчмаасаа гажиж, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн бус асуудлуудад ярилцаж байгаа иймэрхүү дүр зураг байна.

Хоёрдугаарт, сүүлийн үед болохоор нэг бид нарын цаашид анхаарах ёстой юм үзэл бодлоо илэрхийлэх, гудамжинд битгий хэл Улсын Их Хурлын танхим дотор гишүүд үзэл бодлоо илэрхийлэх бол тун эрсдэлтэй болсон. Үүнийг өнгөрсөн хугацаануудад харсан. Янз бүрийн үлгэр зохиож, хардалтуудаар

харлуулдаг дайрдаг, зохион байгуулалттайгаар дайрдаг ийм үйл явдал байнга явж байна.

Одоо жишээлбэл Ерөнхий сайдын эзэмшдэг, 50 хувийг нь эзэмшдэг компанийн чиглэлээс энэ жагсаал цуглаан зохион байгуулж байгаад огцрох амархан, жагсаалын эсрэг жагсаал цуглаан зохион байгуулах хуулийн эсрэг, өөрөөр хэлбэл эсрэг жагсаалыг зохион байгуулж байгаа ийм баримттай талбай дээр одоо яг тэнд ажилладаг хүмүүс нь жагсаал цуглаан зохион байгуулаад мөнгө төлбөртэй холбоотой асуудлууд ингээд явж байна.

Энэ нь яг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Үндсэн хуулийн суурь зарчмыг Ерөнхий сайдын өөрийнх нь эзэмшдэг компани, 50 хувийг нь эзэмшдэг компанийн оролцоотойгоор ийм юм хийж байгаад цаашдаа анхаарах хэрэгтэй. Энэ бол маш олны эгдүүцлийг дургүй хүргээд байгаа гол асуудлууд энэ гэж бодож байна.

Ардчилсан намын хувьд би Засгаас гарах шийдвэр гаргасан нь яг парламент засаглалыг төгөлдөржүүлэхэд чухал алхам гэж бодож байна. Зөв зүйл хийхэд туслахаас илүү муу зүйл хийхээс нь хамгаалах гэдэг маш чухал үүрэг роль гэж бодож байна.

Тэгэхээр Ардчилсан намын энэ Засгийн газарт орсон мөрийн хөтөлбөрүүд нь үргэлжлүүлээд явахад энэ бодлогоо дэмжинэ байх гэсэн бодолтой байна.

Тэгэхээр үүнийг заавал Засгаас гарсан ч гэсэн, гараагүй ч гэсэн заавал энэ мөрийн хөтөлбөрийг нь өөрчлөх хэрэггүй. Үүнийг нь үргэлжлүүлээд яваасай гэж бодож байна.

Тэгээд ер нь сүүлийн үед Үндсэн хуулийн энэ зарчим буюу парламентын бие даасан байдал алдагдаж байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдээр харахад өнгөрсөн хугацаанд ч гэсэн бид нарын 10 сарын хугацаанд Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан хугацаа нь ч гэсэн ер нь парламентын бие даасан байдал маш хэврэг болсон байна гэж харагдаж байгаа.

Засгийн газрын гишүүд нь нэлээн үүрэг рольтой. Эсвэл засагт орох гэсэн зарим гишүүдийн засгаа шүүмжлэх ч гэдэг юм уу, яг энэ хууль тогтоох үйл ажиллагаа хийдэг энэ зарчим маань алдагдаад ирж байна. Өөрөөр хэлбэл энэ буцаагаад улс төрийн эрх барьж байгаа намын дарга ч гэдэг юм уу, Ерөнхий сайд дээр бол асар их эрх мэдлүүд төвлөрч байна. Энэ нь буцаад геополитикийн хувьд эрсдэлтэй асуудал байна гэсэн. Үүнийг улам эрсдэлд оруулж байгаа ийм дүр зураг байгаа учраас энэ тогтолцоог илүү зөв болгоход Ардчилсан нам бол сөрөг хүчнийхээ үүрэг гүйцэтгэх нь маш чухал гэж бодож байна.

Тэгээд амьдрал цаашаа үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Тэгээд бүгдэд нь цэр нь цээжинд бөөр нь бөгсөнд байх болтугай гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч орж ирсэн байна.

Ингээд Ерөнхийлөгч өөрийн байр сууриа илэрхийлнэ. Ерөнхийлөгчийн микрофоныг өгье.

У.Хүрэлсүх: Их баярлалаа. Эрхэм хүндэт төрийн түшээд, Улсын Их Хурлын гишүүд Та бүхэндээ энэ оройн мэнд хүргэе.

Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүн ойрын хэд хоног нэлээдгүй ажилтай байсныг Та бүхэн маань бүгдээрээ мэдэж байгаа.

Австрийн Ерөнхийлөгч ирлээ. Араас нь залгаад алдарт ээж нартаа хүндэтгэл үзүүлэх гээд ажил явагдлаа. Өчигдөр Туркменистаны Ерөнхийлөгч айлчилсан. Сая төрийн айлчлал өндөрлөөд би гаргаж өгөөд.

Тэгээд нөхцөл байдлын талаар нэлээдгүй мэдээллийг сая мониторинг хийж, холбогдох албаны хүмүүсээс авлаа.

Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн тэргүүн, төрийн эрх барих дээд байгууллагынхаа хуралд өөрийн биеэр оролцож, зарим тодорхой бус зүйлүүд дээр өөрийн биеэр хариулт өгөх нь чухал болжээ гэж үзээд Ерөнхийлөгч өөрийн биеэр орж ирж байна гэдгийг Та бүхэндээ хэлье.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш Монгол төрийнхөө парламентад байнгын хүндэтгэлтэй хандаж ирсэн. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Байгуулагдсан хамтарсан Засгийн газрыг бүх талаар дэмжсэн.

Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг Ерөнхий сайд болсон, одоо ажиллаж байгаа энэ 5 жилийн хугацаанд бүх талаар дэмжлээ. Би нэг удаа парламент дээр орж ирж, парламентынхаа тухай, Засгийн газрын үйл ажиллагааны тухай буруу, зөрүү зүйл ярьж байсныг Та бүхэн маань сонсоогүй байх.

Би өөрөө Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүний хувьд Ерөнхий сайдын зовлонг их сайн мэднэ. Энэ бол тийм амархан ажил биш. Нэн ялангуяа би чинь цар тахлын үед ажиллаж байсан. 4 жил ажилласан. Маш хүнд нөхцөлд. Бас заримдаа яс янгинахаар ийм хэцүү ажил байдаг юм. Зовлон жаргалыг нь бас ойлгодог хүний хувьд олон жил энэ Ерөнхий сайдыг хүмүүжүүлж, сургаж, бэлтгэж, хамт амьдарсан улс төрчийнхөө хувьд, удирдагчийнхаа хувьд энд сууж байгаа хоёр даргад би их хүндэтгэлтэй ханддаг юм шүү дээ. Хайрладаг юм, хамгаалдаг юм. Өнөөдөр ч гэсэн би хайртай байгаа.

Тийм учраас би хувь хүмүүсийн асуудлаар энд янз бүрийн асуудал хөндөж ярихыг хүсэхгүй байна.

Тэгэхээр би зарчмын хэд хэдэн зүйл дээр хариулт өгье гэж ингэж бодож байна.

Нэгдүгээрт хүн засаглахгүй ээ. Хууль засаглана. Би Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа дээр миний хэлсэн үгийн хамгийн гол пойнт бол “хүн засаглахгүй хууль засаглана” гэж хэлсэн. Үүндээ өнөөдрийг хүртэл би үнэнч байгаа үнэнч байгаа.

Ямар хүн Монгол Улсыг Ерөнхийлөгчийн засаглал руу шилжих ёстой гэж хэлээд, яриад байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа. Би улс төрд ороод 30 гаруй жил болж байна. Би өөрөө ардчилсан нийгэмд өсөж хүмүүжсэн хүн. Миний итгэл үнэмшил бол парламентын засаглал.

Тийм ч учраас би парламентын засаглалыг боловсронгуй болгохын төлөө өөрийнхөө улс төрийн бүх он жилүүдийг зориулсан. Би Ерөнхий сайд байхдаа Монгол Улс парламентын засаглалтай байх ёстой гэдэг байр сууриа байнга илэрхийлж байсан.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт байна. Саяын 126 гишүүнтэй болсон асуудал байна. Энэ бүх зүйл дээр Ерөнхийлөгч дэмжсэн.

Ерөнхийлөгч өөрийнхөө бүрэн эрхээс бүх юмнаасаа татгалзсан шүү. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид нэг их тийм айхтар эрх мэдэлцээд байх юм бол байхгүй шүү дээ. Бүх эрх мэдэлд Засгийн газар луу шилжсэн. Би үүнийг өөрөө Ерөнхий сайд, Ардын намын дарга байхдаа хийсэн хүн байгаа юм.

Ерөнхий сайд өөрийнхөө Засгийн газрын кабинетын бүх гишүүдийг хэн нэгэн хүнээс хамааралгүйгээр өөрөө томилж чаддаг болсон. Өөрөө чөлөөлж чаддаг болсон. Ерөнхийлөгч энд ямар ч оролцоо байхгүй болсон. Надад зүгээр л нэг мэдэгдээд л, би үүнийг тавих гэж байгаа гэж хэлээд л болоо.

Би өөрөө Ерөнхийлөгчийн эрх мэдэлд байсан Авлигатай тэмцэх газрыг гүйцэтгэх засаглал руу шилжүүлсэн. Гэмт хэрэгтэй тэмцэх субъект бол Засгийн газар юм байна. Ерөнхийлөгч бол Авлигатай тэмцэх газрын даргыг томилдог, санал болгодог энэ байдал олон жил олон улс төрч нарыг хонгилоороо чирч явсан юм байна. Үүнийг таслан зогсоох ёстой. Ерөнхийлөгч өөрөө ард түмнээс сонгогддог учраас парламенттайгаа эн чацуу байдаг.

Манай нөхцөлд Ерөнхийлөгч бол дээд танхимын үүрэг гүйцэтгэдэг юм шүү дээ, хөөрхий.

Тийм учраас Авлигатай тэмцэх газрыг Ерөнхийлөгчийн эрх мэдэлд байлгах нь Монголын улс төрд, энэ шударга ёсонд нийцэхгүй юм байна. Энэ

байгууллага тэр Засгийн газрынхаа бүтцэд байж, парламент нь Засгийн газрыг хянадаг учраас тэндээ байх нь илүү зохимжтой юм байна гэж би өөрөө үзэж Авлигатай тэмцэх газрыг Ерөнхийлөгчийн мэдэлд байлгадаг асуудлыг шилжүүлж гүйцэтгэх засаглал руу өгсөн юм. Энэ ажлыг би өөрөө хийсэн юм.

Та бүхэн үүнийг мэдэж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийг өөрөө байгуулаад шүүгчийг томилдог байсан. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчийг томилохгүй байгаа шүү дээ. Тэр Шүүхийн ерөнхий зөвлөлийг парламент байгуулна. Парламентын мэдэлд очсон. Ерөнхийлөгч хуучин байгуулдаг байсан бол.

Тэгээд парламентаас байгуулсан Шүүхийн ерөнхий зөвлөл ямар хүнийг шүүгч болгох вэ гэдгээ тэндээ хэлэлцээд Ерөнхийлөгч рүү оруулж ирдэг. Ерөнхийлөгчид ямар ч түүнийг ганц удаа л буцаана. Өөр эрх мэдэл байхгүй. Тэгээд оруулж ирснийг нь шууд томилно. Ерөнхийлөгч байгаа эрх мэдэл энэ.

Тэгээд ийм л Ерөнхийлөгч байгаа шүү дээ. Өнөөдөр төрийн тэргүүн хэн нэгэн хүнийг дарамтлаад, засаг төрөө дарамтлаад байх тийм боломж ч байхгүй. Надад ганцхан юм л байдаг юм. Энэ бол ард түмний өгсөн итгэл найдвар л байгаа. Ерөнхийлөгчийн хүч чадал бол зөвхөн ард түмний сонгосон сонголт л үлдсэн. Бараг.

Тийм учраас би албан ёсоор нэг зүйл хэлье. Би өнгөрсөн жилийн 2024 оны 11 сарын 26-ны өдөр буюу Үндсэн хууль, Шинэ Үндсэн хууль, Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойгоор Үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүй. Намайг Ерөнхийлөгчөөр ажиллаж байх гэсэн албан ёсныхоо үгийг хэлсэн шүү дээ.

Сая би өөрийнхөө нэрийн хуудас дээрээс үүнийг албажуулж тавьсан. Та бүхэн маань бүгдээрээ уншсан байлаа. Х.Тэмүүжин гишүүнд талархал илэрхийлье. Зөв хүлээж авсанд.

Манай ард түмний сонгосон сонголт бол парламентын засаглал. Энэ бол бидний үнэт зүйл. Энэ ардчиллын баталгаа бол парламент.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч парламентдаа туйлын хүндэтгэлтэй ханддаг бөгөөд цаашдаа парламентын засаглалыг би байнга дэмжинэ.

Намайг Ерөнхийлөгчөөр ажиллаж байх энэ хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд ямар нэгэн өөрчлөлт орохгүй гэдгийг би албан ёсоор Та бүхэнд хэлье.

Би өөрийгөө дахиж 6 жилээр огт сонгохгүй. Тийм дабл стандарт байж болохгүй. Би үүнийг урьд нь та нарт хэлж байсан шүү дээ. Энэ Засгийн газрын кабинетын гишүүд ч гэсэн би хэлж байсан. Одоо энэ С.Одонтуяа сууж байна.

Тийм ээ. Би дахиж сонгогдохгүй ээ. Би олон гишүүдэд энэ тухай асуудлаа ярьж байсан.

Тэгээд намайг хэн дахин сонгоод байгаа юм бэ.

Яагаад өнөөдрийн энэ болж байгаа улс төрийн нөхцөл үйл байдал, Ерөнхийлөгчийн засаглал, парламентын засаглал гэж тэс ондоо юм яриад ард түмний толгой эргүүлээд, төрийн эрх барих дээд байгууллагын гишүүдийн тархи толгойг эргүүлээд, асуудлыг өөр тийш нь хандуулаад, хариуцлагаас зугтах гээд байгаа юм бэ. Би зарчим ярьж байна шүү.

Би энэ хоёр дарыг хүүхэд байхаас нь авхуулаад зарчимтай байгаарай л гэж байнга л захиж ирсэн. Хулгай дээрмээс хол байгаарай. Хулгай битгий хийгээрэй, худлаа битгий яриарай, хуурч битгий мэхлээрэй бусдыг л гэж аминдаа ах хүний хувьд ч, дарга удирдагчийнх нь хувьд ч гэсэн энэ өнгөрсөн он жилүүдэд бүгдэд нь захиж л ирсэн шүү дээ.

Тэгээд захиасыг маань арай хөсөрдүүлэхгүй байх гэж би одоо хүртэл найдаж байгаа. Найдаж байгаа. Тийм хүн чанаргүй зан авир, тийм эр хүний жудаггүй ааш авир гаргахгүй байх гэдэгт би итгэлтэй байна. Итгэлтэй байна.

Тийм учраас парламент ёсоо цааш нь улам бэхжүүлэхийн төлөө л бүгдээрээ ажиллана. Нэгдүгээр асуудал би маш тодорхой хэллээ шүү. Ард түмэндээ бас хэлж байна.

Хоёртдугаарт, баялгийн санг Ерөнхийлөгч санаачилсан юм. Энэ нэг их өнөөдөр санаачлагдчихсан зүйл огт биш. Би Ардын намын дарга бөгөөд Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуульд Үндэсний баялгийн сан байгуулна гэсэн заалтыг оруулсан юм. Нөхөдтэйгөө хамт.

Би энэ заалт дээр үнэнч байгаа. Би өөрөө Ерөнхий сайдаар ажиллаж байсан. Энэ улс орны нөхцөл байдал хүнд, амьдрал хүнд байгаа учраас парламентаар орж ирээд нэг их ил задгай үг хэлдэггүй шүү дээ. Ихэвчлэн үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаараа хаалттай хуралдаан дээр л Та бүхэнд хэлдэг. Би баялгийн сангийн талаар энэ өнгөрсөн мэдээлэл дээр маш тодорхой хэлсэн.

Баялгийн сангийнхаа хуулиа гаргачихлаа. Одоо та нар зоригтой ажиллаж ажлаа хий, наад баялгийн сангийнхаа ажлыг шуурхай явуул гэж би парламентад хандаж үг хэлснийг Та бүхэн маань бүгдээрээ сонсож байсан биз дээ, энэ чинь.

Тэгээд Монголын газрын баялаг бол ард түмний өмч байх ёстой юм. Энэ бол миний хүүхэд байхаасаа төлөвшиж тогтсон миний үндсэн философи. Энэ байгалийн баялгийг чинь хэн нэгэн компани бүтээхээгүй юм. Энэ чинь бурхны бүтээл.

Тийм учраас Монголын ард түмэн байгалийн баялгаасаа ижил тэнцүү хүртэх ёстой юм. Монголын ард түмний өмч болсон байгалийн баялгийг хулгай хийж авсан этгээд бол энэ баялгийг буцааж өгөх ёстой. Ард түмэн баялагтаа эзэн байх ёстой.

Би 2018 онд санаж байна. Миний Ерөнхий сайд байхад Л.Оюун-Эрдэнэ маань миний Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан юм. Тийм ээ. Би Л.Оюун-Эрдэнэд томилолт бичиж өгөөд чи тэр Норвегт очоод тэр Норвегийн байгалийн баялгийн санг судлаад ир гэж явуулж байсан шүү дээ. Тэгээд Л.Оюун-Эрдэнэ судалж ирж байсан юм. Тэгээд баялгийн сан гэдэг чинь ийм чухал зүйл байдаг юм байна Ерөнхий сайд аа гэж надад танилцуулж, тэгээд одоо үүнийг чинь хийх ёстой. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулъя гэж ингэж Баялгийн сан бий болсон шүү.

Тийм учраас Ерөнхийлөгч ард түмэндээ баялгаа авч өгөх, баялгийн тэгш хуваарилалтыг хийхэд би цаашдаа ч хатуу байр суурьтай байна. Манай ард түмний баялгийг хууль бусаар хулгай хийж авсан хүмүүс баялгаа өгөх ёстой. Би үүнийг дахиад хэлчихье. Энэ миний философи.

Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Үндэсний баялгийн сан байгуулах тухай асуудал бидний санаачилгаар орсон юм. Түүнээс биш энэ чинь нэг тийм цоо шинээр бий болчихсон асуудал биш ээ гэдгийг би нэг хэлье гэж ингэж бодсон юм.

Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч бол гурван зүйл дээр их санаа зовж явдаг юм. Би урьд нь ч Та бүхэндээ хэлж байсан.

Энэ бол нэгдүгээрт Монгол Улсын тусгаар тогтнол.

Хоёрдугаарт, улсын аюулгүй байдал.

Гуравдугаарт, манай ард түмний эв нэгдэл гэсэн энэ гурван зүйл бол төрийн тэргүүний үйл ажиллагааны үндсэн гурван зарчим. Та бүхний маань ч гэсэн үйл ажиллагааны үндсэн гурван зарчим.

Тэгээд сүүлийн 20 хоног харлаа. Энэ гудамж талбайд юу болж байгааг Та бүхэн маань бүгдээрээ анзаарч байгаа байх. Би Ерөнхий сайдад, Их Хурлын даргад нэг зүйлийг хэлж байгаа. Та нар энэ ард түмнээ сонсооч ээ л гэж. Энэ ард түмэн чинь юу яриад байгаа юм бэ. Юу хүсээд, мөрөөдөөд энэ олон зуун залуучууд энэ талбай дээр гарч ирээд 20 хоног жагслаа шүү дээ. Тавьж байгаа шаардлага нь маш тодорхой. Тэгээд Монгол Улс бол ардчилсан засаглалтай. Парламентыг ард түмэн сонгодог.

Тийм учраас ард түмний чинь төлөөлөл болоод залуу үеийнхэн чинь гарч ирээд шударга ёс тогтоох тухай, хариуцлагатай байх тухай хатуу шаардлага

тавьж байхад яагаад үүнийг сонсохгүй ингээд хараагүй юм шиг, сонсоогүй юм шиг энэ залуучуудын тавьж байгаа шаардлагаар шал анги юм энл яриад байна. Асуудлаа тодорхой яриач Та бүхэн. Наад олон түмэн чинь 20 хоног хүлээлээ шүү дээ. 20 хоног энэ талбай дээр юу болж байгааг та бид бүгдээрээ харлаа. Хаана, юу, ямар жагсаал цуглаан болж байна. Бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ ард түмнийхээ тавьж байгаа шаардлагад манай парламент зохих хариуг нь өгөх ёстой гэж би бодож байна. Та бүхэн бол ард түмнээс сонгогдсон ард түмний мандаттай улсын эрх ашгийг, ард түмний эрх ашгийг тэргүүн эгнээнд тавина, аливаа нэг албан тушаалтны асуудлыг ард нь тавина гэж тангараг өргөсөн гэж би боддог юм шүү дээ.

Тэгээд би амьдралдаа 4 албан тушаал өгч байсан хүн байгаа юм. Ардын намын Ерөнхий нарийн бичгийн даргыг өөрийнхөө сайн дураар өгч явлаа. Улсын Их Хурлын гишүүнээс өөрийнхөө сайн дураар татгалзаж байлаа. Шадар сайдынхаа ажлыг өөрөө сайн дураараа өгч байлаа. Ерөнхий сайдын эрхэм өндөр албан тушаалыг би цар тахлын үед хариуцлагагүй ажилласнаасаа болоод өөрийнхөө сайн дураар би огцорч байлаа.

Тэгээд энэ бүхний цаана нэг л юм агуулагдаж байсан. Энэ юу вэ гэвэл энэ олон түмний эрх ашиг, ард түмний эв нэгдлийг удирдагч хүн тэргүүн зэрэгт тавих ёстой. Өөрийн хашиж байгаа нэг өчүүхэн албан тушаалд битгий шигд. Удирдагч хүн бол ухрах үедээ ухардаг, урагшлах үедээ урагшилдаг чадвартай байх ёстой. Дээр нь ард түмнээсээ уучлал гуйдаг чадвартай байх хэрэгтэй. Алдаа гаргасан бол.

Хариуцлага алдсан бол тэр алдсан хариуцлагынхаа хариуцлагыг нь өөрөө үүрч чаддаг байх хэрэгтэй. Үүнийг удирдагч гэж хэлдэг юм. Үнэнээ хэлдэг байх ёстой. Худлаа ярьж болохгүй, хуурч мэхэлж болохгүй. Ард түмний эв нэгдэл, нэгдмэл байдалд гай болж болохгүй. Үүн дээр манай бүх албан тушаалтнууд их анхаарах ёстой. Үүнийг би төрийн тэргүүний хувьд Та бүхэнд зөвлөж байна. Зөвлөж байна.

Хүмүүс намайг хараад их тийм залуу хүн гэж боддог юм шиг байгаа юм. Би улс төрд 35 жил явж байна. Амьдралдаа зөндөө л алдаж онож үзлээ. Сайн муу юмыг нуруун дээрээ үүрч гарлаа. У.Хүрэлсүх хэрвээ худалч, хулгайч байсан бол энэ том намын хамт олон намайг их олон жил дарга цэргээрээ тавих ч үгүй байсан байх, итгэх ч үгүй байсан байх. Ард түмэн намайг сонгох ч үгүй байсан байх.

Би өөрийнхөө албан тушаалыг хэзээ ч бусдад худалдаж байгаагүй. Би улс орноосоо хэзээ ч хулгай хийж байгаагүй. Би Ерөнхийлөгчийн энэ өндөр сэнтийг гадныхны 50 сая воноор зарж байгаагүй шүү. Би 5 нам дамжиж амьдраагүй. Би эхнэрээ солиогүй, намаа солиогүй, нөхдөөсөө урваагүй. Дээр нь би эх орондоо хайртай.

Тэгээд хамгийн эцэст нь Монгол Улсын төрийн тэргүүн Ерөнхийлөгч ард түмнээс сонгогдсон хүн. Би ард түмнийхээ талд бат хатуу зогсоно шүү гэдгийг хамгийн сүүлд нь хэлье.

Би өнөөдөр энэ ард түмний тавьж байгаа шаардлага, энэ олон зуун залуучууд өдөр шөнөгүй хөөрхий энэ талбай дээр ирж сайн дураараа хүсэлт зорилгоо илэрхийлж, эрх чөлөөгөө эдэлж байгаа, шударга ёсыг хүсэмжилж байгаа энэ хүсэмжлэлийг хангахын төлөө би явна.

Би ард түмнээсээ хэзээ ч урвахгүй. Би ард түмнийхээ талд зогсоно шүү. Үүнийг эцэст нь Та бүхэндээ хэлье. Төрийн тэргүүнийхээ үгийг Та бүхэн маань сайн тунгааж, зөвөөр ойлгож, асуудлаа шийдэх байх гэж би найдаж байна.

Хамтарсан Засгийн газар харамсалтайгаар ингээд өндөрлөж байгаад би их харамсаж байна. Би энэ Засгийн газрыг тултал нь дэмжсэн шүү. Надад ямар боломж байна би бүгдээрэнгээр нь дэмжсэн.

Энэ Засгийн газар яагаад тарсан бэ гэдгийг Та бүхэн бараг өөрсдөө мэдэж байгаа болов уу гэж би бодож байна. Үүнийг надаас биш Ерөнхий сайдаас асуух хэрэгтэй. Энэ хамтарсан Засгийн газар яагаад тарах болсон, хэн үүнийг тараах санаачилга гаргасан юм бэ гэдгийг холбогдох хүмүүс өөрсдөө хариулах нь үнэнд нийцэх болов уу гэж би ингэж бодож байна.

Тэгээд ард түмнийхээ үгийг сонс. Та бид өдөр шөнөгүй л ардчилал ярьдаг шүү дээ. Энд бие биеэ доромжилж, гутааж, бусдын нэр хүндэд халдахаа боль. Арай дэндэж байгаа юм биш үү. Нэг үг дуугарсан хүнийг ямар муухай харлуулж, ямар муухай доромжилж, ямар муухай хүнд байдалд оруулж байна. Эрэгтэй, эмэгтэй гэж тоохгүйгээр.

Тэгээд ийм юм хийж байж бид ардчиллын тухай, ардчилыг хамгаалж байна гэж ярьж болж байгаа юм уу. Би энд их гайхаж байна.

Ингээд парламентын гишүүд Та бүхэндээ төрөө авч явах энэ эрхэм бөгөөд нэр хүндтэй ажилд чинь улам их өндөр амжилт хүсье.

Ард түмнээ битгий ингэж талцуулж, шар махтай нь хатаагаад бай. Асуудлаа шийд. Ард түмэн харж байгаа. Хэрвээ Та бүхэн ард түмнийхээ талд асуудлаа шийдэж чадахгүй бол, ард түмний хүссэн хүслэмжлэлийг биелүүлж чадахгүй бол ард түмэн арай ондоогоор ярьж байж магадгүй янзтай байна шүү. Энэ олон залуучууд.

Би харин шударга ёсны төлөө янз бүрийн хатгаасгүйгээр энэ олон залуучууд, янз бүрийн ашиг сонирхолгүйгээр энэ олон залуучууд төрийнхөө ордны гадаа эмх цэгцтэй, үймээн самуунгүй үзэл бодлоо илэрхийлж байгаад би маш их баярлаж байгаа. Манай залуучууд их ондоо болсон юм байна. Их

ухаалаг болсон юм байна. Тэдний ярьж байгаа, хэлж байгааг та бид бүгдээрээ сонсож байгаа.

Одоо тэгээд ард түмнийхээ өмнө нүдний балай болохоо боль. Та бүхэн ард түмнээ төлөөлж байгаа хүмүүс шүү. Эрхэм нэр хүндтэй хүмүүс шүү. Парламентын гишүүн хүн гэдэг бол ард түмний төлөөлөл. Энэ эрхийг Та бүхэнд ард түмэн өгсөн.

Тийм учраас ард түмнийхээ талд зогсож бай. Амин хувийн ашиг сонирхол, ах дүү нарынхаа ашиг сонирхол, албан тушаалын нэг жижигхэн сэнтийд битгий шигд. Эр зоригтой бай. Ингэж чадвал ард түмэн чинь чамайг хайрлана. Удирдагч хүн ийм л байх ёстой. Алдаа гаргасан бол алдаагаа хүлээ. Асуудлаа шийд. Битгий ард түмнийг талцуул, битгий бухимдуул, битгий хуваа.

Гадаад, дотоод нөхцөл байдал хүнд байгааг Та бүхэн маань бүгдээрээ мэдэж байгаа.

Ингээд Ерөнхийлөгч нь өөрийнхөө байр суурийг илэрхийллээ. Нөхцөл байдлыг харж байгаад цаашдаа үг хэлэх шаардлагатай гэж үзвэл төрийн тэргүүн орж ирж Та бүхэнд дараа дараагийнхаа үгийг хэлэх болно гэдгээ илэрхийлье.

Эрхэм төрийн түшээд Та бүхэн маань зөвөөр хүлээж аваарай. Би байгаа үнэнээ л хэллээ. Би нэг их хүнд худлаа яриад байдаг хүн биш. Миний хүмүүжил тийм. Би эх орондоо олон удаа тангараг өргөсөн эр цэрэг хүн. Цэргийн сургуульд намайг ингэж хүмүүжүүлсэн юм. Ямар ч албан тушаалтан хэн гуайгаас ч би айхгүй. Би ганцхан юмнаас айдаг юм. Ард түмний минь итгэл найдвар алдрах вий гэдгээс л айдаг юм. Миний айдаг ганц юм бол энэ.

Тийм учраас энэ гадаа байгаа ард түмэн чинь итгэл найдвар нь алдагдаж эхэлж байна шүү. Их баярлалаа Та бүхэндээ. Амжилт хүсье. /алга ташив/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн байр сууриа илэрхийллээ.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Үндэсний эв нэгдэл маш чухал гэдгийг л хэлмээр байна.

Монгол Улсын Их Хурлын парламент маань бүрэлдэн тогтоод 10 сар гаруй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаа дуусаагүй байтал засгийн асуудлаас болоод танай, манай гээд хуваагдаад эхэлж байгаад би харамсаж байна. Танай Засгийн газар, манай Засгийн газар гэхээсээ илүү Монгол Улсын Засгийн газар.

Тийм учраас энэ удаагийн парламентаас их хүлээлт байгаа. Миний хувьд ямар олон жил улс төр намаар явсан туршлага байх биш. Гэхдээ 7, 8 Ерөнхий сайдын үед ажиллаж үзсэн. 2015 байна уу, 2016 онд байна уу бас энэ Засгийн газрын асуудал болоод цалин нэмэхгүй, жагсаал хийхгүй гэдэг гэрээн дээр гарын үсэг зур гээд тийм дарамт ирж байсан юм. Тэрийг бол би мартаагүй. Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд энэ цалин хөлс, энэ Засгийн газар юу хийв. Тухайлбал Л.Оюун-Эрдэнэ гэдэг Ерөнхий сайдын хувьд ярьж байгаа учраас би хэд хэдэн зүйлийг бол хэлэх нь зүйтэй байх.

Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж 80-аас 2 дахин өссөн ийм үзүүлэлт байна. Тэтгэврийг өвлүүлдэг болсон. 10 жилийн өмнө бол намайг ярьж байхад битгий үлгэр яриад бай гэж хэлдэг байсан юм.

Цаашаа дахиад нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал хүлээгдэж байгаа, татварын асуудал хүлээгдэж байгаа гэдгийг олон нийтийн хүлээлт бол энэ нэлээн өндөр байгаа.

Дараагийн нэг зүйл нь Ерөнхий сайдын орлогоо нотолно. Та нар битгий санаа зовоо гэж хэлж байна. Тэгээд үүнийг бол тэр Авлигатай тэмцэх газар энэ тэр нь, нийгмийн хүлээлт ч байх шиг байна. Тодорхой дүгнэлт саналаа нэг их удаан хүлээлгэхгүй би гаргачих болов уу гэж бодож байна.

Тийм учраас өнгөрсөн хугацаанд байж байгаа нэлээн өндөр хүлээлт бий болсон. Үүнээс илүү ажиллах байх гэдэг итгэл доор энэ парламентад орж ирсэн. Түүнээс биш ямар нэгэн компани, аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс их хэмжээний хандив мөнгө аваад тэрийг нь дараа нь өөрөө хэд дахин нугалж олъё, эсвэл ингээ гэдэг ийм санаагаар орж ирээгүй.

Тэгэхээр саяхан бид 55 хувийн түүхэндээ байгаагүй өндөр итгэлтэй парламентыг бүрдүүлээд хамтарсан Засгийн газраа тавиад, том том амлалт, мега төслүүдээ хөдөлгөө гээд хамтарсан шигээ цаашдаа ч хамтрал, парламент өөрөө нэг л парламент байдаг учраас ажиллаад явах болов уу гэж би бодож байгаа. Аль болохоор улс төржилт багатай.

Тийм учраас энэ тал дээр эрхэм улс төрийн намын удирдлагууд, туршлагатай шинэ, дунд үе гээд энэ хүмүүс маань илүү их эв нэгдэлтэй байгаасай гэж хүсэж байна.

Ард түмэн өндөр хүлээлттэй байгаа. Энэ өндөр хүлээлтийг ч гэсэн энэ Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын үед бий болгосон юм. Цалин хөлсийг нэг жилд нэг 20-оос доошгүй хувь нэмчихдэг. Ганцхан Эрдэнэс Тавантолгойн уурхай дээр нэг бүрэн эрхт төлөөлөгч гээд тавиад тэндээс 1 их наяд орчим төгрөг орж ирсэн. Үүнийг ард түмний орлогыг нэмэгдүүлэхэд зарцуулна гээд түүний хүлээлт нь одоо хүртэл байж байгаа. Сая бол 6 хувиар нэмсэн. Тэгэхдээ олонх нь дэмжсэн. Баяртай байгаа. Бага ч гэсэн. Цаашдаа энэнээс илүү өндөр хүлээлт байгаа.

Тийм учраас цаашдаа ямар ч шийдвэр гардаг бай Засгийн газар иргэдийн орлого гэдэг зүйл рүү нэг номерт анхаарал хандуулах шаардлага байгаа.

Яах вэ, тэр эдийн засгийн нөхцөл байдлаас сүүлийн тэр 14 мегагийнхаа бид хэдийг нь явуулах вэ гэдэг цаашдаа энэ олон жил гацсан энэ асуудлыг явуулах нь зүйтэй гэж бодож байгаа.

Тийм учраас Монголын төр бол эв нэгдэлтэй байх ёстой гэж би бодож байна.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Засаг солигддог гэж зөндөө олон хүмүүс ярьж байсан. Тийм ээ. Маш их солигддог. Намайг дунд сургуульд байхад л засаг солигдоод л байдаг. Би зүгээр асуумаар байгаа юм. Ардчилсан намаас ч тэр, Монгол Ардын намаас ч тэр.

Ер нь засаг солигдох бүрд хэчнээн хүний амьдралд сүүдэр тусдаг вэ гэдгийг ер нь та нар тооцож үзсэн үү. Огцрох асуудал нь улс төржилт л өөрсдөд нь чухал болохоос биш ер нь хүмүүсийн амьдралд яаж тусдаг ер нь тооцдог уу. Тэр үед огцроход тэдэн хүн ингэж хохирсон, энэ үед огцроход ингэж байсан гэдэг асуудал байдаг уу. Ядарсан хүмүүсийн нуруун дээр ямар ачаа үүрдгийг тооцож үзсэн үү гэж байгаа юм.

Хоёрдугаарт, иргэдийн ил тод байдал шаардаад байгаа залуус яахаараа та нарын тоглоом болж дуусдаг юм бэ? Ил тод юм тодруулаад юм асуухаар л танай, манай, тэдний, эдний гээд байх юм. Асуусан асуултад нь хариултыг нь өгчих юм бол тэгээд хариултаа авсан хүмүүс нь яваад үнэхээр тэр зорилттой хүмүүст нь үлдэх байлгүй дээ. Дайснаа зөв тодорхойл л доо.

Гуравдугаарт нь, ер нь энэ хоёр нам аль аль нь ямар ч хариуцлага алга. 7, 8 дугаар ангийн хүүхэд сайн дурын ажил хийнэ гэж яриад нэг жил тэрийгээ хийчихдэг юм шүү дээ. Дүүгээ хараад хичээлээ хийгээд бүх юмаа хийчихдэг. Та нар 10 сар ч болохгүй ингээд л орж гараад л тоглоод байх юм.

Тэгээд энэ хүмүүсийн амьдрал энэ төр засаг чинь тоглоом юм уу? Та нарын бодлоор. Би бол ингэж л асуумаар байна. Тэнд сууж байгаа, энд ирж жагсаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ өмнөөс ингэж асуумаар байна. Та нар эргээд юу гэж ярих юм. Тойрогтоо гишүүдээ.

Тэгээд хамтарсан, хийе гэж ярьсан бид нарын 10 сарын өмнө баталсан ажлын хариуцлагыг хэн үүрэх юм. Яах вэ, өгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал бол та нарт нэг ийм 10 мянгадугаарт ордог асуудал байж болно л доо. Тэгэхдээ хөгжлийн бэрхшээл гэж ямар хүмүүс байдаг гээч. Хэлэх үү. Өөрийгөө илэрхийлж чаддаггүй, эсвэл бусадтай харилцахад хэцүү, шийдвэр гаргахдаа

хүндрэлтэй байгаа хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй гэдэг ийм тодорхойлолт байгаа шүү дээ.

Өнөөдрийн төр засгийн байдал яг л ийм л байна. Асуусан асуулт, хариулт хоёр нь байнгын зөрүүтэй, хоорондоо ярьж байгаа юм нь үргэлж төвөгтэй. Иргэдийн юу хэлээд байгааг ойлгохгүй. Хариу ч өгөхгүй. Бид бараг хөгжлийн бэрхшээлтэй боллоо шүү дээ. Энэ янзаараа ингээд хоёр талд хэрэлдээд ингээд суугаад байх юм бол.

Тэгээд хамтарсан засгаараа үүнийгээ шийдье энэ тэр гэж 10 сарын өмнө ч юм уу яриагүй юм уу. Би үүнийг дахиж асуумаар байгаа юм. Уг нь би хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дээшлүүлэхийн тулд орж ирсэн. Энэ тэгэхдээ 10 мянгадугаар асуудал юм байна. Тэгвэл хөгжлийн бэрхшээлтэй биш нүд чихтэй иргэнээ ядаж сонсоод, тэр ил тод байдлыг нь бий болгохын төлөө яваад өг л дөө.

Миний хувьд хамтарсан байна уу, хамтраагүй байна уу ерөөсөө хамаагүй. Би ил тод байдаг засгийг шаардаж байна. Хаана нь юу нь байгаа нь ойлгомжтой байдаг засгийг шаардаж байна. Үүний төлөө энд байгаа иргэн бүр, гишүүн бүр хариуцлагаа үүрэх ёстой шүү дээ. Яах вэ цөөхөн байж болно. Тэгэхдээ миний үгийг зөндөө олон хүмүүс адилхан сонсож л байгаа. Энэ үгийг хэлэхийг хүсэж байгаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлье.

О.Батнайрамдал: Сая хөндлөгдлөө л дөө. Бид Үндсэн хуульдаа Үндэсний баялгийн сан байгуулаад газрын хэвлийн баялгийг тэгш хүртээмжтэй хуваарилна гээд бид заачихсан.

Тэгэхээр үүнийгээ бид яаж ийгээд л хэрэгжүүлмээр л байна л даа. Нэгэнтээ бид байгалийн баялгаас орлогынхоо дийлэнхийг олж байгаа. Цаашдаа ч гэсэн. Дараагийн 10, 20 жилдээ ч гэсэн бид нарын орлогын гол эх үүсвэр байсаар байх болно.

Яг энэ шударга хуваарилалт явахгүй болохоор нэг чөтгөрийн тойргоосоо хэзээ ч гардаггүй нэг ийм дүр зураг олон орнуудад харагдаад байгаа юм. Урьд нь ч гэсэн би яг тэр орнуудын жишгийг хэлж байсан. Замбиа, Перу, Боливия, Найжириа, Индонези, Папуа Нэгени.

Тэгээд бидний хамгийн олон жишээ авдаг Чили ч хүртэл яг л адилхан асуудал.

Энэ асуудал өөрөө шийдэгдэхгүй болохоор улс төр дээр байгаа засаглалын асуудал нь давхар шийдэгддэггүй. Яагаад гэвэл яг нэг нэгнийгээ татаж унагаадаг чөтгөрийн тойрог л орчхоод байгаа юм л даа.

Яг энэ Баялгийн сангийн хууль ямар ч байсан батлагдаад яг мөнгөжөөд, яг хэрэгжээд, нөгөө баялгийн хэлцэл рүү орох үед яг өнөөдрийн улс төрийн асуудал аягүй өндөр хугацаа авч байна л даа. Тэгээд энэ улс төрийн асуудалтай ярьж байгаад ард талд явж байгаа тэр яг доллар тоологдох мөнгөний асуудал нь орхигдчих вий гэж миний хувьд бол санаа зовж байна.

Яагаад гэх юм бол яг баялгийн сангийн хуваарилалт яг мөнгөнжүүлэлт, яг доллар дээр нь очоод л гацаж байна л даа. Энэ уг нь ашигт малтмалын хуульдаа стратегийн ордын талаар бол энэ чинь аль бараг хориод жилийн өмнө орсон заалт. Хэзээ ч хэрэгждэггүй байсан. Энэ баялгийн сантай хуультай болоод энэ хэрэгжихээр, мөнгөжихөөр болтол ингээд л асуудал үүсэж байгаа юм.

Тэгээд цаашдаа бид тэгээд энэ стратегийн ордууд дээр хэлцэл хийж чадах уу? Уг нь хамгийн том хэлцэл хийсэн тэр Оюу Толгойн холбоо бүхий Онтрэгийн асуудал яригдаж байна. Энэ хэдэн тэрбум доллар шүү дээ. Тэгээд Монгол Улсын эдийн засагт дараагийн 20, 30 жилдээ нөлөө үзүүлэх ийм том хэмжээний зүйлүүд байхгүй юу.

Тэгэхээр ийм том дараагийн 10, 20 жил, 30 жил Монгол Улсын эдийн засагт, бидний амьдрал, амьдралын чанарт шууд нөлөөлөх энэ хүчин зүйлүүдээ бид энэ дунд ингээд орхимооргүй байна. Энэ дунд ингээд шийдэгдэх хэрэгтэй.

Тийм учраас бид бүхэн том зургаа харж, эв нэгдлээ хангаж шийдвэр гаргаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Тэгээд ямар ч шийдвэр гарсан тэгээд хамгийн гол нь олон нийт, ард түмнийхээ өмнө ил тод явмаар байна. Олон улсын жишээ хүмүүс их ярьж байна лээ л дээ. Тэгээд тэр нь яг энэ сонголт дээрээ бид бүхний жишээ авдаг Англи, Герман, Канад, Энэтхэг, Израиль, Итали бүгдээрээ яг Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудал дээрээ бүгдээрээ ил тод явдаг. Олон улсын жишиг нь яг ийм байгаа.

Тэгэхээр яг энэ жишгээр олон нийтийн өмнө нээлттэй, ил тод яваасай гэж хүсэж байна. Тэгээд эцэст нь бүгдээрээ энэ том зургаараа том... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Бүгдэд нь оройн мэнд хүргэе.

Тэгэхээр Ерөнхий сайдаас Улсын Их Хурлын даргад ирүүлсэн итгэл хүлээлгэх энэ бичигт үүссэн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэхэд дэмжлэгийг хүссэн байгаад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан сонгодог парламентын тогтолцоог төлөвшүүлэх, төгөлдөржүүлэх гэсэн энэ зорилтын

хүрээнд өнөөдөр их олон гишүүд өөрсдийнхөө үзэл бодол, байр суурийг илэрхийлж, ярьж байна.

Тэгэхээр ер нь сонгодог парламентын тогтолцоог төлөвшүүлнэ гэдэг бол хамгийн нэгдүгээрт парламентын суурь зарчмуудыг хэрэгжүүлэх тухай асуудал энд яригддаг. Хамгийн нэгдүгээрт иргэдийн санал, сонгуульд өгсөн саналыг хүндэтгэж, тэд нар иргэдийн зүгээс тухайн улс төрийн намд ямар үүрэг хариуцлагыг тухайн сонгуулиар оногдуулсан юм бэ гэдгийг хариуцлагатай хийж хэрэгжүүлэхээс энэ бол эхлэх ёстой гэж бодож байна. Өөрөөр хэлэх юм бол дийлэнх олонхын саналыг авсан бол дангаараа засгаа байгуулаад явах ёстой.

Сонгуульд ялагдсан бол сөрөг хүчнийхээ үүргийг гүйцэтгээд явах ёстой. Энэ бол хамгийн нэгдүгээрт тавигдах ёстой гол зарчим байх.

Хоёрдугаарт нь, парламентын тогтолцоог төлөвшүүлэхийн тулд мэдээж хэрэг парламентыг олонх, цөөнх болсон намууд шийдэл, шийдвэрээ эрүүл саруулаар мэтгэлцэж ярилцах ийм өрсөлдөөний талбарыг энд бий болгох ёстой байх.

Хэрвээ парламент дотор ийм сөрөг хүчин байхгүй болох юм бол, хэрвээ парламент дээр байгаа улс төрийн намууд өөр хоорондоо эвсээд нэгдээд ингээд явчих юм бол хэн сөрөг хүчний үүргийг гүйцэтгэж, хэн хяналт тавьж, хэн хариуцлага тооцох юм? Парламентын гадна байгаа ард түмэн чинь энэ сөрөг хүчний үүргийг гүйцэтгэх болчхож байгаа юм биш үү.

Тэгэхээр энэ тухай асуудлыг бид парламентын тогтолцоогоо төгөлдөршүүлэх тухай дээр бодох ёстой байх гэж бодож байна.

Ер нь хамтарсан засаг байгуулаад явж байсан түүх бол манайд байдаг л даа. 2008 оны сонгуулийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Эндээс стандарт бус Засгийн газар үүсээд, МАНАН гэдэг үүсээд, тэгээд эрх ашгаараа хоорондоо сүлэлдсэн улс төрийн ийм бүлэглэлүүд үүсээд гараад ирсэн. Тэнд хяналт байхгүй, хариуцлага байхгүй болоод ирсэн. Энэ бол бид нарын аягүй том сургамж шүү дээ.

Хэрвээ парламентын тогтолцоогоо цаашид төгөлдөржүүлье гэх юм бол энэ эрсдэлтэй алхмаас бид яаж өөрсдийгөө хамгаалах вэ гэдгийг бид бодох ёстой юм биш үү.

Энэ дээр нэг нийгмийн сэтгэл зүй нэг том үзэгдэл байдаг л даа. Юу гэхээр хамтарсан засаг болоод ирэхийн хэрээр энэ бүлгийн сэтгэлгээний эмгэг гэж нэг үзэгдэл гараад ирдэг. Нэг талдаа гараад ирэхээр бие биедээ зарчмын шаардлага тавьж чадахаа болиод эхэлдэг. Бие биеийнхээ амыг дагаад эхэлдэг. Эргээд энэ нь ердөөсөө хяналт, хариуцлага гэх юм байхгүй, яах аргагүй тэр сөрөг хүчнийг нийгэм үгүйлсэн ийм байдал руу үүсгээд эхэлдэг.

Тэгэхээр өмнөх алдаанаасаа сургамж аваад, өнөөдрийн энэ итгэл үзүүлэх албан бичигт бичигдсэн санаан дээр бид тогтож яримаар байгаад байгаа юм.

Тэгээд хоёрдугаарт нь Улсын Их Хурлын даргаас оруулж ирж байгаа тогтоолын төсөл дотор, Ерөнхий сайдын өгч байгаа тайлбар дотор хэдийгээр сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлнэ гэж заасан хэрнээ логикийн хувьд зөрчилтэй, хамтын хариуцлагад тулгуурласан хамтарсан засгийг байгуулна гээд оруулаад ирэх юм. Үүнийг би нэг л нэг сайн ойлгохгүй байгаад байна.

Энэ чинь угтаа бол бид дангаараа Засгаа байгуулаад явах ёстой юм биш үү. Хэрвээ парламентын засаглалыг яг жинхэнэ мөн чанараар нь хэрэгжүүлбэ гэж байгаа юм бол.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Өдөр Байнгын хороон дээр байр сууриа илэрхийлчихсэн учраас чуулган дээр нэг их олон юм яриад байх шаардлагагүй ээ гэж бодож байна.

Их Хурлын даргаас нэг зүйл хүсэж байна. энэ үгийн дараа гишүүд мэдээж санал хураалт явагдана. Санал хураалтыг илээр явуулж өгөөч ээ гэж горимын санал гаргаж байна. Хүсэлт тавьж байна.

Яагаад вэ гэхээр камерын өмнө нэг өөр ярьдаг, жүжиглэдэг, бөөрөнхийлдөг, зугтдаг, камерын ард гарахаараа, хөшигний ард гарахаараа нэг өөр юм ярьдаг. Төр засгаа самарч тоглодог. Хоолондоо орох гэж байгаа энэ улсуудыг нэг харъя гэж бодож байгаа юм. Энэ багийн цаана байгаа улсуудыг нэг харъя гэж бодож байгаа юм.

Тийм учраас энэ санал хураалтыг хэн нь юуны төлөө явсан юм бэ гэдгийг нэг хармаар байна.

Тийм учраас энэ санал хураалтыг илээр явуулж өгөөч. Одоо бид юунаасаа айх юм, юунаасаа ичих юм, хэн нь хэнээсээ ичих юм. Саналаа өгөхийн тулд ард түмнээсээ нуугаад хаагаад байх юм байхгүй байх гэж бодож байна.

Тийм учраас энэ ярьсан, хэлсэн дээрээ байгаа энэ улсууд байна уу, үгүй юу гэдгийг нь нэг хармаар байна. Энэ дараа дараагийн, ганц энэ удаагаар энэ асуудал яригдахгүй байх гэж бодож байна. Энэ бүрэн эрхийн хугацаа дуустал хэчнээн ч төр засаг солигдохыг мэдэхгүй.

Тийм учраас сургамж болог гэж. Энэ шуналаа дарж чадахгүй байгаа улсуудад сургамж болог гэж энэ санал хураалтыг нэг ил тод явуулж өгөөч ээ гэж ийм л хүсэлт тавих гэсэн юм. Өөр юм алга аа.

Д.Амарбаясгалан: ЦСандаг-Очир гишүүн үг хэллээ.

Гишүүдээс хүсэлт ирж байна. 30 минутын завсарлага өгөөч гэж байна.

Тэгэхээр нэг цаг хүртэл чуулганы хуралдааныг түр завсарлуулъя. /алх цохив/ Нэг цагаас яг цагтаа эхэлнэ шүү. Гишүүд танхимдаа.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье.

Далайн Батбаяр гишүүн үг хэлнэ.

Д.Батбаяр: 7, 8 цаг. 8 цагийн турш бид нар сууж байна.

Ардчилсан намд гомдсон улсууд их байна. Ардчилсан нам иргэдэд, амьдралд гай болж байна гэж ярьсан яриа их байна. Манай Ерөнхий сайд бол гэгээнтэн байсан гэдэг гашуудлын үг их хэлэгдэж байна.

Муу муудаа дээрэлхүү гэдэг шиг хүн болгон л Ардчилсан нам руу шавар цацах гэж оролдож байна. Тэгж байна шүү дээ. Би бодит байдлыг л ярьж байна.

Тэгээд энэ бол зүгээр нэг цүнхний хэрэг бол биш. Энэ гадаа жагсаад байсан улсууд хөдлөх тусам өрөнд ороод байгаа учраас жагсаж байгаа байхгүй юу. Өчигдрийн доллар өнөөдөр үнэтэй байгаад байгаа учраас өнөөдөр зогсож байгаа байхгүй юу. 8 жилийн турш засагласан засгийг эсэргүүцэж зогсож байгаа байхгүй юу.

Өнөөдөр ажиллаад авсан цалин нь амьдралд нь хүрэхгүй байгаа учраас зогсож байгаа юм. Үг хэлсэн нь шоронд орохдоо тулдаг, үзэл бодлоо илэрхийлсэн нь төлбөртэй гэж гүтгүүлдэг болсон учраас энд зогсож байгаа юм, бүгдээрээ.

8 жилийн турш намайг хэн хэлдэг юм бэ, биднийг хэн огцруулдаг юм бэ гэж явсан учраас өнөөдөр ийм байдалд тулж байна. 8 жилийн хугацаанд хараа хяналтгүй явсан учраас өнөөдөр Дархан-Уул аймагт хоёр дахь 60 тэрбумын хэрэг мандаж байна. 60 тэрбум шүү.

Булавч бултайдаг учраас, даравч дардайдаг учраас удахгүй ил болох байх. Бүх юм. Тэгээд нэг их гашуудлын байдалтай. Гашуудаад яах вэ дээ. Ямар солигддоггүй засаг байгаа биш, шүүмжилдэггүй хурал байгаа биш. Тэгээд төр хямраад, тэнгэр нураад байгаа зүйл ч биш.

Энэ чинь одоо тэгээд ганц хүнээс болоод зогсдог амьдрал, ганц хүнээс болоод зогсдог бодлого биш шүү дээ. Улс ч биш.

Тэгээд бидний яриад байгаа энэ сонгодог парламентын мөн чанар нь олуулаа ярих, олон талаас нь шүүмжлэх, болохгүй бол солиход л байгаа шүү дээ. Нэг ёсондоо явдаг юм явдаг жамаараа л явж байна, зарчмаараа л явж байна. Энэ парламент гэсэн үг. Энэ бол асуудал биш.

Өнөөдрийн хуралд Ардчилсан нам бүгдээрээ эсрэг санал өгнө. Итгэл үзүүлэхийг дэмжихгүй. Харин маргаашаас Ардчилсан нам бурууд нь хатуу байна, зөвд нь зөөлөн байна. Зөв зарчмыг нь дэмжээд явна. Парламентын талд, үнэний талд зогсох болно гэдгийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл гишүүн үг хэлье.

О.Алтангэрэл: Шөнийн мэнд хүргэе.

Одоогоос яг 11 сарын өмнө 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр бид тангаргаа өргөөд тэгээд би Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж анхны чуулганаар асуулт асууж байсан юм.

Ер нь энэ хөрөнгө орлогоо нотолж тайлбарлаж чадахгүй байгаа хүмүүсийг яах юм бэ? Хууль бус хөрөнгийг хураадаг дэлхий нийтийн жишиг байна. Үүнийг ер нь хэрэгжүүлэх юм уу, үгүй юу гэж асууж байсан.

Ингээд 07 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газар байгуулагдаад ингээд сонгуулийн үеэр хууль бус хөрөнгийг хураах тухай хуулийн төсөл санаачилж боловсруулна гэж байсан энэ амлалтаа ажил хэрэг болгох боломж олдсон.

Ингээд энэ үзэл санаа хуулийн төсөл болсон. Засгийн газраар орсон. Манай Засгийн газрын нэр бүхий гишүүд эсэргүүцэж байсан. Тэгэхдээ Ерөнхий сайд өөрөө улс төрийн манлайлал гаргаад энэ хуулийн төслийг бид дэмжих ёстой гээд.

Ингээд 01 дүгээр сарын 24-ний өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд хүргүүлж байсан ийм түүх байна.

Дараа нь энэ оны 02 дугаар сард Ухаахудагтай холбоотой асуудал яригдаж эхэлсэн. Улсын Их Хурлаар стратегийн орд газарт хамааруулсан Тавантолгойн орд газрыг “Энержи ресурс” компанид эзэмшүүлсэн асуудал нь хууль ёсны байна уу, үгүй юу гэдэг энэ асуудал хөндөгдсөн. Ажлын хэсэг гарсан. Ерөнхий сайдын захирамжаар миний бие энэ ажлын хэсгийг ахалсан. Ингээд дүгнэлтээ гаргасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлаас 18 жилийн дараа өнгөрсөн 05 дугаар сард Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан.

Тэгэхээр юу гэж хэлэх гэж байгаа юм бэ гэхээр цаашдаа орлогоо нотолгоо гэж шаардаж байгаа иргэд маань өнөөдөр энэ талын хууль эрх зүйн орчныг сайжруулахгүйгээр энэ асуудалд ямар ч боломжгүй ээ гэдгийг ойлгоосой. Цаашид нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах нөхөн төлүүлэх тухай энэ хуулийн үзэл санаа дэмжигдээсэй гэж.

Өнөөдрийг хүртэл энэ Эрүүгийн хуулийн 22.10 буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдгээр ердөө 10 гаруйхан хүн шийтгэгдсэн байгаа гэдгийг ойлгоосой. Өнөөдөр ганцхан энэ Ерөнхий сайд болон Засгийн газартай холбоотой асуудал биш цаашдаа урт удаан хугацаанд үргэлжлэх үзэл санааны тэмцэл гэдгийг ойлгоосой гэж бодож байгаа юм.

Мөн стратегийн орд газрыг эзэмшигч, Монгол Улсын байгалийн баялгийг эзэмшигч аливаа нэг субъект нь, ямарваа нэг компани нь Монголын төрөөс том байх ёсгүй гэдгийг Монгол төрийн бодлого төр дээрээ гардаг, хэрэгждэг байгаасай гэдэг энэ сургамжийг аваасай гэж бодож байгаа юм.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулган дээр үг хэлж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн маань үг болгон протоколд үлдэж байгаа. Хожмын цагт юун дээр тэмцэл болсон юм, хаанаас энэ асуудал учигтай юм, бид нар яаж энэ асуудлаа шийдэх юм бэ гэдэг дээр шийдэл хэлж, үзэл бодлоо хэлж үлдээх нь хожмоо өнөөдөр болж өнгөрч байгаа үйл явдлын үнэн бодит байдлыг ойлгоход тус нэмэртэй гэж бодож энэ үгийг хэлж байгаа юм.

Цаашдаа, өнөөдөр бол Ардчилсан намын бүлэг улс төрийн шийдвэр гараад Ардчилсан намын сайдууд өөрсдөө өргөдлөө өгөөд улс төрийн шийдвэр гаргасан. Тэгэхдээ энэ хууль бус хөрөнгөтэй тэмцэх, Монголын ард түмэн байгалийн баялагтаа эзэн байх асуудал өнөөдрийн энэ Улсын Их Хурлын чуулганы танхимд сууж байгаа төрийн сүлдэндээ хандаж үнэнч ажиллахаа илэрхийлж тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн үүрэг шүү гэдгийг цохон тэмдэглэж хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнбуйангийн Амарсайхан гишүүн үг хэлье.

С.Амарсайхан: Өнөөдөр бид Монгол улсын тусгаар тогтнолын тулах цэг, түших багана болсон энэ парламентын үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа зарчмын төрийн бодлогын, мөн засаглалын, цаашлах юм бол бидний ярьдаг сонгодог парламентын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдөх вэ гэдэгтэй холбоотой асуудлууд яригдаж байна.

Ерөнхий сайдын өөрөө одоо бас бүрэн эрхийнхээ хүрээнд оруулж ирж итгэл хүлээлгэх эсэх тухай асуудлыг зарим талаар манай зарим хүмүүс бодлогын биш, энэ хэлэлцэх шаардлагагүй гэсэн асуудлууд яригдаж байгаа. Хэлж байна.

Тэгэхээр энэ бол бодлогын асуудал гэж харж байгаа. Тэр дундаа Засгийн газрын тэргүүн гүйцэтгэх засаглалын асуудлаа бас ил тод нээлттэй парламент дээрээ ярья, санал бодлоо солилцёе, асуудлуудаа илэн далангүй хэлэлцье гэж оруулж ирсэн бодлогын асуудал гэж. Цаашдаа ч ийм байх ёстой. Мэдээж өнгөрсөн хугацаанд алдаа оноо, шүүмжлэл маргаан дагуулсан үйл явдал олон байхыг үгүйсгэхгүй. Засах сайжруулах зүйлүүд зөндөө бий. Зарчим барих асуудлууд ч олон бий. Гэхдээ цар тахлын үеэс эхлээд эдийн засаг, эрүүл мэнд, мөн одоо бүүр цаашлах юм бол сэтгэл санааны давхар хавсарсан хямралтай үед энэ Засгийн газар үйл ажиллагаа явуулж, бас Шадар сайдын хувиар хамтарч бас тэр зовлон зүдгүүр дундуур нь эрсдэл хүндрэл дундуур нь туулж явсны хувьд зарчмаа ярих ёстой гэж бодож байгаа.

Тэгээд мэдээж цар тахлаас гадна эдийн засгийн асуудал гээд л ингээд үргэлжлээд бид нар шийдэж ирсэн олон зүйлүүд бий. Цаашдаа шийдэх ч асуудлууд бий.

Тэгээд би энэ хамтарсан Засгийн газрын асуудлыг бас нэг тодорхой товч ярих нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Манай Ардчилсан нам, ХҮН намынхан хувь хүний улс төр нэр хүнд гэхээсээ түрүүлээд нийтлэг эрх ашиг, нэгдмэл улс орны хөгжлийн асуудлыг хамтдаа шийдэж, нэг ч гэсэн асуудлуудыг ээдрээ, мөн хүндрэл бэрхшээлийг нь тайлж гаргая гэсэн зорилгоор хамтарсан Засгийн газар байгуулж ажилласан.

Хамтарсан гэхээсээ илүүтэй нэг улсын нэг төрийн нэг зорилготой ийм кабинет гэж ажиллаж ирсэн гэж үзэж байгаа. Тэгэхдээ Ардчилсан намыг энэ асуудал дээрээ нэгэнт ардчилалыг эрхэмлэдэг Ардчилсан намын үнэт зүйлийг, ардчиллын үнэт зүйлийг тээж явж байна гэж байгаа бол энэ хуралдаа суугаад орхиод хаяад гарна гэхээсээ илүүтэй хуралдаа оролцоод, саналаа өгөөд, тэгээд асуудлаа нээлттэй, ил тод ярилцаад, оролцоогоо хангаад, дээрээс нь өөрсдөө сонголтоо хийгээд зарчмаа бариад явах ёстой гэж ингэж дүгнэж байгаа.

Хамтарсан Засгийн газрын бүтэц Үндсэн хуульд нийцсэн парламентын бас тохирсон тогтолцоо гэж бид үзсэн. Тийм ч учраас энэ тогтолцооныхоо сонголтыг хийсэн гэж бодож байгаа.

Цаашаа асуудал яаж ч өрнөдөг бай хамтарсан байдлаар Засгийн газрын үйл ажиллагаа дараа дараагийн он жилүүд, сонгуулиуд, цаашлаад энэ парламентын үйл ажиллагаанд олон жишиг болсон ийм хамтарсан тогтолцоонууд бий болж үргэлжлэх байх гэж бодож байгаа. Мэдээж алдаа оноотой асуудлууд олон бий.

Тэгэхээр Ардчилсан нам маань намын гишүүд маань ухрах бус харин ч оролцоо, ил тод байдлаа хангаж оролцох нь зүйтэй гэдгийг би зориуд хэлье гэж бодож байгаа юм.

Тэгээд өнөөдрийн асуудал эцэст нь хэлэхэд өнөөдрийн хамгийн том аюул бол хэн нэгнийг чөлөөлөх, томилох, эсвэл үгүйсгэхээсээ илүүтэй бид нар энэ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Шөнийн мэнд хүргэе.

Юуны өмнө хамтарсан засагт орж ажилласан Ардчилсан нам, ХҮН намд талархаж байна. Тэр дундаа манай барилга, хот байгуулалтын салбарыг манлайлж хөгжлийг дэмжиж ажилласан Р.Эрдэнэбүрэн сайд, Ж.Батсуурь сайдад баярлалаа гэж хэлмээр байна.

Өнөөдөр энэ танхимаас ямар ч шийдвэр гарсан бай хоёр зүйлийг хэлэхийг хүсэж байна. Монголын залуучууд худалдагдаагүй. Төрийн өндөр албан тушаалтны хувьд, ёс зүйн хувьд ил тод байгаач ээ гэсэн. Өнөөдөр ч тэр байр суурин дээрээ байгаа.

Монголын шинэ үе өөрсдийн ирээдүй, мөрөөдлийг худалдахгүй. Бид эх орондоо сайхан амьдрахыг л хүсэж байгаа. Тэр шаардлагаа л тавьсан.

Чуулганыг одоо ч гэсэн үзээд сууж байгаа. Нийгмийн оролцоотой, идэвхтэй байгаа залуучууддаа баярлалаа гэж хэлмээр байна. Улсын Их Хурал ямар ч шийдвэр гаргасан бай ирээдүйд итгэх итгэлээ битгий алдаасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, хамтарсан Засгийн газар удаан хугацаанд гацсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эхлүүлснийг бид мартаж болохгүй. Өнөөдөр итгэл хүлээлгэсэн бай, үгүй бай төрийн бодлогыг тууштай үргэлжлүүлж, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбарын хөгжлийг тэргүүнд тавьж, цомхон, чадварлаг, үр дүнтэй ажиллахыг Засгийн газраас хүсэж байна.

Улсын эрх ашгийг иргэдийн сайн сайхныг нэгд тавьж, ёс зүйтэй, зарчимтай, гол нь нийгмийн мэдрэмжтэй, эвийг эрхэмлэж ажиллахыг энд сууж байгаа бүх гишүүдээсээ хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье.

Д.Ганмаа: Шөнийн мэнд хүргэе. Бүгдэд нь.

Ер нь сая яриад хэлэлцсэн асуудал дээр одоо энэ Монгол Ардын намын лидерүүд байсан хүмүүсээс санал зөрүүтэй хоёр, гурван байр суурь илэрхийлчхээд явчихлаа. Миний хувьд энэ нь их сэтгэл зовнихоос гадна яг аль нь үнэн яриад, хаана нь бодит байдал байгаа юм гэдэг дээр эргэлзээ үүсэж байна. Нийгэмд ч гэсэн энэ байдлыг төрүүлж байгаа байх.

Тэгээд нэгтгээд хэлэхэд сүүлийн 30 жилийн хугацаанд ер нь энэ амьдрал үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой бодит байдал, эрүүл мэндийн хувьд ч, боловсролын хувьд ч, нийгмийн асуудлын хувьд ч гэсэн тун тэгш бус байдал үнэхээр их байна.

Энэ тэгш бус байдлыг хаана сайн мэдрэгдэх вэ гэхээр сургууль дээр, эмнэлэг дээр, иргэдийн амьдрал дээр, орлого дээр маш тодорхой байгаа.

Энэ тэгш бус байдлыг алга болгож байж бид нарын нэлээн олон асуудал шийдэгдэнэ. Тэрийг яаж засаж залруулах ёстой вэ гэхээр тэр үнэн бодитой байдалтайгаа нүүр тулах шаардлагатай болно. Үнэн бодитой байдалтай нүүр тулахын тулд сүүлийн 30 жил өндөр алба хашиж байсан, өндөр төрийн албанд байсан хүмүүс бүгд орлого бол орлогоо батлах хэрэгтэй. Үнэн бодитой нөхцөл байдлыг ил, нээлттэйгээр гаргаж ирэх хэрэгтэй.

Ер нь энэ гадаа жагсаад байгаа ард түмэн, эдгээрийн шаардаж байгаа асуудал бол яг энэ тэгш бус байдалтай холбоотой байгаа. Тэгш бус байдлаасаа гадна сүүлийн 30 жил өндөр албан тушаалд ажиллачхаад тэр ажилласан хүмүүс нь хаана, юу хийгээд ямар байдлаар яваад байгаа юм. Ярьж байгаа юм нь хийж байгаа юмтайгаа огт таарахгүй, бодит нөхцөлтэйгөө үгүй байгаад л хамгийн дургүйцэж байгаа.

Энэ дээр Ерөнхий сайд өөрөө манлайлал үзээд жишээ болгоод харуулаад явуулаасай гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ шөнийн мэнд хүргэе.

Тэгээд өнөөдөр Монгол Улсын парламентын түүхэнд, засаглалын түүхэнд, Засгийн газрын түвшинд тийм сорилт, сургамж тохиолдсон өдөр болж байна.

Яагаад энэ нөхцөл байдал руу орсон бэ гэдэг дээр улс төрийн ууган хүчин Монгол Ардын намын эрхэм гишүүд, дунд шатны дарга нар маань бас дүгнэлт хийгээсэй гэж бодож байна.

Хамтарч засаглана гэдэг улс эх орныхоо төлөө өөрийн намын болоод өөрийн хувь улс төрчийн эрх ашгийг хойш нь тавьж улсын эрх ашгийг нэгд тавина гэдэг ойлголт гэж би үздэг.

Өнгөрсөн хугацаанд хамтарсан Засгийн газрыг бүрдүүлсэн Ардчилсан намын хувьд, намын даргын хувьд өөрийн нэр төр, бусад бүх юмаа хойш нь тавьж энэ улсын төлөө гэдэг дээр хамтарсан “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэдэг энэ уриан дор нэгдэж ажилласан.

Тэгээд харамсалтай нь олон жил дангаараа засагласан Монгол Ардын намын дунд шатны дарга нарт бас жоохон тухгүй санагдсан байх. Тэгээд хатуу үгийг бас бие биедээ хэлмээргүй байна. Яагаад гэхээр өнөөдөр бидний дундын гэж болох асуудал байгаа шүү гэдгийг бас Та бүхэн маань мэдэрсэн байх. Засгийн газар дангаараа шийдвэр гаргахад ямар их дарамт дунд байдаг вэ. Эдийн засаг, нийгмийн асуудлыг шийднэ гэхээсээ илүүтэй улс төрийн нөхцөл байдлыг шийдэхэд ямар их цаг хүч зардаг вэ гэдэг дээр ойлголттой болсон байх гэж тодорхой хэмжээнд мэдээлэл авсан байх гэж ойлгож байна.

Эцэст нь Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танд бас талархал илэрхийлэх нь зөв байх. Миний хувьд хувь хүний хувьд олон нэр хоч зүүж явдаг. Гэхдээ улс эх орны төлөө энэ шинэ Үндсэн хуулийн парламентын дагуу хамтарч нийлж явах нь улсын эрх ашиг юм гэдэг итгэл үнэмшил дээр өмнө би байсан, одоо ч байгаа, цаашдаа ч байна.

Тэгээд ер нь бол энэ танхимд сууж байгаа бусад бүх хүмүүстээ хандаж хэлэхэд бүгдээрээ олон жил улс төрд явна, гал авна, ачаа үүрнэ, хүч тэнцүүлнэ, өрсөлдөнө. Тэгэхдээ тэр болгонд нэгэн рүүгээ сүрэглэж дайрах, үр хүүхэд рүү нь орох, хөнжил гудсыг нь сөхөх энэ субъектив юм руу битгий ордог байгаасай гэж бас захимаар байна.

Асуудлын хүрээнд, сэдвийн хүрээнд, агуулгын хүрээнд мэтгэлцдэг үзэл санааны мэтгэлцээн өрнөдөг тийм байгаасай гэж бодож байна. Цаашдаа хариуцлагатай байх шаардлага нэлээн ирж байна. Тэгээд амжилт хүсье. Харамсалтай байна.

Д.Амарбаясгалан: Дуламын Бум-Очир гишүүн үг хэлье.

Д.Бум-Очир: Та бүхэнд шөнийн мэнд хүргэе.

Өнгөрсөн 35 жилийн туршид Монголын төр, засгийн хамгийн их алдсан зүйл бол миний ойлгож байгаагаар ард түмэн төрд итгэх итгэлээ алдсан гэж бодож байна. Төрийг харддаг болсон. Төр ч итгэлийг нь алдсан. Дарга нар маань итгэлийг нь алдсан.

Өнөөдрийн хориод хоног үргэлжилж байгаа энэ жагсаал бол энэ итгэл алдарснаас болж байгаа жагсаал гэж би ойлгож байгаа.

Өчигдрөөс хойш надад 200-гаад мессеж ирсэн байна. Дандаа итгэхгүй байна гэдэг л мессеж ирж байгаа. Хэрвээ итгэл үзүүлбэл Та бүхэнд итгэл алдарна шүү гэдэг ийм утгатай мессежнүүд ирж байна. Зөвхөн энэ ирсэн 200-гаад мессеж гэлтгүй 150 мянга орчим хүн гарын үсэг зурсан байгаа гэж байна. Тэр хүмүүсийн итгэл байгаа.

Тэгэхээр өнөөдөр бид нэг ийм итгэлийн сүлжээн дотор байгаад байна л даа. Жагсагчид Ерөнхий сайдад итгэх үү, үгүй юу гэдэг тухай асуудал. Итгэхгүй байна гэдгээ илэрхийлээд байгаа зүйл.

Тэд маань ард түмний томоохон төлөөлөл. Одоо яг Их Хурал дээр бидний хэлэлцэж байгаа асуудал мөн дахиад итгэлцлийн тухай асуудал. Их Хурлын гишүүд ард түмнийг төлөөлж сууж байгаа Их Хурлын гишүүд Ерөнхий сайдаа итгэл үзүүлэх үү, үгүй юу гэдэг тухай асуудал ярьж байна. Үүний үр дүн нь дахиад итгэлцлийн тухай асуудал.

Эндээс өнөөдрийн гаргах шийдвэрээс хамаарч ард түмний төрд итгэх итгэл чангарах уу, сулрах уу гэдэг зүйлийг дахиад ярих гээд байж байгаа ийм хариуцлагатай мөчүүд бид байж байгаа гэж бодож байна.

Бид ард түмнийг төлөөлж энэ танхимд сууж байгаа. Ард түмэн маань гэтэл нэлээд нь талбай дээр гарсан байж байна. Тэд ард түмэн мөн шүү дээ. Тэд юу хүсээд байгаа нь их тодорхой.

Анх нэг хүний асуудал юм шиг гарч ирээд, дараа нь нэг намын асуудал болоод, хоёр намын асуудал болоод, одоо тэгээд Их Хурлын асуудал болох гээд, бүр цаашлаад институт хоорондын асуудал юм шиг болох гээд ингэж дэвэрч явж байгаа нь тун харамсалтай зүйл юм.

Бид юуг бодох ёстой вэ гэвэл ард түмний төрд итгэх итгэлийг хэрхэн сулруулахгүй байх вэ гэдгийг бодох ёстой болов уу гэж би бодож байна. Яагаад гэвэл ард түмэн төрдөө итгэхээ боливол эх орондоо итгэхгүй, ирээдүйдээ итгэхгүй.

Бид магадгүй өнөөдөр яг эсрэгээрээ ард түмний төрд итгэх итгэлийг яаж хадгалж үлдэх вэ гэдэг асуудлыг илүү их анхааран ярих ёстой байсан болов уу гэж бодож байна. Энэ асуудлыг гишүүд маань ч гэсэн бүгдээрээ дор дороо тунгааж үзнэ биз.

Бид өнөөдөр тэр ард түмний итгэлийн тухай асуудлыг хэлэлцэж байна шүү гэдгийг би дахин Та бүхнийхээ анхааралд хүргэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Би гурван санаа л хэлэхийг хүсэж байна.

Ардчилсан ардын намын Бага хурал хуралдаад, тэр Бага хурал хуралдахаас өмнө Ардын намын бүлэг хуралдаад тэр дотор юу яригдаад байна гэдэг хов жив чих дэлсээд л байсан.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы танхимд Ерөнхий сайд үг хэлэхдээ тэр үгүүдийн зарим хэсгийг бас амнаасаа унагалаа.

Сонгуульд өрсөлдөх нам бэхжээд байна. Тэр намаас томилогдсон хүмүүс энд тэнд очоод ажилд ороод байна гэдэг үг надад их цочир бөгөөд үнэхээр эмгэнэлтэй санагдсан.

Энэ улс орон яаж хөгжих вэ, энэ иргэд яаж айдасгүй, чинээлэг, боломжийн амьдрах вэ гэж бодохоосоо илүү ямар нэгэн албан тушаалд орохдоо намаа бэхжүүлдэг, сонгуульдаа бэлддэг гэдэг энэ зүйлийг өнөөдөр батлаад сууж байна шүү дээ. Бид.

Хоёрт нь, дахиад тэнд ямар яриа гарсан бэ гэхээр хэнд, юунд хамаатай мэдээллийг тэд нар мэдчихлээ, мэдээлэл рүү нэвтрээд байна гэж. Ардчилсан намаас нуух ёстой мэдээлэл төрд байна гэдэг чинь тэнд хулгай байна л гэсэн үг шүү дээ. Тэнд луйвар байна гэсэн үг шүү дээ.

Дахиад гурав дахь үг нь хэний хүнийг халаад байна гэж. Сонгуулиар ажилласан хүмүүсээ төрийн өмчит компанид төрийн байгууллагад ажиллуулаад дараагийнхаа сонгуульд бэлддэг. Тэнд зориулж хулгай хийдэг. Үүнийг чинь л тогтолцооны авлига гэж хэлдэг шүү дээ.

Тогтолцооны авлигаар шийдэхийн тулд асуудлаа ч засъя гэхээсээ өмнө Ардчилсан намын эндээс хөөж гаргая гэдэг шийдвэр гаргаж байна гэдэг чинь энэ нам энэ авлигатай тэнцэхгүй гэсэн үг хэлж байна гэсэн үг шүү дээ. Хамгийн аюултай нь шүү.

Тэгээд ний нуугүй хэлэхэд Ардын намын Бага хурал дээр яригдсан ярианы дийлэнх нь маш богинохон тайлбарлагдаж байгаа шүү дээ. Зүгээр л хоёрдугаар ээлж хоолондоо орёе. Ардчилсан намыг хөөж гаргаад.

Яг энэ үг бол бид энэ улс оронд маш олон зүйлийг өөрчлөх ёстой юм байна гэдэг дохио. Асуудлыг шийдье биш. Зүгээр л эрх мэдэл дээрээ хэнийг байлгах, байлгахгүй гэдгийг нэг нам шийдэж байна гэдэг бол Улсын Их Хурлын толгой дээр Ардын намын Бага хурал гарсны хамгийн тод дүр зураг.

Хоёрт нь, нууц санал хураалт. Яасан айдастай байна аа. Улс төрчид өөрийнхөө гаргаж байгаа шийдвэр, саналыг нүүрээрээ гаргах ёстой. Түүнээсээ айж ичдэг байж болохгүй. Энэ бол ардчилсан нээлттэй улсад байдаг суурь зарчим. Үүнийг батлахын тулд нөгөө улсын парламентад бүр болохгүй бол та нар биеэрээ зөвшөөрсөн тэр хаалгаар, зөвшөөрөөгүй нь энэ хаалгаар гар гэж хэлдэг шүү дээ. Тэгж байж шийдвэрээ нотолдог, тэгж байж шийдвэрээ баталдаг.

Гэтэл ардчилсан Монгол Улсад нууцаар саналаа хурааа гэж хэлж байгаа байхгүй юу. Энэ чинь хуйвалдъя гэсэн үг шүү дээ.

Төгсгөлд нь, би яг 12 жилийн өмнө нэг үг хэлж байсан. Ерөнхийлөгчтэй намын зовлон гэж. Та бүхэн тэр зовлонгоо одоо туулж байна. Тэр үед бидийг

басамжилж хардаг байсан. Танай Ерөнхийлөгч нар та нарыг хуваагаад алж байна даа гэж. Энэ бол үнэхээр аюултай.

Парламентыг олонхгүй болгож засагладаг энэ нэг гаж тогтолцоо нэг засагдах ёстой шүү. Ардчилсан... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн үг хэлье.

Ж.Баясгалан: Бүгдэд нь шөнийн мэнд.

Түрүүн шүүмжлэх асуух асуултаа асуусан. Тэгээд одоо энд парламентаас гадна байхад хардаг байсан. Эд нар бусдынхаа эрх ашгийг боддог болов уу, ард түмнийхээ эрх ашгийг боддог болов уу, иргэдийнхээ эрх ашгийг боддог болов уу.

Тэгээд одоо яг тэр байран дээрээ бид нар өөрсдөө ирж байна. Тэгээд яг энэ бүх шийдвэрийн дараа хохирдог хүмүүс нь иргэд л байдаг. Шийдвэр гаргагчид биш иргэд байдаг.

Тэгэхээр иргэдээ бодож шийдвэрээ гаргаарай. Одоо намаа бодож нэг нэгнийгээ бодож, эсвэл улс төрөө бодож ерөөсөө энэ шийдвэрийг гаргаж болохгүй. Энэ дээр иргэдийнхээ талд зогсох хэрэгтэй.

Түрүүн О.Саранчулуун хэлж байсан үнэхээр яг жирийн иргэд дуу хоолойгоо гудамжинд гараад талбай дээр илэрхийлээд, тэгээд түүнийхээ хариуд үр дүндээ хүрч чадахгүй байхад Монгол Улсын 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу нийт өрхийн 13 хувь нь үүнийгээ илэрхийлэх бүр ямар ч боломжгүй.

Тэгэхээр хүн төвтэй парламент шүү дээ. Бид чинь. Хүний эрхийг дээдэлсэн. Тийм болохоор энэ дээр энэ засаг үргэлжилдэг ч бай, дараагийн засаг гарч ирдэг ч бай хүнээ гэсэн энэ бодлогоо үргэлжлүүлж л яваарай. Төрийн залгамж халаа гэж байх ёстой. Энэ бол хувь хүний биш төрийн залгамж халаа үргэлжлэх ёстой шүү.

Тэгээд бүгдээрээ энэ дээр одоо ёстой намаа бодож биш, хувийн эрх ашгаа бодож биш, ерөөсөө улсын эрх ашгаа нэгдүгээрт тавиад бүгдээрээ шийдвэрээ гаргаасай. Хожих нь та нар байж болно. Харин хожигдох нь ард түмэн шүү. Тийм болохоор ард түмнээ сайн бодоорой л гэж хэлмээр байна.

Түрүүнээс хойш шууд маш их чагнаж суулаа. Өөрөө ч ярилаа. Ерөөсөө яг энэ доторх л юмаа ярьж байна шүү дээ. Намынхаа л асуудлыг ярилаа. Бид манай нам, танай нам л гэж ярилаа. Манай засаг, танай засаг, манай сайд, танай сайд л гэж ярилаа. Эндээс ард түмэнд юу очсон тухай нь ярихгүй байна шүү дээ.

Тэгэхээр шийдвэр гаргахдаа яг түүн дээрээ шийдвэрээ гаргаарай. Засаг хэрвээ үргэлжилдэг ч бай, дараагийн засаг гардаг ч бай төрийн залгамж халаа гэдгийг ерөөсөө үргэлжлүүлж явна шүү. Түүнээс биш дараагийнхаа хоолонд орж байгаа, дараагийнхаа ээлжид орж байгаа гэдгээрээ битгий хандаарай.

Хүний эрхийн төлөө яг үргэлж ингээд асуугаад, шаардаад явах болно.

Д.Амарбаясгалан: Жамбын Батсуурь гишүүн үг хэлье.

Ж.Батсуурь: Бүгдэд нь шөнийн мэнд.

Юуны өмнө биднийг урьж нэг танхимд ажиллах боломж олгосон Ерөнхий сайд танд бас талархаж байна.

Бид, тэр тусмаа миний хувьд хэлсэндээ хүрч эхэлсэн ажлаа дуусгахын төлөө тууштай явж ирсэн ийм зарчимтай. Эхэлсэн бол дуусгадаг, хэлсэн бол хийдэг ийм л байх ёстой. Ийм ч зарчмаар манай 8 сайд урилгыг хүлээж аваад өдөр хоногийг үл тооцон, амралтын өдөргүйгээр бас ажиллахыг хичээж ингэж ажиллалаа.

Харамсалтай нь Ардын намын Бага хурал хуралдахын өмнөх орой бид нарын хүсэл эрмэлзлэл, итгэл найдвар, хүсэл тэмүүлэл оргилж байсан. Өглөө нь босоод мэдээ хараад бүх бие хоосорсон. Энэ ямар учир байдаг юм болоо. Яагаад ингэж хүмүүсийн ажил хийх, энэ бэрхшээлийг даван туулах хүсэл мөрөөдлийг тэнд бусдаас асуухгүйгээр, хамтарсан хүмүүстэйгээ ярилцахгүйгээр, мэнд ус мэдэхгүйгээр хүний өмнөөс шийд гаргадаг юм л гэж.

Аливаа гэрээ чинь зүгээр СӨХ-ны гэрээнээс авхуулаад, хүүхдийн сургалтын гэрээнээс авхуулаад хамгийн жижиг гэрээ ч гэсэн нөгөө талтайгаа ярьдаг, хэлдэг. Та ийм юмаа зөрчсөн байна. Сануулдаг барьдаг юм байдаггүй.

Сайн, сайн гээд малгай өмсүүлж байгаад тэгээд буруу буруу, бусдын буруу. Бүгд Ардчилсан намын буруу. Ямар гэрээг зөрчсөн юм. Хэддүгээр заалтыг зөрчсөн юм. Яаж зөрчсөн юм. Өмнө нь сануулсан юм уу, сануулаагүй юм уу.

Зүгээр ингээд одоо 30-аад оны хэлмэгдэл гэдэг шиг тулгаад буудаж байна л даа. Энэ асуудал нь үнэндээ таалагдахгүй байна.

Дээр нь зүгээр ингээд энэ шийдвэрээ гаргаад орхихгүй дэвслээд байхыг хүлцэн тэвчихгүй. Б.Бат-Эрдэнэ гишүүн тэргүүтэй хүмүүс Ардчилсан намыг гонгинож байна гэж. Гонгиносон нэг бичлэг гаргаад ир дээ. Бид нараас “а” ч дуу гараагүй шүү дээ. Бид нараас асуугаагүй юм чинь бид юу дуугарах юм. Асуугаагүй юм чинь юу хариулах юм. Хэлээгүй юм чинь бид юу мэдрэх юм.

Хамтаръя гэсэн хамтарсан, зүтгээ гэсэн зүтгэсэн. Тэгээд өглөө нь босоод ирэхэд нь байхгүй. Тэгээд байхгүй л бол байхгүй шүү дээ.

Тэгээд үүнээс хойш баалаад улс төр хийх гээд байх юм бол үзнэ шүү. Ер нь хүнээс айгаад байдаг нас ч байхгүй. Нас ч биш.

Өнөөдөр ер нь юу гэнэ вэ, Ардчилсан намын л хэдэн сайд нар. Ерөнхийдөө магтаад. Тэгсэн мөртлөө л ер нь Ардчилсан намын сайд нар л ер нь энэ манай Бага хурлын шийдвэрийг гаргачихлаа гэсэн аятай юм яриад байгаа юм. Олон хүн хэлж байна.

Би яг өнөөдөр жишээлэх юм бол Х.Тэмүүжин гишүүн бид бараг энэ 10 цаг сууж байна. Яагаад вэ гэхээр би ер нь хэн ямар масктай байдаг юм болоо, хэн юу хэлдэг юм болоо гэдгийг харах гэж, ингэж мэдрэх гэж суусан юм.

Ингэж болохгүй. 1992 оноос хойш 9 сонгууль боллоо. Миний хувь хүнийхээ хувьд 8 сонгуульд амжилт гаргаж, энэ өнгөрсөн бүх түүхийг нүдээрээ үзэж, гараараа туулж ингэж явсан.

Гэтэл өнөөдөр өөрсдийнхөө хийсэн, өөрсдийнхөө гаргасан балгийг бид нарт огт мэдүүлэхгүйгээр шийдчихээд ингээд буруу, буруу, бусдын буруу гэх юм бол гомдолтой байна. Ийм байж болохгүй ээ. Ийм цаг үеийг бид нар эхлүүлж болохгүй, дуусгаж ч болохгүй.

Д.Амарбаясгалан: Ринчиндоржийн Батболд гишүүн үг хэлье.

Р.Батболд: Одоо шөнийн мэнд хүргэе ээ гишүүддээ.

Түрүүн би дутуу хэлсэн байж магадгүй. Энэ Засгийн газар ажилласан уу гэвэл ажилласан. Сайн ажилласан. Энэ мега төслүүд хөдөлсөн үү гэвэл хөдөлсөн.

Тэгэхдээ энэ дундаа бас дэмжихээр төслүүд ч бий, бүр дэмжихгүй байхаар ч төслүүд бий. Энэ бүхэлдээ орж ирсэн болохоор бүгдээрээ дэмжигдээд л явсан ийм асуудал байгаа.

Тэгээд өнөөдөр яах вэ, Ерөнхий сайдад итгэл үзүүлэх үү, үзүүлэхгүй юу гэдэг дээр л явж байна.

Ер нь итгэл үзүүлэхгүй гэхэд цааш нь ер нь засаг аваад явах хүн Монгол Ардын намд ч тэр, Ардын намд ч тэр, ер нь энэ парламентад байгаа үлдсэн Үндэсний эвсэлд ч тэр, Иргэний Зориг намд ч тэр, энэ ХҮН намд ч байгаа гэж би итгэдэг.

Ер нь тэгээд итгэл үзүүлбэл та Засгийн газраа цааш нь тэгээд тэргүүлээд л аваад явна биз. Энэ бол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуудал болж байгаа.

Тэгээд ер нь хэлэхэд бол ер нь Монгол Ардын намын юм уу, Ардын намын Монгол Улс гэж байхгүй. Энд миний хүүхдүүд, тэдний үр хүүхдүүд, энд сууж байгаа зарим гишүүдийн хүүхдүүд амьдрахгүй байж магадгүй. Тэгэхдээ энэ гадаа жагсаж байгаа залуучууд тэгээд тэд нарын үр хүүхдүүдийн амьдрах газар.

Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтөөр байгуулагдсан шинэ парламентын 126 гишүүн бол ер нь нэг иймэрхүү сэтгэлтэй гишүүд сонгогдсон гэж би итгэж байгаа. Тэгээд цаашид ер нь Засгийн газартаа хяналт тавиад ямар ч Засгийн газар байсан ингээд ажиллаад явж чадах байх л гэдэг итгэлтэй байгаа шүү гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Би хэдэн нэр бас хэлмээр байгаа юм.

Энэ сүүлийн ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойших цаг хугацаан дотор юу болоод өнгөрөв өө гээд. Бид эргэж бас юмаа харж байх ёстой.

Ерөнхийлөгч П.Очирбат ажиллаж байхад. Ганц нэг нэр алдвал бас та бүхэн минь ойлгож үзээрэй. Ерөнхийлөгч П.Очирбат гуай ажиллаж байх үед П.Жасрай, М.Энхсайхан гээд Ерөнхий сайд нар байсан.

Н.Багабанди гуайг ажиллахад М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт, Р.Амаржаргал, Н.Энхбаяр гэсэн Ерөнхий сайд нар байсан. Олон нэр дурдагдаж байна гэдэг бол олон Засгийн газар огцорсон гэсэн үг.

Н.Энхбаяр Ерөнхийлөгч байхад Ц.Элбэгдорж, М.Энхболд, С.Баяр гээд Ерөнхий сайд нар байсан.

Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч ажиллаж байхад С.Баяр, Сү.Батболд, Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэг, Ж.Эрдэнэбат гээд байж байна.

Х.Баттулга Ерөнхийлөгч ажиллаж байхад Ж.Эрдэнэбат, У.Хүрэлсүх, Л.Оюун-Эрдэнэ гээд.

У.Хүрэлсүхийн Ерөнхийлөгч ажиллаж байхад өнөөдөр Л.Оюун-Эрдэнэ гээд ингээд байж байна.

Энэ өөрөө өнгөрсөн цаг хугацааг юу хэлж байна вэ гэхээр энэ үе үеийн Ерөнхийлөгч нар эрх барьж байгаа юм уу, хамгийн том сөрөг хүчин бүрдүүлж байгаа намуудаас гарах нь эргээд энэ парламентыг, улс төрийн намын төлөвшлийг хамгийн их эвддэг зүйл юм байна.

Ойлголцол байхгүй байгаа нь илт харагдаж байна. Хэн хэнийх нь үгэнд гарч ирж байна. Энэ маань өөрөө юуг илэрхийлж байна вэ гэдгийг бид бас бодох ёстой.

Саарын хажуугаар сайн гэгчээр бас сайн зүйлүүд байна. Ардын намын цагаан байшинд гарсан шийдвэр парламентаас томилогдсон Засгийн газрыг огцруулах, хөдөлгөх, өөрчлөх шийдвэр л болж хувирдаг байсан.

Энэ удаа Ардын намын цагаан байрнаас гарсан шийдвэр парламентын босгыг давж орж ирсэнгүй. Намын шийдвэрийг хэрэгжүүлэх ёстой, хэрэгжүүлэх ёсгүй гэдэг хоёр өөр өнцөг ярьж байгаа.

Урьд урьдын Засгийн газрууд огцорч байх үед Ардын намын шийдвэрээр засаг огцроход тэр болгонд нам төрийн дээр гарлаа гэдэг шүүмжлэлийг маш олон хүмүүс хэлж байсан. Одоо тэрийгээ мартсан байх.

С.Баяр Ерөнхий сайдыг томилогдох үед хоёрхон хүн эсрэг санал өгсөн байдаг. Эсрэг санал өгсөн хоёр хүний нэг нь би. Түүний хариу нь 07 сарын 01 болж хувирч байсан.

Засаглалын хямрал ингэж үүсдэг. Улс төрөөсөө болж үүсдэг. Ерөнхийлөгчийн хориг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шийдвэр, Ардын намын байран дахь хурлын шийдвэр энэ 30 жилийн засаглалын хямрал бол эндээс л үүсэлтэй байсан. Үе үеийн цаг үедээ тийм л байсан. Энэ бас өнөөдөр энд тодорхой хэмжээгээр дүгнэгдэж яригдах ёстой байх, ойлгох, ёстой байх гэж гишүүддээ найдаж байгаа юм.

Үндсэн хуулийн олон заалт ер нь цааш цаашдаа амилах юм байна. Энэ Үндсэн хуульд байгаа маш олон заалтыг Улсын Их Хуралд хэрэглэж үзээгүй тийм заалтууд байж байгаа. Энэ 126 гишүүнтэй парламент ард түмний төлөөллийг, иргэдийн санаа бодлыг олон талаас нь оруулж ирж чадах тийм зүйл болно гэдэгт итгэлтэй байна.

Ер нь их л өвдөнө дөө гэж энэ засаг байгуулагдахад... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 5 гишүүний дараа санал хураалт эхэлнэ. Гишүүдийг танхимдаа дуудъя.

Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Мэдээж хэрэг бид төр засаг тасралтгүй ажиллах ёстой. Шөнө орой болтол ингээд хуралдаж л байна. Мэдээж хэрэг хуралдах ёстой гэж бодож байна.

Ингээд юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч сая орж ирээд үг хэллээ.

Миний та нарт 5 жил хэлдэг байсан үгийг л хэлж байна шүү дээ. Одоо эцсийн эцэст би хэллээ, Ерөнхийлөгч хэллээ. Ойлгох юм уу, ойлгохгүй юм уу. Одоо ойлгохгүй гээд яах вэ дээ. Аан. Баярлалаа. Тийм.

Тэгээд орлогоо нотол оо л гэсэн. Л.Оюун-Эрдэнэ сайд аа.

Тэгээд ард түмэн гадаа 20 хоног жагслаа. Хэрэв намайг орлогоо нотол оо гэсэн бол би 2 цагийн дотор л нотолно л доо. Тэгэхгүй бол би шоронд орно. Тэрийгээ ч би мэдэж байна. Жирийн иргэн бас тэгнэ.

Тэр хэмжээнд л бид нар байх ёстой шүү дээ. Хууль дээдэлж л ажиллах ёстой.

Би танд хэлж байсан. Та их вакуумжиж ээ. Эцсийн эцэст ийм байдал таныг ийм байдалд хүргэж байгаа. Би танд хэлж байсан. Эхлээд та ажил аа. Та 68 суудалтай. Сонгууль явсан. Ард түмний санал бол хаан санал. Тэр дагуу л та ажиллах ёстой. Нэгээр илүү бол мянгаар илүү. 64 суудалтай боллоо л бол та засаг барих ёстой байсан.

Тэр үед бүх юм сайхан байсан. Нүүрсний үнэ ч өндөр байлаа. Ямар л бол ямар үлгэр ярьж болохоор байлаа. Түүнд бүгд итгэдэг байлаа. Тэгэхэд би хэлж л байлаа.

Унаж болно оо. Тэгэхэд хэцүүднэ шүү гэж байсан. Миний үгийг аваагүй. Авчихгүй. Тэгээд 68-тай байсан энэ намтайгаа тэгээд зүтгээд үзэх байсан юм.

Тэгээд болохгүй болонгуут нь, хүндрэнгүүт нь арай өөр оролдоод үзэх байсан. Тэгээд алсын хараа дутлаа даа. 10-хан сар дотор дутаж байгаа юм чинь одоо тэгээд л 20, 50 жилийг харна ч гэж юу байх вэ. Нэг ийм юм байна.

Нөгөө талаар Ардчилсан намын сайд нар өргөдлөө өгсөн. Бид албадан хөдөлмөр хийлгэж болохгүй ээ. Ийм хуультай. Энэ 8 сайд маань ахиад хамтарч болохгүй ээ. Хамтарсан засагт орж болохгүй. Яах вэ, ерөнхийдөө хуулиар Ерөнхий сайд өөрийнхөө Засгийн газар хэнийг яах вэ, байгуулах вэ гээд тийм эрхийг нь олгосон байгаа.

Дараагийн Ерөнхий сайд гарч ирээд ажиллах байх. Тэр нь чөлөөтэй.

Өнөөдөр нөхцөл байдал гадаа залуучууд маань жагссан байна. 20 хоног жагслаа. Та хэзээ ч хариуцлага тооцохооргүй тийм Засгийн газрыг байгуулсан байсан л даа.

Нэг юмыг тооцсонгүй. Энэ залуучуудыг. Эрх чөлөөнд дуртай. Үнэхээр тэр орлогоо нотол гэж хэлж чаддаг ийм залуу үе бий болсон байна. Сүүлийн 30 жилд. Энэ залуучууддаа би баярлаж байгаа.

Тэр тусмаа тэр залуучууд дээр очсон Д.Энхтүвшин гишүүндээ, өнөөдөр одоо манай С.Цэнгүүн гишүүндээ, Ч.Лодойсамбуу гишүүндээ, Ш.Бямбасүрэн гишүүндээ, Ж.Баярмаа гишүүндээ, бас өөртөө талархал илэрхийлмээр байгаа юм. Энэ дээр л ардчилал оршиж байгаа байхгүй юу.

Яагаад инээгээд байгаа юм бэ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье.

Ц.Туваан: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгээд өнөөдөр Ардчилсан намын гишүүд бид бүхнийг танхимдаа урьж ажиллуулж сайхан хамтарч ажилласан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танд баярлалаа.

Мөн энд хамтарч ажилласан төрийн гурван өндөрлөгтөө, бидний оруулж ирсэн санал санаачилга, хууль, ажлуудыг дэмжиж, орж кнопдож, дэмжиж урам өгч ажиллуулж байсан Улсын Их Хурлын гишүүддээ, ангийнхандаа бас баярлалаа гэдэг үгээ хэлэх нь зөв байх.

Дэлхий дахинд байдал амаргүй байна. Хүнд байна. Геополитикийн, худалдааны дайнтай байна. Ер нь л чанга байна. Тэгээд энэ үед дотоод нөхцөл байдал ч гэсэн амаргүй л байна. Иргэдийн худалдан авах чадвар муу байна. Улсын орлого чанга л байна.

Тэгэхээр бид хэд энэ нөхцөл байдлыг тооцоод эв нэгдэлтэй л баймаар байгаа юм. Тогтвортой л баймаар байгаа юм. Яг өдийд бол уг нь цаг нь биш л санагдаж байгаа юм гэдгийг бас хэлчихье. Манай гишүүд бас бүгдээрээ үгэндээ хэлж байна.

Төрийн ажил амаргүй. Төрийн ажил бол сэтгэл гаргаж хийдэг, хичээл зүтгэл гаргаж хийдэг, үнэнхүү зүтгэж хийдэг ажил. Тэгээд бид хэд ч яах вэ бас ингээд сэтгэлээ гаргаад чадлаараа л ажиллалаа. Бас дэмжиж үг хэлж, хамтарч шийдвэр гаргалцаж явсан Та бүхэндээ бас баярлалаа.

Би бол үгэндээ суухыг эрхэмлэдэг. Үгэндээ суудаг ийм хүн. Өмнө нь Улсын Их Хурлын Үндсэн хуулийн асуудал орж ирээд, дээрээс нь Сонгуулийн хууль орж ирээд энэ асуудлууд яригдаж байхад тогтвортой байдлын төлөө, хамтралын төлөө ажиллаж ирсэн. Саналаа ч гэсэн үүний төлөө өгч ирсэн. Үүний төлөө ч гэсэн зүтгэж ирсэн. Цаашдаа ч мөн зүтгэнэ. Ямар байдлаар нь яах вэ тэгээд ямар ч байсан зүтгэнэ.

Тэгэхээр энд байгаа хүмүүс ч гэсэн бүгдээрээ ер нь энэ хэцүү нөхцөл байдал байгаа үед улс орныхоо эрх ашгийг бодож шийдвэрээ зөв гаргаж цаашдаа ажиллах байх гэж бодож байгаа юм.

Ардчилсан намын сайд нар салбар салбарт ороод ажилласан. Тэгээд чадлаараа л ажилласан. Дүнг нь 2028 онд дараагийн сонгуулиар ард иргэд тавих байх.

Тэгээд ер нь Ардчилсан намын чинь нэг муу нэр зүүлгээд л, арын хар овоохой болгоод л байдаг. Тэрэнд би бас дургүй. Хүлээн зөвшөөрдөггүй. Ардчилсан нам дотор чинь ч гэсэн бас хамтраад ажиллаж чаддаг, ажил хийж чаддаг, зүтгэж чаддаг улсууд байдаг юм шүү. Ганцхан Монгол Ардын намд ийм улсууд байдаггүй.

Тэгэхээр энэ нэгдсэн нэг Монгол Улс.

Тийм учраас Ардчилсан нам ч тэр, ХҮН нам ч тэр, Иргэний Зориг-Ногоон нам ч тэр, Үндэсний эвсэл ч тэр ийм ажиллаж чадах хүмүүс байгаа. Байдаг гэдгийг харуулахын төлөө ажилласан гэдгийг хэлье.

Тэгээд эцэст нь “Үнээгээ үхэхээр сүйтэйг нь мэддэг” гэж Монголын үг байдаг. Заавал бид хэдийг хэлж байгаа биш. Бид хэд бас өргөдлөө өгсөн байгаа. Тэгээд хамтраад ажиллах, хамтраад зүтгэх шаардлага гарвал нөгөө муу Ардчилсан намын 42 чинь бас байж байгаа шүү. Бас ажиллаж чадах тийм улсууд байгаа шүү гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлье.

С.Одонтуяа: Та бүхэндээ үдшийн мэнд хүргэе.

Тэгээд өнөөдрийн чуулган дээр олон хүн Ардчилсан намын сайд нарыг сайн ажилласан гэдгийг хэлэхэд, үүнийг сонсоход таатай байна.

Ерөнхий сайд ч гэсэн хэллээ. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ талаар одоо бүгдээрээ санал нэгтэй хэлсэнд баяртай байна. Өнгөрсөн 10 сарын хугацаанд бид үнэхээр байдгаараа л хичээж ажилласан.

Тэгээд яамны ажлаас гадна одоо намайг Агаарын бохирдлын үндэсний хороог ахалж ажилла гэхэд “за” л гэлээ. Өдөр шөнөгүй 5 сар ажиллаад үр дүнтэй л болж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилтийг тэмцэх хурлын Үндэсний хороог ахал гэсэн. Би “за” л гэдэг.

Ер нь манай Ардчилсан намын сайд нар ажил хийх гэж л орсон. Бид нэг реформ хийе гэж ордог. Энд бүх хийсэн ажлаа яриад байвал одоо дуусахгүй.

Тэгэхээр би нэг хэдхэн зүйлийг онцолж хэлье гэж хүсэж байна.

Нэгдүгээрт, Эгийн голын асуудал байгаа. 2024 оны 8 дугаар сарын 14-нд Ерөнхий сайд болон манай Л.Гантөмөр сайд намайг дуудаад Эгийн голын усан цахилгаан станцын төслийг гацаанаас гаргах үүрэг даалгаврыг надад оногдуулсан. Өгсөн. Та одоо өнгөрсөн 4 жил Монгол, Оросын парламентын бүлгийн даргаар ажиллаж байсан хүний хувьд энэ ажлыг та хариуцаад хий гэсэн ийм үүрэг өгсөн.

Үүрэг өгөгдсөнөөс хойш 20 хоногийн дараа Оросын Холбооны Улсын Байгаль, экологийн сайдтай санамж бичигт гарын үсэг зурсан. Өмнө нь Оросын Холбооны Улс ЮНЕСКО-гийн Дэлхийн өвтэй бас жоохон хэл амаа ололцдоггүй ийм асуудлууд байсан юм билээ.

Санамж бичиг зурснаас хойш ердөө нэг сарын дараа Эгийн голын усан цахилгаан станц байгуулах Шинжлэх ухааны академийн хамтарсан ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөг баталсан байдаг. Үүнээс 5 сарын дараа Эгийн голын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, ТЭЗҮ-ийн ажлыг эхлүүлсэн.

Нэг ёсондоо надад Монгол Улсын Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврыг 8 сарын дотор бид энэ бүгдийг хамтарсан Засаг хийж чадсан. Тэгээд энэ төлөвлөгөөний дагуу бид 2026 оны хоёрдугаар улирал дуусах ёстой.

Тэгэхээр дараагийн Засгийн газар, сайд нар энэ ажлыг үргэлжлүүлж хариуцлагатай хийх нь улс орны эрх ашиг чухал юм гэж үзэж байна.

Тэгэхээр 60 жил гацсан төслийг бид 8 сард хийж чадсан шүү гэдгийг би бас нэг нүүр бардам хэлчихье гэж бодож байна. Энэ бол бас амаргүй байсан ажил.

Мөн Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, гадаадын төсөл, хөтөлбөрийг Монгол Улсад татах асуудлаар нийт 300 гаруй уулзалт хийсэн байдаг юм.

Тэгээд 40 гаруй сая долларын гэрээ хэлцэл хийсэн. Монгол Улсад карбоны зах зээлийг хөгжүүлэх талаар 2 тэрбум төгрөг, байгаль орчны албан хаагчдыг чадавхжуулах талаар 10 гаруй тэрбум төгрөгийн төслийг Уур амьсгалын ногоон сангаас авахаар болоод төслүүд амжилттай явж байгаа.

Тэгээд би эрхэм гишүүддээ нэг зүйлийг хэлмээр байна. Ер нь Байгаль орчны яам бол үндсэн чиг үүргийн яам байх ёстой юм билээ шүү. Өмнө нь үндсэн чиг үүргийн яам байсан. С.Оюун сайдын үед. Энэ бол өөрөө маш чухал ажил. Одоо ерөөсөө уур амьсгалын өөрчлөлтийн өмнө дэлхий даяараа сөхөрч байна шүү дээ. Энэ дулаарал, энэ хуурайшилт. Сая хуурайшилтаас болоод ойн

түймэр гарсан. Богд уулын талбайгаас хоёр дахин том талбайг бид ойн түймэрт алдчихлаа.

Тэгэхээр энэ уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны салбарт бид онцгой анхаарах ёстой.

Өнгөрсөн 10 сарын хугацаанд 12 хуулийн төслийг бэлдээд Улсын Их Хуралд оруулахаар бэлдсэн байсан. Үүнийг Улсын Их Хурлын гишүүд дараа нь... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүрэнжавын Лүндэг гишүүн алга байна.

Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Өнөөдөр Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороон дээр, чуулган дээр олон талаас нь хэдүүлээ ярилцлаа.

Миний хувьд ч гэсэн бас ийм нээлттэй ярилцлага болж, энэ Монголын төрт ёсны түүхэнд үлдээсэй л гэж бодсон.

Та бүхэн ч тэр, олон нийт ч тэр олон асуудлыг өөр өөрийнхөөрөө л дүгнэж байгаа байх. Дүгнэж байгаа байх. Хамтарсан Засгийн газар цаашдаа олон удаа байгуулагдана гэдэгт би итгэлтэй байгаа. Яагаад гэвэл бид нар 126-тай, холимог тогтолцоотой, парламентын сонгуулийн тогтолцоог сонгож авсан нь өөрөө суурь асуудал.

Тийм учраас өнөөдөр бид нар бас л нэг сургамж, дүгнэлтийг хийж байна. Хамтдаа.

Тийм учраас өнөөдөр цаг зав гаргаж, үзэл бодлоо илэрхийлсэн эрхэм парламентын гишүүд Та бүхэндээ чин сэтгэлээсээ бас талархаж байгаагаа илэрхийлье.

Хамтарсан Засгийн газар бол миний хувьд улс орны хөгжлийг урагшлуулах хамгийн чухал шийдэл гэж үздэг. Энэ үзэл бодол өөрийнхөө идеологи дээр би үнэнч үлдэхийг, бас олон талаас нь асуудлыг тайлбарлаж, нээлттэй асуулт, санал, ийм парламентын мэтгэлцээн байгаасай гэж үзсэн.

Хоёрдугаарт, өнөөдөр бид сонгодог парламентын засаглал, сонгодог парламентын засаглалыг хэрхэн төгөлдөржүүлэх вэ гэдэг талаар тойрч ярилаа.

Би дээр дурдсан. 1991 оны 11 дүгээр сарын 30-нд Монгол Улсын засаглалын хэлбэрийг хэлэлцэх санал хураалтаар Ардын Их Хурлын депутатуудын 186 нь Ерөнхийлөгчийн засаглалыг, 186 нь парламентын засаглалыг дэмжиж, 48, 48 хувиар санал тэнцэж байсан.

Энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат гуай орж Ардын Их Хурал дээр байр сууриа илэрхийлж, парламентын засаглалыг сонгож авч байсан ийм түүхтэй.

Тэр цагаас хойш, 1992 оноос хойш олон зүйл болж өнгөрчээ. Сая Б.Батбаатар дарга бас яг энэ түүхийг ярилаа.

Тийм учраас өнөөдрийн итгэл үзүүлэх асуулга, энэ агуулга дээр сонгодог парламентын засаглалыг төгөлдөржүүлэхэд дэмжлэг хэрэгтэй байна гэсэн. Цаашдаа бид энэ хагас Ерөнхийлөгч, хагас парламентын засаглалыг цэгцэлж байж Монгол Улс илүү гүйцэтгэх засаглал нь тодорхой, гүйцэтгэх засаглал тогтвортой, хөгжлийн төслүүд илүү ойлгомжтой болно.

Олон улсын гадаад харилцаан дээр ч тэр, мөн дотоодод ч гэсэн парламентын хяналт тэнцэл болон бусад асуудал ч гэсэн үүн дээр гол зангилаа байгаа шүү гэдгийг би бас Та бүхэндээ Ерөнхий сайдын хувьд хэлэх нь зүйтэй.

Үүнийг Ерөнхий сайд бүхэн л мэддэг. Суугаад ярихаар бүгдээрээ ярьдаг мөртлөө нээлттэй ярьж чаддаггүй ийм сэдэв.

Тийм учраас энэ өнөөдөр олон талаас нь хөндөгдөж, Ерөнхийлөгч ч бас өөрийнхөө байр суурийг илэрхийлсэн нь өнөөдрийн итгэл үзүүлэх энэхүү парламентын хэлэлцүүлгийн чухал үр дүнтэй бас ийм одоо түүхэн протокол болж үлдэнэ ээ гэдэгт бол итгэлтэй байна.

Цаашдаа 2027 оны Ерөнхийлөгчийн сонгууль. Улс төрийн намууд бүгдээрээ өрсөлдөж оролцоно. Энэ асуудал дээр Монгол Улсын Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалын дунд байгаа энэхүү хяналт тэнцэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль хяналтын байгууллагуудын чиг үүрэг, шүүх болон прокурорын асуудал гээд олон асуудлыг улс төрийн намууд нээлттэй сонгуулийн үндсэн мэтгэлцээний сэдэв болгож ярилцах нь зүйтэй юм. Цаг нь болсон гэж бодож байгаа.

Тийм учраас үүнийг өнөөдөр олон талаас нь ярилцаж сонгодог парламентын засаглалыг илүү төгөлдөржүүлэх тал дээр парламентын гишүүд маань бүгд үгээ хэлж, бас өөр өөрийн байр суурийг илэрхийлсэнд талархалтай байна. Талархалтай байна.

Цаашлаад орлогоо нотлох, хууль бус хөрөнгө, авлигалтай холбоотой асуудал дээр хамтдаа манлайлж ажиллая.

Миний хувьд бас олон нийтэд эргэлзээ төрүүлсэн ийм асуудалд нэр холбогдсондоо уучлалт гуйж байна. Эрхэм парламентын гишүүд Та бүхнээсээ. Энэ асуудал хуулийн дагуу шалгагдаад нотлогдоно гэдэгт эргэлзэхгүй байна.

Дээрээс нь Үндэсний баялгийн сантай холбоотой асуудал, Үндэсний баялгийн сангийн эргэн тойронд бас олон асуудлууд болж өнгөрч байгаа, өрнөж байгаа. Энэ нь цаашдаа бас мэтгэлцээний ийм үндсэн сэдэв байна.

Тэгээд цаг хугацаа өөрөө үнэнийг дэнсэлж, цаг хугацаа өөрөө худлыг ч бас дэнсэлдэг.

Тийм учраас өнөөдрийн яригдаж байгаа Та бидний яригдсан энэ бүх зүйл та бидний сэтгэлд дурсамж болж үлдэнэ. Цаг хугацаа өөрөө аль асуудал нь үнэн, аль асуудал нь худлаа байсныг аяндаа нотолно гэдэгт би огт эргэлзэхгүй байна.

Тийм ч учраас би өнөөдрийн энэ итгэл үзүүлэх эсэх тухай энэ асуудлыг оруулж, нээлттэй ярилцах нь зүйтэй гэж үзсэн юм. Цааш цаашдаа ч гэсэн олон асуудал, олон асуудлын шалтгаант холбоо хөшигний ард өрнөж байгаа асуудлууд Монголын улс төрд ил тод байгаасай гэж би хүссэн.

Та бүхнийгээ мэтгэлцэх энэ асуудалд бас хоорондоо үзэл бодлын талцалтай холбоотой ийм асуудал үүсгэсэн бол хүлцэл өчье. Гэхдээ түүнээс илүү энэ асуудлыг бид олон нийтийн өмнө нээлттэй ярилцах нь илүү их тийм үнэт зүйл болж Монгол Улсын парламентын түүхэнд үлдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Ингээд миний хувьд өөрийнхөө л үзэл санааг илэрхийллээ. Үзэл санаа өөрөө үхэшгүй мөнх зүйл. Санал хураалт эрхэм парламентын гишүүд Та бүхний онцгой бүрэн эрхийн асуудал. Миний хувьд албан тушаалд үлдэх, аль эсвэл ямар нэгэн аргаар асуудлыг өөрөөр тайлбарлах ямар ч зорилго байгаагүй гэдгээ Та бүхэнд хариуцлагатай хэлье.

Туйлын чухал хариуцлагатай асуудал учраас үүнийг би олон талаас нь дүгнэн хэлэлцэх нь дараа дараагийн цаг хугацааны дүгнэлтэд хэрэгтэй болов уу гэж Ерөнхий сайдын хувьд үзсэн юм шүү гэдгээ Та бүхэндээ хэлье.

Ингээд энэ бол миний идеологи. Санал бол Та бүхнийх. Тэгээд та бүхэндээ амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо “Монгол Улсын Ерөнхий сайд итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах талаар санал хураалт явуулна.

Горимын санал. Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ингээд хздүүлээ бүтэн өдөр хуралдлаа.

Эхлээд намын бүлгүүд хуралдлаа. Дараа нь Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдсан. Одоо ингээд чуулган маань хуралдаад өнөөдөр бараг үүр цайлгах гэж байна уу.

Сая Ерөнхий сайд хэллээ. Би цааш цаашдаа албан тушаалтайгаа зууралдаад байх юм алга. Бүх итгэл үнэмшил та бүхэнтэй ярилцлаа. Нээлттэй ярилцлаа. Тэгээд та бүхний итгэл үнэмшлээрээ саналаа өгөөрэй гэсэн ийм зүйл ярьж байна.

Өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бид нууц санал хураалт хураасан. Энэ удаагийн энэ Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудал маань 126 гишүүнтэй, холимог тогтолцоотой энэ парламентын хамгийн анхны Засгийн газар буюу хамгийн анхны Засгийн газрын тэргүүнийхээ асуудлыг өнөөдөр бид итгэл үзүүлэх талын асуудлыг ярьж байгаа юм.

Энэ парламентад магадгүй цоо шинэ улс төрийн тийм түүх болж үлдэхэд.

Тэгээд цаашдаа бид магадгүй олон ч парламент Засгийн газар сонгогдоод явах байх. Хамтарсан Засгийн газар. Ямар л хэлбэрээр бол хэлбэрээр ингээд дэгдээд хамт явах боломж нөхцөл бололцоо цоо шинээр бий болж байгаа юм. 126 гишүүнтэй, холимог тогтолцоотой, 5 нам, эвсэлтэй ийм цоо шинэ парламент байгаа шүү дээ.

Өнөөдрийн ярьсан бүх зүйлүүд олон ургалч үзлийг илтгэсэн ийм сайхан ярилцлага, нээлттэй юмнууд ярилцлагууд боллоо гэж үзэж байгаа юм.

Тэгээд цааш цаашдаа хагарал, талцал, үл ойлголцол бага байгаасай гэсэн уур амьсгалаар Төрийн байгуулалтын байнгын хороон дээр нууц санал хураалт явагдсан.

Би бас дахиад энэ чуулган дээр санал хураалтыг нууц яваасай гэсэн горимын саналыг гаргаж байна.

Нэгдүгээрт нь, нууц санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргаж байна.

Хоёрдугаарт, цаасаар явуулъя. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр явсны нэгэн адилаар цаасаар явуулъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр эхлээд горимын саналаар санал хураах ёстой болно.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хурууныхаа хээг уншуулна ахиж. Бүгд хурууныхаа хээг уншуулсан уу? Хэдэн гишүүн бүртгэгдсэн байна?

Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлыг нууцаар буюу цаасаар санал хураалт явуулъя гэдгийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

77 гишүүн буюу 65.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах ажлыг зохион байгуулах гишүүдээс бүрдсэн тооллогын комиссыг Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна гэж хуулийн заалт байгаа.

Эхлээд энэ тооллогын комиссыг байгуулчих уу? Одонгийн Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье. Горимын санал.

О.Цогтгэрэл: Гишүүддээ шөнийн мэнд хүргэе.

Ардчилсан намын бүлэг маш өндөр 93 хувийн ирцтэйгээр хуралдаж улс төрийн шийдвэр гаргасан.

Ерөнхий сайдад итгэл үзүүлэх санал хураалтад оролцохгүй ээ гэж. Энэ нь бас хоёр талтай.

Нэгдүгээрт нь, улс төрийн шийдвэрийг дангаараа гаргасан Монгол Ардын нам өөрөө дахиад Улсын Их Хурал дээр бие даасан шийдвэрээ гарга, асуудлаа шийд ээ.

Хоёрдугаарт нь, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар санал хураалтад оролцохгүй гэдэг нь өөрөө эсрэг саналыг илэрхийлдэг. Эсрэг саналыг илэрхийлдэг.

Тэгэхдээ бас нууц санал хураалтад гэдэг агуулгыг бас ярина лээ. Гэхдээ энэ ямар ч тохиолдолд оролцохгүй байх нь агуулгаараа эсрэг саналыг илэрхийлж байна гэсэн үг.

Тийм болохоор Та бүхэн улс төрийн шийдвэрээ гаргаад дангаараа гэрээний үүргээ дүгнэлгүйгээр өөрсдөө дур мэдэн шийдсэн учраас хариуцлагаа мэдээж хүлээж байгаа байлгүй. Асуудлаа ухамсарлаж байгаа байлгүй.

Ардчилсан нам, Ардчилсан намын бүлгийн гишүүд бүлгийн хурлаас гаргасан гаргасан улс төрийн шийдвэрээ дагаж энэ удаагийн хуралдаанд оролцохгүй. Бүлгийн гишүүдийг энэ санал хураалтад оролцохгүйгээр чуулганы танхимыг бүлгийн хурлын шийдвэрээ дагаж орхин гарахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Яах вэ, санал хураалтад л оролцохгүй гэж байгаа шүү дээ. Орхиж гарахдаа ч гол нь биш.

Орхиж гарна гэхээр дэгийн тухай хууль яригдаад эхэлнэ. Тийм. Санал хураалтад оролцохгүй ээ л гэсэн ийм байр суурь. Түүнээс танхимыг орхиж гарна гэвэл дэгийн тухай хууль, Үндсэн хууль яригдана. Энэ дээр.

Тэгэхээр яах вэ, санал хураалтад оролцохгүй гэдэг байдлаар.

Цаасаар санал хурааж байгаа тохиолдолд хэдэн саналын хуудас тараагдсан, хэдэн саналын хуудас хүчинтэй, хэдэн саналын хуудас дэмжсэн гэдэг л дүн гарна. Тэгээд эсрэг гарахгүй гэсэн үг болж байгаа юм.

Тэгэхээр санал хураалт явагдсаны дараа тогтоолууд батлагдана.

Ардчилсан намын бүлгийн гишүүдийг байж байхыг хүсье. Санал хураалтад оролцохгүй гэдгийг ойлголоо.

Тооллогын комисс байгуулна. Тооллогын комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах ажлыг зохион байгуулах гишүүдээс бүрдсэн тооллогын комиссыг Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна гэж байгаа юм. /алх цохив/

Тооллогын комиссыг хэдэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байлгах саналтай байна. 7-гоор нь авах уу? 7 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс байгуулъя.

Гишүүд гараа өргөчихье. Тэгэх үү. 7-г. 7-г дэмжиж байгаа юм байна. Тийм ээ. 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулъя.

Яах вэ, нэрсээ бүлэг намын төлөөллүүд нэр өгөх үү?

М.Нарантуяа-Нара, М.Сарнай, Л.Энхнасан гишүүн.

Монгол Ардын намаас хэн орох вэ? О.Батнайрамдал, Э.Болормаа. Одоо хоёр нэр. Д.Батлут, А.Ариунзаяа.

Би тэгвэл тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя. Тооллогын комисс байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Тооллогын комисс байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар нууц санал хураалтыг зохион байгуулж, дүнг танилцуулах үүрэг бүхий тооллогын комиссыг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, М.Сарнай, Л.Энхнасан, О.Батнайрамдал, Э.Болормаа, Д.Батлут, А.Ариунзаяа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Нууц санал хураалт явуулах дүнг гаргах журмыг боловсруулж, санал хураалтыг зохион байгуулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулахыг тооллогын комисст даалгасугай.

3.Тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл санал хураалт явуулъя. Санал хураалтад дахиж бэлдэх үү? Санал хураалтад бэлдье. Гишүүд хурууныхаа хээг уншуулж бэлдье. Гишүүд хурууныхаа хээг уншуулсан уу?

“Тооллогын комисс комисс байгуулах тухай” Их Хурлын тогтоолыг дэмжье гэсэн саналын томъёолол.

Ардчилсан намын гишүүд гараад явсан учраас санал дээр эсрэг гарна.

Тэгэхээр танхимд байгаа гишүүд санал хураалтад анхааралтай оролцохыг хүсье.

“Тооллогын комисс байгуулах тухай” тогтоолыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

76 гишүүн буюу 64.4 хувиар “Тооллогын комисс байгуулах тухай” тогтоол батлагдлаа.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Одоо тооллогын комисс хуралдаад маш богино хугацаанд журмаа Их Хуралд танилцуулж, Их Хурлаар батлуулахаар байгаа. Тооллогын комиссыг хуралдахыг урьж байна.

Тооллогын комисс хуралдаж, дарга аа сонгосон. Журмаа танилцуулахад бэлэн болсон байна.

Улсын Их Хурлын гишүүн, Тооллогын комиссын дарга Мөнхтөрийн Нарантуяа-Нара Тооллогын комиссын боловсруулсан “Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулна.

Индэрт урьж байна.

М.Нарантуяа-Нара: Нууц санал хураалтын комисс хуралдаад дараах тогтоолыг санал хураалт явуулах дүнг гаргах журамтай хамт уншиж танилцуулъя.

“Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журам батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Нууц санал хураалт явуулах дүнг гаргах журам.

Санал хураалт явуулах, дүнг гаргах ажиллагааг дараах журмаар явуулна.

1.Тооллогын комиссын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.

2.Энэ журмын хавсралтад заасан саналын хуудас бүрд тэмдэг дарж баталгаажуулна.

3.Санал хураах хайрцгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож буй гишүүдэд үзүүлнэ.

4.Санал хураах хайрцгийг хааж битүүмжилнэ.

5.Санал хураалтад оролцсон гишүүдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар дуудна.

6.Гишүүдэд саналын хуудас өгнө.

7.Саналын хуудас авсан гишүүнээр гарын үсэг зуруулж, жагсаалтад тэмдэглэнэ.

8.Гишүүд тусгайлан зассан ширээн дээрх үзгээр саналаа дугуйлна.

9.Гишүүд зөвшөөрсөн, эсхүл татгалзсан саналын аль нэгний өмнөх дугаарыг дугуйлна. Өмнөх дугаарыг шүү.

10.Саналын хуудас тараалтад хяналт тавина.

11.Санал хураалт дууссаныг мэдэгдэж, лац хөдөлгөөгүй байгааг гишүүдэд харуулж хайрцгийг нээнэ.

12.Саналын хуудсыг тооллогын комиссын гишүүд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож буй гишүүдэд харагдах газарт тоолно.

13.Саналын хуудсыг нэг бүрчлэн шалгана.

14.Хүчинтэй, хүчингүй хуудасны тоог гаргана.

15.Дараах тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.

15.1.Илүү тэмдэглэсэн, эсвэл хоёуланг нь дугуйлсан.

15.2.Ямар ч тэмдэглэл хийгээгүй, санал өгөөгүй тохиолдолд.

16.Санал хураалтын дүнг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцон гишүүдийн тоо болон хувиар гаргана.

17.Санал хураалтын дүнг комиссын тогтоолд тусгана.

18.Санал хураалтын дүнг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

19.Санал хураалтын баримт бичгийг хүлээлгэж өгнө.

Тооллогын комиссын тогтоолын хавсралт 1 дээр тооллогын 7-н комиссын гишүүд гарын үсгээ зурж, дарга, нарийн бичгийг томилсон байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: “Тооллогын комиссын нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тэгвэл тогтоолын төслөө батлах санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Бэлдээгүй байсан уу? Санал хураалтыг хүчингүй болгоё. /алх цохив/

Гишүүд хурууныхаа хээг уншуулж, санал хураалтад бэлтгэе. Гишүүд бэлэн болсон байна.

Тооллогын комиссын тогтоолыг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68 гишүүн буюу 57.6 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Одоо тооллогын комисс нууц санал хураалт явуулах, дүн гаргах журмын дагуу санал хураах ажлыг зохион байгуулж эхэлье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд анхааралтай сонсож байгаарай.

Та бүхнийг цагаан толгойн үсгээр нэрсийг дуудаж, энэ саналын хуудсыг гишүүн тус бүрд нэг нэг ширхгийг өгнө.

Тэгээд энэ саналын хуудсыг аваад Та бүхэн тэнд баруун жигүүрт, тэнд байрлах хоёр бүхээгний хэсэгт очиж тэнд байгаа балаар зөвхөн энэ “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэдэг хоёр үгийн өмнөх дугаарыг, өөрөөр хэлбэл “зөвшөөрсөн” бол 1-ийн тоог, “татгалзсан” бол 2-ын тоог дугуйлна.

Тэгээд үүнийгээ голоор нь нугалаад, авчраад саналын хайрцагт хийх байгаа юм шүү. Ийм маш амархан байгаа биз. Гишүүд ээ.

Одоо ингээд саналын хайрцгийг шалгах ажиллагааг эхлүүлъя гэж бодож байна.

Наад саналын хуудсаа өгч байгаарай. Түрүүн санал хураах журмыг танилцуулсан. Тэгэхдээ дахиад хэлье.

Хоёр тохиолдолд энэ саналын хуудас хүчингүй болж байгаа. Тэр нь 15.1 дээр “илүү тэмдэглэл хийсэн” бол хүчингүй болно. Мөн түүнчлэн ямар нэгэн “ямар ч тэмдэг байхгүй” бол санал хүчингүйд тооцогдож байгаа шүү.

Ингээд эхний саналын хайрцгийг Та бүхэнд харуулъя. Дотроо юу ч үгүй хоосон байна. Тийм байгаа биз. Хоёр дахь саналын хайрцгийг Та бүхэнд хоосон байгааг нь бас танилцуулъя.

О.Батнайрамдал: Эхлэх үү бүгдээрээ. Арай болоогүй байна уу? Болоогүй байна. Тийм ээ.

Э.Болормаа: Гарын үсэг зуруулахаа А.Ариунзаяа дарга хариуцах юм уу. Тэгэх үү.

А.Ариунзаяа: Энд суугаад л. Хэдэн саналын хуудас болсон?

О.Батнайрамдал: Бэлэн болонгуут би нэрс уншина шүү дээ. Болсон уу?

Эрхэм гишүүд ээ, санал өгөхөд бэлэн болсон байна. Саналын хуудас тоологдсон байгаа.

Одоо 126 гишүүнийг үсгийн дарааллаар нэрсийг уншина. Нэрс уншигдсан гишүүд хоёр талаар ирээд эндээс саналын хуудсаа аваад, хоёр талаар яваад, хоёр талын жигүүрээр ард саналаа өгөөд ирж саналын хуудсаа энд саналын хайрцагт хийнэ.

Жуковын Алдаржавхлан,
Оюунсайханы Алтангэрэл,
Норовын Алтанхуяг,
Наранцэцэгийн Алтаншагай,
Дашзэгвийн Амарбаясгалан,
Сайнбуянгийн Амарсайхан,
Очирбатын Амгаланбаатар,
Чинбаатарын Анар,
Аюушийн Ариунзаяа,
Тилеуханы Аубакир,
Хүрэлбаатарын Баасанжаргал,
Цэндийн Баатархүү,
Мягмарсүрэнгийн Бадамсүрэн,
Энхтайваны Бат-Амгалан,
Батын Батбаатар,
Далайн Батбаяр,
Жигжидийн Батжаргал,
Ринчиндоржийн Батболд,
Дамбын Батлут,
Отгоншарын Батнайрамдал,
Жамбын Батсуурь,
Нацагдоржийн Батсүмбэрэл,

Э.Болормаа: Халтмаагийн Баттулга,

Батмөнхийн Батцэцэг,
Пүрэвийн Батчимэг,
Энхбаярын Батшугар,

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ,
Жадамбын Бат-Эрдэнэ,
Баярмагнайн Баярбаатар,
Жудагийн Баярмаа,
Жадамбаагийн Баясгалан,

О.Батнайрамдал: Буланы Бейсен,

Хөххүүгийн Болормаа,
Энхбатын Болормаа,
Хүрэлбаатарын Булгантуяа,
Дуламын Бум-Очир,
Шинэбаярын Бямбасүрэн,
Сандагийн Бямбацогт,
Жанчивын Галбадрах,
Амгаланбаатарын Ганбаатар,
Гомбын Ганбаатар,
Жамбалын Ганбаатар,
Сайнхүүгийн Ганбаатар,
Дашдондогийн Ганбат,
Пүрэвжавын Ганзориг,
Даваасамбуугийн Ганмаа,
Лувсаннямын Гантөмөр,
Хассуурийн Ганхуяг,
Мөнгөнцогийн Ганхүлэг,
Цэрэнпилийн Даваасүрэн,
Гонгорын Дамдинням,
Тогмидын Доржханд,
Борхүүгийн Дэлгэрсайхан,
Болдын Жавхлан,
Хажекберийн Жангабыл,
Батбаярын Жаргалан,
Дамдинсүрэнгийн Жаргалсайхан,
Сонгобайн Замира,
Батжаргалын Заяабал,
Жаргалсайханы Золжаргал,
Сархадын Зулпхар,
Цагаанхүүгийн Идэрбат,
Чулуунбилэгийн Лодойсамбуу,
Ганзоригийн Лувсанжамц,
Сүрэнжавын Лүндэг,
Мэндбаярын Мандхай,
Лхагвын Мөнхбаатар,
Цагаанхүүгийн Мөнхбат,
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан,
Тогтмолын Мөнхсайхан,

Баатаржавын Мөнхсоёл,
Пүрэвбаатарын Мөнхтулга,
Цэндсүрэнгийн Мөнхтуяа,
Загджавын Мэндсайхан,
Бадралын Найдалаа,
Нанзадын Наранбаатар,
Пүрэвсүрэнгийн Наранбаяр,
Мөнхтөрийн Нарантуяа-Нара,
Чинбатын Номин,
Одсүрэнгийн Номинчимэг,
Нямтайширын Номтойбаяр,
Эрдэнэбилэгийн Одбаяр,
Салдангийн Одонтуяа,
Ухнаагийн Отгонбаяр,
Ганбатын Очирбат,
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ,
Бадамдоржийн Пунсалмаа,
Даваахүүгийн Пүрэвдаваа,
Бөхчулууны Пүрэвдорж,
Дүгэрийн Рэгдэл,
Пүрэвжавын Сайнзориг,
Цэндийн Сандаг-Очир,
Отгоны Саранчулуун,
Мягмардашийн Сарнай,
Лхагвасүрэнгийн Соронзонболд,
Ренчинбямбын Сэддорж,
Цэвэгдоржийн Туваан,
Буяагийн Тулга,
Банзрагчийн Түвшин,
Хишигдэмбэрэлийн Тэмүүжин,
Ганзоригийн Тэмүүлэн,
Агваанлуvsангийн Ундраа,
Чинбатын Ундрaм,
Ням-Осорын Учрал,
Болдын Уянга,
Гончигдоржийн Уянгахишиг,
Доржсүрэнгийн Үүрийнтуяа,
Ганбатын Хосбаяр,
Бадарчийн Хэрлэн
Даваагийн Цогтбаатар,
Дамдины Цогтбаатар,
Одонгийн Цогтгэрэл,
Саруулсайханы Цэнгүүн,
Жигжидсүрэнгийн Чинбүрэн,
Баттогтохын Чойжилсүрэн,
Өлзийхүүгийн Шижир,

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан,
Баттөмөрийн Энхбаяр,
Жадамбын Энхбаяр,
Лутаагийн Энхнасан,
Доржзовдын Энхтуяа,
Дашцэрэнгийн Энхтүвшин,
Мөнхчулууны Энхцэцэг,
Сүхбаатарын Эрдэнэбат,
Сүхбаатарын Эрдэнэболд,
Равжихын Эрдэнэбүрэн.

126 гишүүний нэр уншиж дууслаа.

Д.Амарбаясгалан: Гишүүдийг танхимдаа цуглахыг урьж байна. Санал хураалтыг явуулж дууслаа.

Одоо санал хураалтын дүнг Улсын Их Хурлын гишүүн, Тооллогын комиссын дарга Мөнхтөрийн Нарантуяа-Нараа танилцуулна.

Индэрт урьж байна.

М.Нарантуяа-Нара: “Санал хураалтын дүнгийн тухай” тооллогын комиссоос ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар нууц санал хураалт явуулав.

Нууц санал хураалтад 82 гишүүн оролцов.

Санал хураах хайрцгийг нээхэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах асуудлаар 82 ширхэг саналын хуудас гарсан ба хүчинтэй саналын хуудас 82, хүчингүй саналын хуудас “тэг” байв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн санал тус бүрээр нэг бүрчлэн тоолж гаргахад, “зөвшөөрсөн” гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 44 ширхэг буюу санал хураалтад оролцсон гишүүдийн 53.6 хувь.

2.“Татгалзсан” гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 38 ширхэг буюу санал хураалтад оролцсон гишүүдийн 46.4 хувь нь байна.

Комиссын дарга М.Нарантуяа-Нара, гишүүдэд О.Батнайрамдал, М.Сарнай, Э.Болормаа, Д.Батлут, Л.Энхнасан. Нарийн бичгийн дарга А.Ариунзаяа.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр санал хураалтад 82 гишүүн оролцож, 44 гишүүн итгэл хүлээлгэхийг дэмжсэн, 38 гишүүн дэмжээгүй дүн гарсан байна.

Тэгэхээр дэгийн тухай хуулиараа нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүн дэмжсэн тохиолдолд Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудал тогтоол дэмжигдэхээр байсан.

Тийм учраас Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлаагүй гэж үзнэ.

Батлаагүй тул Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно. /алх цохив/

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Монгол Улсын Ерөнхий сайдыг огцорсонд тооцох тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг огцорсонд тооцсугай.

2.Шинэ ерөнхий сайдыг томилогдох хүртэл хугацаанд үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа,

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр миний бие болон хамтарсан Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй боллоо.

Эх орон, ард түмэндээ зүтгэх нэр төртэй үүргийг хүлээж, цар тахал, дайн, тариф зэрэг олон улсын ээдрээтэй үед ард түмнийхээ төлөө үйлчилсэн нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа.

Намайг дэмжиж, итгэл хүлээлгэж ирсэн Монгол Ардын намын журмын нөхдөдөө талархаж байна.

100 жилийн түүхтэй улс төрийн ууган хүчин Монгол Ардын намыг нэгэн зуунаас шинэ зуунд намынхаа мянга мянган гишүүд дэмжигчдийн хамт ялалтаар түүчээлсэн нь миний амьдралын бахархалт түүх болон үлдэх болно.

Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж ажилласан Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан нарт талархал илэрхийлье.

Мөн Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэндээ талархал илэрхийлж байна.

Салбар бүрийн төлөөлөл 126 гишүүн бүхий холимог тогтолцоотой парламентыг бүрдүүлэх, мөн “Хурдтай хөгжлийн төлөө Зориг” уриан дор хамтарсан Засгийн газрыг байгуулж олон жил гацсан төслүүдийг урагшлуулахад улс төрийн манлайлал үзүүлж хамтран ажилласан Ардчилсан намын нийт гишүүд, Ардчилсан намын дарга Лувсаннэмын Гантөмөр танд, ХҮН нам, ХҮН намын дарга Тогмидын Доржханд танд болон парламентад суудалтай нийт намын удирдлагууд, эрхэм гишүүд, мөн надтай хамтран ажилласан Засгийн газрын нийт бүрэлдэхүүндээ, бүх талаар дэмжиж ажилласан Улсын Их Хурал, Улсын Их Хурлын нийт удирдлагууд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Дараагийн Монгол Улсын Ерөнхий сайдын үйл хэрэг өрнүүн их замд нь амжилт хүсье.

Дараагийн Ерөнхий сайдын амжилт бол монголчууд бидний хамтын амжилт учраас бүх талаар дэмжиж хамтран ажиллах болно.

Намайг дэмжсээр ирсэн ард түмэндээ чин сэтгэлээсээ баярлалаа.

Ил тод, нээлттэй нийгмийн төлөө үзэл бодлоо илэрхийлсэн ардчилсан нийгмийн ирээдүй болсон залуучууддаа талархаж байна.

Надад итгэж үзэл санаа нэгдэж хамт байгаа эрхэм гишүүддээ баярлалаа.

Өнөөдөр ордонд хүч мөхөстөж байгаа ч олон нийтийн хүсэл эрмэлзэл огт өөр байгааг би мэднэ.

Үзэл санаа, үнэт зүйл хэзээ ч ялагддаггүй. Аалзны тор мэт сүлжилдсэн ашиг сонирхлын сүлжээ ард түмнийг дийлнэ гэж хэзээ ч байхгүй.

Мөнх хөх тэнгэрийн доор ардчилсан парламентын засаглал мөнхөд орших болтугай. Баярлалаа. /алга ташив/

Д.Амарбаясгалан: Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдад баярлалаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд уртасгасан цагаар ажиллаж, Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд итгэл үзүүлэх эсэх асуудлаар Улсын Их Хуралд хандсан.

Ардчиллын 33 жилийн түүхэнд хоёр дахь удаагаа итгэл үзүүлэх асуудал ийнхүү Улсын Их Хуралд өргөн баригдаж, санал хураалт явагдаж, үр дүн гарлаа.

Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн хугацаанд хамтарсан Засгийн газар, түүний өмнөх, дангаараа Засгийн газрын эрхийг барьж байх үед Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын улс, эх орны төлөө хийж бүтээсэн олон гавьяа байгаа.

Тэр дундаа улс орны эдийн засаг хасах нэг хувьд орсон байсан цаг үе дээр Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлыг хүлээж авсан.

Богино хугацаанд эдийн засгийн өсөлтийг Ази тивийнхээ хэмжээнд тэргүүлэх зэрэгт хүргэж чадаж байсан түүхэн амжилт бас түүнийх.

Түүний баг, кабинет хоёргүй сэтгэлээр төрийнхөө төлөө зүтгэсэн гэдэгт бид итгэлтэй байгаа.

Цаашдаа ч Монгол Улсын төрийн төлөө, улс төрч хүнийхээ хувьд, залуу хүнийхээ хувьд хичээн зүтгэнэ гэдэгт бид итгэж байгаа.

126 гишүүнтэй парламент анх удаа бүрдэж, анхны Засгийн газрыг хамгийн олон суудал авсан 3 нам хамтарсан Засгийг байгуулах шийдвэрийг Улсын Их Хуралд оруулж дэмжигдэж байсан.

Мэдээж зорилго бол үгсэн хуйвалдаж явах гэдэг зорилго байгаагүй. Үндсэн зорилго улс орны өмнө тулгамдсан улс төрийнхөө шийдлийг хүлээсэн олон том төслүүдийг хэрэгжүүлэхэд гол зорилгоо тавьж ажилласан.

Хэдийгээр энэ хамтарсан Засгийн газар богинохон 10 сарын хугацаанд ажилласан хэдий ч 15-аас 30 жилийн хугацаанд улс төрийн гол сэдэв болж гацсан төмөр замын холболт, ураны төсөл, газрын тосны бүтээн байгуулалт гэх мэт олон төслийг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гэх мэт аж үйлдвэрийн болон эрчим хүчний салбарын томоохон төслүүдийг хөдөлгөж чадсан нь энэ Засгийн газрын бодитой ажил болсон гэдгийг бас энд товчхон дүгнэж хэлэхийг хүсэж байна.

Цаашдаа 126 гишүүнтэй парламент засаглалын тогтвортой байдлыг хангаж, байгуулсан засгаа дэмжиж, улс орныхоо эдийн засгийг урагшлуулахад нам харгалзахгүй хамтран зүтгэх нь бидний чухал үүрэг юм гэдгийг бас бодолцох ёстой.

Нөгөө талдаа иргэд, олон нийтийн зүгээс ихээхэн хүлээлт бий болсон нь ойрын өдрүүдэд болж өнгөрсөн үйл явдлуудаас харагдаж байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд улс төрчдийн хувийн гэлтгүй гаргаж байгаа алдаа дутагдлыг олон нийт соргогоор мэдэрч, шүүмжилж, асуудалд өөр өөрийн гэсэн байр суурийг чөлөөтэй илэрхийлж хандаж байгааг улс төрчид ялангуяа анзаарч анхаарч ажиллах ёстой.

Ордон доторх амьдрал нэг өөр, гадна талд байгаа амьдрал нэг өөр хэлбэрээр ажиллах боломжгүй.

Тийм учраас улс төрч бүр энэ бодлого дээр анхаарлаа төвлөрүүлж, олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлэхийн төлөө хичээн зүтгэхийг Та бүхэндээ бас хүсэж байна.

Ингээд Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдынхаа цаашдын ажилд нь амжилт хүсье. Улс төрийн зам нь дардан байх болтугай гэж бас хүсэн ерөөе. Баярлалаа. /алга ташив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 9 цаг 11 минут үргэлжилж, 03 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД